Шашин шүтэх эрх нь хувь хүний асуудал боловч шашин хоорондын зөрчил, шашны харгис урсгалыг дэлгэрүүлэхгүй байх, шашны итгэл үнэмшлээр далимдуулж нийгмийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх, нийгмийн тогтворгүй байдал бий болох зэргээс урьдчилан сэргийлэх нь төрийн үүрэг юм. Шашин сүмийн асуудал нь тухайн улсын үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулаад байгаа бусад улс орнуудын нөхцөл байдлаас үзэхэд шашны асуудлыг урсгалд нь орхих нь хэтдээ залруулж болшгүй аюул, заналын эх үндэс болдог гашуун сургамжийг судалж, цаг алдалгүй шийдвэртэй алхам, зохицуулалт хийхийг мэргэжилтнүүд[1] зөвлөж байна.

Монгол Улсад шашны байгууллага, сүм хийдийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа бөгөөд олон төрлийн шашин номлол сургаалаа түгээж үйл ажиллагаа явуулж байна. Тухайн шашны байгууллагууд үйл ажиллагаа эрхлэхдээ

[1] Д.Адъяабазар, "Монгол Улсын дотоод аюулгүй байдлын эрсдэл бүхий зарим асуудал", Стратеги судлал сэтгүүл 2011 он. 53, 35 дахь тал.

ТББ-ын нэр дээр халхавчлан үйл ажиллагаа эрхлэх явдал түгээмэл болсон байна[2]. ТББ-ын хуульд хамаарахгүй төрийн бус байгууллага болох шашны байгууллага маш олноор ТББ гэж бүртгүүлэн ТББ-ын хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа нь ТББ-ын тухай хуулийн 3.1-г зөрчиж байна[3]. Хуулийн этгээдийн бүртгэлийн асуудлыг хариуцах төрийн байгууллагаас авсан судалгаанаас нийт 17673 ТББ-ын 525 нь шашны байгууллага байна[4]. Ерөнхийлөгчийн Шашны бодлогын зөвлөх 2018 оны 10 дугаар сард хэвлэлд өгсөн ярилцлагадаа зарим гадаад орны санхүүжилттэй төрийн бус байгууллагууд хууль зөрчиж шашны үйл ажиллагаа явуулдаг талаар дурдсан[5] байдаг. ТББ-ын санхүүгийн эх үүсвэр, хандив тусламжийн дүн, эргэн зарцуулалт тодорхой бус, хянагддаггүй, эрх зүйн орчин муу байгаагаас мөнгө угаах эрсдэл энэ салбарт 62 хувьтай байгаа талаар ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг тэмдэглэсэн[6].

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн шалгалтын мэдээгээр 2016 онд улсын хэмжээнд 6 төрлийн шашны 20 гаруй урсгалын 848 хуулийн этгээд шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаагаас 54.2% нь христийн, 34.6% нь буддын, 5.1% нь исламын, үлдсэн 6% нь бусад чиглэлийн шашны байгууллага[7] байна. Исламын шашны сүм хийд (мечеть), төвүүд Казахстан, Турк, Персийн булангийн улсуудын шашны байгууллагуудаас санхүүгийн тусламж авдаг. Мөн сүүлийн үед нэмэгдэж буй христ, католик сүм, санваартан нар гаднаас санхүүжилтээ[8] авдаг байна. 2011 онд гаргасан судалгаагаар ТББ-ын санхүүжилтийн 67.7% гадаадын, 2% Монголын төр гаргажээ[9]. Гадаад улс Монголын иргэний нийгмийг санхүүжүүлэх замаар өөрсдийн бодлогоо тулгах эрсдэлийг бий болгодог. Монголд үйл ажиллагаа явуулж байгаа шашны байгууллагын дийлэнх санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй байгаа бөгөөд үүнийг хянах тогтолцоо дутмаг байна. Тиймээс шашны секторуудын үйл ажиллагаанд мөнгө угаах гэмт хэрэг байж болзошгүй байна.

Дэлхийн энх тайван, эв нэгдлийн төлөөх гэр бүлийн холбооны (Эв нэгдлийн сүм) үйл ажиллагааны талаарх видео бичлэг "YouTube.com" дээр гарсантай холбогдуулж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны нэгэн газрын даргад дарамт учирч, улмаар ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргасан[10]. Түүнийг Эв нэгдлийн сүмд зориулж мөнгө угаасан гэх үндэслэлээр шалгахыг Авлигатай тэмцэх газраас шаардаж байв[11].

1993 онд батлагдсан Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар[12] зохицуулж ирсэн нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн

[2] Төр ба шашны харилцаа: шашны байгууллагын бүртгэл, харгис болон гаж урсгалын шашныг зохицуулах эрх зүйн механизм харьцуулсан судалгааны тайлан. ХЗҮХ 2018 он.
[3] Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа. 2017 он.
[4] Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас 2017 оны 9 сард гаргаж өгсөн тоо баримтаас.
[5] https://mn.usembassy.gov/2018-international-religious-freedom-report-mn/
[6] http://eagle.mn/r/64791
[7] ХЗДХ-ийн Сайдын 2016 оны А/73 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн шалгалтын дүн.
[8] Олон улсын шашны эрх чөлөөний тухай илтгэл, АНУ-ын Төрийн Департамент, 2009 он.
[9] http://itoim.mn/article/Gq2tI/14864
[10] https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2016-international-religious-freedom-report-mn/
[11] International Religious Freedom Report for 2016, United States Department of State.
[12] Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль 1993 он

өөрчлөлт гарсан тул хуулийн төслийг Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль болгон өргөжүүлж, шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулах ажлыг 2018 онд эхлүүлсэн. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд тулгуурлан, Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн талаарх олон улсын гэрээний суурь зарчимд нийцүүлэн тодорхойлно. Мөн шашны бүлэг, шашны байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээллийг ил тод, нээлттэй байх журмыг тогтооно. Энэ хүрээнд шашны бүлэг, шашны байгууллагын орлого болон бусдын өгсөн хандивыг хэрхэн бүртгэх, гадаадын иргэн, байгууллагын хандив, санхүүжилтэд тавих хяналт зэрэг асуудлыг тодорхой болгож, шашны байгууллагад үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан мэдээ гаргаж, тайлагнах үүргийг хүлээлгэх аж[13]. Шинээр боловсруулж буй Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төсөлд заасанчлан "шашны байгууллага" статусаараа явах болж байгаа учир ашгийн төлөө бус хуулийн этгээдийг шашны үйл ажиллагаа явуулахыг хориглож байна.

Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төслийн хориглох зүйлийн жагсаалтын 27.2.8 "Гадаад улсын Засгийн газар, түүнээс санхүүждэг хуулийн этгээд, шашны байгууллагаас хандив авах" зэрэг үйл ажиллагааг хязгаарласан[14]. Мөн хуулийн төслийн 38 дугаар зүйлд Шашны байгууллагын санхүүжилт, тайлагналтын талаар дэлгэрэнгүй тусгаж өгсөн[15] хэдий ч мөнгө угаах гэмт хэргийн эрсдлийг бууруулахад хангалттай арга хэмжээ тусгагдаагүй гэж үзэж байна. Гадны орнуудад дараах хэлбэрээр шашны байгууллагаар мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгддэг бөгөөд Монгол Улсын онцлогт тохируулан төрийн хуулийг боловсронгуй болгох, тус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүйн зохицуулалт хийх нь зүйтэй. Үүнд:

- Шашны байгууллагыг мөнгө угаах үйл ажиллагаанд ашиглаж болох нэг арга бол сүм хийдэд зээл олгох явдал юм. Сүм хийдийн барилга барих, ажил гүйцэтгэх гэрээ зэрэг үйл ажиллагаанд зээл олгох, улмаар сүм нь зээлдүүлэгчдэд мөнгөн шилжүүлэг хийх, чек өгөх замаар зээлээ төлдөг[16]. Зээл төлөлт нь санхүүгийн системд цэвэр мөнгө гэж үзэх болно.
- Олон улсад үйл ажиллагаа явуулдаг сүм хийд мөнгө угаах гэмт хэрэгт ороцолдох нь цөөнгүй байдаг. Хууль бус аргаар олж авсан мөнгийг шашны хандив гэсэн нэрийн доор хилээр гаргаж сүм хийд рүү шилжүүлдэг. Бохир мөнгийг хүлээн авсан сүм хийд тус мөнгийг банкинд байрлуулж тодорхой хувь хүн, хуулийн этгээд руу шилжүүлэх аль эсвэл

[13] Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, ХЗДХЯ, 2018 он.
[14] Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай (Шинэчилсэн найруулга) төсөл, 2018 он.
[15] Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төслийн 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Шашны байгууллага нь гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнээс мөнгөн болон бусад хөрөнгө, санхүүжилт авсан бол бодит зарцуулалт, ашиглалтын талаарх мэдээллийг холбогдох баримтын хамт өөрийн цахим хуудаст тухай бүр байршуулна". Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төслийн 38 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "Хувь хүн, хуулийн этгээдээс өгсөн мөнгөн хандивыг зориулалтын дагуу хандив өгөгчийн заасан хугацаанд зарцуулах бөгөөд хэрэв хандив өгөгч зарцуулах тодорхой хугацаа заагаагүй бол хандивыг хүлээн авснаас хойш 1 жилийн дотор зориулалтын дагуу зарцуулна".
[16] https://goldstreetbusiness.com/editiorial-features/the-church-and-money-laundering/

тухайн орондоо зарцуулна. Ийм тохиолдолд мөнгийг цэвэрхэн харагдуулахаар угаасан байдаг[17].

- Хувь хүн, хуулийн этгээд сүм хийдэд мөнгөн хандив өгөхдөө зориулалтыг тусгадаг. Хандивлаж буй мөнгөн дүнгийн тодорхой хэмжээг хилийн чандад байгаа өөр нэгэн хүмүүнлэг, шашны байгууллагад хандивлах нөхцөлтэйгөөр шилжүүлнэ. Анхдагч хандивыг хөндлөнгийн этгээд өөрийн данснаас гаргаснаар мөнгөний эх үүсвэрийг нуун далдалж, дээрх хандивыг сүм хийд хүлээн авснаар мөнгө угаах гэмт хэрэгт санаатай болон санамсаргүй байдлаар татан оролцох нөхцөл байдал үүснэ[18].
- Гадны улс орноос ирж буй хандив, санхүүжүүлэлтийн эх үүсвэрийг тухай бүр тогтоох боломжгүй байдаг тул мөнгө угаах зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг таслан зогсооход хүндрэл учирдаг.

Монгол Улсад шашны байгууллагаар мөнгө угаах гэмт хэргийн эрсдлийг нэмэгдүүлж болзошгүй нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх

Олон улсын стандартад мөнгө угаах үйлдлийг дараах байдлаар тодорхойлсон байдаг[19] : (i) тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус үүсвэрийг нуух, далдлах, эсхүл эрх зүйн үндсэн зөрчлийг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд өөрийн үйлдлийн төлөө хүлээх хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх; (ii) тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, шилжүүлэх, эзэмшигч буюу эд хөрөнгийн эрхийг нуух буюу далдлах; (iii) тухайн эд хөрөнгийг олж авах үед түүнийг гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийг олж авах, эзэмших буюу ашиглах; (iv) мөнгө угаах гэмт хэргийг үйлдэхэд оролцох, хамтрах, үгсэн тохиролцох, үйлдэхийг завдах болон хамжих, хатгах, туслах болон зөвлөгөө өгөх гэж тодорхойлсон байдаг[20].

Мөнгө угаах ойлголт манай улсад олон улсынхтай ижил том хэмжээний бүлэглэлийн хоорондох хар тамхи, хүний наймаа бус энгийн хялбар, хүний нүдэнд өртөхөөргүй нөхцөл байдлаар үйлдэгдэж байж болзошгүйг хууль хяналтынхны судалгаа харуулдаг. Тухайлбал, олон улсын байгууллагын санхүүжилтээр сайн санааны, хүмүүнлэгийн сан байгуулах үзэгдэл газар авсаар байна. Дээрх сангийн зорилго, үйл ажиллагааны чиглэл нь хүмүүнлэгийн, буцалтгүй тусламжаар хөгжингүй болон ядуу буурай орны иргэдийн амьдралд дэмжлэг үзүүлэх зорилгоор өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг учраас тухайн сангийн санхүүжилт, мөнгөний эх үүсвэрийг төдийлөн шалгадаггүй. Харамсалтай нь сан байгуулах нэрээр оруулж ирж байгаа мөнгө ямар ч хүний нүдэнд буцалтгүй тусламж, хандив хэлбэрээр харагддаг учир татвараас зайлсхийх тун

[17]https://www.simmsshowerslaw.com/granting-money-from-a-u-s-charity-or-church-to-a-foreign-individual-or-ngo-substantial-risks-and-best-practices/
[18] http://www.tlcompliance.co.uk/blog/charity-donations-used-by-money-laundering--criminals/
[19] Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, Палермо, 2000 он.
[20]https://www.mongolbank.mn/listcma.aspx?id=3

энгийн мөртлөө хялбар арга болдог. Олон улсын практикт мөнгө угаах гэмт хэрэг ихэвчлэн ийм аргаар үйлдэгддэг судалгаа[21] байна.

Манай улсад мөнгө угааж буй дараагийн нэг хэлбэр бол хөрөнгө оруулалт, хувь эзэмших явдал юм. Үүнээс гадна авлигад авсан эд хөрөнгийг бусдын нэр дээр шилжүүлэх, дүрсийг нь хувиргах, эдийн засгийн эргэлтэд оруулж болзошгүй нөхцөл манай улсад бий болсон нь анхаарал татаж эхэлсэн. Энэ бол мөнгө угаалтын нэг хэлбэр гэж албаныхан үздэг юм[22]. Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлын хэсгийн үнэлгээгээр манай улсын энэ салбарт буюу төрийн бус байгууллагуудаар дамжин мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг үйлдэгдэх өндөр эрсдэлтэйг[23] анхааруулсан.

Монголд үйл ажиллагаа явуулж байгаа шашны байгууллагын тоо нэмэгдсээр байгаа бөгөөд тэдний санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй байгаа нь нууц биш. Шашны үйл ажиллагааг ТББ-ын нэрийн доор явуулж байгаа нь мөнгө угаах гэмт хэрэг агуулагдаж байж болзошгүй юм. Эрх зүйн зохицуулалтын хийдэл, хяналт, бүртгэлийн сул талыг ашиглан шашны үйл ажиллагааг төрийн бус байгууллага (ТББ), боловсролын, эрүүл мэндийн болон хэвлэл мэдээллийн байгууллагаас гадна ашгийн төлөөх хуулийн этгээдийн хэлбэрээр бүртгэгдсэн байгууллагууд ч эрхлэн явуулж байгаа тохиолдол цөөнгүй байна[24]. Жишээлбэл, Гадаадын иргэн харъяатын газраас зөвшөөрөл аван үйл ажиллагаа явуулж байсан Америкийн Нэгдсэн Улсад төвтэй "Жи Эс Эм" төрийн бус байгууллагын төлөөлөгчийн газар нь олгогдсон зөвшөөрлийн дагуу зорилгодоо нийцсэн үйл ажиллагаа явуулаагүй, христийн шашныг нийтэд сурталчилж, санхүүжүүлсэн тул Гадаадын иргэн, харъяатын газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/57 тушаалаар үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон байна[25]

Төрийн бус байгууллагуудад дараах нийтлэг дутагдал, эрсдлийг нэмэгдүүлж болзошгүй нөхцөл байдал байна. Үүнд[26]:

- Зарим төрийн бус байгууллагуудын санхүүгийн тайлангаас үзэхэд арилжааны банкин дахь харилцах дансанд их хэмжээний мөнгө тодорхойгүй шалтгаанаар хуримтлагдсаар ирсэн тохиолдлууд байна.
- Хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй дийлэнх төрийн бус байгууллагын төлөөлөгчийн газрууд нь иргэдэд мөнгө санхүүгийн тусламж үзүүлэх нэрийдлээр далдуур шашны үйл ажиллагаа явуулж, улмаар хууль зөрчсөн тохиолдлууд гарсан байна.

[21] https://dnn.mn/монгол-улсын-мөнгө-угаалттай-тэмцэх-бодлого-буюу-саарал-жагсаалтын-сураг/
[22] https://dnn.mn/монгол-улсын-мөнгө-угаалттай-тэмцэх-бодлого-буюу-саарал-жагсаалтын-сураг/
[23] Anti-money laundering and counter-terrorist financing measures Mongolia, mutual evaluation report, APG, September 2017.
[24] ХЗДХ-ийн сайдын 2016 оны А/73 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн шалгалтын дүнд хавсаргасан шалгалт хийх шаардлагатай шашны үйл ажиллагаа явуулдаг байгууллагын жагсаалтад ТББ, ББСБ, ХХК, эмнэлэг, худалдааны төв, сургууль, цэцэрлэг, хүүхдийн зуслан, хэвлэлийн статус бүхий байгууллагыг хамруулсан байсан болно.
[25] https://news.zindaa.mn/2mdc
[26] Монгол Улсын Терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдлийн үнэлгээ, СМА, ТЕГ, ТТАЗЗ, УБ хот, 2018 он.

- Зарим гадаадын хөрөнгө оруулалттай салбар төлөөлөгчийн газрууд нь донор буюу хандивлагч байгууллагуудаас ирүүлж буй санхүүжилтийг байгууллагын албан ёсны харилцах дансаар авахгүйгээр төлөөлөгчийн газрын тэргүүний хувийн дансаар авч улмаар тус санхүүжилтийг юунд зарцуулж буй эсэх нь тодорхойгүй байдал гарсан.
- Гадаадын хөрөнгө оруулалттай төрийн бус байгууллагуудын дийлэнх хувь нь санхүүгийн тайлангаа харилцагч санхүүгийн байгууллага болон хяналт тавих эрх бүхий төрийн байгууллагад хүргүүлдэггүй, мэдээлдэггүй байдал гарч байна. Ялангуяа төв болон гадаадын донор байгууллагуудаас хичнээн төгрөгийн санхүүжилт авч үүнийг хэрхэн, юунд зарцуулсан тухайгаа холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад тайлагнадаггүй байдалтай байна.

Дүгнэлт, санал

Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн өөрчлөлт, эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд журам, заавар, аргачлал, гарын авлага зэргийг гаргаж, олон нийтэд багагүй ойлголтыг өгөөд байна. Дотоодын болон олон улсын түвшин дэх хамтын ажиллагааг өргөжүүлж мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд тодорхой алхам хийгдсээр байна.

Харин шашны байгууллагаар мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход цаашид хэрэгжүүлэх шаардлагатай олон алхам байна.

Төрийн бус байгууллагын тухай хуулийн 3.1-д заасныг үндэслэн хийгдсэн шалгалтаар илэрсэн төрийн бус байгууллагын нэрээр шашны үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудыг татан буулгах, зөвшөөрөлгүй шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа шашны байгууллагын үйл ажиллагааг зогсоох асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн хурал, холбогдох газарт нь тавьж шийдвэрлүүлэх шаардлага[27] байгаа хэдий ч шашны байгууллагын бүртгэл, үйл ажиллагааг нэг мөр зохистой буюу шашны байгууллагыг ТББ-аас ялгаатай, онцлогтойгоор зохицуулалт хийснээр ТББ-ын гажуудлыг арилгаж урт хугацааны шийдэл бий болно.

Төрийн бус байгууллага болон Иргэний нийгмийн бусад байгууллагын нийтлэг байдал, тэдгээрийн онцлог ялгааг харгалзсан зохицуулалтгүй байдал нь ТББ нэрийн дор улс төр, шашны төдийгүй ашгийн төлөөх байгууллага, боловсрол, эрүүл мэндийн байгууллагууд хүртэлх өргөн хүрээг хамарсан байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Шашны үйл ажиллагаа явуулдаг холбоо, хүмүүсийн нэгдэл нь ТББ-ын статустай байх нь зохимжгүй юм. Учир нь шашин, сүм, хийдүүдэд ТББ-д тавигдах нийтлэг шинжүүд бий боловч зарим шашны урсгалын хувьд уг нэгдэлд орох, гарах эрх нь хязгаарлагдмал тул "сайн дураар эвлэлдэн нэгдсэн байх" шалгуурыг хангадаггүй. Тиймээс шашны байгууллага болон төр, сүм хийдийг ТББ гэж үзэхэд учир дутагдалтай. ТББ-ын

[27]Хууль зүйн сайдын 2016 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн А/76 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн саналаас

тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамрахгүй шашны байгууллагыг ТББ-д хамруулахгүй байх, хуулийн үйлчлэх хүрээг зөв тодорхойлох, хамаарахгүй хуулийн этгээдийг салгах ажлыг нэн тэргүүнд хийх шаардлагатай байна.

Шашны байгууллагын хяналтыг сайжруулж тус тусын салбарын хуулиар зохицуулах нь тухайн салбарын бодлого нэг мөр хэрэгжих, нэгдсэн зохион байгуулалт, хяналтын хүрээнд хөгжих боломжийг бүрдүүлэх давуу талтай бөгөөд шашны байгууллагыг ашиглаж мөнгө угаах зэрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх механизм, оновчтой эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх ажлыг шат дараатай хийх боломжтой болно. Сүм хийдийн үйл ажиллагаанд тавих хяналт, бүртгэл, гадаад, дотоодын санхүүжилт, тайлагналт, бодит зарцуулалт зэрэг асуудлыг тодорхой хуульчилснаар эрх зүйн зохицуулалтын хүрээнд үүсээд буй зөрчил, хийдэл арилж, нэгдсэн зохицуулалттай болно. Улмаар сүм хийдийн тогтолцоо, үйл ажиллагааг урвуулан ашиглах, түүгээр мөнгө угаах зэрэг гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой болно.

Эх сурвалжийн жагсаалт

1. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, Палермо, 2000 он.
2. Д.Адъяабазар, “Монгол Улсын дотоод аюулгүй байдлын эрсдэл бүхий зарим асуудал”, Стратеги судлал сэтгүүл дугаар 53, 35 дахь тал, 2011 он.
3. Төр ба шашны харилцаа: шашны байгууллагын бүртгэл, харгис болон гаж урсгалын шашныг зохицуулах эрх зүйн механизм харьцуулсан судалгааны тайлан, ХЗҮХ, 2018 он.
4. Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, 2017 он.
5. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас 2017 оны 9 сард гаргаж өгсөн тоо баримтаас.
6. ХЗДХ-ийн сайдын 2016 оны А/73 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн шалгалтын дүн.
7. Олон улсын шашны эрх чөлөөний тухай илтгэл, АНУ-ын Төрийн Департамент, 2009 он.
8. Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, ХЗДХЯ, 2018 он.
9. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай (Шинэчилсэн найруулга) төсөл, 2018 он.
10. Монгол Улсын Терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдлийн үнэлгээ, СМА, ТЕГ, ТТАЗЗ, УБ хот, 2018 он.
11. Хууль зүйн сайдын 2016 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн А/76 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн саналаас.
12. Anti-money laundering and counter-terrorist financing measures Mongolia, mutual evaluation report, APG, September 2017.
13. International Religious Freedom Report for 2016, United States Department of State.
14. https://goldstreetbusiness.com/editiorial-features/the-church-and-money-laundering/

15. https://www.simmsshowerslaw.com/granting-money-from-a-u-s-charity-or-church-to-a-foreign-individual-or-ngo-substantial-risks-and-best-practices/
16. http://www.tlcompliance.co.uk/blog/charity-donations-used-by-money-laundering--criminals/
17. https://dnn.mn/монгол-улсын-мөнгө-угаалттай-тэмцэх-бодлого-буюу-саарал-жагсаалтын-сураг/
18. https://news.zindaa.mn/2mdc
19. https://mn.usembassy.gov/2018-international-religious-freedom-report-mn/
20. http://eagle.mn/r/64791

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ИРГЭНИЙ НЭХЭМЖЛЭЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗАМ

THE WAY TO IMPROVE CIVIL ARBITRATION PROCEEDINGS IN CRIMINAL PROCEEDINGS

М.Ванчигмаа
Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Аюулгүй байдлын сургуулийн Нийгэм хүмүүнлэгийн тэнхимийн ахлах багш, хууль зүйн доктор
Vanchigmaa M.
Instructor at National Defense University, Ph.D in Law

✉ vanchigmaa9194@gmail.com

"Хүний эрхийн олон улсын зарчим, хэм хэмжээнд дотоодын байгууллагын үйл ажиллагааг нийцүүлэх нь зүйтэй"[1]

Abstract: Article 14 of the Constitution of Mongolia stipulates that "the rights and freedoms provided by the law and international treaties of Mongolia have been violated, the right to reparation for the damage caused illegally..." Article 8 of the Universal Declaration of Human Rights states "Basic the right to restitution of the right to a competent national court shall be liable if the fundamental rights granted by law or law are violated", and Article 14, paragraph 1 of the "International Covenant on Political Rights and Political Rights" shall have equal access to all persons before the Tribunal and the Special Tribunal. Everyone has the right to be heard and prosecuted within the jurisdiction of a criminal case or to have jurisdiction over the jurisdiction of the jurisdiction over the jurisdiction of the jurisdiction over the jurisdiction of the jurisdiction of the jurisdiction. The legal grounds of the procedure for verifying and resolving issues pertaining to civil litigations during criminal procedure have been identified and the civil claim and its legal regulation are an important form of ensuring human rights.

Хураангуй: Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван зургаа дугаар зүйлийн 14 дэх хэсэгт "Монгол Улсын хууль болон олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлөх..." эрхтэй хэмээн хуульчилсны зэрэгцээ Хүний эрхийн түгээмэл тунхаглалын[2] 8 дугаар зүйлд "Үндсэн хууль болон бусад хуулиар олгогдсон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ сэргээн тогтоолгох эрхтэй", мөн "Үндсэн хууль болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт[3]"-ны 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүх ба тусгай шүүхийн

[1] Ж. Амарсанаа. "Хүний эрхийн олон улсын ба үндэсний эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судалгаа". Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2000. 177 дахь тал.
[2] Http//www.legalinfk.mn/insys/lawmain.php?viawld=3756
[3]Http//www.legalinfk.mn/insys/lawmain.php?viawld=3757.НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдөр 2200А (XXI) тоот тогтоолоор баталж 1976 оны 3 дугаар сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон Монгод Улс 1968 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр гарын үсэг зурж, 1974оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталсан.

өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгарсан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй" хэмээн тунхагласан явдал нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэний нэхэмжлэлтэй холбогдох асуудлыг шалгах, шийдвэрлэх үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлсон бөгөөд иргэний нэхэмжлэл, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь хүний үндсэн эрхийн хэрэгжилтийг хангах чухал хэлбэр мөн болохыг илэрхийлж байна.

Манай улсад нийгэм, эдийн засаг, улс төрийн харилцаа хувьсан өөрчлөгдөхийн хэрээр гэмт хэргийн гаралт болон гэмт хэргийн төрөл, түүнээс үүсэх хор хохирол ч хэлбэрээ өөрчлөн хувьсаж буйг статистик судалгаа харуулж байна. Ийнхүү хүний эрхийг дээдлэх үзэл хүчтэй хөгжиж байгаа ардчилсан нийгэмд хууль зүйн салбарын аливаа үйл ажиллагааны чиглэл хандлага бүр хууль ёсонд нийцэж байх, хүний жам ёсны эрхийг хөндөхгүй байх, хүний эрхийн талаар болон ёс зүйн хэм хэмжээг чанд сахидаг, ухамсар, соёл, хуулийн зөв ойлголт, хууль хэрэглээний чадвартай байхыг иргэдийн зүгээс шаардаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах, тус үүргийнхээ дагуу гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн этгээдийн эрхийг хэрхэн хангаж буйг илэрхийлэх нэг үзүүлэлт бол "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь иргэний нэхэмжлэл" юм. Судлаачийн хувьд уг сэдвийг сонгон авч судлах явцад цугларсан онол, практикийн мэдээллүүдийг нэгтгэн дүгнэх, эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шинээр батлагдан мөрдөгдөж байгаа Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн уялдаа холбоо, тэдгээрийн хэм хэмжээг харьцуулах замаар судалж найруулга, нэр томьёо, утга агуулгын шинжтэй зарим зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байгааг судалгааны үр дүнд тодорхойлон гаргах, санал боловсруулах юм. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь хоорондоо салшгүй холбоотой, харилцан шүтэлцээтэй хуулиуд бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикт уг хуулиудын уялдаа холбоог онол практикийн төвшинд хослуулан хэрэглэх нь зүйтэй байдаг. Энэ тухай хууль зүйн шинжлэх ухааны доктор Б.Чимэд "Материаллаг хуулийн хэм хэмжээгээр тодорхойлогдсон агуулгыг хэзээ, хаана, ямар арга хэлбэрээр хийж гүйцэтгэхийг гагцхүү процессын хэм хэмжээгээр л журамлаж тохируулах боломжтой" гэж тэмдэглэсэн байна. Тийм учраас эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар дамжин үр дүнтэй хэрэгжиж, Эрүүгийн хуулийн үзэл баримтлал хэлбэрждэг гэж үзэж болох юм.

Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдсан харилцааг нарийвчлан журамлаж зохицуулах процесс хэм хэмжээ дутагдвал энэ нь эрүүгийн процессын эрх зүйн хийдэл болох бөгөөд харин нийгмийн харилцааны бодит нөхцөл байдлыг дутуу үнэлэн тогтоосны хор уршгаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

тухай хуулийн зүйл заалт нь тухайн эрүүгийн эрх зүйн харилцааг зохицуулах боломжгүйд хүргэдэг тул нэг ёсны алдаа болох юм.[4]

Практик туршлагаас харахад дараах нийтлэг дутагдал байна.

- Иргэний нэхэмжлэгч, хариуцагчийг тухай бүрд нь тогтоохгүй орхих;
- Яллагдагч, шүүгдэгч нарын болон иргэний хариуцагчийн хөрөнгийг олж илрүүлэх, шаардлагатай үед цаг алдахгүй битүүмжлэх, нэхэмжлэлийг хангах арга хэмжээ хангалттай авагдахгүй байх болон орхих;
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэр хэмжээг эрх бүхий байгууллага, мэргэжлийн хүмүүсийн үнэлгээнд тулгуурлаж, нарийвчлан тогтоолгүйгээр зөвхөн иргэний нэхэмжлэгч, хохирогч нарын үнэлгээг үндэслэн тогтоох;
- Гэмт хэрэгтэй холбогдон гараагүй материаллаг бус зардлыг хохиролд хамааруулах;
- Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол хүлээсэн этгээд болон иргэний нэхэмжлэгчид, шүүхийн хэлэлцүүлэг хүртэлх мөрдөн шалгах ажиллагааны аль ч үе шатанд иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг тайлбарлаж өгөхгүй орхигдуулах;
- Иргэний нэхэмжлэл гаргаагүй тохиолдолд прокурор өөрийн санаачилгаар хохирол хүлээсэн этгээдийн эрхийг хамгаалах арга хэмжээ авдаггүй зэрэг дутагдал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэвшмэл болсон байна.

Иймд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь иргэний нэхэмжлэлийг хангах үйл явцыг боловсронгуй болгоход чиглэсэн дараах санал, арга замуудыг санал болгон боловсруулж, тэднийг хэрэгжүүлэн туршиж үзэх нь зүйтэй байна гэж үзлээ.

- Манай улсын хувьд иргэний нэхэмжлэл гаргах эрхийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэгт баталгаажуулан зааж өгсөн боловч хэрхэн ямар хэлбэрээр гаргах тухай нарийвчилсан зохицуулалт байдаггүй нь практикт хуулийн хэрэглээг нэг мөр хэрэгжүүлэх хэлбэрийн төөрөгдлийг бий болгож байна. Иргэний нэхэмжлэгчид ихэвчлэн хохирлоо мэдүүлэгт дурдах төдийгөөр илэрхийлж байгаагаас үзвэл хохирогчийн мэдүүлэг нь иргэний нэхэмжлэлийн бодит үндэслэл болж чадах эсэх нь эргэлзээтэй байна. Иймд иргэний нэхэмжлэлд тавигдах шаардлагыг тодорхой болгож, хуульчлан тусгаж өгөх шаардлагатай байна.
- Хохирогч, иргэний нэхэмжлэгчид учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг эргэлзээгүй үнэн бодитой тогтоох, учирсан хохирлын хэмжээг зөв үнэлэх зарчим тусгай шалгуурыг хангаж байхаар арга зүй, технологийг олон улсын төвшинд сайжруулах шаардлагатай байна. Үүнийг нарийвчлан судлан хэлэлцвэл хууль зүйн шинжлэх ухаан, техникийн шалгуурыг хангахын тулд шинжилгээ хийх үйл явц шинжлэн магадлах үйл ажиллагааны зарчимд хамаараах асуудлыг нэлээдгүй хөндөх учир цухас дурдав. Сэдвийн агуулгын хүрээнд хохирол, тэр

[4] Г.Совд,“Эрүүгийн хариуцлага түүний уламжлал, шинэчлэл” хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл, Уб хот, 1992 он, 174 дэх тал.

дундаа эд хөрөнгийн бус хохирлыг үнэлэн тогтоох эрх зүйн зохицуулалт, арга зам төлөвшин бүрдээгүй нь ихээхэн учир дутагдалтайгаас гадна иргэдийн эрх ноцтой зөрчигдөх гол үндэс болж байна. Түүний дотор сэтгэл санааны болон хүний амь хохирсон тохиолдлуудад хэрхэн үнэлэх, зарим тохиолдолд үүссэн нөхцөл байдлыг далимдуулан бодит байдлаас давсан нөхөн төлбөр нэхэмжлэх тохиолдол ч практикт гарсаар байна. Иймд хэргийн шинж, байдлаас хамаарч тогтоож буй үнэлгээ, түүнийг тогтоосон үндэслэлийг шалгах, эсхүл үнэлгээ нарийвчлан тодорхойлж тогтоох ерөнхий аргачлалыг нэвтрүүлж хэрэглэх байдлаар асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна.

- "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль"-ийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт[5] /шинжилгээ заавал хийлгэх/-д "эдийн болон эдийн бус хохирол нэхэмжилсэн этгээдийн эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, сэтгэл зүй, бие махбодод учирсан хохирол /зовуурь, шаналал, өвчин буюу өвдөлт/-ын зэрэг, шинж байдал, үнэлгээг тогтоох" гэсэн агуулгыг нэмж оруулах шаардлага нийгэм цаг үеийн хөгжлийг даган тавигдаж байна.
- Судалгааны явцад гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч, иргэний нэхэмжлэгч өөрт нь хуулиар олгогдсон иргэний нэхэмжлэл гаргах, гаргасан иргэний нэхэмжлэл нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх, иргэний нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авхуулах тухай хүсэлт гаргах эрхээ бүрэн хэрэгжүүлдэггүйгээс гадна, иргэний нэхэмжлэлийг ямар хэлбэрээр гаргахаа мэдэхгүй байгаа нь иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсар хангалтгүй байгаатай холбоотой гэж дүгнэн тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх цогц хөтөлбөр боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.
- Хохирогч болон иргэний нэхэмжлэгчид хуулиар олгогдсон эрх бүрэн хэрэгжихгүй байгаа нь нэг талаас Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой байгааг судалгаанд хамруулсан эрүүгийн хэргүүдийг судлан танилцах явцад, түүнчлэн санал асуулгын аргаар авсан судалгаанд оролцогчдын 75.8 хувь нь Цагдаагийн байгууллагад итгэх итгэл, уг байгууллагын хүнд суртал, өмнө нь хохирогчид хандаж байсан хандлага зэргээс шалтгаалан хохирсон тухайгаа мэдэгдээгүй гэж хариулж байсан нь тэдний ажлын үзүүлэлтийг тодорхойлж байх тул цаашид Цагдаагийн байгууллага гэмт хэргийн хохирогч, иргэний нэхэмжлэгчийн

[5] Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ЭХХШХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт "Шинжилгээ хийлгэх журам"-ыг зохицуулсан байх бөгөөд тэнд

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд эд зүйл, хөрөнгийн үнэлгээ тогтоохоор, эсхүл тусгай мэдлэг зайлшгүй шаардлагатай бол шүүх, прокурор, мөрдөгч шийдвэр гаргаж шинжилгээ хийлгэнэ.

2.Дараахь тохиолдолд заавал шинжилгээ хийлгэнэ:

2.1.гадны нөлөөгөөр, эсхүл сэжигтэй байдлаар хүн нас барсан бол түүний шалтгааныг тогтоох;

2.2.хүний эрүүл мэндэд учирсан хохирлын шинж байдлыг тогтоох;

2.3.гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэрэгт ач холбогдол бүхий байдлыг бодитой тусгаж, зөв мэдүүлэг өгөх чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл түүний сэтгэцийн байдлыг тодорхойлох;

2.4.бүх насаар хорих ял оногдуулж болох гэмт хэргийн яллагдагчийн сэтгэцийн байдлыг тодорхойлох гэж хуульчилсан байна.

эрхийг аль болох хангахад анхаарч ажиллах шаардлагатайг тодорхой илэрхийлж байна[6].

Эрдэмтэн Монгол улсын гавьяат хуульч, цагдаагийн хурандаа С.Рэнцэнхорлоо "Цагдаа ард түмэнд ойр байж, тэдний эрхийг дээдлэн ажиллах явцдаа дэмжлэг авч чадахгүй бол цагдаагийн тоог гурав дахин нэмээд ч нэмэргүй" гэж хэлснийг өмнөтгөл болгож Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, харилцаа хандлагыг сайжруулах хэрэгцээ шаардлага нийгэмд хурцаар тавигдаж буйг тэмдэглэх нь зүйтэй байна.

- Иргэний нэхэмжлэлийг хуулийн дагуу зөв хянан шалгаж шийдвэрлэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх эрхийн баталгаажих үндэс нь иргэний нэхэмжлэлийг хангах ажиллагаа байдаг боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчид уг ажиллагаанд төдийлөн анхаарал хандуулдаггүй, харин гэм бурууг нотлох ажиллагаанд голчлон анхаарч ажилладаг, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар иргэний нэхэмжлэлийг хуульд заасан хэлбэрээр гаргуулж авдаггүй, иргэний нэхэмжлэгч, хариуцагчийг тогтоох ажиллагааг зохих түвшинд хийдэггүй нь тэднийг ЭХХША дахь иргэний нэхэмжлэлийн талаар хангалттай мэдлэггүй, прокурор гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд төдийлөн анхаарахгүй, тавих хяналт сул байгааг илэрхийлж байна. Иймд тэдний иргэний нэхэмжлэлийн талаарх үзэл баримтлал, ойлголт, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэг мөр болгох шаардлагатай байна. Манай орны хууль тогтоомжид иргэний нэхэмжлэлийн шаардлага, хэлбэр, эрх зүйн зохицуулалтын талаар нарийвчлан заасан зүйлгүй, онолын хувьд тогтсон ойлголт үгүй байгаа нь учир дутагдалтай байна.
- Иргэний нэхэмжлэлийн шаардлагыг хангах зорилгоор "хөрөнгө барьцаалах" арга хэмжээ авах тухай асуудлыг илэрхийлсэн утга агуулга бүхий зохицуулалтыг нэмж оруулах, Өөрөөр хэлбэл барьцааны хөрөнгөөр хохирол нөхөн төлүүлэх боломжтой зохицуулалтыг ЭХХШ тухай хуульд нэмж оруулах нь зүйтэй байна.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэний нэхэмжлэгч, хариуцагчийг тогтоох ажиллагаа хууль зүйн шаардлагын төвшинд хийгдэхгүй байгааг практик судалгаанаас дүгнэн үзэж болохоор байна. Жишээ нь: Насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт холбогдох иргэний нэхэмжлэлийн гүйцэтгэх ажиллагаанд иргэний хариуцагчаар хууль ёсны төлөөлөгчийг нь татан оролцуулах, хуулийн этгээдийн удирдлага нь үйл ажиллагааныхаа хүрээнд зохих үүргээ биелүүлээгүйгээс иргэнд хохирол учирсан бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг иргэний хариуцагчаар татах тухай хуулийн заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Ер нь энэ төрлийн эрх зүйн зохицуулалт практикт хэрэгжихгүй, хэлбэрийн төдий илрэн гарч байгаа тул нарийвчлан шалгаж, хэрэг хянан шийдвэрлэх

[6] УЕПГ-н сургалт, судалгааны төв, Судалгааны эмхтгэл I, Уб хот, 2019 он.

ажиллагааны явцад холбогдох албан тушаалтнууд хэрэгжилтийг хангаж ажиллахыг даалгах нь зүйтэй байна.

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг тогтоох буюу үнэлэх ажиллагаа зохих журмын дагуу хийгддэггүй, хамгийн төлөвшсөн гэж үзэх боломжтой эд хөрөнгийн хохирлын хэмжээг тогтоох асуудал, цаашлаад эрүүл мэнд, амь насанд учирсан хохирол, сэтгэл зүй, бие махбод, нэр төр, алдар хүндэд учирсан хохирлын хэмжээг тогтоох буюу үнэлэх аргачлал, журам байдаггүй, эрх зүйн зохицуулалт нь нарийвчлан зохицуулагдаагүй учраас хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх ажиллагаа, үйл явц нь бэрхшээлтэй, шийдвэрлэхэд төвөгтэй тулгамдсан асуудлуудын нэг хэвээр байна. Өнөөдөр хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх аргачлал байхгүй, үнэн магадтай байдал нь эргэлзээ бүхий, зарим зүйлийн үнэлгээ ч тогтоогүй байгаа нь иргэнийхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд төр хайнга хандаж байгаагийн илрэл бөгөөд хүний эрхийн эрх зүйн баталгааг хэлбэрээс агуулгад шилжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Шүүхийн практик судалгаанаас харахад эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр арилгуулахаар гаргасан нэхэмжлэлийн ихэнхийг нь хэрэгсэхгүй болгох, нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг эрс багасгах гэх зэргээр шийдвэрлэж байна. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, хэр хэмжээг нотлох, нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авах ажиллагаа төдийлөн хийгддэггүй нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикаас харагдаж байна. Иргэний хууль, бусад хууль тогтоомжоос харвал зөвхөн эд хөрөнгийн бодит хохирлыг нөхөн төлүүлэх журмыг хуульчилсан байна. Харин сэтгэл зүй, бие эрхтэнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар хууль тогтоомжид тусгаагүй орхигдсон байна. Бусдын амь нас хохирсон хэрэгт оршуулгын явцад гарсан шууд зардлыг л төлүүлдэг төдийгүй зан үйл шашны холбогдолтой зардлыг шүүхээс нөхөн төлүүлэлгүй орхисон тохиолдол ч практикт байна.[7] Энэ нь иргэд өөрийн үзэл бодол итгэл үнэмшилтэй байх, Үндсэн хуулиар олгогдсон шашин шүтэх эс шүтэх эрхийн тухай асуудлыг үл хүндэтгэсэн хэрэг гэж үзэж болохоор байна.[8] Зарим тохиолдолд амь хохирогчийн ар гэрийнхэнд олгох нөхөн төлбөр харилцан адилгүй тогтоогдож байгаа нь хүний амийг амь хохирогчийн нийгмийн гарал, байр суурь, ажил мэргэжлээс хамааруулан ялгавар үнэлж буй шударга бус практик болж байна.

Харин нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, сэтгэл зүй, бие эрхтэнд нь хэдий хэмжээний гэмтэл учирсныг шатлал /зэрэг/-аар шинжилгээ хийх замаар тогтоож, шатлал бүрд учрах хохирлын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд үндэслэсэн тодорхой тарифыг баримтлан хохирлыг тооцох боломжтойг зарим улс орнууд хэрэгжүүлэн хуульчилсан байгаа практик байна.

- Мөн хорих ял эдэлж буй хоригдлуудын хувьд хугацаанаас өмнө тэнсэн суллагдах тохиолдолд хуульд заасан шаардлагын дагуу хохирлыг нөхөн

[7] УЕПГ-ын Сургалт, судалгааны төв, Судалгааны эмхтгэл I, Уб хот, 2019 он, 194 дэх тал.
[8] Мөн тэнд. 189 дэх тал.

төлөхөөс бусад тохиолдолд хохирлыг нөхөн төлдөггүй ба хоригдлыг хөдөлмөр эрхлүүлэх ажлын байргүйгээс хөдөлмөр эрхлүүлэх боломж хязгаарлагдмал байдаг, тэдний хөдөлмөрийн хөлсний үнэлгээ нь нийгэм дэх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага байдаг, хорих ангийн ачаалал буюу хоригдлын тоо хэвийн байх ёстой хэмжээнээс 50% орчим илүү байдгаас хоригдлын хөдөлмөр эрхэлсний хөлсийг хоригдлын, хорих байгууллагын хэрэгцээний төсөвт зарцуулдаг учир хоригдож байх хугацаандаа хохирол нөхөн төлөх боломж бараг байдаггүй зэрэг шалтгаанаар бусдад учруулсан хохирлоо төлдөггүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зүгээс ч хохирол нөхөн төлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авдаггүй байна.[9]

- Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар "хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагаанд бус иргэний нэхэмжлэлийн талаар гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах /иргэний нэхэмжлэлийг хангах/ ажиллагаанд ач холбогдол өгч ажиллах"-ыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт даалгах;
- Хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаанд хэрэглэж буй "Иргэний нэхэмжлэгчээр тогтоох" тухай хэвшсэн бланкийг хуульд заасны дагуу өөрчлөх;
- Иргэний нэхэмжлэлийг хуульд заасан хэлбэр /иргэний нэхэмжлэлийг бичгээр гаргах ИХШХШХ-ийн заалт бий/-ээр гаргуулж хэвшүүлэх, энэ талаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрд анхаарч ажиллахыг зохих байгууллага, албан тушаалтанд даалгах;
- Монгол Улсын Иргэний хуулийн 230 дугаар зүйлд: "Эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй" гэж заасан байдаг боловч энэ хуульд зааснаар: "гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө" гэжээ. Ийм учраас эдийн бус гэм хорыг арилгах нөхөн сэргээх (төрөлх байдлаар), хуульд заасан бол нөхөн төлбөр (мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх) хэлбэрийг тогтоожээ.[10]

Гэм хор учрах буюу түүнээс урьдчилан сэргийлэх, учирсан гэм хороос үүдэн гарах хохирлын хэмжээ нэмэгдэхэд хохирогчийн буюу эрх бүхий этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй) нөлөөлсөн бол гэм хорыг арилгах үүрэг болон түүний хэмжээг тодорхойлохдоо тэдгээрийн гэм бурууг харгалзана[11] гэсэн ба энэ тохиолдолд "хэрэв хохирол учирсан этгээд өөрөө тодорхой хэмжээнд гэм буруутай бол бүрэн хэмжээний хохирлыг шаардах эрхгүй"[12] гэсэн үзэл баримтлалыг удирдлага болгож байгаа нь судалгааны явцад ажиглагдсаар байна.

Монгол Улсын Дээд Шүүхийн "Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай" 2000 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 3 тоот тогтоолд"

[9] УЕПГ-ын сургалт, судалгааны төв, Судалгааны эмхтгэл I, Уб хот, 2019 он, 194 дэх тал.
[10] Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. Ерөнхий анги, Туршилтын хэвлэл, Уб хот, 2005 он 1030 дахь тал.
[11] Иргэний хуулийн 230 дугаар зүйл.
[12] Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. Ерөнхий анги, Туршилтын хэвлэл, Уб хот, 2005 он 1031 дэх тал.

"нэр төр, алдар хүнд, санаа сэтгэлийн" талаар хохирол хүлээсэн этгээдийн хохирлын хэмжээг ихэнхдээ мөнгөн илэрхийллээр тогтоох боломжгүй бөгөөд дээрх үндэслэлээр хохирогчоор тогтоогдсон этгээд эд материалын хохирол хүлээснээ үндэслэл бүхий нотлох баримтаар нотолж хохирлын тухай тооцоогоо мөнгөн илэрхийллээр гаргаж ирсэн тохиолдолд шүүх түүнийг ердийн журмаар хянан шийдвэрлэх үүрэгтэй"[13] гэж тайлбарласан байдаг нь нэг талаас хохирлоо нэхэмжлэх, түүнийг шүүх хянан шийдвэрлэх боломжийг олгосон байна.

Манай нийгмийн амьдралд өөрчлөн байгуулалтыг эрх зүйн талаар хангах, ардчилал, ил тод байдлыг баталгаатай болгох, төрийн хуулийг дээдлэх ёсыг төгөлдөржүүлэх, хууль ёсыг бэхжүүлэхэд эрх зүйн системд шинэчлэл хийхийн тулд юуны өмнө хууль зүйн онолын сэтгэлгээний төвшнийг шинэ цаг үе, нөхцөл байдлын шаардлагад зохицуулан хөгжүүлэх явдал онцгой чухал ач холбогдолтой байна[14] хэмээн оновчтой тодорхойлсныг тэмдэглэх зөв бөгөөд хэлбэрийн төдий зохицуулалтуудыг агуулгад шилжүүлэх хэрэгтэй байна.

Эх сурвалжийн жагсаалт

Хууль:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он;
2. Эрүүгийн хууль 2015 он;
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он;
4. Шүүхийн тухай хууль 2012 он;
5. Иргэний хууль 2002 он;
6. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он;
7. Прокурорын тухай хууль 2017 он;
8. Цагдаагийн албаны тухай хууль 2017 он.

Ном, сурах бичиг:

Монгол хэл дээр

1. Б.Бат-Эрдэнэ "Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй" /ерөнхий анги/ УБ., 2000 он;
2. Б.Бат-Эрдэнэ "Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй" /тусгай анги/ УБ., 1999 он;
3. Х.Сэлэнгэ "Ромын эрх зүй" УБ., 2000 он;
4. Д.Батсайхан "Ромын эрхзүй" УБ., 2000 он;
5. Ц.Бүжинлхам "Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй"/тусгай анги/ шүүхийн ажиллагаа.УБ., 2007 он;
6. УЕПГ-н сургалт, судалгааны төв, Судалгааны эмхэтгэл I, УБ хот, 2019 он.

Гадаадын хэл дээр

1. Головка Л.В."Реформа уголовного процесса во франции" /Государство и право 2001№8/;
2. Гученко К.Ф, Филипинов Б.А. "Уголовный процесс зарубежных государств" М., 2004 г;
3. International Encyclopedia of laws. Criminal provedure law Volnme 4. London8 Boston 1993-2004;

[13] Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол эмхтгэл I, Уб хот, 2001 он, 205 дахь тал.

[14] Г.Совд,"Эрүүгийн хариуцлага түүний уламжлал, шинэчлэл" хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл, Уб хот, 1992 он, 34 дэх тал.

Бусад материал:

1. Д.Зүмбэрэллхам “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах ажиллагааг зарчмын үүднээс савч үзэх нь” Монгол төр, эрх зүй сэтгүүл. УБ., 1996/4 дугаар;
2. “Өмгөөлөгч” сэтгүүл 2012 он №48;
3. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2012 он №1 (38);
4. Прокурорын мэдээлэл сэтгүүл 2012 он №5/30.

ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХОЛБОГДОХ ГЭМТ ХЭРГИЙГ НОТЛОХ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН БА ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛЫН ЗАРИМ ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

SOME THEORETICAL CONCEPTS OF CRIMINAL AND PROCEDURAL LAW AND THE CURRENT STATE OF THE LEGAL ENVIRONMENT TO PROVE CRIMES RELATED TO LEGAL ENTITIES

Я.Цэлмэн
Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч
Tselman.Ya
Senior Lecturer at the Department of Criminal Procedure in
Police School in University of Internal Affairs, police major

Хураангуй: Монгол Улсын Их хурлаас 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг тусгаж өгсөн. Одоогоор эрүүгийн хуулийн 30 гаран зүйл, заалтаар хуулийн этгээдийн холбогдсон гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан. Мөн 2017 оны эрх зүйн зохицуулалт, практик аргачлал дутагдалтай байгааг судалгаанд үндэслэн танин мэдэхийг зорьсон. Дэлхий нийтээр хувь хүнд эрүүгийн хариуцлага оногдуулдаг хандлага өөрчлөгдөж байна. Хуулийн этгээдийн зүгээс үйлдэж болох гэмт хэргүүд нь Монгол Улсын хувьд томоохон хохирол учруулж байсан гашуун туршлагуудад тулгуурлан учруулж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан сэргийлэх, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зайлшгүй шаардлага нэгэнт бий болсон гэдгийг судлаачид судалгаа, үндэслэлтэйгээр гарган ирж байна.

Хуулийн этгээдэд холбогдох гэмт хэргийн криминалистик шинжийг товч тодорхойлох шаардлагатай. Энэ нь гэмт хэрэг мөрдөхөд арга зүйн хувьд зөвлөмж өгөх бололцоог бүрдүүлдэг. Хуулийн этгээдэд холбогдох бүх гэмт хэргийн криминалистик шинжийг тодорхойлох зорилт тавиагүй тул ерөнхий агуулгаар нь авч үзэв.

Abstract: The Parliament of Mongolia approved a revised version of the Criminal Code on May 11, 2017, which provides for criminal liability for legal entities. Currently, more than 30 articles and provisions of the Criminal Code provide for criminal liability for crimes committed by legal entities. It also seeks to identify shortcomings in the 2017 legal framework and practice based on research. There is a changing trend around the world to criminalize individuals. Researchers have proven that there is an urgent need to prevent, deter, and compensate for the risks that can be committed by legal entities, based on the bitter experiences that have caused significant damage to Mongolia.

The forensic nature of the crime against the legal entity needs to be briefly defined. This provides an opportunity to provide methodological advice on criminal investigation. It does not aim to determine the criminological nature of all crimes involving legal entities, so it is considered in its general context.

Түлхүүр үгс: Хуулийн этгээд, эрүүгийн хариуцлага, эрх зүйн шинэтгэл
Keywords: Legal entity, criminal liability, legal reform.

Хуулийн этгээдийн буюу корпорац /компани/-ийн эрүүгийн эрх зүй болон эрүүгийн процессын эрх зүйн ойлголт

Хуулийн этгээдийн тухай ойлголт дэлхий даяар тархан нэвтрээд цөөнгүй жилийг үдсэн боловч түүнээс нийтэд болон иргэдэд учруулж болох гэм хорын талаар харьцангуй сүүлд буюу арван наймдугаар зууны хагасаас англо-саксоны эрх зүйн бүлийн улс орнууд тухайлан анхаарч эхэлсэн байдаг.

Орчин үеийн хууль эрх зүйн тогтолцоонд цогц заалтууд нь корпорацуудын бүтцийг зохицуулж, удирдах байгууллагуудын шинж чанар, үүрэг, зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны горим, корпорацын үйл ажиллагаанд оролцдог хүмүүсийн эрх мэдэл, үүргийг тодорхойлдог. Корпорацын хэмжээ, шинж чанараас хамааран түүний бүтэц нь төвөгтэй, олон давхаргат, төвлөрсөн бус, төвлөрсөн бус, зарим талаар шаталсан байдлаар зохион байгуулалттай байж болно. Байгууллагын янз бүрийн загварууд, тушаал эсвэл удирдлагын өөр гинж байж болно. Корпорацын бүтцийн нарийн төвөгтэй байдал нь корпорацын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг хүмүүсийн хууль бус үйлдлийн үр дагаврыг хариуцах хуваарилалтад хүнд асуудал үүсгэдэг. Энэ нь корпорац болон түүний хувьцаа эзэмшигчид эрүүгийн процессын ажиллагаанаас материаллаг ашиг хүртэх тохиолдолд ялангуяа үнэн юм. Эрүүгийн хуулийн хүрээнд орчин үеийн бүх тогтолцоо нь корпорацын ашиг сонирхлын үүднээс гэмт хэрэг үйлдсэн хүмүүст эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой гэсэн үндсэн ойлголтыг нэгтгэдэг. Корпорац нь хуулийн этгээдийн хувьд корпорацын цаашдын зорилгын дагуу үйлдсэн гэмт хэргийн улмаас хууль ёсны дагуу ямар хэмжээнд, ямар байдлаар хариуцлага хүлээх ёстой вэ?

АНУ-д 1909, Австрали улсад 1921 оноос, Англи улсад 1975 оноос тус анхлан хуулийн этгээдэд холбогдох гэмт хэрэг буюу компани, корпарацийн гэмт хэргийг үндсэн хуулийн болон шүүхийн прецедентээр эрүүгийн хариуцлага хүлээлгэж эхэлжээ. Анхны хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээсэн жишээ нь: төмөр зам барихаар гэрээлсэн компанид зориуд санаатай гэрээний гүйцэтгэл хийгээгүй үндэслэлээр өндөр торгууль оногдуулсан явдал байдаг.

Хуулийн этгээд гэдэг бол хөрөнгө төвлөрүүлэх, аж үйлдвэрийг хөгжүүлэх явцад бий болсон ойлголт юм. Монгол Улсын Иргэний Хуульд зааснаар өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хэлнэ гэсэн байдаг. Иргэний хуулийн[1] 25 дугаар зүйлийн 25.1-д хуулийн этгээдийн үндсэн шинжийг тодорхойлжээ.

1. Өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй.
2. Өөрийн үйл ажиллагаагаараа эрх олж, үүрэг хүлээх чадвартай.

[1] Иргэний хууль. УБ., Төрийн мэдээлэл 2016. №07

3. Үйл ажиллагаанаасаа үүсэх үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг.

Эрүүгийн эрх зүйн уламжлалт хандлагад эрүүгийн хариуцлагыг бие махбод, зүрх сэтгэл, сүнслэг биетэй буюу хүнд л хүлээлгэнэ гэх ойлголт давамгайлж байлаа. Нэг үгээр эрүүгийн хариуцлага хүлээх субъект нь хүн байх тухай сургаал, үзэл номлол их эдүгээ хүртэл хүчтэй байна. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулахын тулд уламжлалт хандлагаас өөр өнцгөөр асуудалд хандаж үзэх хэрэгтэй болно. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийг нотлох ажиллагаа нь онолын болон практик үндэслэлтэй байх шаардлагатай.

Эрүүгийн болон процессын эрх зүйн уламжлалт хандлага бүхий эрдэмтэн, судлаачид "субъектийн онол"-ын үүднээс хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлгүй гэж тайлбарладаг. Төр бол "нийгмийн гишүүд"-ийн эсрэг үйлдсэн гэмт хэрэгт үндэслэн түүхэн хөгжлийн явцад бүрэлдэж ирсэн "шийтгэл" гэдэг эрх зүйн үр дагаврыг оноож "яллах, буруутгах" замаар тухайн нийгэм дэх хэв журам, ашиг сонирхлыг сахин хамгаалах тогтолцоо /нийгмийн гишүүдийн хамтын амьдралыг хамгаалах суурь тогтолцоо/ юм гэдэг тал дээр нэгдмэл байна гэж үзье. Энэ нь хуулинд заагаагүй бол хэнд ч гэмт хэрэг үйлдсэнд тооцож хариуцлага хүлээлгэхгүй /идэвхгүй/ байх зарчим, хариуцлагын зарчим агуулагдах, агуулагдаж ирэх гэдэгтэй адил байгаа боловч энэ тохиолдолд "эрүүгийн хариуцлага" нь (жишээлбэл, нийгмийн эсрэг чиглэсэн аюултай шинж чанарыг агуулаагүй) бодлоготой хүсэл зоригийн илэрхийлэлд үндэслэсэн үйлдэл (physical defendece)-ийн объектив шинж, үр дүнтэй холбоотой зүйл, зөвхөн "бодгаль этгээд"-д холбоотой гэж үзэх хандлага байдаг[2].

Гэвч энэ нь өрөөсгөл ойлголт юм. Учир нь хуулийн этгээд нь хиймэл оюун ухаанаар өөрийгөө удирддаг болоогүй байгаа өнөө цагт түүний бүх зохион байгуулалтыг өнөөх сүнслэг бие болох хүн хэмээх эрх зүйн этгээд хийж байгаа гэдгийг дурдах нь зүйтэй. Тиймээс хуулийн этгээдийг амьгүй зүйл мэтээр тайлбарлах нь уламжлалт гэхээсээ илүү хоцрогдсон үзэл хандлага мөн.

Орчин үеийн систем дэх том үзэл суртлын хуваагдал нь эрүүгийн хууль нь корпорацад өөрөө хамаатай эсэхтэй холбоотой юм. Зарим тогтолцоонд эрүүгийн хууль нь хувь хүмүүсийн болон аж ахуйн нэгжийн аль алиных нь гэмт хэргийг хянадаг. Бусад системүүд нь зөвхөн хувь хүмүүсийн эрүүгийн үйлдлийг шийтгэх байдлаар эрүүгийн хуулийг хязгаарладаг. Аж ахуйн нэгжийн хариуцлагыг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд түүнийг ногдуулж болох нөхцөл байдлыг тодорхойлох журамд өөр өөр байдаг. Хил дамнасан олон улсын корпорацууд ба бизнесийн зохицуулалтын ертөнцөд бид корпорацуудыг зохицуулсан хууль нэгдэхийг хүлээж магадгүй юм. Гэхдээ хөгжингүй улс орнуудын дунд корпорацын гэмт хэрэгтэй тэмцэх механизмын хувьд маш том цоорхой байсаар байна. Корпорацын эрүүгийн хариуцлагыг няцаах орчин үеийн системүүд нь зарим корпорацууд хувь хүнээс илүү их хохирол учруулж болзошгүй гэсэн ойлголтыг үгүйсгэдэг. Эдгээр системүүд нь эдгээр байгууллагууд криминогеник байгууллага болохыг хүлээн

[2] Ито Кэсүкэ. (Япон Улсын Кэйогийн Их сургуулийн Мэргэжлийн хуульч бэлтгэх сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн багш) "Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх онолын үндэслэгээ ба практик шаардлага". Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2017, 10-11 дэх тал.

зөвшөөрдөггүй. Иймээс эдгээр зохион байгуулалттай гэмт хэрэгтнүүдийг эрүүгийн хуулиар шийдвэрлэх шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрөхгүй байна. Корпорацын эрүүгийн хариуцлагаас татгалзах системүүд нь бодлогын дүн шинжилгээгээр биш харин албан ёсны сургаалын онолоор үндэслэгддэг. Уран зөгнөлийн онол ба хожмын хүн төрөлхтний зарчим нь dogma societas delinquere non potest non-potest-ийн хүчин төгөлдөр үргэлжлэх хүчин зүйлийн талаарх ижил төстэй онолын дүгнэлтэд хүрдэг[3].

Эдгээр онол нь хүн төрөлхтөн дангаараа эрүүгийн хуулийн анхаарлын төвд байгааг нотолж байна; зөвхөн хувь хүн өөрийгөө тодорхойлох чадвар, ёс суртахууны сонголт хийх чадвартай байдаг бөгөөд эрүүгийн хариуцлагын мөн чанар нь тухайн хүнд өвөрмөц өвөрмөц физиологийн хүчин зүйлүүдийн нийлбэрээс хамаардаг. Энэ өнцгөөс харахад корпорацууд шоронд хоригдож, эрүүгийн шийтгэлийн үр дагаварт хүргэхгүй тул амьд этгээдийг хувийн зан үйлийнх нь төлөө хариуцлага тооцохыг шаарддаг. Энэ утгаараа шийтгэл, нөхөн сэргээх нь утгагүй зорилт юм. Түүгээр ч барахгүй байгууллагуудад үзүүлж буй эрүүгийн шийтгэл нь гэм буруугүй гуравдагч этгээдүүд, тухайлбал, буруутай хувьцаа эзэмшигчдэд асар их нөлөө үзүүлдэг гэж үздэг[4].

Хуулийн этгээд нь хууль эрх зүйн хувьд эрх эдэлж үүрэг хүлээж, эрх зүйн үр дагаврыг бий болгодог болгодог субьект /legal fiction/ гэж үзэж болно. 1980-аад оноос эрүүгийн эрх зүйн онолын салбарт хуулийн этгээдийн оршин буй тухай болон түүний үйлдэл, үйл ажиллагаа нь нийгэмд ашуултай байгаа талаар хүлээн зөвшөөрч эхэлсэн байдаг. Хуулийн этгээд нь хэдийгээр улс орны эдийн засагт чухал нөлөөтэй боловч үүний хажуугаар тэдний холбогдсон мөнгө угаах[5] төрлийн хэргүүд нь нийгэмд учруулах хохирлоороо үлэмж байсан. Ялангуяа Америкийн Нэгдсэн Улс /АНУ/, Англи зэрэг улсууд хуулийн этгээдэд илүү анхаарлаа хандуулсан. Эдгээр улсуудад хуулийн этгээдийн фикцийн онол[6] ихээхэн дэлгэрсэн байсан ч хуулийн этгээд бодитоор оршин тогтнож байгааг хүлээн зөвшөөрсөн юм. Өөрийн бодгаль бие, оюун санаа, сүнслэг байдалгүй хийсвэр зүйлд гэм бурууг халдаах ёсгүй гэсэн эрүүгийн эрх зүйн уламжлалт ойлголтыг АНУ-ын Холбооны шүүх анх удаа өөрчилсөн. Гэм хор учруулснаас үүсэх үүрэг буюу ажил олгогч, ажилтны харилцаанд тулгуурлаж хуулийн этгээд өөрийн ажилтын үйлдсэн гэмт үйлдлийн төлөө хариуцлага хүлээх иргэний эрх зүйн зарчмыг эрүүгийн эрх зүйд татан авч тайлбарласанаар дам хариуцлага хүлээх /imputation doctrine[7]/ эрх зүйн зохицуулалтыг бий болгосон байна.

Дээрх зохицуулалтаас үүдээд АНУ-ын загвар буюу хуулийн этгээд өөрийн бүх ажилтнуудаас үйлдсэн гэмт хэргийн төлөө эрүүгийн эрх зүйн хариуцлага хүлээдэг тогтолцоо бий болсон. Харин энэхүү загварыг Англичууд хуулийн этгээд

[3] Энэ бол корпорац нь эрүүгийн хариуцлага хүлээх чадваргүй гэсэн өргөн тархсан зарчим юм.
[4] Models of corporate criminal liability in comparative law. Washington university global studies law review vol.4
[5] 1989 онд дэлхийн их наймын уулзалтаар улс орон бүрийн Засгийн газрууд нэгдсэн, тодорхой бодлогыг хэрэгжүүлэх тухай FATF /Financial Action Task Force/-ийг байгуулсан.
[6] Хуулийн этгээдийн фикцийн онолын төлөөлөгч Германы хуульч К.Ф.Савиний юм. Тэрээр 19-р зуунд үүссэн эрх зүйн дэг сургуулийн удирдагч. Хуулийн этгээдийн эрх зүйн харилцааны бодит субъект бол эрх бүхий хувь хүн юм гэж үздэг нь фикцийн онолын гол үзэл санаа байдаг.
[7] V.S.Khanna, Corporate Criminal Liability: What Purphose does it Serve, Har.L.Rev. 109 (1996), page 1488

зөвхөн өөрсдийн удирдах албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас эрүүгийн хариуцлага хүлээх[8] болгон авч хэрэгжүүлсэн байна.

Монгол Улсын хувьд шинэчилэн найруулсан эрүүгийн хууль[9]

9.1 дүгээр зүйл. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл

1.Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийн шинжийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргаж, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан нь хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл болно.

2.Хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, зөвшөөрөл өгч энэ хуульд заасан гэмт хэргийг бусдаар үйлдүүлсэн, эсхүл хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй үйлдэл, эс үйлдэхүйгээр энэ хуульд заасан гэмт хэргийг үйлдсэн бол энэ хуульд заасан ял оногдуулна.

Дээрхи хуулийн заалтыг "Identificatian" буюу эрүүгийн хуулинд заасан тухайн гэмт хэрэгт хүнд хүлээлгэх хариуцлагыг адилтган хуулийн этгээдийн удирдлагад ял оногдуулах, "Vicarious liability" буюу төлөөлүүлэн хариуцлага хүлээлгэх гэсэн онолын үүднээс бичигдсэн гэж дүгнэж болно.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэмт хэргүүдээс Эдийн засгийн гэмт хэрэг, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг түгээмэл үйлдэгдэж байна.Эдийн засгийн гэмт хэрэг нь нууц далд аргаар үйлдэгдэх бөгөөд хуулийн этгээдийн хувьд гэмт үйлдлээ нуун далдлах, мөрдөгчийн эсрэг үйлдэл гаргах, гэмт хэрэг үйлдэгдэхэд бололцоо олгосон нөхцөл байдлыг ашиглах нийтлэг хэв шинжтэй байна. Энэ төрлийн гэмт хэргийн талаарх мэдээлэл нууцлаг, мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнд илрэх нийт зүй тогтолтой байдаг. Иймээс мөрдөн шалгах ажиллагаанд хамтын ажиллагаа зайлшгүй чухалд тооцогдоно.

Хуулийн этгээдийн криминалистик шинж

Терроризмын аюул манай улсад заналхийлж байгаа нөхцөлд бид энэ төрлийн гэмт хэргийн криминалистик шинжийг авч үзэх шаардлагатайг нөхцөлдүүлж байна. Нэгэнт террор үйлдэх, террор үйлдэхэд бэлтгэх, террор үйлдэхийг санхүүжүүлэх гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөлд мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, бусад байгууллагатай хамтран ажиллах арга зүйг боловсруулах нь онол, практикийн ач холбогдолтой. Практик ач холбогдол нь энэ төрлийн гэмт хэргийн газарт нягт нямбай ажиллах, албаны шуурхай байдлыг хангаж, алба хаагч өөрийн болон бусдын амь нас эрүүл мэндэд хохирол учруулахгүй байх, мөн урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг авах талаар шуурхай ажиллах боломж бүрдэнэ гэж үзэж байна. Нөгөөтэйгүүр албадын хамтын ажиллагааг зохион байгуулалтад оруулах, хамтран ажиллахад ямар нэгэн шийдвэрлээгүй асуудалгүй байх нь энэ төрлийн гэмт хэргийг мөрдөхөд онцгой ач холбогдолтой. Судалгаа шинжилгээний хувьд эргэлтэд орсноор бид энэ төрлийн гэмт хэргийг зөв таних, бусад гэмт хэргээс

[8] Celia Wells, Corporations and Criminal Responsibility, page 85(Oxford University press 2nd ed. 2005)
[9] Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл 2016 он. №7

ялган зүйлчлэх, сураллцагчдад онолын мэдлэг олгох, цаашлаад урьдчилан сэргийлэх талаар бүтээл гарах боломж нээлттэй болно.

Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг өсөх хандлагатай байгааг бид анхаарах шаардлагатай. Энэ төрлийн гэмт хэргээс олох хууль бус орлого жил ирэх тусам нэмэгдэж байна. Тийм ч учраас бид энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд криминалистик шинжийг нь авч үзэх зайлшгүй шаардлагатай болно.

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэмт хэргүүдийн дотор Эрүүгийн хуулийн тусгай ангийн "Эдийн засгийн гэмт хэрэг" 26%, "Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг" 24%, "Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг" 21%-ийг эзэлж байна. Олон улсын туршлагаас дээр дурдсан дийлэнх хувийг эзэлж буй гэмт хэргүүд нь хуулийн этгээдэд холбогддог нь ажиглагдаж байна. Мөн соёлын өвийн эсрэг гэмт хэрэг 10%, Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг 8% байгаа нь төрөөс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээ тодорхойлж байгаа хэлбэр гэж үзэж байна.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд холбогдох гэмт хэргүүдээс зөвхөн "*Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хамгаалахад хайнга хандах*" гэсэн хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байгаа юм. Тэгвэл хуулийн этгээдэд холбогдох гэмт хэрэг нь санаатай үйлдэгддэг гэдэг нь анхаарал татаж байна. Ийм нөхцөлд хуулийн этгээдэд холбогдох гэмт хэргийн криминалистик шинжид субъектив шинжээс авч үзэх асуудал нь гэм буруугийн санаатай хэлбэр болохыг тэмдэглэх нь зүйтэй. Энэ нь мөрдөн шалгах ажиллагааны явцад зайлшгүй нотлох нөхцөл бүрдүүлэх бөгөөд анхаарах асуудал болно.

Хуулийн этгээдэд холбогдох гэмт хэрэг нь холбогдсон этгээдийн хувийн байдлыг авч үзэхээс шалтгаална. Тухайлбал: хуулийн этгээдийн нэрийн өмнөөс болон хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал нь бидний таамаглаж байгаагаар *"цагаан захтан"* байх нөхцөл бүрэн дүүрэн байна. Энэ нь уг хуулийн этгээдэд холбогдох гэмт хэргийн онцлог болно. Энэ онцлогоосоо хамаарч мөрдөн шалгах ажиллагааны эсрэг үйлдэл хийх, холбогдож байгаа этгээдийн хувьд нотлох баримт өөрчлөх, гэмтээх, устгах зэрэг хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах зорилго бүхий санаатай үйлдэл гаргах талтайг илтгэн харуулна.

Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 9.1.2-т зааснаар "Хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, зөвшөөрөл өгч энэ хуульд заасан гэмт хэргийг бусдаар үйлдүүлсэн, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө өөрийн үйлдэл, эс үйлдэхүйгээр энэ хуульд заасан гэмт хэргийг үйлдсэн бол энэ хуульд заасан ял оногдуулна[10]" гэж заасан нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн талаарх тодорхой дүгнэлт хийх боломжоор олгож байна. Өөрөөр хэлбэл хуулийн этгээд гэмт хэрэг үйлдэхдээ эрх бүхий албан тушаалтан эсхүл тухайн хуулийн этгээдийн ашиг сонирхолын төлөө өөрийн үйлдэл, эс үйлдлээрээ гэмт хэрэг үйлдсэн хүн байна.

[10] Эрүүгийн хууль. /шинэчилсэн найруулга/. УБ., Төрийн мэдээлэл 2016. №07

Бидний үзэж байгаагаар хуулийн этгээдэд тодорхой шинжүүд байдаг талаар энд авч үзэж байна. Иргэний хуулийн 4 дүгээр бүлэгт "Хуулийн этгээд[11]"-ийн талаар заасан байна. Хуулийн этгээд нь зохион байгуулалтын нэгдэл гэж үзвэл түүний гэмт үйлдэл нь нуугдмал буюу зохион байгуулалттай байх нөхцөл байдал илэрч байна.

Зохион байгуулалттай гэмт бүлэглэл, гэм бүлэг, гэмт байгууллага буюу мафижсан хуулийн этгээд мөн эсэхийн мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоох нь хүндрэлтэй болох, зардал, хүч зарцуулах, хамтын ажиллагааг гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага эрчимтэй хөгжүүлэх шаардлагатайг илэрхийлнэ.

Хуулийн этгээдэд холбогдох гэмт хэргүүд нь шинжээрээ өөр хоорондоо ялгаатай боловч дараах нийтлэг криминалистик шинжтэй байна.

Анхны мэдээллийн шинж нь нуугдмал, илрүүлэхэд хүндрэлтэй байдаг нь онцлог болно. Бид гэмт хэргийн шинжийг тогтооход анхны мэдээлэл ач холбогдолтойг энд нарийвчлан авч үзэхгүй. Гэхдээ анхны мэдээлэл хууль сахиулах байгууллагад ирснээр түүнийг тогтоох талаар тодорхой ажиллагаа явуулах үндэслэл болдог. Гэтэл мэдээлэл нууцлагдмал байдаг нь шалгах ажиллагаа явагдахгүй байх нөхцөл байдал үүсэх боломж зарим талаар үүсэн бий болно гэж үзэх үндэслэлтэй байна.

Байж болох сэжигтэн, яллагдагчийн хувийн байдлын талаар бид товч авч үзсэн. Дийлэнх тохиолдолд "цагаан захтан"-аас үйлдэх боломжтой. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн гэмт хэргийн шинжид хамаарах уг нөхцөл байдал нь мөрдөн шалгах ажиллагаанд хүндрэл үүсгэх боломжийг үүсгэнэ. Учир нь хуулийн этгээдийн зүгээс эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх талаар эсрэг үйлдэл гаргах, мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулах зорилгоор нотлох баримт устгах үйлдэл идэвхтэй гаргах магадлалтай.

Гэмт хэрэг үйлдэхэд бололцоо олгосон нөхцөл байдал. Энэ шинжид хуулийн этгээдийн нэрийн өмнөөс болон хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө эрүүгийн хуулийн тусгай ангид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэрэг үйлдсэн этгээд байх нь тодорхой. Уг этгээд нь гэмт хэрэг үйлдэхдээ өөрт байгаа боломжит нөхцөл байдлыг ашиглах эсхүл тийм боломжит нөхцөл байдлыг өөрөө бүрдүүлсэн байдаг онцлогтой. Хууль тогтоомжийн боловсронгуй бус байдлыг хуулийн этгээд ямагт ашиглах бөгөөд энэ нь боломж олгож буй хэрэг гэж үзэж байна.

[11] Иргэний хууль. 25 дугаар зүйл. Хуулийн этгээд

25.1.Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагааанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.

25.2.Хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно.

25.3.Хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчийн байна.

25.4.Хуульд өөрөөр заагаагүй бол хэд хэдэн хуулийн этгээд нь үйл ажиллагаагаа зохицуулах зорилгоор нэгдэж болох бөгөөд нэгдлийн оролцогчид хуулийн этгээдийн эрхээ хадгална.

25.5.Хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

Санал, дүгнэлт

Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлагын механизмыг судлахдаа чухал ялгаа нь эрүүгийн хариуцлагын хяналтад хамрагдах байгууллагуудыг тодорхойлох явдал юм.

Харьцуулсан туршлагаас харахад гурван боломжит загвар эсвэл шийдлийг санал болгож байна.

Нэг арга нь "байгууллага" гэсэн нэр томьёог аливаа тодорхойлолт, хязгаарлалтгүйгээр ашиглах явдал юм.

Хоёр дахь арга нь эрүүгийн хариуцлага хүлээлгэж болох бүх төрлийн байгууллагуудын жагсаалтыг гаргах явдал юм.

Гурав дахь арга нь иргэний хууль тогтоомжид хамаарах хуулийн этгээд гэж үздэг байгууллагуудад зөвхөн хариуцлагыг хязгаарлах явдал юм.

Дээрх шинжээс хамааран хууль сахиулах байгууллагын зүгээс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, нотлоход шаардлагатай арга зүйг боловсруулах нь зүйтэй. Энэ нь мөрдөн шалгах ажиллагаанд ахиц гаргах, хамтын ажиллагааг сайжруулах өргөн боломж гэж бид үзэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл 1992. №01;
2. Эрүүгийн хууль. /шинэчилсэн найруулга/ УБ., Төрийн мэдээлэл 2016. №07;
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. /шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл 2016. №23;
4. Иргэний хууль. Төрийн мэдээлэл 2016. №07;
5. Хууль зүй, дотоод хэргийн яам. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Сургагч багш нарт зориулсан гарын авлага. УБ., 2017 он;
6. Хууль зүй, дотоод хэргийн яам. Монгол Улсын Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/, Сургагч багш нарт зориулсан гарын авлага. УБ., 2017 он;
7. Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.УБ., 2017 он;
8. Models of corporate criminal liability in comparative law. Washington university global studies law review vol.4;
9. V.S.Khanna, Corporate Criminal Liability: What Purphose does it Serve, Har.L.Rev. 109 (1996);
10. Celia Wells, Corporations and Criminal Responsibility, page 85(Oxford University press 2nd ed. 2005).

Цахим эх сурвалж:

1. http://www.trends.mn
2. http://www.legalinfo.mn
3. http://vip76.mn
4. http://mojha.gov.mn
5. https://simple.wikipedia.org/wiki/Legal_entity
6. http://thelawdictionary.org/legal-entity/

ОЛОН УЛСЫН ШИНЖТЭЙ ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ, АНГИЛАЛЫН АСУУДАЛ

PROBLEM CLASSIFICATION AND DESCRIPTION ON INTERNATIONAL CRIME

Г.Билгүүн
Дотоод хэргийн их сургуулийн докторант
Bilguun G.
Ph.D Student, University of Internal Affairs

Хураангуй: Эрдэм шинжилгээний өгүүлэлд олон улсын шинжтэй гэмт хэрэг, үндэстэн дамнасан гэмт хэргийн нэр томьёо болон ойлголтын талаар судлаачдын байр суурь, тодорхойлолтод дүн шинжилгээ хийж, онцлог шинжийг тодорхойлохыг зорьсон болно.

Abstract: This research article is to analyze and define the characteristics of researchers' positions and definitions of international crime and transnational crime terms and concepts.

Түлхүүр үгс: Олон улсын шинжтэй гэмт хэрэг, үндэстэн дамнасан гэмт хэрэг, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг.

Keywords: International crime, transnational crime, transnational organized crime.

Удиртгал

Олон улсын эрх зүй, эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд "олон улсын шинжтэй гэмт хэрэг" гэсэн ойлголт, ангилал, тодорхойлолтыг урьд өмнө нь ул суурьтай боловсруулж ирсэн уламжлалтай төдийгүй олон улсын гэмт хэргийн шинжийг гэмт хэрэг илрүүлэх шинжлэх ухааны тодорхойлолт боловсруулах, тайлбарлахдаа харгалзан үзсээр иржээ.

Өнөө үед гэмт хэргийг үр дүнтэй мөрдөн шалгах асуудалд хандах улс хоорондын үйл ажиллагаа эрчимтэй өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор олон улсын эрх зүй болон эрүүгийн эрх зүйд нийтлэг гэмт хэргүүдийг тусгайлан авч үздэг болсон байна. Учир нь зарим гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүн таслах үйл ажиллагааг бусад улсын харилцан туслалцаагүй явуулах боломж хомс байдаг. "Сэжигтэн гэмт хэрэг үйлдээд хилийн чанадад гарч, тэндээ нуугдах тохиолдол"[1], өөрөөр хэлбэл хилийн чанадад зугтан гарах үр дагавартай аливаа гэмт хэрэг[2] нь нийтлэг гэмт хэргийн жишээ гэж үзэж болох юм.

Тухайлбал, өөрийн улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэдийн эсрэг үйлдсэн гэмт хэргүүд[3], эсхүл гадаадын иргэд тухайн орны нутаг дэвсгэрт үйлдсэн гэмт

[1] Международное право. / Под ред. Л.Н.Шестакова. – М.: Юридическая литература, 2005. – С. 284.
[2] Манина Е.Л. Особенности местного, федерального/межгосударственного и международного розыска преступников; Королькова О.А. Правовые и организационные проблемы межгосударственного розыска лиц, скрывшихся от следствия и суда: Автореф. дис. ... канд. юрид. наук. – М., 2002.
[3] Бастрыкин А.И. Проблемы расследования уголовных дел с участием иностранных граждан: Автореф. дис. ... канд. юрид. наук. – Л., 1980; Щадрин О.Ю. Методика расследования преступлений,

хэргүүд[4] гэж тусгайлан ангилж үзсэн байна. Ийм ангилалд хамаарах гэмт хэргийг мөрдөн шалгахад гадаадын бусад орны гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий тусгайлсан байгууллагуудаас сэжигтний хэн болохыг нь тогтоох, криминалистикийн бүртгэлээр шалгах, хувь хүний тодорхойлолт болон лавлагаа-бүртгэлийн бусад мэдээлэл гаргуулж авах, олон улсад эрэн сурвалжлах зэрэг шаардлага гарч болно. Цогцос болон амьд бие, төрх таниулах, эд хөрөнгийг дүрсээр нь (гэрэл зураг, дүрс бичлэг), эсвэл биечлэн таниулах шаардлага цөөнгүй гардаг. Дээрх нөхцөл байдлыг тодруулахын тулд олон улсын гэмт хэрэгтэй тэмцэх суваг ашиглах шаардлага үүсдэг.

Дэлхийн улс орнуудад олон улсын шинжтэй гэмт хэрэг хэмээн уламжлагдан, тодорхойлогдож ирсэн гэмт хэргүүдэд далайн дээрэм, боолчлол, боолын наймаа, хүний наймаа, терроризм, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисуудын хууль бус үйлдвэрлэл, худалдаа, хуурамч мөнгөний үйлдвэрлэл, зохион байгуулалттай гэмт хэрэг[5] зэргийг хамруулан авч үзсээр байна.

ОХУ-ын профессор И.И.Карпец олон улсын шинжтэй гэмт хэргүүдийн тоонд "...онгоц хулгайлах, хүн барьцаалах, олон улсын хамгаалалтад байдаг этгээдүүдийн эсрэг гэмт хэрэг үйлдэх, байгаль орчныг бохирдуулах, улс түмний үндэсний соёлын үнэт зүйлсэд халдах, садар самууныг сурталчилсан зүйлсийг түгээх, далайн хөлөг онгоцууд мөргөлдөх, далай, тэнгист тусламж үзүүлэхгүй байх, тивүүдийн эрэг орчмын далайн гүехэн устай бүсэд гэмт хэрэг үйлдэх..."[6] зэрэг гэмт үйлдлийг шинээр авч үзсэн байдаг.

Түүнчлэн, Европын Холбооноос олон улсын хамтын нийгэмлэгийн эрх ашгийг шууд хөнддөг бөгөөд олон улсын шинжтэй гэмт хэргүүдэд хамааруулж болох гэмт хэргийн 32 бүрэлдэхүүнийг тусгайлан ангилсан байдаг.

"Европын баривчлах зөвшөөрөл болон гишүүн улсуудын хооронд гэмт этгээдүүдийг шилжүүлэн өгөх журмын тухай" 2002 оны зургадугаар сарын 13-ны өдрийн ерөнхий шийдвэрийн II зүйлд зааснаар олон улсын гэмт хэргүүдийн бүлэгт дараах төрлийн гэмт хэргүүдийг хамааруулан авч үзжээ.

Үүнд: зохион байгуулалттай гэмт бүлэгт оролцох, терроризм, хүн худалдаалах, хүүхдийн бэлгийн мөлжлөг, хүүхдийн садар самууныг сурталчилсан зүйлс, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлт, зэвсэг, галт хэрэгсэл, тэсрэх бодисын хууль бус худалдаа, авилга, санхүүгийн луйвар, гэмт хэргийн замаар олсон орлогыг угаах, хуурамч мөнгө, мөнгөн тэмдэгт үйлдвэрлэх, компьютерийн гэмт хэрэг, экологийн гэмт хэрэг, хууль бус цагаачлал, аллага ба эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулах, хүний эрхтэн болон эд эсийн хууль бус худалдаа, хүн хулгайлах, эрх чөлөөг нь хууль бусаар хасах, хүн барьцаалах, арьс өнгөөр ялгаварлах ба гадаадын зүйлсийг үл тэвчих үзэл гаргах,

совершаемых иностранными гражданами и в отношении граждан иностранных государств (по материалам Дальневосточного региона): Автореф. дис. ... канд. юрид. наук. – М., 1998.

[4] Смирнов О.Н. Особенности расследования преступлений, совершенных этническими группами: Автореф. дис. ... канд. юрид. наук. – Волгоград 2004 .; Кромарев А.Г. Особенности допроса граждан иностранных государств. М., 1976.

[5] Международное право. / Под ред. Л.Н.Шестакова. – М.: Юридическая литература, 2005. – С. 284.

[6] Международное уголовное право // И.П. Блищенко, Р.А. Каламкарян, И.И. Карпец и др. – М.: Наука, 1995; Карпец И.И. Преступления международного характера. М., 1979.

зохион байгуулалттай, эсвэл зэвсэглэн үйлдсэн дээрэм, соёлын эд зүйлсийн хууль бус худалдаа, үнэт цаасны зах зээлд луйвар үйлдэх, рэкет болон хүч хэрэглэхээр заналхийлэх замаар бусдын хөрөнгийг дээрэмдэх, барааны тэмдэгт ашиглах ба хуурамч бараа үйлдвэрлэх, албан ёсны баримт бичгүүдийг хуурамчаар үйлдэх болон худалдах, төлбөрийн хэрэгслүүдийг хуурамчаар үйлдэх, гормонтой эм бэлдмэлүүдийн хууль бус худалдаа, цацраг идэвхт бодисын хууль бус наймаа, тээврийн хэрэгслүүдийн хууль бус наймаа, хүчингийн хэрэг, галдан шатаах, Олон улсын эрүүгийн хэргийн шүүхийн харьяалалд хамаарах гэмт хэрэг, агаарын болон усан хөлөг онгоцыг хууль бусаар эзлэн авах, олон улсын шинжтэй үйл ажиллагааг тасалдуулах санаатай ажиллагаа зэргийг багтаажээ. Уг жагсаалтаас харахад гэмт хэргүүдийн уг бүлэгт эрүүгийн нийтлэг гэмт хэргүүд ч (жишээ нь, хүчингийн хэрэг болон аллага), олон улсын шинжтэй гэмт хэрэг хэмээн үздэг уламжлалт гэмт хэргүүд ч (жишээ нь, мансууруулах бодисын наймаа, терроризм, хуурамч мөнгө үйлдвэрлэх) багтаж байна. Энд Олон улсын эрүүгийн хэргийн шүүхийн харьяалалд хамаарах гэмт хэргүүдийг тусгайлан оруулсныг тэмдэглэх нь зүйтэй.

Энэхүү олон улсын баримт бичгээр дээрх гэмт хэргүүдийг олон улсын гэмт хэрэгт тооцохын зэрэгцээ эдгээр гэмт хэргийг мөрдөн шалгах үед удирдлага, зохион байгуулалтын нэгдсэн механизмууд болон тактикийн зарчмуудыг ашиглах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн байна[7].

Бидний үзэж байгаагаар олон улсын хамтын нийгэмлэгийн эрх ашгийг хөнддөг бөгөөд тэдгээрийг мөрдөн шалгахад гадаадын эрх бүхий зохих байгууллагууд болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах зайлшгүй шаардлага тулгардаг гэмт хэргүүдийг тусгайлан ангилан авч үзсэн нь үндэслэлтэй бөгөөд цаашид "олон улсын шинжтэй гэмт хэрэг", "үндэстэн дамнасан гэмт хэрэг", "үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг" гэсэн ойлголтуудыг хооронд нь ялган ангилж, тусгайлан тайлбарлах шаардлагатай байна.

Үндсэн хэсэг

Олон улсын шинжтэй гэмт хэргүүд[8] нь үндэсний эрх зүйн хэв журамд халдаж, олон улсын хамтын нийгэмлэгийн эрх ашгийг хөнддөг үндсэн шинжтэй бөгөөд зарим эрдэмтэн судлаачид "олон улсын гэмт хэрэг"-ийг конвенцийн гэмт хэрэг гэж нэрлэдэг. Учир нь улс хоорондын хамтын ажиллагаа нь олон улсын шинжтэй тодорхой гэмт хэргүүдтэй тэмцэх зорилготой олон талын гэрээнүүдийн үндсэн дээр хэрэгждэг[9] гэж үзсэн.

"...Олон улсын шинжтэй гэмт хэрэг гэдэг нь олон улсын гэрээнүүдэд тусгагдсан, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгтэй хамааралгүй боловч улс орнууд хоорондын хэвийн харилцаанд халдсан, харилцааны янз бүрийн салбарын (эдийн засаг, нийгэм-соёл, эд хөрөнгө, цахим орчин гэх мэт) хамтын

[7] Яблоков Н.П. Расследование организованной преступной деятельности. – М.: Юрист, 2002. – С. 50 – 51.

[8] Чекалина А.А., Томина В.Т., Сверчкова В.В. Комментарий к Уголовному кодексу Российской Федерации
Юрайт-Издат, 2006., Наумов А.В. Практика применения Уголовного кодекса Российской Федерации: комментарий судебной практики и доктринальное толкование.

[9] Международное право. / Под ред. Л.Н.Шестакова. – М.: Юридическая литература, 2005. – С. 284.

ажиллагаанд, түүнчлэн байгууллага, иргэдэд хохирол учруулдаг, олон улсын гэрээгээр тогтоосон хэм хэмжээний дагуу эсхүл эдгээр гэрээтэй нийцсэн үндэсний эрүүгийн хууль тогтоомжид тусгагдсан хэм хэмжээний дагуу шийтгэдэг үйлдлүүд юм...” гэж И.И.Карпец тодорхойлсон байдаг[10].

Харин, “Үндэстэн дамнасан гэмт хэрэг” гэсэн ойлголт нь бусад орны эрх зүйн нэр томьёоноос иш үндэс аван нэвтэрсэн төдийгүй англи хэлээр илэрхийлсэн “transnational crime” хэмээх ойлголтын хадмал орчуулга бөгөөд олон улсын шинжтэй гэмт хэрэг[11] гэсэн ижил агуулгыг өөртөө тээж, практик үйл ажиллагаанд нэвтэрчээ.

Профессор, Ж.Албани: Үндэстэн дамнасан гэмт хэрэг гэдэг нь нэгээс дээш улсын хууль тогтоомжийг урьдчилан төлөвлөж санаатайгаар зөрчиж, тэдгээр улсуудад эрх ашиг сонирхолд сөрөө нөлөө үзүүлдэг үйлдлийг хэлнэ. Тэдгээр гэмт хэрэг нь бусад төрлийн гэмт хэргээс үндэстэн дамнасан шинжээр ялгагддаг бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах өвөрмөц онцлогтой байдаг. Үндэстэн дамнасан гэмт хэргийн үндсэн 3 хэсэгт ангилаж болно. Үүнд:

1. Хууль бус худалдаа /мансууруулах бодисын наймаа, хулгайлагдсан эд зүйлийг худалдаалах, галт зэвсгийн худалдаа болон хуурамч бараа бүтээгдэхүүний худалдаа/;

2. Хууль бус үйлчилгээ /хүний наймаа, секс үйлчилгээ/;

3. Засгийн газрын болон аж ахуйн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх /залилах, дайлган сүрдүүлэх, мөнгө угаах, авилга/ зэргийг хамааруулна. Харин Олон улсын гэмт хэрэг нь хүн төрөлхтний энхтайвны эсрэг чиглэсэн бөгөөд нэг эсхүл түүнээс дээш улсын хэмжээнд үйлдэгддэг гэмт хэрэг. Тухайлбал, геноцид, терроризм дайны гэмт хэргүүд хамаарч байна.[12].

Олон улсын гэмт хэрэг болон үндэстэн дамнасан гэмт хэргийг ялгахын тулд Олон улсын эрүүгийн эрх зүй, үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх хууль гэсэн хоёр ойлголтыг авч үзэх ёстой. Профессор Бассиоуни Олон улсын эрүүгийн эрх зүй гэдэг нь тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг улс үндэстний засаглалын дэглэм, эрх зүйн тогтолцооноос үл хамааран гэмт хэрэгт тооцдог бөгөөд олон улсын эрүүгийн шүүхээр хянан шийдвэрлэдэг гэмт хэргүүдтэй холбогдоно[13] гэж тэмдэглэсэн байна.

Үүнээс үзвэл “олон улсын эрүүгийн эрх зүй дэх гэмт хэрэг”, “үндэсний эрх зүй дэх олон улсын гэмт” хэрэг гэсэн хоёр ойлголт ажиглагдаж байна. Зарим улсын эрүүгийн хуульд гэмт хэрэг гэж заагаагүй үйлдэл, эс үйлдэхгүйг олон улсад гэмт хэрэг гэж тооцдог бөгөөд үүнийг тухайн улсын хууль тогтоомжоос үл хамааран хянан хэлэлцэж, шүүн таслаж болдог. Тухайлбал, дайны гэмт хэрэг, хууль бус зэвсэг ашиглах, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, геноцид, апартеид, боолчлол, боолын холбоотой үйлдэл, эрүүдэн шүүх, хууль бус эмнэлгийн

[10] Международное уголовное право // И.П. Блищенко, Р.А. Каламкарян, И.И. Карпец и др. – М.: Наука, 1995. – С. 116.
[11] Encyclopedia of Law Enforcement. Vol. 3. – Thousand Oaks: Sage Publications, 2005. – P. 1115-1116.
[12] Jay s. albanese. Transnational crime and the 21st century: criminal enterprise, corruption, and opportunity 1st edition. 2009
[13] Mueller, ‘Transnational crime: Definitions and Concepts’, in Williams and Vlassis, supra note 2, at 13 and 21.

туршилт, дипломат ажилтныг хулгайлах, иргэнийг барьцаалах зэрэг гэмт хэргийг дурьдаж болох юм.

Харин үндэстэн дамнасан дамнасан гэмт хэргийг олон улсын эрүүгийн шүүх хянан хэлэлцэхгүй бөгөөд хамтын нийгэмлэг болон, эрх ашиг нь хөндөгдсөн улсуудын хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэдэг. Бүх төрлийн гэмт хэрэг үндэстэн дамнан үйлдэгдэж болох бөгөөд нийгмийн хор аюулаар ихтэй зарим төрлийн гэмт хэргийг НҮБ-аас гэмт хэрэгт тооцох, тэдгээр гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын нийгэмлэгийн оролцоог тодорхойлж өгдөг[14]. Тухайлбал, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенц, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай 2000 оны НҮБ-ын Конвенц (UNTOC), НҮБ-ын Авилгын эсрэг 2003 оны конвенц (UNCAC) зэргийг дурдаж болно.

Манай улсын хууль тогтоомжид дээрх ойлглтууд дараах байдлаар тусгагдан, практик үйл ажиллагаанд ашиглагдаж байна. Тухайлбал, "үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг"[15] "олон улсын шинж чанартай гэмт үйл ажиллагаа"[16] "олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн гэмт хэрэг"[17] зэрэг нэр томъёогоор тэмдэглэгджээ.

Зарим судлаач үндэстэн дамнасан зохион байгуулалт гэмт явдлыг дараах байдлаар ангилсан байна. Үүнд:

1) Олон улсын гэмт хэрэг (нийт хүн төрөлхтний оршин тогтнохуйн байдалд хандсан гэмт хэрэг);

2) Олон улсын шинжтэй гэмт хэрэг (улс орнуудын хэвийн харилцаа, энх тайван хамтын ажиллагаа нь иргэд байгууллагад гэмт хор учруулж байгаа гэмт хэрэг);

3) Гадаадын иргэдэд холбоотой гэмт хэрэг (гадаадын иргэдээс үйлдсэн болон тэдний эсрэг үйлдсэн гэмт хэрэг)[18].

Энэ ангилалаар харвал олон улсын шинжтэй гэмт хэрэг нь үндэстэн дамнасан гэмт хэргийг бүрдүүлж байгаа харагдаж байна. Гадаадын зарим орон, тухайлбал Оросын Холбооны Улсын эрх зүйн акт болон олон улсын хэлэлцээрүүдэд "олон улсын шинжтэй гэмт хэрэг" гэсэн ойлголт нь[19] дурдагдсан байдаг.

---

[14] Bassiouni, 'The Sources and Content of International Criminal Law: A Theoretical Framework', in Bassiouni, supra note 11, at 32–33 and 62–69, for the full list.

[15] Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор батлагдсан "Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр, Эрүүгийн хуулийн 6.15 дугаар зүйл.Гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлэх.

[16] Монгол улсын олон улсын гэрээ. "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц".

[17] Монгол улсын олон улсын гэрээ "Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц, 1 зүйл".

[18] С.Отгонбаяр "Монгол Улсад үндэстэн дамнасан шинжтэй зарим гэмт хэргийг шүүн таслаж буй өнөөгийн байдал, анхаарах зүйлс" сэдэвт илтгэл. УБ.2015 он.

[19] 1 Ст. 13 Федерального закона «О Федеральной службе безопасности», абз. 5 п. 1 ст. 17 Федерального закона от 31 июля 1998 г. № 155-ФЗ «О внутренних морских водах, территориальном море и прилежащей зоне Российской Федерации», подп. 1 абз. 1 ст. I Соглашения о сотрудничестве между Министерством внутренних дел Российской Федерации и Министерством общественной безопасности Китайской Народной Республики (Пекин, 18 декабря 1992 г.), преамбула Соглашения о сотрудничестве между Министерством внутренних дел Российской Федерации и Министерством внутренних дел Словацкой Республики (Москва, 29 мая 1994 г.) и др.

Манай улсын зарим судлаач “олон улсын гэмт хэрэг”-ийг тодорхойлохдоо: улс үндэстний оршин тогтнох үндэст халдсан олон улсын эрх зүйг зөрчсөн, хүн төрөлхтний энхтайван, аюулгүй байдалд аюул заналхийлсэн ноцтой гэмт хэрэг бөгөөд олон улсын гэмт хэргийн объект нь хүн төрөлхтний энхтайван, олон улсын аюулгүй байдал, улс үндэстнүүдийн сайн хөршийн харилцаа, үндэстэн ард түмний өөртөө засан тогтнох эрх, дайны хууль, ёс заншил зэрэг байж болно...”[20] гэж тэмдэглэжээ.

“Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг” гэсэн ойлголтыг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн конвенцид ашигласнаар тухайн нэр томьёо манай улсын болон бусад орны шинжлэх ухааны бүтээлүүдэд эргэлтэд орж эхэлсэн[21]. Тухайлбал, “үндэстэн дамнасан гэмт хэрэг”-ийг олон улсын эрүүгийн эрх зүй, дотоодын эрүүгийн эрх зүйд тусгагдсан хоёр ба түүнээс илүү улс орны нутаг дэвсгэрийг дамжин үйлдэгдсэн, эсвэл хоёр ба түүнээс дээш иргэн, хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулж, тодорхой цаг хугацаанд үйлдэгдсэн гэмт хэргийн нийлбэр цогц[22] хэмээн тодорхойлсон нь анхаарал татаж байна. Уг нэр томъёо нь зохион байгуулалттай гэмт бүлгүүд болон зохион байгуулалттай гэмт бүлгүүдийн нэгдлүүдээс үйлддэг гэмт үйл ажиллагаа, олон улсын шинжтэй гэмт хэрэг, эрүүгийн нийтлэг гэмт хэргийн төрлүүдийн нийлбэр гэсэн утгатай болно.

Дүгнэлт

Дээрх судлаачид болон бүтээлүүдэд тусгагдсан тодорхойлолтод задлан шинжилгээ хийж үзвэл олон улсын шинжтэй гэмт хэргийн шинж нь дараах байдлаар илэрч байна. Үүнд:

а) нэгээс дээш тооны улсад үйлдсэн;

б) нэг улсад үйлдсэн боловч бэлтгэл, төлөвлөлт, зохион байгуулалтын (удирдлага) эсвэл хяналтын ажиллагааны гол хэсгийг өөр улсад хэрэгжүүлсэн;

в) нэг улсад үйлдсэн боловч нэгээс дээш тооны улсад гэмт үйл ажиллагаанд оролцдог зохион байгуулалттай гэмт бүлгийн хүрээнд хэрэгжүүлсэн;

г) нэг улсад үйлдсэн болон ноцтой үр дагавар нь өөр улсад үүссэн.

Олон улсын шинжтэй гэмт хэргийн ялгарах гол шинж тэмдэг нь гэмт хэрэг үйлдэхэд бэлтгэх, түүнийг үйлдэх, нуун дарагдуулах үе шатуудад гэмт хэргийн арга барил, гэмт хэрэгтэн, хохирогч хэн болох зэрэг элементийн хооронд үүсдэг онцгой уялдаа холбоо юм. Гэмт хэргийн, ялангуяа зохион байгуулалттай гэмт хэргийн олон улсын шинж нь “үүсмэл” хэв маягтай байдаг. Учир нь гэмт хэргийн субъект өөрийгөө болон өөрийн мэддэг гэмт хэрэг үйлдэхэд бэлтгэх, түүнийг үйлдэх, нуун дарагдуулах аргуудаа гадаадын нөхцөл байдал буюу гадаадын хохирогчдын онцлогт, үйл ажиллагааны олон улсын цар хэмжээнд нийцүүлэх шаардлага үүсдэг байна.

[20] Д.Тунгалаг “Эдийн засгийн аюулгүй байдлын талбар толь” УБ., 2005 он. 89 дэх тал.
[21] Овчинский В.С. XXI век против мафии : Криминальная глобализация и Конвенция ООН против транснациональной организованной преступности. - М. : Инфра-М, 2005.; Яблоков Н.П. Расследование организованной преступной деятельности. — М.: Юрист, 2002. — С. 38 — 43; и др.
[22] Д.Тунгалаг “эдийн засгийн аюулгүй байдлын талбар толь” УБ., 2005 он. 138 дахь тал.

Бидний зүгээс үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг нь хууль зүйн номлол болон практикт хүлээн зөвшөөрдөг олон улсын шинжтэй гэмт хэргүүдийн зөвхөн нэг тусгай бөгөөд онцгой хэсэг хэмээн тайлбарлаж болно.

Эх сурвалжийн жагсаалт

1. Международное право. / Под ред. Л.Н.Шестакова. – М.: Юридическая литература, 2005;
2. Манина Е.Л. Особенности местного, федерального/межгосударственного и международного розыска преступников;
3. Королькова О.А. Правовые и организационные проблемы межгосударственного розыска лиц, скрывшихся от следствия и суда: Автореф. дис. ... канд. юрид. наук. – М., 2002;
4. Бастрыкин А.И. Проблемы расследования уголовных дел с участием иностранных граждан: Автореф. дис. ... канд. юрид. наук. – Л., 1980;
5. Шадрин О.Ю. Методика расследования преступлений, совершаемых иностранными гражданами и в отношении граждан иностранных государств (по материалам Дальневосточного региона): Автореф. дис. ... канд. юрид. наук. – М., 1998;
6. Смирнов О.Н. Особенности расследования преступлений, совершенных этническими группами: Автореф. дис. ... канд. юрид. наук. – Волгоград 2004 .; Кромарев А.Г. Особенности допроса граждан иностранных государств. М., 1976;
7. Международное уголовное право // И.П. Блищенко, Р.А. Каламкарян, И.И. Карпец и др. – М.: Наука, 1995;
8. Карпец И.И. Преступления международного характера. М., 1979;
9. Яблоков Н.П. Расследование организованной преступной деятельности. – М.: Юрист, 2002;
10. Чекалина А.А., Томина В.Т., Сверчкова В.В. Комментарий к Уголовному кодексу Российской Федерации 2006;
11. Наумов А.В. Практика применения Уголовного кодекса Российской Федерации: комментарий судебной практики и доктринальное толкование;
12. Encyclopedia of Law Enforcement. Vol. 3. – Thousand Oaks: Sage Publications, 2005. – P. 1115-1116;
13. Jay s. albanese. Transnational crime and the 21st century: criminal enterprise, corruption, and opportunity 1st edition. 2009;
14. Mueller, 'Transnational crime: Definitions and Concepts', in Williams and Vlassis, supra note 2, at 13 and 21;
15. Bassiouni, 'The Sources and Content of International Criminal Law: A Theoretical Framework', in Bassiouni, supra note 11, at 32–33 and 62–69, for the full list;
16. Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор батлагдсан "Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр;
17. Эрүүгийн хууль;
18. Монгол Улсын олон улсын гэрээ. "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц";
19. Монгол Улсын олон улсын гэрээ "Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц";
20. С.Отгонбаяр "Монгол Улсад үндэстэн дамнасан шинжтэй зарим гэмт хэргийг шүүн таслаж буй өнөөгийн байдал, анхаарах зүйлс" сэдэвт илтгэл. УБ.2015 он;
21. Д.Тунгалаг "эдийн засгийн аюулгүй байдлын талбар толь" УБ., 2005 он;

22. Овчинский В.С. XXI век против мафии : Криминальная глобализация и Конвенция ООН против транснациональной организованной преступности. - М. : Инфра-М, 2005.

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ОБЬЕКТЫН СУДАЛГАА ХИЙХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES OF LEGAL REGULATION AND IMPROVEMENT OF THE POLICE DATABASE

Г.Бямбадорж
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш, цагдаагийн хошууч
Byambadorj G.
Senior researcher-Lecture, Institute of Criminology and Police research, University Internal Affairs, Mongolia, Police major

ganbaatarbyamba88@gmail.com

Хураангуй: Цагдаагийн байгууллага, шүүх, прокурор болон дотоод хэргийн яамны харъяа тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудаас обьектын судалгаа хийх үйл ажиллагааг хууль тогтоомжид хэрхэн тусгасан талаар судалж, цаашид цагдаагийн байгууллагаас обьектын судалгаа хийх эрх зүйн зохицуулалтыг хэрхэн боловсронгуй болгох талаар авч үзсэн болно.

Abstract: In the article of how the law provides for object research by the police, the judiciary, prosecutors, and special services under the Ministry of the Interior, and how to further improve the legal framework for object research by the police.

Түлхүүр үгс: Цагдаа, обьект, эрх зүй, үйл ажиллагаа, судалгаа, тоо бүртгэл, мэдээллийн сан.

Keywords: Police, objects, law, operations, research, statistics, database.

Цагдаагийн байгууллагаас обьектын судалгаа хийх ажлыг дараах хууль, эрх зүйн актаар зохицуулж байна.

Үүнд: Монгол Улсын Үндсэн хууль[1], Статистикийн тухай хууль[2], Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль[3], Прокурорын тухай хууль[4], Авлигын эсрэг хууль, Цагдаагийн албаны тухай хууль[5], Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль[6], УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2015 оны 23 дугаар тогтоол, шүүхийн хэмжээнд "Шүүхийн статистикийн мэдээлэл, тайлан гаргах журам"[7], Прокурорын байгууллагын хэмжээнд "Дотоод ажлын аргачилсан заавар"[8], "Үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх аргачилсан заавар"[9], "Мэдээлэл, мэдээллийн

[1] "Төрийн мэдээлэл" эмхэтгэл. 1992.№01
[2] "Төрийн мэдээлэл" эмхэтгэл. 1997.№07
[3] "Төрийн мэдээлэл" эмхэтгэл. 1998.№01
[4] "Төрийн мэдээлэл" эмхэтгэл. 2017.№24
[5] "Төрийн мэдээлэл" эмхэтгэл. 2017.№08
[6] "Төрийн мэдээлэл" эмхэтгэл. 2017.№24
[7] ШЕЗ-ийн 2008 оны 17 дугаар тогтоолоор батлсан.
[8] Улсын ерөнхий прокурорын 2011 оны 34 дүгээр тушаалаар батлсан.
[9] Улсын ерөнхий прокурорын 2015 оны А/65 дугаар тушаалаар батлсан.

системийн аюулгүй байдлыг хангах журам[10], Хууль зүйн салбарын хэмжээнд "Салбарын статистик мэдээллийн сан бүрдүүлэх, эрхлэн хөтлөх журам"[11], "Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журам"[12], Цагдаагийн байгууллагын хэмжээнд "туслах тоо бүртгэлийн заавар", шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд "Нэгдсэн тоо бүртгэл хөтлөлтийн заавар", "хорих байгуллагын стандарт"[13]зэрэг эрх зүйн актаар зохицуулж байна.

Цагдаагийн байгууллагаас обьектын судалгаа хийх ажлын үндсэн эх сурвалж бол Үндсэн хууль мөн. 1992 онд Монгол Улсын Үндсэн хууль батлагдсанаар хувь хүн болон төрийн хоорондын харилцаанд цоо шинэ хандлага гарсан. Төр нь хүний эрхийг хангах үүрэг хүлээж, иргэн нь эрхээ хангахыг шаардах эрхтэй болсон. Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэгт хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан бөгөөд хүнийг дээдэлж, түүний эрх, эрх чөлөөт байдлыг хүлээн зөвшөөрсөн нь Үндсэн хуулийн язгуур үзэл баримтлалын нэг болов.

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт: "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт "амьд явах эрхтэй. Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно", мөн зүйлийн 16.2 дахь хэсэгт "эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй", мөн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт: "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.", мөн зүйлийн 19.2 дахь хэсэгт: "Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө", мөн зүйлийн 19.3 дахь хэсэгт: "Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй" гэж тус тус заасан.

Үндсэн хуулийн дээрх заалтын хэрэгжилтийг хэмжих хэмжүүр үзүүлэлт нь цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх оновчтой бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, аливаа шийдвэр, үйл ажиллагаагааг судалгаа шинжилгээнд үндэслэх явдал мөн. Үүнд иргэнийхээ аюулгүй орчинд амьдрах баталгааг хангах, гэмт халдлагад өртөхгүй байх нөхцөлийг хангах үйл ажиллагаа гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх үйл ажиллагаатай зайлшгүй уялдана.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2016 оны 2-р сарын 19 дүгээр тогтоолоор Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлогын бичиг баримтыг

[10] Улсын ерөнхий прокурорын 2015 оны А/66 дугаар тушаалаар баталсан.
[11] ХЗС-ын 2014 оны А/48 дугаар тушаалаар баталсан.
[12] ХЗС-ын 2016 оны А/04 дүгээр тушаалаар баталсан.
[13] ШШГЕГ-ын даргын 2016 оны А/30 дугаар тушаалаар баталсан.

баталсан. Бодлогын бичиг баримтын зорилго нь Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болох зорилго тавьж үүнтэй уялдуулан үндсэн долоон зорилт дэвшүүлсэн.

Уг бодлогын баримт бичгийн 7-р зорилтод Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлж, үндэсний хиймэл дагуул хөөргөнө.

I үе шат (2016-2020): Нийт хүн амын 70 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, газар нутгийн байршлаас үл хамаарсан ижил үнэ, тарифыг мөрдөж, Ази, Европыг холбосон мэдээлэл дамжуулах өндөр хурдны сүлжээгээр дамжих мэдээллийн урсгалын хэмжээг арав дахин нэмэгдүүлэх.

II үе шат (2021-2025): Нийт хүн амын 90 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, хөдөө, орон нутгийн хүн амын 70 хувь нь өргөн зурвасын интернетийн үйлчилгээ ашиглах, төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээний 50-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлэх.

III үе шат (2026-2030): Нийт хүн амын 95 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээний 85-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, үндэсний хиймэл дагуул хөөргөн ашиглах[14].

Гэж заасан нь мэдээлэл технологийн салбарт болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд шинжлэх ухаан, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ололтыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах үндэс болжээ.

Түүнчлэн цагдаагийн байгууллагаас хийх обьектын судалгааг боловсронгуй болгох, утасгүй сүлжээ ашиглан Монгол Улсын өнцөг булан бүрээс обьектын судалгааны сан бүрдүүлэх, түүнийг гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаандаа ашиглах боломжийг нэмэгдүүлэх юм.

Цагдаагийн байгууллагаас обьектын судалгаа хийх ажлын эрх зүйн үндэсийг шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуульд нарийн тодорхой зааж өгөөгүй боловч, энэхүү ажлын эрх зүйн үндэс нь цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үндсэн үүрэгтэй шууд холбоотойгоор хуульчлагдсан байна. Үүнд:

Шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуулийн 18-р зүйлд цагдаагийн судалгааны төвийг ажилуулах талаар шинээр хуульчилж өгсөн бөгөөд цагдаагийн судалгааны төв нь цагдаагийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх стандарт, дүрэм, журам, зааврыг боловсронгуй болгох, гэмт хэрэг, зөрчлийн ул мөр илрүүлэх, буулган авах, бэхжүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг нотлох, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, гүйцэтгэх ажил явуулах арга тактикийг боловсронгуй болгох, зам тээврийн осол, хэрэг болон насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах асуудлаар бодлого боловсруулах чиглэлээр дүн шинжилгээ хийж, цагдаагийн байгууллагыг

[14] Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030.

мэдээллээр хангах, цагдаагийн төв байгууллагын даргын даалгасан бусад чиглэлээр судалгаа хийхээр заасан ч цагдаагийн байгууллагаас обьектын судалгаа хийх ажлын эрх зүйн үндсийг шууд тусгаагүй зөвхөн үйл ажиллагаандаа судалгаа хийх чиглэлийг тогтоосон байна.

Мөн хуулийн 10 дугаар зүйл "гэмт хэрэгтэй тэмцэх гэсэн зүйлийн 10.2-д Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд дор дурдсан үүрэг хэрэгжүүлнэ. Үүнд: 10-р зүйлийн 10.1.1-д "гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгуулах", мөн зүйлийн 1.2-д "гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах, бүртгэх, олзлох, цуглуулах, олж авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах, гэмт хэргийг илрүүлэх", мөн зүйлийн 1.3-д "гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах", мөн зүйлийн 1.7-д "хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдсэн хүнийг эрэн сурвалжлах, баривчлах", мөн зүйлийн 1.10-д "гэмт хэрэг, тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, лавлагаа гаргах", мөн зүйлийн 10.2-д Цагдаагийн байгууллага энэ хуулийн 10.1.5, 10.1.6-д заасан ажиллагаа явуулахад шаардлагатай тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, тусгай техник, арга хэрэгсэл ашиглах, халхавчийн байгууллага, нууц гүйцэтгэх болон туслагч, туслах ажилтныг ажиллуулна.[15]

Дээр дурьдсан эрх зүйн зохицуулалтаас үзвэл цагдаагийн байгууллагаас обьектын судалгаа хийх ажлын эрх зүйн үндсийг шууд тусгаагүй боловч тоо бүртгэл хөтлөхтэй холбоотой заалтууд хуульчлагджээ.

Мөн Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлд Цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа 20 төрлийн тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сүлжээ, сан үүсгэж ашиглах тухай анх удаа хуульчилж өгсөн нь онол, практикийн онцгой ач холбогдолтой болжээ.

Гэвч цагдаагийн байгууллагаас хариуцсан нутаг дэвсгэрийн обьектын судалгаа хийх ажлын эрх зүйн зохицуулалтыг бүрэн тусгаагүй бөгөөд зарим заалт нь обьектын судалгааны төрөл, зүйлтэй холбоотой, зарим заалт нь гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд илүү тусгалаа олсон байна.

Дээр дурьдсан гэмт хэрэгт сэжиглэгдсэн, эрүүгийн хэрэгт сэжигтнээр тооцогдсон, яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн хүний талаар, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, ялыг хойшлуулсан, өршөөл, уучлалд хамрагдсан хүний талаар хөтлөх тоо бүртгэл нь цагдаагийн байгууллагаас хийх субьектын судалгааны төрөл болох хорихоос суллагдсан хүний судалгаатай хийх эх сурвалж болдог.

Цагдаагийн байгууллага хорихоос суллагдсан хүний судалгаа явуулж, тэдний ял шийтгэгдсэн зүйл заалт, хэдэн удаа ямар ямар зүйл ангиар ял шийтгэгдсэн, ялын төрөл, хэмжээ зэргийг тодорхойлоход ашиглаж болно.

[15] Г.Бямбадорж. Цагдаагийн байгууллагаас хийх обьектын судалгаа. УБ., 2018. 35 дахь тал.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний талаарх бүртгэл нь хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн хүмүүсийн судалгааны эх сурвалж болно.

Энэхүү тоо бүртгэл нь хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн хүмүүсийн судалгаанд эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээд хэд хичнээн байгаа, ямар хэргийн учир эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан зүйл заалт, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээний талаарх мэдээлэл субьектын судалгаанд хамааралтай.

Мөн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналтад байгаа хүний талаар тоо бүртгэл хөтлөх явдал нь цагдаагийн байгууллагаас Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зургадугаар бүлэг 41-р зүйлд заасан хорих ял эдлээд суллагдсан хүнд хяналт тогтооход ач холбогдолтой байна.

Гэмт хэрэгт сэжиглэгдсэн, эрүүгийн хэрэгт сэжигтнээр тооцогдсон, яллагдагчаар татагдсан, эрүүгийн хэрэг, үйлдэл холбогдол нь хэрэгсэхгүй болж цагаатгагдсан хүний талаар тоо бүртгэлийг субьектын судалгааны бүрэлдэхүүн хэсэг болох гэмт хэрэгт холбогдогчдын судалгааны зарим хэсгийг бүрдүүлж болно.

Эрэн сурвалжлагдаж байгаа хүний тоо бүртгэл нь Монгол Улсын хэмжээнд болон тухайн нутаг дэвсгэрт эрэн сурвалжлагдаж байгаа хүмүүсийн нэгдсэн тоо мэдээ гаргах, тухайн этгээдийг эрэн сурвалжлагдаж байгаа хүмүүсийн судалгаанд авч судлах үндэслэлийг тогтоосон заалт болжээ.

Мөн тээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигчийн болон тээврийн хэрэгслийн татвар, даатгал, оношилгооны талаар, галт зэвсгийн тухай хуулийн 12.9-д заасан мэдээллийн сан бүрдүүлэх тухай заасан нь хариуцсан нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл, галт зэвсэгтэй иргэдийн судалгаа хийх эрх зүйн үндэстэй холбоотой төдийгүй эдгээр тоо бүртгэл нь Криминалистикийн тоо бүртгэл хөтлөх, галт зэвсгийн сан бүрдүүлж ашиглахтай эрх зүйн зохицуулалттай шууд холбогдож байна.

Түүнчлэн, хүүхдээ хүмүүжүүлэх үүргээ биелүүлэхгүй, мөн хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлж байгаа, хүүхэдтэй хэрцгий харьцаж байгаа этгээдийн талаар тоо бүртгэл хөтлөх нь гэр бүл орчиндоо тааламжгүй байдал гаргадаг хүмүүс болон гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүсийн судалгаатай зарим талаараа холбоотой байна.

Дээр дурьдснаас бусад тоо бүртгэл, сан бүрдүүлж ашиглах талаарх зүйл заалт нь цагдаагийн байгууллагаас обьектын судалгаа явуулах ажлын эрх зүйн зохицуулалттай холбогдохгүй цагдаагийн байгууллагын зарим гүйцэтгэх чиг үүрэгтэй холбоотой байж болох юм. Үүнд:

Цагдаагийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан захиргааны хяналт тавих чиг үүрэгтэй холбоотой дараах тоо бүртгэл байна. Тухайлбал: Жолоодох эрхийн үнэмлэх авсан хүн, гэрээт болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн талаарх тоо бүртгэл хөтлөх нь энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх заалттай холбогдож байна.

Харин Цагдаагийн алба хаагч галт зэвсэг хэрэглэсэн тохиолдлын талаарх тоо бүртгэл нь Цагдаагийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлд заасан Галт

зэвсэг хэрэглэх үндэслэл, цагдаагийн дотоод албаны дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, галт зэвсэг хэрэглэсэн тохиолдол шинжлэн судлах, хуульд зааснаар дүн шинжилгээ хийх, судалгаа явуулах эрх зүйн зохицуулалттай холбогдож байна.

Мөн Хуулийн этгээдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа дүрс бичлэгийн хэрэгслийн тоо бүртгэл нь Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй холбоотой. Тухайлбал: Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30.1.5.барилга байгууламжийн гадна орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа дүрс бичлэгийн техник, хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд үнэ төлбөргүй холбох, шаардлагатай техникийн нөхцөл, боломжийг бүрдүүлэх[16]. Гэсэн заалтын хүрээнд цагдаагийн байгууллага хуулийн этгээдийн дүрс бичлэгийн тоо бүртгэл хөтлөж дүрс бичлэгийн техник, хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдох боломжтой.

Харин Криминалистикийн тоо бүртгэл, сан үүсгэж ашиглахтай холбоотой гарын хээ, сум, хонгио, генетикийн мэдээлэл зэрэг тоо бүртгэл хөтлөх үйл ажиллагаатай уялдаж байна.

Дээр дурьдсан тоо бүртгэл бүхнээс үзэхэд цагдаагийн байгууллагаас хариуцсан нутаг дэвсгэртээ обьектын судалгаа явуулах ажлын эрх зүйн зохицуулалтыг бүхэлд тогтоож өгөөгүй, субьектын зарим төрлийн судалгаа хийх ажлын эрх зүйн үндэс, судалгааны төрөлтэй зарим талаараа холбоотой болох нь ажиглагдаж байна.

Мөн Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9-р зүйлийн 9.2-д Гүйцэтгэх ажилд хууль тогтоомжийг чанд сахиулах, нууцыг хангуулах зорилгоор Тагнуулын байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

9.2.1.гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, энэ талаарх холбогдох журмыг баталж мөрдүүлэх, 13-р зүйлийн 13.3.3.өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн болон нууц арга хэрэглэж зохиосон ажлын тоо, бүртгэл хөтөлж, энэ талаар мэдээллийн сан байгуулж ажиллуулах, гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлэх.[17] гэсэн заалтаас үзэхэд гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий албан тушаалтан өөрөөр хэлбэл эрүүгийн мөрдөгч, сумын хэсгийн төлөөлөгч болон бусад эрх бүхий ажилтан нар хариуцсан нутаг дэвсгэртээ дээр дурьдсан тоо бүртгэл, мэдээллийн сан үүсгэж ажиллах тухай заасан байна.

Энэхүү чиг үүрэг гүйцэтгэхдээ мөн хуулийн 9-р зүйлийн 9.2.2-д заасан гүйцэтгэх ажил явуулахад дагаж мөрдөх журам, зааврыг хууль тогтоомжид нийцүүлэн батлаж дагаж мөрдөх тухай заажээ.

Дээр дурьдсан заалтуудаас үзэхэд хариуцсан нутаг дэвсгэртээ обьектын судалгаа хийх талаар тухайлсан заалт байхгүй бөгөөд гүйцэтгэх ажилтны чиг үүрэгтэй холбоотой дээрх заалтуудыг тусгаж өгсөн байна.

[16] “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2019.№42
[17] “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2006.№31

Түүнээс гадна ЦЕГ-ын даргын 2003 оны 6-р сарын 3-ны өдрийн 229 дүгээр тушаалаар батлагдсан Хэсгийн байцаагчийн ажлын зааврын 5.4-д дараах төрлийн судалгаа хийх эрх зүйн үндсийг тусгажээ. Үүнд:

Дуур дурьдсан ЦЕГ-ын даргын 2003 оны 6-р сарын 3-ны өдрийн 229 дүгээр тушаалаар батлагдсан хэсгийн байцаагчийн ажлын зааврын дагуу өнөөг хүртэл дээр 15 төрлийн бүртгэл, судалгааг цагдаагийн хэсгийн байцаагч нар хороо, сум бүрт дээрх төрлийн судалгааг хийж хэвшүүлэн, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Эдгээр хууль эрх зүйн акт нь хэсгийн байцаагч нараас нутаг дэвсгэрийнхээ орчны байдал, обьектын судалгаа хийх эрх зүйн эх сурвалж болох юм.

Мөн ЦЕГ-ын даргын 2018.12.20-ны өдрийн А/262 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам (код-703) Судалгаа, хяналтын тоо бүртгэл хөтлөх журам юм.

Дээрх зааварын 703.5-д обьектын судалгааг Судалгаа-хяналтын мэдээллийн сан гэж нэрлэж субьектын 22 төрлийн, обьектын 27 төрлийн бүртгэл, судалгааг хамруулсан байна.[18]

Мөн Цагдаагийн байгууллагаас гадна шүүх, прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар зэрэг төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагууд хариуцсан нутаг дэвсгэртээ судалгаа хийх, бүртгэл хөтлөх ажлын эрх зүйн зохицуулалтыг хэрхэн тусгасан талаар авч үзэх нь зүйтэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 6-р сарын 9-ны өдөр баталсан бөгөөд обьектын бүртгэл, судалгаа хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлж ашиглах талаар дараах эрх зүйн зохицуулалтыг тусгажээ. Үүнд:

260 дугаар зүйлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын чиг үүргийг хуульчилсан уг зүйлийн 1.3-д "хууль тогтоомжид нийцүүлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаанд холбогдох журам, стандарт, заавар, зөвлөмж боловсруулж хэрэгжүүлэх, боловсронгуй болгох, биелэлтийг хангуулах", 264-р зүйлийн 264.1.8-д "хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд төлбөртэй этгээдийн бүртгэл, гүйцэтгэх баримт бичгийн тоо бүртгэл, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн цахим сан хөтлөх, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх"[19] хэмээн заасан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч нараас хариуцсан хорих анги, ялтны талаар бүртгэл, судалгаа явуулах ажлын үндсийг хуульчилжээ.

Мөн Хууль зүйн сайдын 2014 оны А/230 дугаар тушаалын 1-р хавсралтаар "Хорих байгууллагын стандарт"-ыг анх удаа баталсан ба уг стандартын 12-р зүйлд хорих байгууллагын үйл ажиллагаанд хөтлөгдөх баримт бичиг, судалгааны хийх ажлын төрлийг заасан байна. Үүнд: 12.1.9."зөрчлийн бүртгэл" ялтны овог нэр, ял хэргийн байдал, гаргасан зөрчил, зөрчлийг илрүүлсэн албан хаагч, шийдвэрлэсэн талаар, мөн зүйлийн 1.10-д "эргэлт, уулзалтын бүртгэл" Зөвшөөрөл, уулзсан хүмүүсийн овог нэр, эргэлтэд гарсан ялтан, хоригдогчийн

[18] ЦБҮАЖ-ын код 703 Судалгаа, хяналтын тоо бүртгэл хөтлөх.
[19] Төрийн мэдээлэл" эмхэтгэл. 2017.№24

овог нэр, гарсан, орсон цаг минут эргэлтээр авчирсан эд зүйлсийн жагсаалт, мөн зүйлийн 1.12-д "анхаарал татсан ялтны судалгаа" ялтны овог нэр, 3 талаас харуулсан зураг, ял хэргийн байдал, анхаарал татах болсон шалтгаан, харуул хамгаалалтын бүрэлдэхүүнд анхааруулах зүйл, содон шинж тэмдэг зэргийг тодорхой тусгана, мөн зүйлийн 1.14-д."ялтны нэгдсэн бүртгэл" ялтны овог нэр, ял хэргийн байдал, ажлын заалт, бүртгэгдсэн цаг хугацааг тусгана гэжээ.

Шүүхийн захиргааны тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн статистик судалгааны чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх Шүүхийн судалгаа, мэдээллийн байгууллагатай байна гэж заасны дагуу 2014 онд Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнг дэргэдээ байгуулсан. Улмаар Шүүхийн статистикийн мэдээлэл, тайлан гаргах журмын дагуу тус хүрээлэн нь Монгол Улсын 3 шатны шүүхүүдээс статистик тоон мэдээг хүлээн авч нэгтгэдэг байна.

Дээр дурьдсан шүүхийн мэдээллийн сан, бүртгэлийг цагдаагийн байгууллагын тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэхэд ашиглаж байна.

Үүнд:

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс дараах үзүүлэлтээр мэдээлэл боловсруулж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Үүнд: Хүлээн авсан хэрэг, хүний тоо, Хэргийн тоо, гэмт хэргийн төрөл, шүүх хурлын төрлөөр, Шүүхээр шийдвэрлэгдсэн нийт хэргийн тоо, Давж заалдах шатны хэргийн тоо, Шүүхээр шийтгүүлсэн хүний тоо, Насанд хүрээгүй гэмт хэрэгтний тоо, Гэмт хэрэгтний нас, хүйс, харьяаллаар, Шүүхийн шийдвэр төрлөөр, Цагаатгасан хэргийн эзлэх хувь, 1 жилд шийдвэрлэсэн хэргээс ял шийтгэл ногдуулсан хэргийн эзлэх хувь, 1 жилд шийдвэрлэсэн хэргүүдээс гэм буруутай нь тогтоогдсон хэргийн эзлэх хувь, Хэрэгсэхгүй болгосон хэргийн эзлэх хувь, Шүүхээс хорих ял шийтгэгдсэн хүүхдийн тоо, Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, Шүүхээр ял шийтгүүлсэн хүн хүйсээр, насны ангиллаар, боловсролын түвшингээр гэх мэт обьектын судалгаанд тусгавал зохих тоо бүртгэл хөтлөж байна.

Мөн 2017 оны 2-р сарын 2-ны өдөр батлагдсан Гамшигаас хамгаалах тухай хуулийн 44-р зүйлд зааснаар Онцгой байдлын байгууллага алба хаагч нь дараах үндсэн чиг үүрэгтэй. Үүнд:

Мөн хуулийн 48-р зүйлийн 48.1 дэхь хэсэгт Онцгой байдлын байгууллагын алба хаагч Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээс гадна дараахь үүргийг хүлээнэ. Үүнд: 48-р зүйлийн 48.1.1-д "гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах, оролцох", мөн зүйлийн 1.2-д "аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг чанд сахих, байгууллага, албан тушаалтан, иргэнд мэргэжлийн чиглэлээр зааварчилгаа өгч, туслалцаа үзүүлэх", мөн зүйлийн 1.3-д "хариуцсан техник, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах" хэмээн заасан нь уг байгууллагын алба хаагч гамшигаас урьдчилан сэргийлэх, хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ иргэд байгууллагын орон байрыг шалгаж дүгнэлт гаргах, урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт явуулж обьектын судалгаа хийх ажлын эрх зүйн үндэсийг тогтоожээ.

Түүнчлэн, Галын аюулгүй байдлын тухай хуулийг шинэчлэн найруулж 2015 оны 7-р сарын 2-ны өдөр баталсан бөгөөд хуульд хариуцсан обьектоо судлах талаар дараах эрх зүйн зохицуулалтыг тусгажээ. Үүнд: 4-р зүйлийн 4.1.3-д "гал түймрийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, гал түймрийн шалтгаан, нөхцөлийг судлах, судалгаа, шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх чиглэлийг тогтоох", 6-р зүйлийн 6.1.1-д "барилга байгууламжийн байршлыг тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж мэргэжлийн дүгнэлт гаргах", мөн зүйлийн 1.4-д "барилга байгууламжийг ашиглалтад авах улсын комиссын бүрэлдэхүүнд оролцох, хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд санал, дүгнэлт гаргах", мөн зүйлийн 1.6-д "аж ахуйн нэгж, байгууллагын барилга байгууламжид шууд, тусгай хамгаалалттай объектод урьдчилан мэдэгдэж, орон сууцанд иргэний хүсэлт, мэдээллийн үндсэн дээр нэвтрэн орж, галын аюулгүй байдлын болон галын техникийн үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгах тухай албан шаардлага, мэдэгдэл бичих, биелэлтэд хяналт тавих" 24-р зүйлийн 24.3-д "онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь улсын хэмжээнд гарсан гал түймрийн бүртгэлд дүн шинжилгээ хийж, гал түймрээс урьдчилан сэргийлэх, улсын хяналт явуулах чиглэлийг тогтоож, бодлого боловсруулна.[20]

Гэсэн заалтуудаас харахад онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага хариуцсан нутаг дэвсгэрийн обьектын байршил, шинж чанарыг тодорхойлон судлаж дүгнэлт гаргах, хариуцсан обьектод үзлэг шалгалт явуулах, гал түймэрийн улмаас учирсан хохирол, гарсан гал түймэрийн шалтгаан нөхцөл зэргийн талаар нэгдсэн тоо бүртгэл хөтлөж, цаашид гал түймрээс урьдчилан сэргийлэх, улсын хяналт явуулах чиглэлийг тогтоож, бодлого боловсруулж хэрэгжүүлж байгаа нь хариуцсан обьектоо судлаж үйл ажиллагаагаа шинжлэх ухааны үндэстэй төлөвлөн хэрэгжүүлж байгаа нь ажиглагдаж байна. Түүнчлэн онцгой байдлын байгууллагын дээр дурьдсан тоо бүртгэлийн обьектын судалгаа явуулахдаа ашиглаж болох юм. Тухайлбал: Шинээр барилга байгууламжийг ашиглалтад авах улсын комиссын бүрэлдэхүүнд оролцох, хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд санал, дүгнэлт гаргах ажлын хүрээнд хүлээн авсан байрилгын схем, зургыг аж ахуйн нэгж байгууллагын судалгаа хийхэд ашиглаж баяжуулах.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 40-р зүйлд Шүүхийн шинжилгээний мэдээллийн сан үүсгэж ашиглах талаар заасан бөгөөд мөн зүйлийн 1-д "шүүхийн шинжилгээний төв байгууллага нь улсын хэмжээний шүүхийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн сантай байна" хэмээн заасан ба шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжилгээний статистик бүртгэл, хөтлөлт, ашиглалттай холбоотой үйл ажиллагааг тус байгууллагын бүтцийн нэгж болох Шинжилгээний бүртгэл, мэдээллийн хэлтэс голчлон хариуцдаг байна. Тус алба дараах сан үүсгэж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Үүнд:

- НЦГ-ын эрэлч нохойн албаны үнэрийн лаборатори;
- Гарын мөрний сан;
- Галт зэвсгийн сан;
- Мөр судлалын сан;

[20] Төрийн мэдээлэл" эмхэтгэл. 2015.№14

- Биологийн сан;
- Физикийн сан;
- Бичиг техник, бичиг судлалын сан;
- Шүүх эмнэлэг гэх мэт сангуудыг үүсгэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

ЦЕГ-ын мэдээлэл судалгааны төвд буй ял эдэлсэн хүмүүсийн тоо бүртгэлийг гэмт хэрэг илрүүлэхэд идэвхитэй ашиглаж чадахгүй зөвхөн өмнө нь тухайн этгээд ял шийтгэл эдэлж байсан эсэхийг тогтоох лавлагааны зориулалтаар ашиглаж байна.

Түүнээс гадна шүүхийн шинжилгээний байгууллагын хувьд хийсэн шинжилгээ, оролцсон хэргийн газрын үзлэгийн талаархи мэдээллийг батлагдсан маягт, тодорхой шалгуур үзүүлэлтүүдийн дагуу бүртгэж, нэгдсэн мэдээллийг холбогдох байгууллага хүргүүлж, 2013 оноос ШШҮХ-ийн төв лаборатори, нэгжүүдэд хийх шинжилгээний бүртгэлийг дагнан хариуцсан нэгж буюу Шинжилгээний бүртгэл, мэдээллийн хэлтсийг байгуулсан нь шүүхийн шинжилгээ явуулахтай холбоотой процессын шинжтэй асуудлуудыг шийдээд зогсохгүй цагдаагийн байгууллагаас тоо бүртгэл хөтлөх, бусад байгууллагатай лавлагаа, мэдээлэл солилцоход дэвшил гаргахад чиглэсэн алхам болсон гэж дүгнэж байна.

Монгол Улсын Их хурлаас 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Хилийн тухай хуулийг шинэчлэн баталсан бөгөөд уг хуулийн 36-р зүйлд Улсын хил хамгаалах байгууллагын бүрэн эрхийг заасан байна. Үүнд: 36-р зүйлийн 36.1.10-д "хилийн зөрчилтэй холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад албан шаардлага хүргүүлэх, зөрчлийг арилгуулах", мөн зүйлийн 1.11-д "улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх журамд хяналт тавихын тулд зайлшгүй шаардлагатай бүртгэл хөтлөх", мөн зүйлийн 36.2-д "улсын хил хамгаалах байгууллага энэ хуулийн 36.1-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд зэвсэгт хүчин, тагнуул, цагдаагийн болон холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллана".[21] Хэмээн заасан нь улсын хилийн дархан байдлыг хангах үйл ажиллагаандаа бүртгэл судалгаа, хөтлөх цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах цагдаагийн байгууллагын мэдээллийн санг ашиглах эрх зүйн зохицуулалтыг тус тус заасан нь хилийн аюулгүй байдлыг хангахад ашиглах бүртгэл, судалгаа хөтлөх ажлын эрх зүйн үндэс нь болжээ.

Мөн дээрх хуулийн дагуу Хилийн албаны эрх бүхий албан хаагч хил орчим нутаг дэвсгэр, түүний онцлог, хил орчимд нутагладаг айл өрх, мал аж ахуй, хилийн зөрчлийн тоо, урьд өмнө хил зөрчсөн хүмүүсийн бүртгэл, судалгаа, хилийн зөрчил гарч болзошгүй эмзэг цэг, газруудыг судалгаа бүртгэл хөтлөн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Дээрх бүхнээс үзвэл обьектын судалгаа хийх талаар төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, эрх актад зарим заалт туссан боловч хариуцсан нутаг дэвсгрийн обьектын төлөв байдал, тоо хэмжээ, онцлог шинж, төрөл зэргийг дэлгэрэнгүй тусгаагүй байна.

[21] "Төрийн мэдээлэл" эмхэтгэл. 2017.№06

Дүгнэлт

Обьектын судалгаа хийх, судлах зүйл, ангилал, төрөл, тоо, хэлбэр, хэмжээ, загвар зэргийг тогтоосон эрх зүйн зохицуулалт үгүйлэгдэж байна. Тухайлбал: Цагдаагийн байгууллагын обьектын судалгааг цагдаагийн газар, хэлтэс түүний алба хаагчид ямар нэгэн тогтсон арга, арчилалаар бус практикийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөр өөр арга хэрэгслээр, харилцан адилгүй хийж байгаа нь зарим талаараа үүнтэй холбоотой байж болох юм.

Дээр дурьдсан албадын зарим чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд судалгаа явуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байгаа нь ажиглагдаж байна.

Эрх зүйн шинэчлэл хууль тогтоомжийн өөрчлөлтөд үндэслэн шинэчлэлтийн хүрээнд обьектын судалгаа хийх ажлын эрх зүйн зохицуулалтыг тухай бүр уялдуулж зарим төрлийн судалгааг обьектын судалгааны төрлөөс хасах, зарим төрлийн судалгааг нэмж хийх эрх зүйн зохицуулалт бий шаардлагатай тулгарч байна.

Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгээ хээргжүүлэхэд Улсын бүртгэлийн мэдээллийн сан, төрийн байгууллагын болон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын төвлөрсөн мэдээллийн санд шуурхай нэвтэрч мэдээ, мэдээлэл авах шаардлага гардаг нь судалгаар ажиглагдлаа иймд дээр дурьдсан байгууллагуудын мэдээллийн санд нэвтэрч албаны хэрэгцээнд ашиглах үйл ажиллагааг зохицуулаагүй байна.

Цагдаагийн байгууллагын обьектын судалгаа бүрдүүлэх ялангуяа гэмт хэрэгт холбогдож болзошгүй сэжигтэй хүмүүс, гэмт хэрэгт холбогдогчдын, эрэн сурвалжлагдаж буй оргодол, этгээдүүдийн, хорих ял эдлээд суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн, ял хойшлогдсон, гэр бүл орчиндоо байнга тааламгүй байдал гаргадаг, түр оршин суух, гадаадын болон харъяалалгүй иргэдийн судалгаа, насанд хүрээгүй хүмүүсийг уруу татагчдыг, туслах хүчний зэрэг судалгаанд хүмүүсийг хамруулах үндэслэлийг эрх зүйн актаар зохицуулах зайлшгүй шаардлагатай байна.

Санал

1. Улсын бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.13-д нэмэлт оруулж бүртгэл мэдээллийн санг цагдаагийн байгууллага чиг үүрэг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ашиглаж болно" хэмээн нэмэлт заалт оруулах;

2. Цагдаагийн албаны тухай хуулийн 61.8-д "Хуульд өөрөөр заагаагүй бол цагдаагийн байгууллага, алба хаагч үүргээ гүйцэтгэх үедээ төрийн байгууллагын болон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын төвлөрсөн мэдээллийн санд шуурхай нэвтрэх, албаны хэрэгцээнд ашиглах эрхтэй" гэж нэмэлт заалт оруулах 2. ЦЕГ-ын даргын 2003 оны 6-р сарын 3-ны өдрийн тушаалаар батлагдсан Хэсгийн байцаагчийн ажлын зааврийн 5.4-т "хэсгийн байцаагч хариуцсан нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон обьект, субьектын судалгаа хийнэ" гэж нэмэлт, өөрчлөлт оруулах;

3. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам (код-703) Судалгаа, хяналтын тоо бүртгэл хөтлөх журамд субьектын судалгаанд бүртгэн авч судлах дараах үндэслэлийг тусгаж нэмэлт өөрчлөлт оруулах. Үүнд:

а. Гэмт хэрэгт холбогдож болзошгүй сэжигтэй хүмүүсийн судалгаанд бүртгэх, судлах үндэслэлийг архи согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэж гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэрэг үйлдсэн хэмээн сэрдэгдсэн, сэжигтэн яллагдагчаар татагдсан, эрүүлжүүлэгдсэн, баривчлагдсан, гэр бүл орчиндоо бүлэг бөөгнөрөл үүсгэдэг, гэмт бүлэглэлд элссэн, урьд өмнө нь гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэрэг үйлдэж ял шийтгэл тохиолдолд;

б. Гэмт хэрэгт холбогдогчдын судалгаанд бүртгэх, судлах үндэслэлийг гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдсэн, холбогдон шалгагдсан, гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэрэг үйлдэж ял шийтгэл эдэлсэн тохиолдолд;

в. Эрэн сурвалжлагдаж буй оргодол, этгээдүүдийн судалгаанд бүртгэх, судлах үндэслэлийг гэмт хэрэг үйлдэж хэрэг, зөрчлийн газраас оргон зайлсан, гэмт хэрэг үйлдэн шалгагдаж байгаад мөрдөн шалгах, зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих, шүүх таслах ажиллагаанаас оргон зайлсан, цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр зэрэг зөрчил гэмт хэрэг шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тухайн этгээдийн эрэн сурвалжлах талаар гаргасан тогтоол, магадлал, шийдвэр гаргасан тохиолдолд;

г. Хорих ял эдлээд суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн, ял хойшлогдсон хүмүүсийг бүртгэх, судлах үндэслэлийг хорих ял эдлэж байсан ялтан хугацааны өмнө шүүхийн магадлангаар, эсхүл хорих ялыг бүрэн эдлэж хугацаа дуусч суллагдсан, шүүхийн шийтгэх тогтоолоор хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн, ял хойшлуулах тухай шүүхийн шийтгэх тогтоолд тухайн этгээдийн нэр дурьдагдсан тохиолдолд;

д. Гэр бүл орчиндоо байнга тааламгүй байдал гаргадаг хүмүүсийн бүртгэх, судлах үндэслэлийг архи согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэж гэр бүл орчиндоо гэмт хэрэг үйлдсэн, гэр орчиндоо гэмт хэрэг үйлдсэн хэмээн сэрдэгдсэн, сэжигтэн яллагдагчаар татагдсан, эрүүлжүүлэгдсэн, баривчлагдсан, урьд өмнө нь гэр бүл орчиндоо гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэрэг үйлдэж ял шийтгэл тохиолдолд;

е. Түр оршин суух, гадаадын болон харъяалалгүй иргэдийг бүртгэх, судлах үндэслэлийг **т**ухайн нутаг дэвсгэрт түр оршин сууж байгаа бүртгэлтэй, эсхүл бүртгэлгүй тохиолдолд мөн гадаадын иргэн болон харъяалалгүй хүн болохыг нотолсон бичиг баримттай, гадаадын иргэн болон харъяалалгүй болохыг нотолсон мэдээлэл, лавлагаа бусад эрх бүхий байгууллагаас ирүүлсэн мэдээ материал ирүүлсэн тохиолдолд;

ё. Насанд хүрээгүй хүмүүсийг уруу татагчдыг бүртгэх, судлах үндэслэлийг урьд өмнө гэмт хэрэг үйлдэхдээ насанд хүрээгүй хүмүүс оролцуулсан, тэдэнд гэмт хэрэг үйлдэхийг зааж сургасан, гэмт хэрэг зөрчил үйлдэхэд нөлөөлсөн, өдөөн хатгасан, ятгасан зэрэг үндэслэл илэрсэн тохиолдолд;

ж. Туслах хүчийг бүртгэх, судлах үндэслэлийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан, зогсоох, илрүүлэх ажилд сайн дурын үндсэн дээр хуулийн этгээд, иргэд хамтран оролцсон тохиолдолд тус тус субьектын судалгаанд авах үндэслэл болох талаар дээр дурьдсан эрх зүйн актанд нэмэлт оруулах зэрэг болно.

Эх сурвалжийн жагсаалт

Хууль тогтоомж
1. Цагдаагийн албаны тухай хууль (Шинэчилсэн найруулга), “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2013. №29;
2. Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2014. №07;
3. Цагдаагийн албаны тухай хууль (Шинэчилсэн найруулга).“Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2017. №08;
4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2015. №28;
5. Прокурорын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2017. №24;
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2002 он, №08;
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (Шинэчилсэн найруулга). “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2017. №24.

Бодлогын бичиг баримт
8. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УИХ-ын тогтоол. 2010.07.15. №48;
9. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030;
10. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай. УИХ-ын тогтоол. 2012.09.18. №37.

Ном сурах бичиг
11. Т.Батсүх Цагдан сэргийлэхийн сэргийлэн хамгаалах алба. УБ., 1976 он;
12. С.Жанцан. Хууль зүйн сэтгэл судлал. УБ хот., 2005 он;
13. Н.Жанцан Гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ. УБ., 1986 он;
14. Ж.Долгорсүрэн, Д.булган Монгол Улсын цагдаагийн эрх зүйн курс. УБ., 2014 он
15. Г.Бямбадорж. Архидан согтуурах явдалтай тэмцэх үйл ажиллагаа, УБ., 2013 он.

Эрдэм шинжилгээний сэтгүүл
16. Цагдаа судлал онол арга зүйн сэтгүүлийн 2018 оны дугаар №1;
17. Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүлийн 2016 оны дугаар №2;
18. Монголын төр эрх зүй сэтгүүлийн 2017 оны дугаар №2;
19. Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүлийн 2016 оны дугаар №2.

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧ БИЕИЙН ХҮЧ ХЭРЭГЛЭХ ОЙЛГОЛТ, СУРГАЛТЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

CONCEPM OF USE OF COMPULSORY BY POLICE OFFICERS AND PROBLEMS OF THEIR TRAINING

Б.Батжав
МУБИС-ийн докторант
Batjav Batsaikhan
Doctoral student at the Mongolian University of Education

Хураангуй: Энэхүү өгүүллээр цагдаагийн биеийн хүч хэрэглэх ойлголтыг авч үзэж, улмаар сургалт, эрх зүйн тулгамдсан асуудлыг гадаад орны туршлагад үндэслэн шийдвэрлэх арга замыг эрэлхийлсэн болно.

Abstract: This article examines the concept of the use of physical force by police officers and looks for ways to solve its educational and legal issues based on foreign experience.

Түлхүүр үгс: Цагдаагийн албаа хаагч, бие хүч, биеийн хүч хэрэглэх, гардан тулаан, крав мага.

Keywords: Police officer, physical force, use of physical force, hand-to-hand combat, krav maga.

Цагдаагийн албаа хаагч биеийн хүч хэрэглэх тухай асуудал нь манай орны хувьд төдийлөн судлагдаагүй сэдэв бөгөөд сүүлийн жилүүдэд нийгмийн эрэлт хэрэгцээ шаардлагаар нарийвчлан судлах шаардлага гарч байна. Өнөөдөр аль ч улс оронд тулгамдаж буй нэг асуудал нь өдөр бүр нэмэгдэж буй дотоод аюулгүй байдал бөгөөд иргэдийн амар тайван байдлыг хангах үүрэгтэй цагдаагийн албаа хаагчид албан үүргээ хэрэгжүүлэхэд өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангахын тулд биеийн хүч хэрэглэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Дэлхийн бусад орны цагдаагийн байгууллага, эрдэмтэн, судлаачид Цагдаагийн албаа хаагч биеийн хүч хэрэглэх чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгаа хийж, энэ төрлийн сургалт, семинар олноор зохион байгуулж байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байна.

Улс орон хөгжихийн хэрээр нийгмийн харилцаа өөрчлөгдөж хууль зүйн орчин шинэчлэгдэж, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал зарим талаараа хүндэрч, гэмт хэрэг, зөрчлийн тоо нэмэгдэж байна. Мөн иргэд цагдаагийн албаа хаагчдад хандах хандлага харилцаа өөрчлөгдөж цагдаагийн албаа хаагчийг үл хүндэтгэх, эрүүл мэнд, эрх чөлөө, амь насанд нь халдах тохиолдол багагүй гарах боллоо. Техник технологийн дэвшил, мэдээллийн цахим сүлжээг ашиглан цагдаагийн албаа хаагчийн хэлсэн үг, гаргасан алдааг дүрсжүүлэн баримтжуулах, олон нийтэд сөрөг мэдээлэл тавих зэрэг олон асуудлууд гарч байгаа нь цагдаагийн албаа хаагчийг бүх үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд мэргэжлийн түвшинд ажиллахыг шаардаж байна. Иймээс дэлхийн зарим орнуудын цагдаагийн албаа хаагч биеийн хүч хэрэглэх сургалт, түүний эрх зүйн

зохицуулалтыг харьцуулан судалж энэхүү өгүүллээр судалгааны үр дүнг толилуулж байна. Энэ өгүүлэлд тусгагдсан материалууд нь цагдаагийн алба хаагч биеийн хүч хэрэглэх асуудалтай холбоотой шийдвэрийг бүрэн гүйцэд баримтжуулаагүй бөгөөд шинжлэх ухааны судалгааны эхний үе шатандаа явж байгаа юм. Өгүүллийн зорилго нь цагдаагийн алба хаагч биеийн хүч хэрэглэх сургалтын агуулга, тактик, зарчим, үндсэн элементүүдийг авч үзэх, уламжлалт бус аргаар шинжлэх ухааны нухацтай хэлэлцүүлгийн эхлэл байх болно.

Биеийн хүч хэрэглэх тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт:

"Биеийн хүч" гэх нэр томъёог монгол үг зүйн талаас нь судалж үзэхэд "Бие" гэсэн үгийг "Хүн амьтны цогц эрхтэн, махбод"[1]гэсэн утгаар тайлбарласан бол "Хүч"[2] гэдэг үгийг "Аливаа юмыг хөдөлгөх"[3] гэсэн утгаар тайлбарласан байна. Дээрх хоёр үгийг харьцуулан дүгнэхэд "Өөрийн бие махбодыг ашиглан аливаа юмыг хөдөлгөх" гэсэн утга санаа илэрхийлэгдэж байна.

Манай орны цагдаагийн байгууллагын түүхэн уламжлалд цагдаагийн алба хаагч биеийн хүч хэрэглэх талаар тусгагдсан байдлыг судлахад биеийн хүч хэрэглэх гэж томьёолоогүй боловч тухайн үед хэрэглэгдэж байсан "Мэх" гэх нэр томьёотой холбоотой "Эрх зүйн зөрчил үйлдсэнтэй холбоотойгоор түүнийг үргэлжлэн гаргахгүй болгох, учирч болзошгүй аюулыг нэмэгдүүлэхгүй зайлуулах зорилготой төрийн захиргааны эрх мэдлийн байгууллагаас хуульд заасан үндэслэлээр хэрэглэж байгаа шууд албадах ажиллагааг захиргааны таслан зогсоох албадлага хэмээн ойлгож болно."[4] гэж тодорхойлоод "Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх ажиллагааг цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх захиргааны таслан зогсоох тусгай албадлага, бусдыг нь таслан зогсоох нийтлэг албадлага гэж үзнэ."[5] гэж тодорхойлсон байна.

Судлаач Д.Дашмягмар "Албаны тусгай бэлтгэлийн хичээлийн хэлбэр, зохион байгуулалт сургалт арга зүйн бүтцийн уялдаа холбоо нь албаны тусгай бэлтгэлийн хичээлийн явцад сонсогчдод бие бялдрын зөв хөгжилт, бие хамгаалах урлагийн хөдөлгөөний шинэ чадвар дадлыг олгоод зогсохгүй эр зоригийн хүмүүжил, бие бялдрын соёлыг эзэмшүүлнэ. Мөн хэрэг зөрчил гаргасан этгээдийг эрэн сурвалжлах ажиллагааны тактик, галт зэвсэг чадварлаг эзэмших, ард иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэнэтийн халдлагаас урьдчилан сэргийлэх арга зүйд суралцуулна."[6] гэсэн нь цагдаагийн алба хаагчийн биеийн хүч хэрэглэх онолын асуудлыг хөндсөн байна. Монгол Улсын Үндсэн Хуулийн 38–р зүйлийн 7–д "Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх"[7] нь засгийн газрын үндсэн бүрэн эрх, гэж заасан байдаг ба Нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах энэхүү үүргийг цагдаагийн алба нь хуульд заасан чиг үүргийнхээ дагуу хэрэгжүүлдэг.

[1] Я.Цэвэл."Монгол хэлний товч тайлбар толь" УБ. 1966. 82-дахь тал.
[2] Мөн тэнд. 751 дэх тал.
[3] Мөн тэнд. 780 дахь тал.
[4] Д. Таванжин. "Монгол Улсын Цагдаагийн эрх зүй" УБ. 2006.186 дахь тал.
[5] Ж. Долгорсүрэн. "Монгол улсын цагдаагийн эрх зүй" УБ. 2000. 248 дахь тал.
[6] Д.Дашмягмар . "Албаны тусгай бэлтгэлжилтийг боловсронгүй болгох арга зүйн зарим асуудал" сэдвээр боловсрол судлалын магистрын зэрэг горилсон дипломын ажил. УБ. 2000.
[7] Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992. 38-р зүйлийн 7-д

Цагдаагийн албаны тухай хуулийн тавдугаар бүлэг "Албадлагын арга хэмжээ хэрэглэх" гэсэн заалтын 47.3. Цагдаагийн алба хаагчийг биеийн хүч, тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх бэлтгэл хангах журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.[8] гэж хуульчилсан ба уг хуулийн 3 дугаар зүйл. "Хуулийн нэр томьёоны тодорхойлолт" гэсэн заалтын 3.1.6. "Биеийн хүч хэрэглэх" гэж цагдаагийн алба хаагч өөрийн бие махбод, мэргэжлийн тусгай бэлтгэлийг ашиглан бусдын хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор биеэр хийх үйлдлийг.[9] гэж тайлбарласан байна. Дээрх хуулийн заалт нь цагдаагийн алба хаагчийг бэлтгэх мэргэжлийн сургалтанд биеийн хүч хэрэглэх сургалт явуулах эрх зүйн үндэс болно. Оросын Холбооны Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 18 дугаар зүйлд "Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг ашиглах эрх" гэсэн зүйлийн 1-т "...Цагдаагийн алба хаагч бие махбодын хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсгийг биечлэн, хэсэг (бүлэг) болгон ашиглахыг холбооны үндсэн хууль тогтоомж, энэ Холбооны хууль болон холбооны бусад хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглах эрхтэй..."[10] гэж заасан нь манай улсын цагдаагийн албаны хуульд заасан "Биеийн хүч" гэх нэр томьёо мөн ижил хуульчилсан байна.

Түүнчлэн, тус хуулийн 18–р зүйлийн 4-т "...Цагдаагийн алба хаагч тусгай сургалтанд хамрагдахаас гадна бие махбодын хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхтэй холбоотой нөхцөлд мэргэжлийн үйл ажиллагаанд тохирсон эсэхийг үе үе шалгаж байх ёстой..."[11], 18–р зүйлийн 5-д "...Цагдаагийн алба хаагчдад зориулсан тусгай сургалтын хөтөлбөрийн агуулгыг дотоод хэргийн салбарын холбооны гүйцэтгэх байгууллага тодорхойлно..."[12] гэсэн заалтууд нь цагдаагийн алба хаагчдад биеийн хүч хэрэглэх сургалтыг тогтмол явуулахаас гадна хүч хэрэглэх тусгай бэлтгэлийг нь тогтмол шалгаж байхаар хуульчилснаас гадна сургалтын хөтөлбөрийн агуулгыг хэн тодорхойлохыг тусгайлан авч үзсэн байна.

Мөн ОХУ-ын гардан тулааны мастер А.А.Кадочников, М.Б.Ингерлейб нарын хамтран боловсруулсан "Специальный армейский рукопашный бой" Система А.А.Кадочникова[13], сурах бичигт "Оросын арми, цагдаагийн гардан тулаан нь бусад бие хамгаалах гардан тулаанаас өөр тусгай загвар юм" гэжээ өөрийн боловсруулсан сургалтын загварыг уг бүтээлээр хүргэсэн байна. Уг бүтээлд А.А.Кадочников гардан тулааны төрлийг доорх байдлаар ангилан авч үзсэн байна.

Хүснэгт 1. Гардан тулааны төрлүүд[14]

Төрөл	Армийн гардан тулаан	Цагдаагийн гардан тулаан	Спортын гардан тулаан
Зориулалт	Гадаад довтолгооноос төр, улсаа хамгаалах	Улс орны дотоод дахь хэв журмыг сахиулах	Спортын шинжтэй байна. Бүх нийтийн

[8] Цагдаагийн албаны тухай хууль УБ. 2017, 47.3-р зүйл.
[9] Мөн тэнд. 3.1.6-р зүйл.
[10] Федеральный закон Российской Федерации от 7 февраля 2011 года № 3-ФЗ "О полиции" Статья 18.
[11] Мөн тэнд. 18-р зүйл: 4 дэх заалт.
[12] Мөн тэнд. 18-р зүйл. 5 дахь заалт.
[13] А.А Кадочников, М.Б. Ингерлейб " Специальный армейский рукопашный бой" Система. А.А. Кадочникова. Ростов – на- Дону. 2005.
[14] Мөн тэнд. 63 дахь тал.

			Бүгдэд хүртээмжтэй Тодорхой харагдахуйц Ухамсартай, аюулгүй байдлыг хангасан
Аюултай нөхцлийн шатлал	Хүний амь насанд аюул учруулна.	Хүний амь насанд аюул учруулдаггүй боловч зарим үед аюул учруулах нөхцөл бий болдог.	Хүний амь насанд аюул учруулдаггүй
Хязгаарлах нөхцөл ба удирдамж	ОХУ – ын цэргийн номлол. ОХУ – ын БХЯ – ны сайдын тушаал цэргийн стратеги тактик	ОХУ –ын Эрүүгийн хууль, УЕП –оос хяналт тавих, холбогдох хууль зүйн актууд.	Спортын төрлийн дүрэм, журам
Байлдааны ажиллагаанд хүрэх зорилго	Ямарч үнээр хамаагүй байлдааны даалгаврыг биелүүлэх	Хуулийн дагуу гэмт этгээдийг баривчлах	Спортын ялалтанд хүрэх

Гардан тулааны тусгай загвар болох "ОХУ-ын зэвсэггүй тэмцэх загвар" нь өөрийнхөө аюулгүй байдлыг хангах, иргэдийн болон нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах, биомеханик, анатоми, физиологи, сэтгэл зүйн шинжлэх ухааны талаарх цогц мэдлэг дээр тулгуурласан хүний оршин тогтнох тусгай загвар юм.[15] Өөрөөр хэлбэл хүнд хэцүү байдлаас гарах арга замыг хайж олох бие махбодь, сэтгэл зүйгээ бэлтгэх тусгай сургалтыг /Тусгай модуль/ заадаг.[16] гэжээ. Дээрх баримтуудыг нэгтгэн дүгнэж үзэхэд цагдаагийн алба хаагч биеийн хүч хэрэглэх сургалт нь спортын гардан тулааны сургалт биш цагдаагийн мэргэжлийн тусгай сургалт болох нь нотлогдож байна.

Англи улс орчин үед төрөлжүүлж нэгтгэсэн эрүүгийн хуульгүй цөөн орны нэг бөгөөд эрүүгийн эрх зүйн эх сурвалжид парламентаас баталсан хууль статус, шүүхийн прецедент жишиг хамаардаг. Хэдий гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлыг эрүүгийн эрх зүйн онол, шүүхийн практикт тулгуурлан авч үздэг хэдий ч 1967 онд баталсан "Эрүүгийн эрх зүйн тухай" хуулийн 3 дугаар зүйлд "...Аливаа хүн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохын тулд гэмт хэрэгтэн болон сэжигтнийг баривчлах, баривчлахад туслахын тулд бололцоотой хэмжээнд хүч хэрэглэж болно..." гэж гэмт хэрэгтнийг баривчлах саатуулах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуульчилж өгчээ.[17]

Америкийн Нэгдсэн Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоо нь Холбооны эрүүгийн загвар хууль, муж улсуудын Эрүүгийн хууль, холбоонд үйлчилдэг бусад хуулиас бүрддэг. Америкийн Нэгдсэн Улсын Холбооны эрүүгийн хууль нь жинхэнэ биет хуулийн шинж чанаргүй, зөвхөн шинжлэх ухааны зөвлөмжийн шинж чанартай эрх зүйн актууд байдаг. Иймээс Нью–Йорк, Техас муж улсуудын Эрүүгийн хуулийг төлөөлүүлэн судаллаа.

[15] Юриг Серебрянский "Спецподготовка и рукопашный бой" 2006.
[16] http://spezpodgotovka.ru/ сайтад нийтлэгдсэн.
[17] Л.Бат-Очир "Гэмт этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах үйлдэл: онол, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал" хууль зүйн докторын диссертац. УБ. 2019. 130 дахь тал.

1909 оны Нью-Йорк муж улсын Эрүүгийн хуулийн 35.30 дугаар зүйлд "...Хэрэв нийгмийн хэв журам сахиулж буй цагдаагийн ажилтан болон бусад албан тушаалтан гэмт этгээдийг баривчлах явцад хүч хэрэглэсэн нь баривчлах үеийн нөхцөл байдалд нийцсэн, зайлшгүй шаардлагатай болсон бол хууль ёсны гэж үзнэ..." гэж тодорхойлолт өгсний зэрэгцээ баривчлах ажиллагаанд тавигдах шаардлага, хэр хэмжээ үүсэх үр дагаврыг нарийвчлан тусгажээ.

Техас муж улсын Эрүүгийн хуулийн "Эрүүгийн хуулийн нийтлэг зарчим" гэсэн 2 дугаар хэсгийн "Эрүүгийн хариуцлагыг үгүйсгэх, зөвтгөх" гэсэн 4 дүгээр бүлгийн 9.51 дүгээр зүйлд гэмт этгээдийг баривчлах болон нэгжих явцад эсэргүүцсэн тохиолдолд хүч хэрэглэх, 9.52 дугаар зүйлд саатуулагдсан этгээд оргон зайлахыг таслан зогсоох, 9.53 дугаар зүйлд хорих газар аюулгүй байдлыг сахиулах асуудлыг хуульчилжээ. 9.51 дүгээр зүйлд "...Хууль сахиулах байгууллагын ажилтан эсвэл бусад этгээд хууль сахиулах ажилтны даалгавраар баривчлах, нэгжих ажиллагааг явуулах эсвэл баривчилсны дараа оргон зугтахыг таслан зогсоох зорилгоор бусдад хүч хэрэглэсэн бөгөөд ийнхүү хүч хэрэглэсэн нь тухайн нөхцөлд зайлшгүй байсан, баривчлах нэгжих ажиллагаа явуулахад тавигддаг шаардлагад нийцсэн бол хууль ёсны гэж үзнэ..." гэж заасан байна.[18] АНУ-ын цагдаагийн алба хаагч биеийн хүч хэрэглэх сургалтын шинэ загварыг, Хууль сахиулах байгууллагын ахмад ажилтан, дэслэгч, тулааны урлагийн чиглэлээр мэргэшсэн сургагч багш Кевин Диллон (Рет) "LOCKUP" гэсэн загвар боловсруулсан бөгөөд одоогоор Коннектикут муж улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт бүхий (Бие хамгаалах тактик) системийг АНУ-ын 18 муж болон 4 улсад цагдаагийн алба хаагч биеийн хүч хэрэглэх сургалтыг явуулж байна.[19] гэжээ. АНУ-ын цагдаагийн албаны эрх зүйн актанд "Цагдаагийн алба хаагч хүч хэрэглэх" гэдэг нь цагдаагийн ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй эсэргүүцсэн үйлдэлд, сэтгэл зүйд нь нөлөөлөх, дарамт, шахалт үзүүлэхийг хэлнэ."[20] гэж тодорхойлоод "Хүч" нь биеийн хүч, химийн хүч, цохилтын хүч, цахилгаан төхөөрөмжийн хүч, галт зэвсгийн хүчний нийлбэр юм.[21] гэж тодорхойлсон байна.

Мөн цагдаагийн алба хаагч хүч хэрэглэх тусгай бэлтгэлийн төрлийг доорх байдлаар ангилан авч үзсэн байна.

- "Биеийн хүч" гэж гар, хөлөөрөө өшиглөх, цохих, биеэрээ хийж болох бусад аргуудыг,
- "Химийн хүч" гэж нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч бодис болон химийн бодис ашиглахыг,
- "Цохилтын хүч" гэж резинэн бороохой болон бусад төрлийн цохилтын хэрэгслийг,
- "Цахилгаан төхөөрөмжийн хүч" гэж цахилгаан бороохой, ухаан алдуулдаг буу, цахилгаан зэвсгүүд,

[18] Мөн тэнд.131 дахь тал.
[19] https://www.policecombat.com/sample-page-2/
[20] Police use of force in America 2011.1 тал.(International Association of Chiefs of Police)
[21] Мөн тэнд 1 дэх тал.

- "Галт зэвсгийн хүч" гэж төрөл бүрийн галт зэвсгүүдийг хэрэглэхийг ойлгоно.[22] гэж авч үзсэн нь цагдаагийн алба хаагч хүч хэрэглэх аргуудыг цогцоор нь оновчтой зөв авч үзсэн байгааг манай орны цагдаагийн албан хэрэг, сургалтанд авч хэрэглэх боломжтой гэж судлаачийн хувьд үзэж байна.

Сан-Марино Улсын Эрүүгийн хуулийн "Зөвтгөж болох нөхцөл байдал" гэсэн дөрөвдүгээр бүлгийн 43 дугаар зүйлд "...Албан тушаалтан өөрийн албан тушаалын үүргээ биелүүлэх, хэрэгжүүлэх явцад хууль ёсны үйл ажиллагааг нь эсэргүүцсэн, саад учруулсан тохиолдолд биеийн хүч хэрэглэсэн бол ял оногдуулахгүй. Энэ нөхцөлд зөвхөн хуульд шууд заасан тохиолдолд зэвсэг хэрэглэж болно.."[23] гэж хууль ёсны дагуу биеийн хүч хэрэглэх үйлдлийг заасан байна.

Үүнээс гадна цэрэг, цагдаагийн алба хаагчдад зориулсан "Krav Maga"[24] гэх тусгай загварыг Израиль улсын иргэн Ими Лихтенфельд гэгч цэргийн мэргэжилтэн 1955 онд боловсруулж өнөөдөр дэлхийн 98 оронд салбартай олон улсын байгууллага болон үйл ажиллагааг явуулж байна. "Крав Мага" гэж бүх төрлийн хүчирхийлэл, дайралтаас хэрхэн урьдчилан сэргийлэх, хэрхэн тэсч үлдэх, давах талаар заадаг практик болон тактикийн систем юм.

Крав Мага нь аливаа дайралтаас өөрийгөө хамгаалах болон тулалдах чадвар, мөн түүнчлэн бусдыг хамгаалах чадварыг өвөрмөц цогц сургалт, төгс арга замаар эзэмшүүлдэг. Крав Мага бол өвөрмөц, логик ухагдахуунтай хэвтээ систем юм. Хүн өөрийн төрөлх байдлаараа болон зөн совингийн дагуу гүйцэтгэж сурах, дадал зуршил болгоход хялбар байдаг. Үүнийг дарамттай /стресстэй/ нөхцөлд бодит байдлаар ашиглах боломжтой. Харин Крав Магагаас салангид авч үзэх боломжгүй, чухал нэг хэсэг нь, түүний сургалтын явц, арга зүй, сургалтын арга замууд юм.[25] гэжээ.

НҮБ–ын наймдугаар их хурлаар батлан гаргасан "Хууль сахиулах албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль"-ийн "Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчмууд" гэсэн заалтад "Мэргэшил, бэлтгэх ба зөвлөгөө" гэсэн хэсгийн 19-д "Засгийн газар болон хууль хамгаалах байгууллага, хэв журам сахиулах үүрэг бүхий бүх албан тушаалтанг хүч хэрэглэх үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, хүч хэрэглэх тусгай бэлтгэлийг нь шалгах нөхцлөөр хангана. Хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг хэрэглэх талаар тусгай сургалтанд суралцаж төгссөний дараа галт зэвсгийг биедээ зохих зөвшөөрлийн дагуу авч явах ёстой."[26] гэж заасан нь олон улсын байгууллагаас, улс орон болгон өөрийн цагдаагийн алба хаагчдыг биеийн хүч хэрэглэх сургалтанд хамруулж сургаж байх эрх зүйн үндсийг дээрх хуулиараа баталгаажуулжээ. Монголын нээлттэй нийгмийн хүрээлэнгээс эрхлэн гаргасан "Орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа" номонд "Хүний эрхтэй холбогдох хууль дүрмийн дагуу биеэ авч явж,

[22] Joel H.Garner,Christopher D.MaxwelI."Use of Force by Police" 68 дахь тал.
[23] Л.Бат-Очир "Гэмт этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах үйлдэл: онол, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал" хууль зүйн докторын диссертац.УБ. 2019. 130 дахь тал.
[24] http://kravmaga-ikmf.com/
[25] Б.Батжав "Иргэний крав мага" сургагч багшийн гарын авлага.УБ. 2019. 26 дахь тал.
[26] Хүний эрхийн дээд комиссарын газар Хүний эрхийн төв. "Хүний эрх ба хууль сахиулах нь" УБ. 2005. 256 дахь тал.

үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд цагдаагийн ажилтнууд тактикийн тусгай ур чадварыг хөгжүүлэн, эзэмших хэрэгтэй болно”[27] гэсэн баримтуудаас үзэхэд цагдаагийн алба хаагч нь зөвхөн биеийн хүч хэрэглэх чадвартай байхаас гадна хуульд заасан бусад хүч хэрэглэх мэдлэг, чадвар дадалтай, тактиктай байх асуудал давхар хөндөгдөж байна. Дээрх судалгаанаас цагдаагийн алба хаагчдыг бэлтгэх, мэргэжил олгох сургалтанд биеийн хүч хэрэглэх асуудал нь манай орны төдийгүй гадаадын улс орнуудын боловсролын тогтолцоо, сургалтын үйл ажиллагааны практикт тусгайлан авч үзсээр иржээ.

Биеийн хүч хэрэглэх онцлог:

Цагдаагийн алба хаагчийн бүхий л үйл ажиллагаа иргэдтэй харьцах харилцаан дээр үндэслэсэн байдаг. Тиймээс цагдаагийн алба хаагч нь харилцааны үе шатыг ойлгож, харилцааны дадалтай байх нь цагдаагийн ажлыг мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай нөхцөл юм. Цагдаагийн алба хаагчийн гүйцэтгэх үүргийн гол хэсэг нь зөрчлийг шийдвэрлэх явдал эзэлдэг. Хоёр ба түүнээс дээш талууд хоорондоо зөрчилдөх, жишээ нь: Хөршүүд хоорондоо маргалдан хэрэлдэх, гэр бүлийн маргаан эсвэл гудамжны зодоон гэх мэт нөхцөл байдалд оролцсон талуудын сэтгэл санаа ихээхэн хөдөлсний улмаас байдлыг улам хүндрүүлж зөрчил улам эрдрээ төвөгтэй болдог. Ийм нөхцөл байдлыг зөв шийдвэрлэж, зохицуулж чадахгүй бол зөрчилдөгч талууд цагдаа руу халдах, довтлох магадлал өндөртэй байдаг. Мөн бие биедээ хүч хэрэглэх эрсдэл бий болдог. Ийм төрлийн бүх асуудлыг үргэлж амжилттай шийдвэрлэх боломжгүй юм.

Заримдаа эдгээр бэрхшээлт асуудлыг шийдвэрлэхэд цагдаагийн алба хаагчаас хуульд заасан биеийн хүч хэрэглэхээс өөр аргагүй байдалд ордог. Дээрх нөхцөл байдлаас эхлээд хүнд хэцүү асуудлуудтай байнга нүүр тулан үүргээ гүйцэтгэх шаардлага цагдаагийн алба хаагчдад үүсдэг. Жишээ нь: Хулгайн гэмт хэрэг, танхайн гэмт хэрэг, хүн амины гэмт хэрэг гэх мэт хэрэг, зөрчилтэй шууд тулгарахад уг гэмт хэргийг үйлдэж буй хүн (бүлэг) нь цагдааг эсэргүүцэх, галт зэвсэг, бусад зүйлийг зэвсгийн чанартайгаар ашиглан эсэргүүцэх явдал, практикт гарч байна. Энэ нь цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, үндсэн чиг үүргээ биелүүлэхэд өөрийгөө болон бусдыг аюултай нөхцөл байдлаас аврах, хамгаалах, гарч болзошгүй аюул заналхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор хуульд заасан хүч хэрэглэх, түүний дотор биеийн хүч хэрэглэх сургалтанд тогтмол хамрагдаж өөрийн хийгээд иргэдийн аюулгүй байдлыг хангах шаардлага гардаг ба биеийн хүч хэрэглэхээс өөр аргаар таслан зогсоох, урьдчилан сэргийлэх боломжгүй тохиолдол гардаг. Хүний эрхийн байгууллагаас “Хэрэв цагдаагийн алба хаагч нь тусгай бэлтгэлд бэлтгэгдээгүй байж гэмт этгээдтэй барьцалдаж авах, хөөж барих, ноцолдох, хол замд гүйх, саадыг давах, өндөрт авирах, бусдыг аврах үед та өөрөө бэртэж гэмтэхээс эхлээд бусдыг аварч чадахгүйд хүрч болзошгүй. Та аль болох бие хамгаалах болон ямар нэгэн спортоор байнга хичээллэх цагийг өөртөө гаргадаг байх хэрэгтэй. Мэргэшсэн цагдаагийн ажилтан байж гэмээнэ ард олонд тусламж үзүүлэх найдвар нэмэгдэж, хүмүүс ч таныг

[27] ЦЕГ, “Орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа” УБ. 2004. 69 дэх тал.

төдийгүй цагдаагийн албаа хаагчдыг хүндэтгэж харьцах болно гэдгийг ямагт сана."[28] гэж бичсэн нь биеийн хүч хэрэглэх мэдлэг чадвартай байх ямар ач холбогдолтой болохыг давхар нотолж байна. Бусад улсын цагдаагийн байгууллагын туршлагаас үзэхэд иргэдийнхээ амар тайван байдлыг хангах, хууль дүрмээр тогтоосон дэг журмыг мөрдүүлэхэд биеийн хүч хэрэглэх сургалт чухал ач холбогдолтой гэж үзэн цагдаагийн сургалтын үйл ажиллагааны ихэнх хэсгийг чиглүүлсэн байна. Цагдаагийн албаа хаагч нь хуулиар хүлээсэн ажил, үүргээ хэрэгжүүлэхэд зайлшгүй биеийн хүч хэрэглэх мэдлэг, ур чадвар эзэмших шаардлагатай байдаг нь олон баримтаас харагдаж байна.

Манай орны цагдаагийн албаа хаагч гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг гүйцэтгэхэд цагдаагийн албаа хаагч ямар нэгэн асуудалд орсон, агсам согтуу, мансуурсан, бухимдсан, эрсдэл учруулж болзошгүй хүмүүстэй тогтмол харьцдаг учраас цагдаагийн албаа хаагч өөрөө эрсдэл бүхий орчин, нөхцөлд үүрэг гүйцэтгэж байна.

Тухайлбал: ЦЕГ-ын Аюулгүй байдлын хэлтсээс 2020 оны 02-р сард гаргасан цагдаа, дотоодын цэргийн албаа хаагч, ажилтнаас халдлагад өртсөн, бэртэж гэмтсэн сүүлийн 3 жилийн судалгааг гаргасан байна. Үүнд: цагдаа, дотоодын цэргийн 34 нэгжийн 408 албаа хаагч халдлагад өртсөн гэж бүртгэгдсэнээс албан үүргээ гүйцэтгэх явцдаа 394 албаа хаагч, бусад байдлаар буюу албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдолгүй байдлаар 14 албаа хаагч халдлагад өртсөн, түүнээс офицер 132, ахлагч 274, энгийн ажилтан 2, эрэгтэй 383, эмэгтэй 25 албаа хаагчид халдлагад өртсөн байна. [29] гэсэн дүн мэдээ нь цагдаагийн албаа хаагчид ямар эрсдэл бүхий орчинд ажилладаг нь харагдаж байна.

Энэ хийж буй ажил нь цагдаагийн албаа хаагчийг өөрийг нь гэмт хэрэг, зөрчилд холбогдох нөхцлийг бас бүрдүүлэх онцлогтой гэж үзэж болно. Биеийн хүч хэрэглэх нь цагдаагийн албаа хаагчийн мэргэжлийн сургалтын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд албаа хаагчдыг сургаж, хүмүүжүүлэх ажлын салшгүй чухал хэсэг юмаа. Иймд уг сургалтыг явуулах багшлах бүрэлдэхүүн нь цагдаагийн ажил мэргэжлээр практикт албан үүрэг гүйцэтгэж байсан ажлын туршлагатай, биеийн хүч хэрэглэх эрх зүйн болон онолын мэдлэг, биеийн хүч хэрэглэх аргуудыг өөрийн биеэр хийж үзүүлэх чадвартай, сурган заах арга зүйн мэдлэг эзэмшсэн багш уг хичээлийг заах ёстой нь судалгааны явц ажиглагдаж байна. Мөн сургалтанд хамрагдаж буй сонсогчдоос маш нарийн дэг журам, сахилга бат, зохион байгуулалт, сэтгэл зүйн бэлтгэл шаарддаг онцлогтойгоос гадна сургалтыг бодит нөхцөл байдалд ойртуулсан орчинд явуулах шаардлага тавигддаг ба тусгай хэрэглэгдэхүүнд тулгуурлан мэдлэг, чадвар дадал олгох бөгөөд бэлтгэл сургалтын 80%-ийг дадлагын хичээл эзэлдэг нь цагдаагийн албаа хаагч биеийн хүч хэрэглэх сургалтын онцлог, мөн чанар юм. Эдгээр онцлог шалгуур нь хувь хүнийг сургаж дадлагажуулахаас гадна ёс зүйг олгож байдгаараа бусад хичээл сургалтаас илүү практик ач холбогдолтой байдаг. Дээрх онолын ойлголтууд, онцлогийг нэгтгэн дүгнээд доорх тодорхойлолтыг дэвшүүлж байна.

[28] Монголын Эмнести Интернэшил. "Хүч ба галт зэвсэг хэрэглэх нь" УБ. 2007. 66 дахь тал.
[29] ЦЕГ-ын 2020.02.10№3/51 дүгээр албан бичиг

“Цагдаагийн алба хаагчийн биеийн хүч хэрэглэх” гэдэг нь цагдаагийн алба хаагч өөрийн сэтгэл зүй, бие махбодыг ашиглаж тухайн эсэргүүцсэн үйлдлийг таслан зогсоож, хяналтандаа авах, өчих, баривчлах, хамгаалах, сэтгэл зүйд нь нөлөөлөх аргуудын нийлбэр гэж үзэж тодорхойлж болохоор байна. Тодруулж хэлбэл, цагдаагийн алба хаагч хууль сахиулах үүргээ биелүүлэх буюу иргэдийг аврах хамгаалахад цагдаагийн алба хаагчаас биемахбодын болон сэтгэл зүйн хувьд ямар хурд, хүч, авхаалж, самбаа, заль мэх, тактик шаардагдахыг судалж түүнд тулгуурлан тусгай төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхийг ойлгоно.

Дүгнэлт, санал

Дээрх баримтуудыг нэгтгэн дүгнэж үзэхэд дэлхийн улс орны цагдаагийн албаны тухай хууль тогтоомж болон бусад эрх зүйн баримт бичгүүдэд “биеийн хүч ” гэх нэр томъёо хэрэглэгдэж буй нь ажиглагдаж байна. Мөн цагдаагийн алба хаагчийн биеийн хүч хэрэглэх сургалт бэлтгэлийн онол, арга зүй бусад тулааны спортын төрлүүдээс өөр тусгай загвар болохыг бусад орны цагдаагийн мэргэжил олгох сургалт, сургалтын гарын авлага, судалгаанаас нотлогдож байна.

Иймд дараах саналыг дэвшүүлж байна:

1. Монгол Улсын цагдаагийн албаны биеийн хүч хэрэглэх тусгай загварыг “Бие хамгаалах тактик” гэж нэрлэн, шинэ сургалтын хөтөлбөр, стандарт боловсруулж нэвтрүүлэх;

2. Цагдаагийн биеийн хүч хэрэглэх сургалтыг явуулах багшийг сургах, чадваржуулах хөтөлбөр хэрэгжүүлэх;

3. Цагдаагийн албаны тухай хуулийн 5 бүлгийн “Албадлага хэрэглэх” гэсэн заалтыг “Хүч хэрэглэх” гэж өөрчлөх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.

Эх сурвалжийн жагсаалт

Нэг: Хууль, ном, гарын авлага, судалгааны тайлан

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992;
2. Цагдаагийн албаны тухай хууль. 2017;
3. ХСИС, Цагдаа судлалын төв, Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэтгэл судалгааны тайлан, санал, зөвлөмж. уб. 2013;
4. ЦЕГ, Орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа. уб. 2004;
5. Монголын Эмнести Интернэшил. “Хүч ба галт зэвсэг хэрэглэх нь” уб. 2007;
6. Б.Батжав. Цагдаагийн алба хаагчийн биеийн хүч хэрэглэх тусгай бэлтгэлийн сургалтын онолын үндэс. уб. 2014;
7. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. уб. 1966;
8. Д. Таванжин “Монгол Улсын Цагдаагийн эрх зүй” уб. 2006;
9. Ж. Долгорсүрэн “Монгол Улсын цагдаагийн эрх зүй” уб. 2000;
10. Б.Батжав “Иргэний Крав мага” сургагч багшийн гарын авлага. уб. 2019;
11. Хүний эрхийн дээд комиссарын газар, Хүний эрхийн төв. “Хүний эрх ба хууль сахиулах нь”, уб. 2005.

Хоёр: Орос хэлээрх хууль, сурах бичиг, гарын авлага

1. Федеральный закон Российской Федерации от 7 февраля 2011 года № 3-ФЗ "О полиции;

2. А.А Кадочников, М.Б. Ингерлейб “Специальный армейский рукопашный бой” Система А.А. Кадочникова. Ростов – на- Дону.2005;
3. Юриг Серебрянский, “Спецподготовка и рукопашный бой” 2006.

Гурав: Докторын диссертаци, магистрын дипломын ажил
1. С. Хаянгарваа “Цэрэг, цагдаагийн сургуулийн бие хамгаалах сургалтыг хөгжүүлэх зарим боломжийг судалсан нь диссертац” уб. 2011;
2. Л.Бат-Очир, “Гэмт этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах үйлдэл: онол, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” сэдэвт хууль зүйн докторын диссертаци. уб. 2019;
3. Д.Дашмягмар. ”Албаны тусгай бэлтгэлжилтийг боловсронгүй болгох арга зүйн зарим асуудал” сэдвээр боловсрол судлалын магистрын зэрэг горилсон дипломын ажил. уб . 2000;
4. С.Хасбаатар “Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагчаас тусгай мэх хэрэглэснээс үүсэх хууль, зүйн үр дагавар” магистрын дипломын ажил. уб. 2008.

Дөрөв: Англи хэлээрх материал, сайт
1. Joel H.Garner, Christopher D.MaxwelI. “Use of Force by Police”;
2. Police use of force in America 2011. (International Association of Chiefs of Police)
3. http://kravmaga-ikmf.com/
4. https://www.policecombat.com/sample-page-2/
5. http://spezpodgotovka.ru/

УЛСЫН ХИЛ, ХИЛ ОРЧМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ЭДИЙН ЗАСГИЙН АРГААР ХАНГАХ АРГА ЗАМ

THE ECONOMICAL WAYS TO IMPROVE BORDER REGION'S SECURITY

М.Баярсайхан
Дотоод хэргийн их сургуулийн Ахисан шатны боловсролын сургуулийн хөтөлбөрийн менежер, хил судлалын ухааны докторант, дэд хурандаа
Bayarsaikhan M.
Lieutenant colonel. Program Manager, Graduate school,
University of Internal Affairs. Doctoral candidate in Science of Border Studies

Хураангуй: Монгол Улсын хилийн халдашгүй, дархан байдлын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудалд шинжилгээ хийж, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийг эдийн засгийн аргаар хөгжүүлэх арга замыг тодорхойлох.

Abstract: Analyzing current status of inviolability and invulnerability of Mongolian border and its challenges, determining ways to economically develop the state border and border area.

Түлхүүр үгс: Үндэсний аюулгүй байдал, Хилийн аюулгүй байдал, Улсын хил хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал.

Keywords: National security, border security, security of the state border and its area.

Удиртгал

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил хамгаалалт нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс, үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг, амин чухал асуудал болно.

Аливаа улс орны хилийн бодлого нь түүний Үндэсний аюулгүй байдлыг хангах ерөнхий тогтолцоонд, хуулийн үндсэн дээр явагддаг. Хилийн аюулгүй байдлыг хангахын тулд түүхийн бүхий л цаг хугацаанд төрөөс олон талт арга хэмжээг авсаар ирсэн. Үүний нэгэн илрэл "Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого"-ыг 2002 онд УИХ-аас батлан гаргасан явдал юм.

Энэхүү баримт бичигт хил орчмын нутаг дэвсгэрийн эдийн засгийн хөгжил нь хилийн аюулгүй байдлын салшгүй нэг хэсэг болохыг тодотгон гаргаж ирсэн байдаг.

Хилийн орчмын нутгийг хөгжүүлж томоохон хот, суурин газрыг бий болгох, улмаар орон нутгийн хамгаалалт, оролцоо, дэмжлэгт суурилсан хил хамгаалалт, батлан хамгаалалтын цогцолбор арга хэмжээ авч хэрэгжүүлэх асуудал чухлаар тавигдаж байна.

Хүн амын төвлөрлийг улсын хил орчмын нутаг дэвсгэр, хилийн сумдад бий болгох нь орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах, зэвсэгт хүчний нэгдмэл тогтолцоог төлөвшүүлэх, улсын хилийн хамгаалалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

"Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого"-ыг 2002 онд УИХ-аас баталсан. Тус баримт бичигт хил орчмын нутаг дэвсгэрийн эдийн засгийн хөгжлийг хангах нь хилийн талаар баримтлах бодлогын нэг тулгуур зарчим болохыг тогтоож, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан хил орчмын нутаг дэвсгэрийг нийгэм, эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авч хөгжүүлнэ гэж заасан.[1]

Мөн "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д хил орчмын нутгийн эдийн засгийг хөгжүүлэхдээ үндэсний нэгдмэл ашиг сонирхлыг дээдэлж, төрийн нэгдсэн бодлогод захирагдах тухай тодорхойлсон.

УИХ-аас баталсан 2002 онд "Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого"-д хил орчмын нутаг дэвсгэрийн эдийн засгийн хөгжлийг хангах нь хилийн талаар баримтлах бодлогын нэг тулгуур зарчим болохыг тогтоож, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан хил орчмын нутаг дэвсгэрийг нийгэм, эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авч хөгжүүлнэ гэж заасан.[2]

Нэг. Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн эдийн засгийн хөгжил ба хилийн аюулгүй байдал

Монголын тусгаар тогтнол, газар нутаг, улсын хилийн бүрэн бүтэн байдал нь үндэсний аюулгүй байдлыг хангах ажиллагааны гол цөм бөгөөд Монгол Улсын иргэд, нийт монголчуудын бахархал, олон зууныг дамжин үргэлжилсэн тэмцлийн үнэ цэнэ, үндэсний үнэт зүйл мөн.

Тиймээс аливаа улс орны тусгаар тогтносон шинжийг илэрхийлж байгаа гол үзүүлэлт бол "...нутаг дэвсгэр..." байх нь тодорхой байгаа бөгөөд үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал чухал байр суурь эзэлж байгаа нь харагдаж байна.

Монгол Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь бүхэлдээ хилийн аюулгүй байдал гэсэн ухагдахуунд хамаарч Үндэсний аюулгүй байдлын хүрээнд багтаж байдаг зүй тогтолтой цогц ойлголт юм.

Хил орчмын нутаг дэвсгэрт Хилийн тухай хуулийн дагуу хилийн 14 аймгийн 67 сум хамаарах бөгөөд үүний 30 нь БНХАУ-тай, 35 нь ОХУ-тай, Дорнод аймгийн Чулуунхороот, Баян-Өлгий аймгийн Улаанхус сум БНХАУ болон ОХУ-тай зэрэг хиллэж байна.

Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн эдийн засгийг хөгжүүлэх нь:

1. Тус бүс нутагт амьдарч буй өрх гэр, иргэн амьжиргаагаа дээшлүүлэх, ашиг олох, шунахайн зорилготойгоор улсын дархан хилийг зөрчиж, хилийн хориотой худалдаа эрхэлж буй хилийн зөрчлийг иргэдийн амьдрал ахуйг сайжруулах байдлаар таслан зогсоох;
2. Хил орчмын бүс нутаг дах эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг бий болгож, шилжих хөдөлгөөнийг бууруулах;

[1] "Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого"-ийн нэгдүгээр бүлгийн 1.4 дэх хэсэг, хоёрдугаар бүлгийн 2.2 дахь хэсэг.
[2] "Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого"-ийн нэгдүгээр бүлгийн 1.4 дэх хэсэг, хоёрдугаар бүлгийн 2.2 дахь хэсэг.

3. Эдийн засгийн хөгжлийг бий болгох замаар хилийн сумд, хилийн бүс, зурвас дахь иргэн, ААН-ийн төвлөрлийг нэмэгдүүлэх;
4. Ирээдүйд үүсч болзошгүй гадаад аюул заналаас урьдчилан сэргийлэх, иргэд болон чадварлаг орон нутгийн засаг захиргааны дэмжлэг, хамтын ажиллагаан дээр суурилсан хил хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх *зэрэг ач холбогдолтой юм.*

Хилийн сумдын хүн амын тоо бага, нягтаршил муу байгаа нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдалтай шууд холбоотой асуудал юм. Хилийн 67 сумын хүн амын нягтрал нь бусад сумд, хот, суурин газраас харьцангуй бага байгаа бөгөөд нягтралыг нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд (339 сум, 9 дүүрэг) хэмжээнд байр эзлүүлж үзвэл хилийн 24 сум нь 300-343-р байранд, 22 сум нь 200-300-р байранд, 18 сум нь 100-200-р байранд, 5 сум нь 1-100-р байранд хамаарч байна (Зураг-1).

Зураг 1. Хилийн сумдын нягтрал, хүн/км^2, 2018 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хилийн 37 сумын нягтрал 0.5 хүн/км^2-ээс бага, 19 сумынх 1 хүн/км^2-ээс бага, 8 сумынх 2.0 хүн/км^2-ээс бага, 5 сумынх 2.0 хүн/км-ээс их байна. Хүн амын нягтрал хамгийн өндөр хилийн сумд нь Увс аймгийн Тэс сум, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум, Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Өмнөговь аймгийн Ханбогд сумдууд байгаа бол хамгийн бага нь Баян-Өлгий, Дорнод аймгуудад харьяалагдаж байна.

Хилийн сумдын хүн амын тоо бусад бүс нутгийн сумдтай харьцуулахад харьцангуй бага байгааг Зураг-2 харуулж байна.

Зураг 2. Хүн амын суурьшил, сумаар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллого

Баруун бүсийн Баян-Өлгий, Ховд Төвийн бүсийн Өмнөговь аймгийн Ханбогд, Номгон, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Дорнод аймгийн Дашбалбар, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Онгон сумдын хүн ам 4000-10000,

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хүн ам 14,473[3], бусад хилийн сумдын хүн 4000-аас бага хүн амтай байна. Ялангуяа өмнөд хилийн 4, хойд хилийн 4 сумын хүн ам 2000-аас бага хүн амтай байна.

Дотоодоос үйлдэгдэж буй хилийн зөрчил[4], түүний шалтгаан: Хилийн сумдын хүн ам цөөн, төвөөс алслагдсан, тээврийн зардал өндөр, төвөөс ирж байгаа бараа бүтээгдэхүүний үнэ өндөр, өөрсдийнх нь зарж, борлуулж байгаа мал, түүхий эд, материалын үнэ доогуур байгаагаас дотоодоос шалтгаалсан, хил орчмын иргэдийн оролцсон

хилийн зөрчил буурахгүй байна. Нутгийн иргэдийн оролцож буй хилийн зөрчил нь хилийн хууль бус худалдаа, зохион байгуулалттай хил дамнасан малын хулгай, хар тамхины худалдаа, соёлын үнэт зүйлс, ургамал, амьтан, ашигт малтмалын түүхий эдийг хууль бусаар хил гаргах зэрэг байна.

Монгол Улсын бүх нутаг дэвсгэрт малчид жилийн 4 улиралд хилийн бүс, зурваст нутагладаг, малчин иргэдийн орлого хангалтгүй, 2 хөршид малын үнэ өндөр байгаа нь дотоодоос малын хулгайг зохион байгуулалттайгаар хийх үндэс болж байна. Нөгөө талаас зарим малчид "малын хулгай" нэрийн доор хилийн хууль бус худалдааг зохион байгуулж байна. Эдгээр зөрчлүүд нь хил орчмын ард иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулж, нутгаа орхин, шилжин нүүх нэг шалтгаан болж байгааг дурдах шаардлагатай.

Зарим хилийн бүс нутагт шинээр суурьшлын бүс үүсэх, уул уурхайн орд газар нээгдэх, экспортод чиглэсэн авто замын тээвэрлэлт өсөхтэй зэрэгцэн хилийн зөрчил нэмэгдэх хандлагатай байна.

Жишээлбэл: Гашуунсухайт, Шивээхүрэн, Булган, Баянхошуу, Ханги, Бичигтийн хилийн боомтоор Монгол Улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох нефьт, зэсийн баяжмал, нүүрсийг тээвэрлэх зорилгоор 14500 орчим том оврын тээврийн хэрэгслээр 15700 орчим жолооч тээвэр хийдэг. Тэд олон удаагийн давтамжаар тээвэр хийхийн тулд "Меми" гэх сэтгэцэд нөлөөлөх эм бодисыг хэрэглэдэг тухай баримтууд байна (БХЭШХүрээлэн, 2019 он).

Мөн хилийн бүс нутгаар эмийн ургамал түүх нэрийн дор хар тамхины төрлийн бүтээгдэхүүн олзворлох, тариалж ашиглах, хар тамхины гүүр болгон ашиглах гадны хүчний сонирхол өсч байна.

Цаашид Монгол Улс үүсээд буй аюул заналыг бууруулах, үүсч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд хилийн талаасаа хил, гааль, мэргэжлийн хяналт, хууль сахиулах байгууллагуудыг бэхжүүлэх, ажлын уялдаа холбоо, тоног төхөөрөмжийг сайжруулах, хилийн бүс нутгийг бүрэн хяналтад авах шаардлагатай.

Хилийн ихэнх сумдын болон хил орчмын нутаг дэвсгэрийн суурьшлын бүсүүдийн хөгжил, хотжилт хангалтгүй байгаагаас иргэдийн амьдрах эрх ноцтой

[3] 2011 оны хүн амын тооллого

[4] Хилийн зөрчил нь дан ганц Монгол Улсын хилийг зөрчиж буй хэрэг бус найрамдалт харьцаатай хөрш улсын хилийг давхар зөрчиж байгаа хэрэгж болно.

зөрчигдсөөр байна. Үүний нэгэн том жишээ нь Өмнөговь аймгийн Цагаан хад суурьшлын бүс болоод байна. Тус суурьшлын бүсэд гэмт хэрэг, биеэ үнэлэлт газар авч эрчим хүчний эх үүсвэргүй, усан хангамж байхгүй зэргээс шалтгаалан хөгжих боломж хязгаарлагдаж байгаагаас гадна байгаль орчны бохирдол санаа зовоосон асуудал болоод байна.

Зураг.3 "Цагаан хад" суурьшлын бүс



Эх сурвалж www.zindaa.mn

Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үүсч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хилийн зөрчлийг бууруулах, таслан зогсоохын тулд хил орчмын сумдыг хөгжүүлэх шаардлагатай. Үүний үр дүнд:

1. Нийт хилийн дагуу хилийн зөрчил гарахгүй байх нөхцөл бүрдэх,
2. Хил орчмын бүс нутагт оршин суух иргэдийн орлого нэмэгдэж, дотоодоос шалтгаалсан хилийн зөрчил багасах,
3. Хүн амын суурьшил нэмэгдэж, хил орчмын нутгийн газрын ашиглалт сайжирч хилийн аюулгүй байдал хангагдах,
4. Орон нутгийн иргэд, ААН, орон нутаг, хил хамгаалах байгууллагын хамтарсан хилийн хамгаалалт цогц хамгаалалт бий болох
5. Тухайн бүс нутагт үүссэн байгалийн гамшиг, гал түймэр, малын гоц халдварт өвчнийг дотоодын нөөц бололцоогоор ашиглан таслан зогсоох, урьдчилан сэргийлэх,
6. Монгол Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт нутагт үндэстний хэв шинж бүхий барилга байгууламж баригдаж, Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнохуйн аюулгүй байдал хангагдах зэрэг олон давуу талыг бий болно.

Хоёр. Алслагдсан болон хил орчмын нутаг дэвсгэрээ хөгжүүлсэн болон хөгжүүлж буй зарим орнуудын туршлага

Эдийн засгийн хөгжлийн түвшин, нийгмийн байгууллын хэлбэрээс үл хамааран ихэнх улс орны төрийн бодлогын нэг чиглэл нь алс хязгаар, улсын хил, хил орчмын бүс нутгуудыг хөгжүүлэх асуудал болсоор ирсэн байна.

Хилийн алслагдсан болон хөгжил дорой бүсүүдийг хөгжүүлэх төрийн бодлогод эсрэг, тэсрэг хоёр үзэл санаа давамгайлж байна. Үүнд:

Нэг дэх нь[5] : Эдийн засаг, нийгмийн хөгжлийн ихээхэн ялгаа үүсч төрийн оролцоо зайлшгүй болсон алслагдсан бүс нутгуудыг хөгжүүлэх тусгайлсан хөтөлбөр боловсруулах шаардлагатай гэж үзэх үзэл юм. (АНУ, Канад, ОХУ-д илүү өргөн тархсан) Энэ үзэл санаа нь санхүүгийн болон хүний нөөцийн хомстолтой, үндэсний хэмжээнд бүсийн асуудлыг бүрэн шийдвэрлэх бололцоогүй, өргөн уудам газар нутагтай, хөгжингүй болон ядуу буурай орнуудад хамгийн тохиромжтой бодлого гэж үзсэн байна.

Хоёр дахь чиглэл нь: нутаг дэвсгэрийнхээ тэнцвэртэй хөгжлийг хангах зорилгоор бүс нутгийг хамарсан иж бүрэн хандлага юм. Иж бүрэн хандлага гэдэг нь бүсчилсэн хөгжлийн бодлогыг нутаг дэвсгэрээ тэнцвэртэй хөгжүүлэх гол арга зам гэж үзэж, үүнд хил орчмын нутаг дэвсгэрийг хамруулан, хөрөнгө хүч, бодлого, төлөвлөлтийн хувьд ихээхэн анхаарч, ач холбогдол өгч байх хандлага юм. (Буурай хөгжилтэй орнуудын хувьд бүсчилэн хөгжих нь хэдийгээр хамгийн тулгамдсан асуудлын нэг боловч цогцоор шийдвэрлэхэд хөрөнгө мөнгө, удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын чадавх байнга дутагдах нийтлэг бэрхшээл байдаг.

Хилийн алслагдсан болон хөгжил сул нутгуудыг хөгжүүлэхдээ 1) Санхүүгийн дэмжлэг, 2) Бизнесийн орчныг сайжруулах, 3)Төлөвлөлт, удирдлагын бүтэц, механизмыг боловсронгуй болгох гэсэн бодлогын арга хэрэгслүүдийг ашигладаг байна.

Хүн амын төвлөрлийг сааруулах, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах хандлага: Хүн амын шилжих хөдөлгөөнийг зохистой түвшинд барих, төвлөрлийг сааруулах чиглэлд улс орнууд ерөнхийдөө дараах 4 чиглэлээр асуудалд хандаж байна.

а/ Шилжих хөдөлгөөнийг зогсоох. Энэ хүрээнд зарим хотыг шилжилт хөдөлгөөн хийхэд хаалттай болгох, зөвшөөрөлгүй иргэдийг хүчээр нүүлгэх, хаягийн бүртгэлийн хязгаарлалт тогтоох, ажил эрхлэлтэд хязгаар тогтоох, орон сууц, газартай болох боломжийг хязгаарлах зэрэг ирэгсдэд хориг тавих арга хэмжээ багтдаг байна. [6]

б/ Шилжих хөдөлгөөнийг удирдан чиглүүлэх. Энэ бодлого нь шилжих хөдөлгөөн зайлшгүй байх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч, түүний эерэг үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэдэг. Өөрөөр хэлбэл шилжих хөдөлгөөний урсгалыг шаардлагатай гэж үзсэн бүс нутагруу чиглүүлэн шилжигсдэд ажил эрхлэх, нийгмийн үйлчилгээнд хамрагдах болон бусад боломжийг бий болгох арга хэмжээг хэрэгжүүлдэг.[7]

в/ Шилжих хөдөлгөөний урьдчилсан сэргийлэх. Шилжих хөдөлгөөнд нөлөөлдөг голлох шалтгаан болох ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, тэгш бус байдлыг арилгах замаар хүн амыг орон нутагт нь тогтоон барихад чиглэсэн арга

[5] Монголын бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, удирдлагын асуудлууд УБ, 2004 он, Р. Ринчинбазар.
[6] Энэ арга нь шилжих хөдөлгөөнийг зогсооход шууд нөлөөлж хүний эрхэд халдсанаараа байнгын эсэргүүцэлтэй тулгарч байсан.
[7] Ийм бодлогыг БНСУ, Мексик улсууд амжилттай хэрэгжүүлсэн боловч шилжих хөдөлгөөний урсгал хөгжлөөр давуу бүс нутгуудруу чиглэн, бусад хэсгүүдрүү суурьших нь бага байсаар байсан. (Сонгдо хот ба Сөүл хот)

хэмжээ авдаг. Харин ихээхэн хөрөнгө хүч шаарддаг, үр дүн нь урт хугацааны дараа мэдрэгддэг онцлогтой. [8]

г/ Шилжих хөдөлгөөний сөрөг үр дагаврыг арилгах. Энэ бодлого нь шилжих хөдөлгөөний үр дагаврыг шилжин явагчдын уугуул болон шилжин явсан нутаг дэвсгэрт нь багасгахад чиглэгддэг ба шилжин ирэгчид тухайн хот, тосгоны хөгжилд зохих хувь нэмэр оруулж, хөдөөд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд ихээхэн үүрэгтэй гэж үзэж, дэмжих арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

Улс орнууд хилийн алслагдсан болон хөгжлийн хувьд хоцрогдсон бүс нутгаа хөгжүүлэхдээ улс орноо бүхэлд нь хамарсан, эсвэл тодорхой бүс нутгийг онцгойлон анхаарсан гэсэн хоёр үндсэн чиглэлийг баримталж байна. Эхний чиглэлийг Англи, Франц, Япон Швед зэрэг оронд голлон баримталж байсан бол дараах чиглэлийг АНУ, Канад, ХБНГУ, Голланд, Бельги, Норвеги, Дани зэрэг оронд хэрэгжүүлсэн байна.

Оросын Холбооны улс (ОХУ): Оросын умард хязгаар түүнтэй адилтгах бүс нутагт оршин суугчдад (ажилчин, албан хаагчид, тэтгэвэр тэтгэмж авагчид, анхан болон дунд шатны мэргэжлийн боловсролын сургуульд суралцагсад) тухайн газар нутгийн байгаль цаг уурын онцлог, төвөөс алслагдсан байдал зэргийг харгалзан тэдгээрийн цалин, тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлгийг тодорхой коэффициентээр (мужийн коэффициент) нэмэгдүүлэн олгодог.

Бүсийн нэмэгдлийн коэффициентийн хэмжээ нь тухайн газар нутгийн байгаль цаг уурын онцлог, алслалт зэргээс хамаарч харилцан адилгүй байдаг. Жишээлбэл: хамгийн алслагдсан Хойд мөсөн далайн арлууд Саха (Якут), Чукотка, Курилийн арлууд, Камчатка, Сахалин мужийн тодорхой нутагт оршин суугчдын бүсийн нэмэгдлийн коэффициент 2.0 байхад Красноярск, Мурманск, Хабаровск, Тюмень, Томск, Эрхүү муж, Алс дорнодод 1.8-1.4 байдаг байна.

Мөн говь, цөлийн бүсэд болон далайн түвшнээс дээш 1500 метрээс дээш оршдог газар нутгийн оршин суугчдад 1.4 хүртэл коэффициентийн нэмэгдэл олгодог.

Зураг 4. ОХУ-ын бүсийн коэффицент, 2019 он



Эх сурвалж: ОХУ-ын Хөдөлмөрийн тухай хууль(Трудовой кодекс РФ)

[8] Энэхүү аргыг Латин Америкийн Перу улс хэрэгжүүлж хөдөөгийн фермер хоршоологчдыг дэмжин, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авснаар ихээхэн үр дүнд хүрсэн хэдий ч технологийн шинэчлэл нь эргээд ажиллах хүчний илүүдэл бий болгож байжээ.

Үүнээс гадна дээрх бүс нутгуудад оршин суугчдад нэмэлт амралтын өдөр (цалингүй), ажлын богиносгосон долоо хоног, ээлжийн амралтын нэмэлт хоног, эмчилгээний замын зардал, шилжин суурьших зардал олгох зэрэг хөнгөлөлт үзүүлэхээр заажээ.[9]Төсвийн байгууллагад ажиллагсдын бүс нутгийн нэмэгдлийг холбооны болон мужийн төсөв, орон нутгийн засаг захиргааны төсвөөс гаргах бөгөөд төсвийн бус салбарт ажиллагсдын нэмэгдлийг тухай ажил олгогч нар хариуцдаг.

Канад улс: Канад улс алслагдсан бүс нутгийн оршин суугчид ажил олгогч нартаа тухайн газар нутгийн алслалт, байгаль цаг уурын байдал зэрэг нөхцөлүүдийг харгалзан тэдгээрийн цалин, орлогод ногдох орлогын албан татвараас тодорхой шалгуурыг үндэслэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх хэлбэрээр бүс нутгийн иргэдээ дэмждэг байна.

Ийм хөнгөлөлтийг 1987 оноос эхлэн олгож эхэлсэн бөгөөд дараах 2 үндэслэлээр олгодог. Үүнд:

- Цаг агаарын хүнд, бараа үйлчилгээний хязгаарлагдмал нөхцөл
- Гол зах зээлээс алслагдсан тул амьдралын өртөг өндөр

Энэ хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг Канад улсын "Хүн амын орлогын албан татварын хууль"[10]-аар зохицуулдаг. Тус хуулиар хоёр төрлийн, гурван хэлбэрийн хөнгөлөлт, хасалт хийдэг байна.

Хүн амын орлогоос: Өдрийн 15 ам.долларааар бодож жилд 5475 ам долларын орлогын албан татварын нийлбэрээс хасч тооцдог.

Ажил олгогчоос:

а/ Ажилтны амралтаараа нутагтаа очих зардлыг жилд 2 удаа ажил олгогч санхүүжүүлсэн,

б/ Тогтоосон ямар нэг хязгааргүйгээр эмнэлгийн үйлчилгээ авах зардлыг санхүүжүүлсэн бол тус тус хасалт хийнэ.

Татварын хөнгөлөлтийн хэмжээг бүс нутгийн алслалт, байгаль цаг уурын онцлог, бараа бүтээгдэхүүний өртөг зэрэг хүчин зүйлсээс улбаатай зардлуудын дарамтыг сулруулах үүднээс ялгавартай тогтоохдоо А буюу Умардын, Б буюу Завсрын бүсүүдэд хуваадаг байна. Чөлөөлөлтөд хамрагдах оршин суугчид тухайн бүс нутгийн нутагт буюу А, Б бүсүүдэд хамгийн багадаа 6-аас доошгүй сар амьдарсан байх шалгуур үзүүлэлтийг ч тавьдаг.

Умардын бүсэд оршин суугчид нь хөнгөлөлт буюу хасалтын 100 хувийг эдлэх, завсрын бүсэд оршин суугчид 50 хувийн хөнгөлөлт чөлөөлөлт эдэлдэг байна.

Англи улс: Англи улс 1920 оноос эхлэн төр засгийн түвшинд эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн асуудлыг авч үзсэн (Mc Crone 1969). 20-р зууны эхэн үед Европт аж үйлдвэрийн хувьсгал эхэлж нүүрсний болон төмрийн хүдрийн ордуудыг тойрсон төвлөрөл бий болж эхэлсэн бөгөөд үүний эсрэг талд Шотланд, Уэльс, Умард бүсүүдэд ажилгүйдэл ихсэж, хүн амын амьдралын түвшин доройтсоноос бусад бүс нутгуудруу чиглэсэн их нүүдэл эхэлжээ.

[9] Трудовой кодекс РФ от 30.12.2001 статья 319-323, 325-327).
[10] https://www.canada.ca/en/revenue-agency/cra-canada.html

1928 онд Англи улсын ЗГ-аас сул хөгжилтэй бүс нутгуудын ажилгүйчүүдэд шинээр мэргэшил олгох, туслах ажлыг зохион байгуулж эхэлсэн бол дэлхийн эдийн засгийн хямралын[11] дараа Шотланд, Өмнөд Уэльс болон Умард бүсийн баруун, зүүн хэсгийг хөгжлийг дэмжих талаар 1934 онд тусгай хууль гаргажээ. Энэ хууль нь бүхэлдээ ажилгүйдэл ядуурлыг тус нутгуудад бууруулах зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжиж ажлын байр олноор бий болгоход чиглэсэн юм.

Энэ үед Англи улсын Засгийн газраас дараах тодорхой арга хэмжээ, үйл ажиллагааг эрчимтэй хэрэгжүүлсэн байна. Үүнд:

а/ Татварын хөнгөлөлт, урамшуулал олгох;

б/ Ажлын байр бий болгох;

в/ Түрээсийн хөнгөлөлт үзүүлэх;

г/ Мэдээллээр хангах.

Үүний зэрэгцээ Англи улсын төр засгийн зүгээс хүн амын нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр ихээхэн анхаардаг байсан байна. Жишээлбэл:

- Төр захиргааны томоохон байгууллагуудыг шилжүүлэн байршуулах;

- Нийгмийн болон үйлдвэрлэлийн дэд бүтцийг хөгжүүлэх, хөгжлийг тэтгэх голомт болж чадах хотуудыг бий болгох зэрэг.

Ийнхүү байгаль цаг уурын онцгой болон алслагдсан бүс нутагт амьдарч буй иргэдэд төрөөс дэмжлэг үзүүлэх тэднийг тухайн бүс нутагт амьдрах боломж, бололцоогоор хангах төдийгүй хүн амын шилжилт хөдөлгөөн, бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг зохицуулахад чухал түлхэц болж байна.

Гурав. Хил орчмын нутаг дэвсгэр, хилийн бүсийг хөгжүүлэх Монгол Улсын туршлага ба өнөөгийн байдал

1992 оноос өмнө хил орчмын бүс нутгийг хөгжүүлэхдээ бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийн бодлого болон зарим хилийн сумдыг онцгойлон хөгжүүлэх бодлогуудыг хослуулан авч хэрэгжүүлж байсан байна. Үүнд:

Хилийн болон Говийн бүсэд хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих бодлогын хүрээнд: Бүгд Найрамдах Монгол Ард улсын Сайд нарын Зөвлөлийн (СнЗ) тогтоолоор 1971 оноос Говийн болон Хилийн нэмэгдлийг дараах чиглэлээр олгож ирсэн. Үүнд:

- Алслагдсан болон говь нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагч, багш, эмч нарт цалин хөлсний нэмэгдэл урамшуулал олгох арга замаар тогтвор суурьшилтай ажиллуулахад нь төрөөс дэмжлэг үзүүлэх

- Улсын хилийн хамгаалалтыг сайжруулах зорилгоор хилийн заставуудыг байгаль, цаг уурын нөхцөлөөр нь ангилан тогтоож, тэдгээрт алба хааж байгаа офицер, албан хаагчдад хилийн нэмэгдэл олгох зэрэг багтана.

Эдгээр нэмэгдлүүдийг 1971 оноос олгож эхэлсэн бөгөөд 1990 оноос хойш

- Ач холбогдол алдсан;

- Хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн;

- Эдийн засгийн хүндрэлд орсон зэрэг шалтгаанаар хүчингүй болгосон байна.

[11] 1929-1932 оны хооронд үргэлжилсэн.

Нутаг дэвсгэрийг жигд хөгжүүлэх бодлогын хүрээнд: Нэгдэл нь бүс нутгийг тэнцвэртэй хөгжүүлэх, бүх бүс нутаг, сумдад үйлдвэрлэлийн гол материаллаг баазыг бий болгох цогц систем байсан. Социализмын оргил үед МУ-ын нутаг дэвсгэрт бүх суманд нэгдэл байсан.

Хилийн болон алслагдсан нутгуудыг тусгайлсан хөгжүүлэх бодлогын хүрээнд: Тэжээлийн болон сангийн аж ахуйнуудыг (ТАА, САА) тухайн орон нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль, орчин, нөөцийн онцлогт тохируулан хил орчмын нутаг дэвсгэрт байгуулж байсан. Үүнд: Ногооннуурын САА (Баян-Өлгий аймгийн Ногооннуур сум), Баруунтуруугийн САА (Увс аймгийн Баруунтуруун сум) Тэсийн ТАА (Завхан аймгийн Тэс сум), Тариалан САА (Хөвсгөл аймгийн Тариалан сум), Халх гол САА (Дорнод аймгийн Халх гол сум) зэрэг олныг дурдаж болно. Эдгээр сангийн аж ахуйнууд нь тухайн үедээ хүн ам, эдийн засаг, соёлын төв болон хөгжиж байсан бөгөөд зарим САА-ууд одоо ч ач холбогдлоо алдаагүй, зарим нь сум, сумын төв болон хөгжсөн байна.

1992 оноос хойш хил орчмын нутаг дэвсгэрийн эдийн засгийг хөгжүүлэх бодлого алдагдсан байна: Төрөөс хилийн талаар авч хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийн хэрэгжилт туйлын хангалтгүй байна. "Монгол Улсын төрөөс Хилийн талаар баримтлах бодлого"-ыг 2002 онд баталсан бөгөөд тус бодлогын баримт бичигт хил орчмын нутаг дэвсгэрийн эдийн засгийг бүсчилсэн хөгжилд тулгуурлан хөгжүүлнэ гэж заасан. Судалгаанаас үзэхэд:

1. Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжилт хангалтгүй байна:

Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар[12] бүсчилсэн хөгжлийн бодлогыг тодорхойлсон ч эдийн засгийн ямар арга замаар бүсчлэх талаар нэгдсэн бодлого тодорхойгүй[13], хил орчмын бүс нутгийг хэрхэн хөгжүүлэх асуудал тусгагдаагүй хэвээр байсаар үзэл баримтлалын хугацаа дууссч байна.

2. "Хилийн" болон "Говийн" нэмэгдлийг хүчингүй болгож, "Бүсийн нэмэгдэл"-ийн бодлогыг нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд ялгамжгүйгээр, хавтгайруулан зохион байгуулсан.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд алслагдсан болон говь нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагч, багш, эмч нарт цалин хөлсний нэмэгдэл урамшуулал олгох, амьдралын нөхцөлийг нь сайжруулах, тогтвор суурьшилтай аж төрөхөд нь дэмжлэг үзүүлэх, бүсийн хөгжлийг төсөв, татвар, хөрөнгө оруулалт, мөнгө зээлийн бодлогоор дэмжих гэсэн зүйл, заалтууд туссан байна[14]. 2000 оноос хойш бүсийн нэмэгдлийн чиглэлээр УИХ дөрвөн хууль, найман тогтоол баталж, Засгийн газраас 10 гаруй тогтоол гарч байжээ. Гэвч эдгээр шийдвэрүүд нь дараах дутагдалтай байна. Үүнд:

- Зөвхөн хөдөлмөрийн чадвараа түр алдсан иргэн болон ахмад настанд хамааралтай;

- Төрийн захиргааны албан хаагчдыг хамруулалгүй зөвхөн хил хамгаалах байгууллага, гаалийн зэрэг төрийн тусгай албан хаагчдад хамааралтай;

[12] 2001 онд батлагдсан.
[13] "Монгол Улсын төсвийн төвлөрлийг сааруулах үйл явц ба орон нутгийн эдийн засаг санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх арга зам".
[14] Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал-ийн 4.7.2.в. заалт.

- Төрийн үйлчилгээний зарим албан хаагчдад (ЕБС, цэцэрлэгийн багш, эмнэлгийн байгууллагын эмч, тэдгээрийн албан хаагчид) нэмэгдэл олгохдоо хилийн бүс нутгийг онцгойлон авч үзээгүй, нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хавтгайруулан олгодог болсон.

3. Малчин өрхүүдэд хавтгайруулан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлснээр шилжилт, хөдөлгөөнийг удирдах боломжгүй болж, хил орчмын бүс нутаг эзгүйрсэн:

1990 оноос хойш нэгдэл тарсны дараа малыг хувьчилж хувьд шилжсэнээр малчид малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тээврийн зардал малчдын мал борлуулах орлогоос хасагддаг болсон. Ялангуяа зах зээлээс хол байрлах хил орчмын нутаг дэвсгэрт байгаа малчдад тухайн зардал илүү хүнд тусдаг болсон. Үүнээс шалтгаалан зах зээлд аль болохоор ойрхон холбогдох бүс нутаг руу малчид тэмүүлэх болж тэдгээрийн тоо ч нэмэгдэж улсын хэмжээнд малын тархалт тэнцвэргүй байдалтай болж иржээ. Хуулиар малчин өрхүүдэд хэт хавтгайруулан олгосон хөнгөлөлт чөлөөлөлтийн үр дүнд малчин өрхийн шилжих хөдөлгөөн, малын тоо толгойг тогтоох арга хэрэгсэл үндсэндээ байхгүй болсон байна.

*4. Хилийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, ажил олгогчдыг дэмжих бодлого явуулаагүй**:***

Хилийн бүсэд аж ахуй эрхлэх давуу тал, хөнгөлөлт чөлөөлөлтийг хуульд тусгайлан зааж өгөөгүй байна.

Жишээлбэл: ААНОАТ-ын тухай хуульд Нийслэлээс 500 км ба 1000 км гэж хавтгайруулан авч үзсэн. Энэхүү хөнгөлөлтийг хэт богино буюу 2 жилийн хугацаатай хэрэгжүүлж, хугацаа нь дууссан. Мөн тус хуулинд 2017 оны 02-р сард хийсэн нэмэлт өөрчлөлтөөр газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл болон түүнд холбогдох туслах үйл ажиллагаа, .хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэхмэлийн болон хувцас үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэл эрхлэгчдэд ААНОАТ-ын 90 хувийн хөнгөлөлтийг 4 жилийн хугацаанд бүх буй нутгуудад адил байхаар тусгасан. Тус хуульд хилийн болон говийн бүс нутгийг тусгайлан авч үзээгүй байна.

Зураг 5. Нийслэлээс 500 км ба 1000 км ээс дээш алслагдсан бүс нутгууд



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөөнөөс хот, суурин газарлуу шилжих хөдөлгөөний шалтгаан: Хөдөөгөөс сум, аймгийн төврүү шилжиж байгаа шалтгааны 81.7 хувийг эдийн засгийн, 10 хувийг гэр бүлийн шалтгаан эзэлж байна. Гэр бүлийн шалтгаан нь

эхнэр эсвэл нөхрийн ажлын байрыг даган шилжих хөдөлгөөн эсвэл нэгэнт аймаг, сумын төвд ажил хөдөлмөр эрхэлж, амьдран сууж буй гэр бүлийн гишүүнтэйгээ ойртох шалтгаан зонхилж байна.

Харин томоохон хот, нийслэлрүү шилжих шалтгааны 46.9 хувь нь эдийн засгийн, 25.8 хувь нь гэр бүлийн, 12.5 хувь боловсрол, эрүүл мэндийн 11.5 хувь амьжиргааны нөхцөл байдлаа сайжруулах, 3.3 хувь бусад нөхцөлөөр тайлбарлагдаж байна.

Эдийн засгийн шалтгааныг авч үзвэл :

-Цаг уурын хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан малаа алдсан иргэд цалин хөлстэй ажил хийхээр хот, суурин газарлуу шилжих

-Дээд болон дунд боловсрол эзэмшсэн залуус орон нутагт нь ажлын байр байхгүйгээс хот суурин газарт ирж мэргэжлийн дагуу ажил хөдөлмөр эрхлэх

-Амьжиргааны болон байр орон сууцны нөхцөлөө сайжруулж, хүүхдээ цэцэрлэг сургуульд ойртуулах зэрэг орж байна.

Зураг 6. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот руу шилжигсдийн шалтгаан



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 7. Аймаг, аймгийн төврүү чиглэсэн шилжих хөдөлгөөний шалтгаан



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Энэ судалгаанаас дүгнэн үзвэл:

- Шилжигчдийн дийлэнх нь 25–39 насны, хөдөлмөрийн насны насанд хүрсэн хүмүүс байна. Тэд хөдөлмөрийн нөхцөлөө сайжруулах боломжийг эрэлхийлэн уугуул нутгаа орхиж явж байна.

- Хөдөөгийн хүн ам ажлын байр, орлогын эх үүсвэр байхгүйгээс болж орлогогүй, амьжиргааны эх үүсвэргүй байна.

- Шилжигчид үндсэндээ эдийн засгийн шалтгаанаар уугуул нутгаа орхин явж байна.

Шилжих хөдөлгөөнд голчлон залуус болон малчин өрхүүд хамрагдаж байна. Залуусын хувьд өрхийн эдийн засгаа сайжруулах, мэргэжил эзэмших, эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах зорилготой нүүж байгаа бол малчин өрхийн шилжилт хөдөлгөөн худаг усны хангамж, бэлчээрийн хүртээмж, зах зээлд ойртох гэсэн шалтгаануудаар тайлбарлагдаж байна. Мөн төрөөс ААН, иргэнд үзүүлэх татвар, төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт, нийгмийн тэтгэвэр, тэтгэмж, халамжийг бүсийн ялгамжгүйгээр, нийт нутаг дэвсгэр, иргэд, ААН-ийг хамарсан байдалтайгаар зохион байгуулсны үр дүнд шилжих хөдөлгөөнийг нэмэгдүүлж, хил орчмын бүс нутаг эзэнгүйдэх үндсэн суурийг тавьсан байна.

УИХ-иас “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ыг 2002 онд баталж, 18 жил өнгөрсөн ч хил орчмын ихэнх бүс нутгийн хөгжил дорой хүн амын нягтрал бага байсаар байна. Энэ нь

- “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулаагүй;

- Хил орчмын нутаг дэвсгэрийг “Бүсчилсэн хөгжил”-д суурилан хөгжүүлэхээр тусгасан боловч бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд хил орчмын нутаг дэвсгэрийг хөгжүүлэх бодлого тусгагдаагүй;

- Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилт туйлын хангалтгүй;

- “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ын хүрээнд хилийн сумдын эдийн засгийг тусгайлан хөгжүүлэх бодлого стратеги байхгүй.

- Хэрэгжүүлэх байгууллага нь тодорхойгүй зэргээр тайлбарлагдах юм.

Иймд төв болон орон нутгийн засаг захиргаанаас дараах хэд хэдэн бодлогын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.Үүнд:

- Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгахад чиглэсэн тогтвортой, тэнцвэртэй хөгжлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх

- Оршин сууж буй иргэдийг бизнес эрхлэх нөхцөл боломжоор хангах, хөдөлмөр эрхлэлтийн илүү сайн боломжуудыг бий болгохын тулд бичил зээлийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх

- Буцах шилжилтийг дэмжихийн тулд уугуул нутгийн ахуйн орчин нөхцөлийг сайжруулах, ажлын байрыг бий болгох бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх зэрэг болно.

Дүгнэлт

“Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг шинжлэх ухаан, эдийн засаг, техник, технологийн ололт, мэргэшсэн байгууллагын үйл ажиллагаанд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулна” гэсэн төрийн бодлого чиглэл доголдоход хүрч байна.

1992 оноос өмнө Монгол Улс хосолсон хандлагаар хил орчмын бүс нутгийг хөгжүүлж байсан бол, 1992 оноос хойш улс орныг бүхэлд нь тэнцвэртэй

хөгжүүлэх бодлого баримталсан байна. Гэвч бүсчилсэн хөгжлийн бодлого хэрэгжээгүйтэй зэрэгцэн хилийн ихэнх сумдад хүн амын шилжих хөдөлгөөн бий болж түүний үр дүнд хүн амын тоо, нягтрал, эдийн засгийн хөгжил буурсан.

Хил хамгаалах байгууллага хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй офицер, ахлагч, цэргийн албан хаагчид хилийн нэмэгдлийг ялгамжтайгаар, офицер ахлагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, сурч боловсроход дэмжлэг үзүүлэх, гэр бүлийн гишүүдийг ажлын байраар хангах, бүсчилсэн хил хамгаалалтыг зохион байгуулах зэрэг олон ажлыг амжилттай зохион байгуулсан.

Мөн хугацаанд хил хамгаалах хүчин чадлыг төсөв, хөрөнгийн хязгаарлагдмал нөхцөл байдалд оновчтой зохион байгуулж, өргөтгөж байгаа ч Монгол Улсын хил урт, газар зүйн байршил, цаг уурын нөхцөл хүнд, зэрэг олон нөхцөлөөс шалтгаалж хил хамгаалалтын асуудлыг дангаар шийдвэрлэх боломжгүй юм.

Эдгээрээс дүгнэвэл 1990 оноос хойш Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хил орчмын нутаг дэвсгэрийг хөгжүүлэх түүхэн уламжлал алдагдсан байна.

Хил орчмын ихэнх бүс нутгийн хөгжил дорой байгаа нь иргэдийн зүгээс хилийн зөрчил гаргах, улмаар энэ нь хөрш улсуудад Монгол Улсын хилийн халдашгүй, дархан байдлыг алдагдуулах шалтаг, шалтгаан болж болзошгүйг анхаарах шаардлагатай.

Нөгөө талаас бүс нутаг болон хөрш улсуудын зарим хэсэгт Монгол Улсын бүрэн эрхт байдал, аюулгүй байдалд ноцтой нөлөөлж болзошгүй нөхцөл байдал бий болсон, даамжрах хандлагатай байгаа тул цаашид бүс нутгийн(баруун бүс, хангайн бүс, зүүн бүс, өмнөд бүс, хойд) хил хамгаалах байгууллага, орон нутгийн засаг захиргаа, иргэнийг хамруулсан цогц хилийн бүсчилсэн хамгаалалтыг төгөлдөржүүлэх зайлшгүй хэрэгцээтэй.

Тиймээс цаашид төрөөс Монгол Улсын нийт хилийн дагуу аюулгүй байдлыг хангаж, хилийн зөрчлийг бууруулахын тулд хил орчмын нутаг дэвсгэрийг “тусгайлан” хөгжүүлэх бодлогыг боловсруулж, бүсчилэн хил хамгаалалтыг төгөлдөржүүлэхийн тулд цэрэг, зэвсэг, техник, тоног, төхөөрөмж, хүн ам, эдийн засгийн нөөц, төвлөрөл бүхий тулгуур хот, суурин газрыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал дээр тулгуурлан тус тус хөгжүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Эдийн засгийн хөгжил сул хил орчмын бүс нутгийг хөгжүүлэх төрийн бодлогын онцлог нь тухайн бүс нутагт амьдардаг иргэн болон ААН, байгууллагад татварын болон татварын бус аргаар нөлөөлж бусад бүс нутагт ажиллаж, амьдрах, үйл ажиллагаа явуулахаас давуу, уян хатан, таатай нөхцөлийг бий болгох явдал юм.

Хил орчмын бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэх бодлогын татварын арга зам нь урт хугацаанд ААН болон иргэнд хөнгөлөлт,чөлөөлөлт үзүүлэх явдал байх бол татварын бус арга зам нь илүү богино хугацаанд хэрэгжүүлэх :

- төрийн үйлчилгээг сайжруулах
- санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- малчдын худаг ус, усан хангамжийг нэмэгдүүлэх
- эрчим хүч дэд бүтцийг байгуулах

- үйлдвэрлэлийн зориулалттай эрчим хүчний хэрэглээнд татаас үзүүлэх зэрэг хөрөнгө оруулалт, төсөв ихээр шаардагдах ажлууд байна.

Эдгээрийн үндэсний хөгжлийн хэмжээнд явуулж буй бодлогуудтай уялдуулан шийдвэрлэх боломжтой юм.

Цаашид төрөөс хилийн эдийн засгийн хөгжлийн талаар баримтлах бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Монгол Улсын нийт хилийн дагуу аюулгүй байдлыг хангаж, хилийн зөрчлийг бууруулахын тулд улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийг "тусгайлан" хөгжүүлэх бодлогыг, хилийн бүсчилсэн хамгаалалтыг[15] төгөлдөржүүлэхийн тулд цэрэг, зэвсэг, техник, тоног, төхөөрөмж, хүн ам, эдийн засгийн нөөц, төвлөрөл бүхий тулгуур хот, суурин газрыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал дээр тулгуурлан хөгжүүлэх шаардлагатай байна.

Хил дагуух сумдыг хөгжүүлэх тусгай бодлого нь богино болон дунд хугацаанд хэрэгжиж, урт хугацаандаа хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийн талаар нийгэм, эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авах шаардлагатай.

Хил орчмын нутаг дэвсгэрийн эдийн засгийг хөгжүүлэхдээ дараах үе шаттай хөтөлбөрүүдийг баримтлах.Үүнд:

- Хилийн сумдад нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг бий болгож, хүн амын шилжих хөдөлгөөнийг зогсоох;
- Эдийн засгийн хөгжлийн суурь нөөцийг бий болгох;
- Дэд бүтэц, эрчим хүчний хангамжийг сайжруулах;

Хил орчмын бүс нутгийн нийгэм эдийн засгийн тогтвортой байдлыг бий болгох хөтөлбөрийн хүрээнд:

- Хил орчмын бүс нутагт одоо ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг тогтвортой ажиллах нөхцөл бололцоог хангаж татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, цалингийн нэмэгдэл зэрэг санхүүгийн дэмжлэг болон халамжийн арга хэрэгслүүд
- Малчин өрхийн санхүүгийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор малжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх, худаг, ус, хөв цөөрөм байгуулах
- Хил орчмын бүс нутагт мал эмнэлгийг нэмэгдүүлэх

Эдийн засгийн хөгжлийн суурь нөөцийг бий болгох хөтөлбөрийн хүрээнд:

- Бэлчээрийн доройтолд орсон бүс нутгуудаас малчин өрхүүдийг татварын бодлогоор хил орчмын бүс нутагруу шилжин суурьших давуу байдлыг бий болгох
- Хил орчмын бүс нутагт бизнес эрхлэх давуу байдлыг татварын болон татварын бус аргаар дэмжих,
- Эрчим хүч, зам тээвэр, тээвэр, ложистикийн сүлжээг өргөтгөх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Эх сурвалжийн жагсаалт

1. А.Энхбат, П. Г., 2019 он. Монгол орны байгаль орчны төлөв байдлын судалгаа, УБ хот;
2. Б.Нарангэрэл, С., 2017 он. Тал хээрийн бүсийн бэлчээрийн доройтолд малчдын үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох нь, УБ хот;

[15] Хилийн тухай хуулийн 32-р зүйлийн 32.1.4 дэх заалт.

3. Б.Роломжав, 1987 он. БНМАУ-ын тариалангийн хураангуй түүх, Түүхийн судлал.Том.XIV боть, УБ хот;
4. Барилга хот байгуулалтын яам, 2019 он. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, УБ хот;
5. БХЭШХүрээлэн, 2019 он. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал: Өнөө ба ирээдүй, УБ хот;
6. Д.Булгамаа, С. Б. ,. У., 2015 он. Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан, УБ хот;
7. Д.Оюунбилэг, 2017 он. Малын хөлийн татварыг сэргээе. Өнөөдөр сонин. УБ хот;
8. Н.Наранжамц, 2007. Хил судлал. УБ хот;
9. Н.Наранжамц, 2008. Хил судлал. УБ хот;
10. ОУШХБ, 2016 он. Монгол Улс: Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа, УБ хот;
11. П.Сүндэв, 2004 он. Хил хамгаалах бодлого, үйл ажиллагаа. УБ хот;
12. Р.Ринчинбазар, 2004 он. Монголын бүс нутгийн тогтвортой хөгжлийн асуудал. УБ хот;
13. С.Чулуун, Ю. К., 2013 он. Сангийн аж ахуй, УБ хот;
14. ҮСХороо, 2019 он. Мал тооллогын урьдчилсан дүн 2019, УБ хот;
15. ХААИС-МЭСургууль, 2017 он. Малын эмч эмхэтгэл, УБ хот;
16. Ц.Ганзориг, 2016 он. Хилийн аюулгүй байдлыг хангахад нөлөөлөх гадаад хүчин зүйлс, УБ хот;
17. Ш.Мөнхцэрэн, П., 2019 он. Монгол Елсын төсвийн төвлөрлийг сааруулах үйл явц ба орон нутгийн эдийн засаг санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх арга зам, УБ хот.

БҮХ НАСААР ХОРИХ ЯЛЫН МӨН ЧАНАР, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АНХААРАХ АСУУДАЛ

SOME ISSUES OF LEGAL REGULATION ON A LIFETIME SENTENCE

Ц.Мөнхбат
Улсын ерөнхий прокурорын газрын Сургалтын төвийн сургагч багш, прокурор
Munkhbat Ts.
Instuctor and Prosecutor of Training center, The State General Prosecutor's Office of Mongolia

✉ pro_mo@yahoo.com

Хураангуй: Улсын Их Хурлаас шинэчлэн найруулж баталсан 2015 оны Эрүүгийн хуульд тусгасан бүх насаар хорих ялын хэрэгжилтэд гарч буй тулгамдсан асуудлыг судалж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлов.

Abstract: It is determined that here challenges and factors to lifelong sentence which has been newly regulated in Criminal Code of Mongolia, 2015.

Түлхүүр үгс: Бүх насаар хорих ял, цаазаар авах ял, олон улсын гэрээ, туршлага, хүний эрх, эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал.

Keywords: Lifelong sentence, capital punishment, International treaties, human rights, legal environment, challenges.

Оршил

Улсын Их Хурал "*Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протоколд нэгдэн орох тухай*" Монгол Улсын хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр баталсан.[1] "*Шоронжсон*" гэж шүүмжлэлд өртөж байсан 2002 оны Эрүүгийн хуулийг халж," дэлхийн нийтийн чиг хандлага, стандартад нийцсэн Эрүүгийн хуулийг 2015 онд баталж чадсан"[2] ба цаазаар авах ялыг халж, бүх насаар нь хорих ялыг шинээр тусгасан байна. Энэ нь "*иргэнд байхгүй эрхийг төр эдлэх ёсгүй*" гэсэн нийгмийн гэрээний онолын агуулгатай нийцэж байна. Гэвч Эрүүгийн хуулиас цаазаар авах ялыг хасч, оронд нь бүх насаар хорих ялтай болсон нь нийгмийн зүгээс зарим шүүмж дагуулж байгааг дурдах нь зүйтэй байна. Тухайлбал: "Хэдийгээр цаазаар авах ял нь хүмүүнлэг бус гэгдэж байгаа ч гэмт хэрэгтэн хөл дээрээ баттай зогсож амжаагүй, хөхнөөсөө ч гараагүй нялх хүүхдийг хүчирхийлж байгаа нь монгол хүний зан заншил хийгээд соёлт хүн төрөлхтөний ёсонд харшлах онц ноцтой харгис, хэрцгий, жигшүүрт үйлдэл юм"[3] гэж үзэж бүх насаар хорих ялыг халж, зарим төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цаазаар авах ялыг сэргээх шаардлага тавьж буй нийгмийн нэг хэсэг байна.

[1]Монгол Улсын хууль тогтоомжийн сангаас үзнэ үү.
[2]Д.Ганбат. Шоронжсон хуулийг халж энэрэнгүй эрүүгийн хуультай боллоо. Ардын эрх. УБ. 2015.12.09.
[3]Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулгын Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид 2017 онд хүргүүлсэн албан бичгийг үзнэ үү.

Энэхүү өгүүлэлд бүх насаар хорих ялын мөн чанар, нийгмийн шаардлага, олон улсын гэрээ конвенцийн дагуу хүлээсэн үүрэг, түүний хэрэгжилт, эрх зүйн зохицуулалтын тулгамдсан зарим асуудлыг судалснаа толилуулав.

Бүх насаар хорих ял бий болгох шаардлага, үндэслэл

Нөхөшгүй алдаанаас зайлсхийх хамгийн оновчтой арга нь цаазаар авах ялыг бүх насаар нь хорих эсхүл тодорхой хугацаагаар хорих ялаар солих явдал юм. Хууль дээдлэх зарчимд тулгуурласан хамгийн боловсронгуй хуулийн тогтолцоо ч гэсэн хууль зүйн алдаанаас ангид байж чаддаггүйг практик нэгэнт нотолсон байна. Хууль ёс нэг мөр хэрэгжээгүй цагт гэм буруугүй хүнийг цаазлах эрсдэл хэзээ ч арилдаггүй. Цаазаар авах ялыг халснаар хохирогчийн нөхөн төлбөрийн асуудал, ялтны "*гянданд*" тохирсон хөдөлмөр эрхлүүлэх замаар насан туршид нь төлбөрийг барагдуулах зэрэг бусад эдийн засгийн шийтгэлийн хувилбаруудыг хэрэгжүүлэх боломж нээгддэг[4]. Цаазаар авах ялыг халж, оронд нь бүх насаар, эсхүл хугацаагүй хорих ялыг бий болгохын ач холбогдол нь онц хүнд гэмт хэрэг үйлдсэн хүмүүст урт хугацааны хорих ял оногдуулах замаар шударга ёсыг тогтоож, нийгмийн үнэт зүйлийг хамгаалдагт оршдог. Цаазаар авах ялыг бодит амьдрал болон хуулиас бүрмөсөн хасахгүйгээр монголчууд бид хүний эрхийг дээдэлсэн хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх боломжгүй[5] гэж зарим эрдэмтэд үздэг. Эрүүгийн хууль гэмт хэрэг үйлдсэн хүнд тохирох ялыг шударгаар ногдуулахаас гадна нийгмийн үнэт зүйлсийг гэмт халдлагаас хамгаалах, Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгыг агуулж байдаг[6].Зарим судлаач бүх насаар нь хорих ял бол тухайн хүндээ маш хатуу ял шийтгэл[7] гэсэн байна. Цаазаар авах ялыг бүх насаар хорих ялаар сольсон нь ялын хэмжээг зөөлрүүлсэн мэт боловч уг чанартаа гэмт хэргийг тогтоон барихад ялын хатуу чанга нь бус гарцаагүй байх нь чухал бөгөөд хатуу ял шийтгэгдэх айдаснаас хөнгөн боловч гарцаагүй шийтгүүлнэ гэсэн мэдрэмж илүү нөлөөтэй гэсэн онол, олон улсын чиг хандлагатай нийцэж байна.

Цаазаар авах ялыг халж, бүх насаар хорих ял оногдуулж ирсэн практиктай улсуудын эрдэмтэн судлаачид "*бүх насаар хорих ял нь цаазаар авах ялыг орлох боломжтой илүү үр нөлөөтэй*" гэсэн дүгнэлтийг хийсэн байна. Учир нь хүн төрөлхтөн "*Үхэл бол мөнхийн амгаланд хүрэх, зовлон бэрхшээлээс ангижрах арга*" хэмээдэг ажээ. Харин бүх насаараа торны цаана сууж, бусдын эрхшээлд байхыг хэн ч хүсдэггүй бөгөөд энэ нь зовлон гачаалын төгсгөл биш харин эхлэл болох учир бүх насаар хорих ял бол цаазаар авах ялаас илүүтэй бусдад нөлөөлж, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж чаддаг.[8] Кримонологч, судлаачид цаазаар авах ялаас илүү "*гянданд*" насаар нь хорих нь маш хүнд

[4] Эмнести интернэйшнл. Цаазаар авах ялыг халах үндэслэлүүд. 2016. албан ёсны сайтаас үзнэ үү.
[5] О.Мөнхсайхан. Цаазаар авах ялыг хасах нь Үндсэн хуулийн өмнө хүлээсэн үүрэг. www.trends.mn 2015.04.16.
[6] Б.Батцэрэн. Хүнийг удаан хорьсноос хүмүүжүүлэх нь чухал. Өдрийн сонин. 2018.12.08.
[7] Б.Энхбаяр. Бүх насаар нь хорих ял үнэндээ там юм шүү дээ. Өдрийн сонин. 2018.04.03.
[8] С.Гантулга. Б.Энхболд. Эрүүгийн хуулийг эмчлэх нь. 2017. Хууль зүй, Дотоод хэргийн яамны албан ёсны сайтаас үзнэ үү.

шийтгэл гэдэг.[9] "*Бүх насаар нь хорих ял бол цаазын ялнаас илүү том ял*"[10] бөгөөд хатуу чанга ял юм. Иймд энэ ялаар гэмт хэрэгтнийг цээрлүүлж, хариуцлага хүлээлгэж болно. Мөн гэм бурууг хүнийг хожим ч гэсэн суллах боломжтой гэдэг утгаараа бүх насаар хорих ял нь цаазаар авах ялаас илүү ач холбогдолтой юм. Нөгөө талаар хүний эрхэм чанар, үнэт зүйлсийг арай бага зөрчдөг нь шударга ёсонд нийцдэг.[11]

Төр гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмд дахин аюул учруулахгүй байх үүрэгтэй учраас олон жил хорих буюу бүх насаар нь хорих гэсэн ялын төрлийг оруулж ирсэн.[12] Гэмт хэрэг үйлдсэн хүн гэм буруутай нь тогтоогдвол шүүх Эрүүгийн хуульд зааснаар ногдуулсан хорих ял нь тухайн этгээдийн эрх чөлөөг нь хязгаарлаж, олон нийтээс тусгаарлаж, тусгай дэглэм бүхий хорих ангид албадан байлгадаг,төрийн албадлагын хатуу цээрлэл агуулсан арга хэмжээ[13] бөгөөд ардчиллын зарчимтай нийцэж, нөгөө талаар хүний эрхийг хамгаалахад түлхэц болж байна.[14]

Олон улсын эрх зүйн баримт бичигт хамаарах зарим асуудал

Эрүүгийн эрхийн хүрээнд Монгол Улс нэгдэж орсон 50 гаруй гэрээ[15] болон хүний эрхийн чиглэлээр 9 конвенцид нэгдэж орсон байдаг[16]. Дэлхийн улс орнуудаас 130 гаруй нь цаазаар авах ялыг Эрүүгийн хуулиас хассан[17] байна.Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблей "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протокол"-ыг 1989 онд баталж 1991 онд хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн. Энэхүү нэмэлт протоколд 85 улс нэгдэж орсон бол 38 улс гарын үсгээ зурсан. Монгол Улс одоогийн Эрүүгийн хуулиас цаазаар авах ялыг халж, хуульд бататгасанаар "*дефакто*" буюу бодит байдал дээр цаазын ялыг хууль тогтоомжоос бүрэн халсан улсын бүртгэлд орсон[18] байна. Харьцуулсан зарим судалгаа хийхэд манай хууль тогтоомжинд давуу тал ажиглагдаж байна. Манай Эрүүгийн хуульд арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн хүнд бүх насаар хорих ял ногдуулахгүй[19] гэж заасан байхад бусад улс оронд өсвөр насны хүнд жишээлбэл:" *2014 оны 01 дүгээр сард Египтийн өмнөд мужид мөргөлдөөн болж ерөнхийлөгч Мухамед Мерсиг түлхэн унагаасан ба Кайр хотод 3 настай Ахмед хүүг 16 сартай байхдаа энэ жагсаалд оролцсон гэмт хэрэг үйлдсэн*" хэмээн бүх насаар нь хорих ял ногдуулсан байна.

---

[9] Х.Нямбаатар. Хүчингийн гэмт хэрэг бүх насаар хорих ялтай. www.news.mn 2017.10.30 ярилцлагыг үзнэ үү.
[10] М.Ичинноров. Бүх насаар хорих ял бол цаазаас ч илүү том ял. 2017.11.29. www.mongol.com
[11] О.Мөнхсайхан. Цаазаар авах ялыг халснаар Эрүүгийн хууль сул болчихсон гэсэн үг биш. www.ikon.mn 2017.10.18.
[12] Д.Дорлигжав. Гэмт хэргийн хохирлоо барагдуулсан тохиолдолд заавал хорих ялаар шийтгэхгүй. www.itoim.mn. 2015.12.04.
[13] Улсын дээд шүүх. Ханнс Зайделийн сан. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2010. 162-163 дахь тал.
[14] Д.Дорлигжав. Ялын бодлогыг ялгавартай болгосноор хохирол барагдаж, шоронжилт багасна. сонин. сайт. 2015.02.09.
[15] Н.Учрал. Эрүүгийн эрх зүйд тогтоосон уламжлалт дэг жаяг.news.mn.УБ., 2017.
[16] Иргэний ба улс төрийн эрхийн олон улсын пактын хэрэгжилтийн талаархи Монгол Улсын ээлжит 6 дахь тайлан. УБ., 2015.
[17] Г.Энхбаатар. Эрсдэл дагуулсан Эрүүгийн хууль. Ардын эрх. 3225(502). 2006.12.29.
[18] Б.Энхбаяр. Бүх насаар нь хорих ял үнэндээ там юм шүү дээ. Өдрийн сонин. 2018.04.03.
[19] Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл. эмхтгэл. 2016. №07., 5. 6 дугаар зүйл .

Бүх насаар хорих ялын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал

Эрүүгийн хууль тогтоомжид тусгасан бүх насаар хорих ялын талаар харьцуулсан судалгаа хийхэд дараах нөхцөл байдал тогтоогдсон байна. Тухайлбал:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хаалттай хорих анги нь энгийн болон тусгай зэрэглэлтэй байх ба тусгай зэрэглэл нь бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ганцаарчлан ял эдлүүлэх тусгай нэгжтэй[20] байна. Хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол нь 90 хоногт 1 удаа түр хугацааны уулзалт хийх нь тусгай нэгжид ял эдлэх хоригдлын 180 хоногт 2 удаа түр уулзалт хийх[21] заалттай агуулгын хувьд адил байгаа нь хоорондоо ялгамжтай байх зарчмыг үгүйсгэж байна.

Ялгаатай нэг тал нь тусгай нэгжид байх хоригдол нь бусадтай удаан хугацааны уулзалт хийх, утсаар ярих боломжгүй байна. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн этгээд 25 жилийн турш бусадтай удаан хугацаагаар уулзалт хийж, Гэр бүлийн тухай хуульд заасан зарим хүмүүстэй биологийн хэрэгцээг хангаж чадахгүй, мөн утсаар ярих эрхгүй байгаа нь Үндсэн хуульд заасан хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх,[22] хэнд ч болов хүнлэг бус[23] хандаж болохгүй гэсэн хүний эрх, эрх чөлөөний талаархи заалтыг зөрчсөн гэж үзэж болох талтай.

2. Хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлийн бүтцэд тусгай нэгж байгааг эргэж харууштай.Нэгэнт тэдгээрт хуулиар тавигдах шаардлага өөр байгаа тохиолдолд хамтад нь нэг зэрэглэлд бус, тус тусад нь байлгах нь зохимжтой. Тэгэхээр хуульд "*Хаалттай хорих анги нь энгийн, тусгай болон онцгой зэрэглэлтэй байна*" гэсэн заалт оруулж,онцгой зэрэглэлд нь тусгай нэгжийг хамааруулах нь зүйтэй юм.

3. Хаалттай хорих ангид ял эдэлж байгаа хоригдлыг зөвхөн хорих байгууллагын үйлдвэрлэлд[24] ажиллуулах хүрээнд, тусгай нэгж дэх хоригдлыг хорих ангийн байранд хөдөлмөрлүүлж[25] болох заалтыг зөвшөөрөгдсөн хөдөлгөөн хийхээс бусад цагт хорих өрөөнөөс гаргахгүй байдлаар бус харин ч боломжийн хэлбэрээр ажил хэрэг болгох шаардлагатай юм. Хоригдлыг урамшуулахад хөдөлмөрлөх үүргээ амжилттай биелүүлсэн[26] байх нөхцөл нөлөөлдөг.

4. Хаалттай хорих ангийн тусгай нэгжид ял эдэлж байгаа хоригдлыг ганцаарчилсан тасалгаанд хорих бөгөөд шаардлагатай гэж үзвэл хорих ангийн дарга прокурортой зөвшилцөн хоригдлыг хоёроор нь хорьж болдог[27] зохицуулалттай. Энд "*зөвшилцөх*" гэсэн нь "*санал солилцох, саналыг бичгээр оруулах, бичгээр санал авах, нэгдсэн саналд хүрэх, хуульд заагаагүй бусад тохиолдолд заавал нэгдсэн саналд хүрэхийг шаардахгүй байх, биечлэн уулзах*"

[20] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл. эмхтгэл. 2017.№.24. 199 дүгээр зүйл.
[21] Дурдсан эх сурвалж. 200 дугаар зүйлийн 200.4 дэх хэсэг.
[22] Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. эмхтгэл. 1992. №1. 14 дэх тал.
[23] Дурдсан эх сурвалж. 16 дугаар зүйл. 13 дахь хэсэг.
[24] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл. эмхтгэл. 2017. №23. 199 дүгээр зүйл. 199.6 дах хэсэг.
[25]Дурдсан эх сурвалж. 200 дугаар зүйл. 200.3 дахь хэсэг.
[26]Дурдсан эх сурвалж. 223 дугаар зүйл. 223.1 дэх хэсэг.
[27]Дурдсан эх сурвалж. 200 дугаар зүйл. 200.1 дэх хэсэг.

зэргээр олон талт хэлбэрээр ойлгогдож байна. Иймд хуульд прокурортой "*зөвшилцөх*" гэснийг өөрчилж нэг мөр "*прокурорын зөвшөөрлөөр*" гэх нь илүү ойлгомжтой болох юм.

5. Тусгай нэгжид ял эдэлж байгаа хоригдол нь шагналын хоног авахын тулд сахилгын зөрчил гаргаагүй байх, хуваарилсан ажил, үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэсэн, сургалт хүмүүжлийн ажил болон нийгэмшүүлэх хөтөлбөрт идэвхитэй хамрагдсан, хууль тогтоомж, хорих ангийн дотоод журмыг мөрдөж байгаа байдал, өөрийн зан үйл, хувийн байдлаараа хорих ангийн дарга, алба хаагчаас эерэг үнэлгээ авсан, хөдөлмөрт хамрагдсан хугацааны нийлбэр нь 160 цагаас доошгүй ажлын бүтээмж чанартай[28] байх зэрэг шаардлагыг хангаж чадах эсэх нь эргэлзээ төрүүлж байна. Өнөөгийн нөхцөлд дээрх шаардлагыг биелүүлэх нөхцөл боломж байхгүй тохиолдолд хэрхэх вэ? гэсэн асуулт гарч, шийдлээ хүлээж байна.

6. Хаалттай хорих ангийн тусгай нэгжид бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлэх[29] ба бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 10 жил ял эдэлсэн тохиолдолд хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлж болохоор[30] байгаа нь хууль доторхи зөрчилдөөнийг харуулж байна. Энд тодруулахад тусгай нэгжид ял эдэлж байгаа хоригдлын үйлдсэн гэмт хэргийн шинж, хоригдлын хувийн байдал, засрал хүмүүжлийн байдлыг харгалзан эхэлж хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд, дараа нь энгийн зэрэглэлд шилжүүлэх зохицуулалт хэрэгтэй юм. Мөн хаалттай хорих ангийн хуваарилагдсан зэрэглэлд (*тусгай нэгж*) хорих ялын талаас багагүй хувийг эзэлсэн[31] байх нь тусгай зэрэглэлд шилжих нэг үндэслэл байж болох юм.

7. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдолд холбоотой асуудалд хууль тогтоогч 5 удаа "болно" гэдэг үг хэрэглэсэн байна. Жишээ нь: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд а) *...хорих ангийн дарга прокурортой зөвшилцөн хоригдлыг хоёроор нь хорьж болно* б) *...хөдөлмөрлүүлж болно.* в) *...илгээмж авч болно.* г) *...энгийн зэрэглэлд шилжүүлж болно* гэх мэтээр заасан нь хоёрдмол утгыг илэрхийлэх учир шууд утгаар нэг мөр болох нь зүйтэй бөгөөд энэ нь эрх бүхий албан тушаалтны хувийн сэдэлтээр хууль бус шийдвэр гаргахаас урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм.

8. 2015 оны Эрүүгийн хуульд бүх насаар нь хорих ял шийтгүүлсэн этгээдийн хувьд 25 жил хоригдсоны дараа ялтны хувийн байдал[32], гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар зэргийг харгалзан суллах эсэх асуудлыг шийдвэрлэдэг. Олон улсын туршлагаас харахад суллах хугацаа нь харилцан адилгүй байна. Тухайлбал: Армени, Австри улсад 15 жил, Азербайджан, Албани, Белорусь, Вьетнамд 25 жил, Бельгид 15 жил, Болгарт 20 жилийн ял эдэлсний дараа холбогдох асуудлыг шийдвэрлэдэг байна. Зарим судлаачид "*хорих ял эдлүүлэх нь гэмт хэрэгтэй тэмцэх оновчтой арга биш*" гэж үзсэн байдаг.Тухайлбал: 2015 онд ХБНГУ-д зохион байгуулсан "Дэлхийн ял

[28]Дурдсан эх сурвалж. 224 дүгээр зүйл. 224.3 дахь хэсэг.
[29]Дурдсан эх сурвалж. 199 дүгээр зүйл. 199.1 дэх хэсэг.
[30]Дурдсан эх сурвалж. 206 дугаар зүйл. 206.5 дах хэсэг.
[31]Дурдсан эх сурвалж. 206 дугаар зүйл. 206.4 дэх хэсэг.
[32]Б.Энхбаяр. Эрүүгийн хууль бол төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх бодлого. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны албан ёсны сайт. 2017.

шийтгэлийн бодлого, чиг хандлага" сэдэвт эрдэмтдийн уулзалт, хэлэлцүүлэгт олон улсын эрх зүйн томоохон эрдэмтэн **Ханнс Ёорг Албрехт** "*Шорон бол гэмт хэрэгтнүүдийг бэлтгэдэг их сургууль юм*"[33] гэж дүгнэсэнтэй судлаачийн хувьд санал нэг байна. Хорих ялын үр нөлөө хангалтгүй,зардал ихтэй, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх, засан хүмүүжүүлэх, иргэн нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, эрүүгийн хариуцлагын зорилго хангагдахгүй байгаа нь бодит үнэн билээ.

Түүнчлэн "Эрүүгийн хуульд бүх насаар хорих ял ногдуулсан бол тухайн этгээдийг нас бартал нь хорих ангид байлгах, түүнийг зэрэглэл бууруулж шилжүүлэхгүй байх нь зөв" гэж үзэх хандлага байгааг тэмдэглэж байна. Иймд ялын нэршлийг оновчтойгоор өөрчлөх буюу бүх насаар хорих ял гэхгүй байх, хорих ялын дээд хязгаарыг 25-30 жил хүртэл нэмэгдүүлэх байдлаар шийдвэрлэж болох болох талтай юм.

Дүгнэлт

Судалгааны дүнг үндэслэн "*Эрүүгийн хуульд тогтоомжид заасан бүх насаар хорих ялын эрх зүйн зохицуулалт дутмаг, цаашид боловсронгуй болгох шаардлагатай*" гэсэн дүгнэлтийг хийж байна.

Санал

1. Эрүүгийн хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах,эрх зүйн шинэчлэлт хийх, хуулийн зүйл, хэсэг, заалтын уялдаа холбоог сайжруулах;
2. Бүх насаар хорих ялтай хоригдлын"*хүний эрх, эрх чөлөө*"-г хангах;
3. Хоригдлыг нийгэмшүүлэх, хөдөлмөрөөр хүмүүжүүлэх, ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэгдсэн дорвитой арга хэмжээ авах нь хуулийн хэрэгжилтэд эерэгээр нөлөөлөх хүчин зүйл болох юм.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. эмхтгэл. 1992. №1;
2. Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл. эмхтгэл. УБ. 2016. №07;
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл. эмхтгэл. 2017.№.24;
4. Монгол Улсын хууль тогтоомжийн сан;
5. Улсын дээд шүүх. Ханнс Зайделийн сан. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ. 2010;
6. Иргэний ба улс төрийн эрхийн олон улсын пактын хэрэгжилтийн талаархи Монгол Улсын ээлжит 6 дахь тайлан. УБ. 2015;
7. Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулгын Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид 2017 онд хүргүүлсэн албан бичиг;
8. Б.Батцэрэн. Хүнийг удаан хорьсноос хүмүүжүүлэх нь чухал. Өдрийн сонин. 2018.12.08;
9. Д.Ганбат. Шоронжсон хуулийг халж, энэрэнгүй эрүүгийн хуультай боллоо. Ардын эрх. УБ. 2015.12.09;

[33] С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн хуулийг эмчлэх нь. Хууль зүй, дотоод хэргийн яамны албан ёсны сайт. 2017.

10. С.Гантулга. Б.Энхболд. Эрүүгийн хуулийг эмчлэх нь. 2018. Хууль зүй, дотоод хэргийн яамны албан ёсны сайт;
11. Д.Дорлигжав. Гэмт хэргийн хохирлоо барагдуулсан тохиолдолд заавал хорих ялаар шийтгэхгүй. Itoim.mn. 2015.12.04;
12. Д.Дорлигжав. Ялын бодлогыг ялгавартай болгосноор хохирол барагдаж, шоронжилт багасна. Сонин. сайт. 2015.02.09;
13. М.Ичинноров. Бүх насаар хорих ял бол цаазаас ч илүү том ял. 2017.11.29. Mongol.com;
14. О.Мөнхсайхан. Цаазаар авах ялыг хасах нь Үндсэн хуулийн өмнө хүлээсэн үүрэг. Trends.mn. 2015.04.16;
15. О.Мөнхсайхан. Цаазаар авах ялыг халснаар Эрүүгийн хууль сул болчихсон гэсэн үг биш. ikon.mn. 2017.10.18;
16. Х.Нямбаатар. Хүчингийн гэмт хэрэг бүх насаар хорих ялтай.news.mn. 2017.10.30;
17. Н.Учрал. Эрүүгийн эрх зүйд тогтоосон уламжлалт дэг жаяг.news.mn. УБ. 2017;
18. Г.Энхбаатар. Эрсдэл дагуулсан Эрүүгийн хууль. Ардын эрх. 3225.(502). 2006.12.29;
19. Б.Энхбаяр. Бүх насаар нь хорих ял үнэндээ там юм шүү дээ. Өдрийн сонин. 2018.04.03;
20. Б.Энхбаяр. Эрүүгийн хууль бол төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх бодлого.Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны албан ёсны сайт. 2017;
21. Эмнести интернэйшнл. Цаазаар авах ялыг халах үндэслэлүүд. 2016. албан ёсны сайт.

ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ ТОГТООХ ШИНЖИЛГЭЭГ АШИГЛАХ БОЛОМЖ

THE USE OF THE RESOURSES OF CRIME SITUATIONAL EXPERTISE

Т.Бүрэнхаан
Дотоод хэргийн их сургуулийн докторант, Хөвсгөл аймгийн
Шүүхийн шинжилгээний албаны ахлах шинжээч, цагдаагийн ахмад
Burenkhaan T.
Ph.D student of University of Internal Affairs, Police captain,
Senior expert of Forensic Department, Khuvsgul Province

Хураангуй: Өнөөгийн байдлаар гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээ нь Шинжлэн магадлах ухааны салбарт хэрхэн төрөлжиж ангилагдах, ямар байр суурь эзлэх талаар криминалистикийн сурах бичиг, ном зохиолуудад нэгдмэл ойлголт байдаггүй. Энэхүү илтгэлийн зорилго нь шинжлэн магадлах ухааны салбарт гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээний талаарх байр суурь, чиг хандлага бүтцийг тайлбарлах, шинжилгээний объект, шинжилгээний чиглэлийн талаар судлаачийн байр суурийг тодорхойлоход оршино.

Abstract: There is still no consensus in the criminalistics literature on the place of forensic crime situational investigation in the current classification and on its right to independent existence. The purpose of this article is to describe the existing points of view about the nature of forensic situational investigation and to determine the author's position on its object, subject and tasks.

Түлхүүр үгс: Гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээ, шинжлэн магадлах ухаан, шинжлэх ухааны хэлэлцүүлэг, нөхцөл байдал тогтоох шинжилгээний объект, субъект.

Keywords: Crime situational expertise, forensic investigation, scientific discussions, object, subject and tasks of forensic situational investigation.

Оршил

Энэхүү судалгааны ажил нь ерөнхий утгаараа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгчийн гэмт хэргийн газрын үзлэгээр нотлох баримтыг илрүүлж, бэхжүүлж буй ажиллагаа, мөр үүсэх зүй тогтол, гаж тогтол зэргийг шинжлэх ухааны тусгай мэдлэг бүхий шинжилгээ болохыг тодорхойлохын зэрэгцээ процессын болон процессын бус оношлол зүйн шинжилгээг хийж, нотлох баримтуудын хоорондын харилцан хамаарал, зүй тогтлыг судалж, гэмт хэргийн болж өнгөрсөн үйл явдлыг материаллаг нотлох баримтын үндэслэлтэйгээр сэргээн дүрслэх үйл ажиллагааны онол арга зүйг боловсруулж буй ажил юм.

Тухайн төрлийн шинжилгээний онол, арга зүйг боловсруулснаар гэмт хэргийн илрүүлэлт, мөрдөн шалгах, яллах, шүүхээр шийдвэрлэх ажиллагаанд маш том дэвшил гарна гэдэгт судлаачийн зүгээс итгэлтэй байна. Тухайлбал, өнөөгийн нийгэмд ард иргэдийн дунд эргэлзээ төрүүлэхүйц нийгмийг цочроосон

маш олон гэмт хэргийн жишээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч байна. Эдгээр хэрэг маргааныг шинжлэх ухааны үндэслэлтэй үнэнээр шийдвэрлэхийн тулд бидний үйл ажиллагаанд шинэчлэл, технологийн дэвшил, мэргэшсэн мэдлэг маш их хэрэгтэй байгаа учраас дээрх шинжилгээний онол арга зүйг боловсруулж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах боломжийг судлан тулгамдаж буй асуудлыг хөндөв.

Гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээний бүтэц, ангилалын асуудал

Гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээг хэрэглэх санааг анх 1977 онд одоогийн Оросын Холбооны улсын эрдэмтэн Г.Л.Грановский "Криминалистикийн нөхцөл байдал тогтоох шинжилгээ" сэдэвт илтгэлээр гаргаж ирсэн бөгөөд тухайн төрлийн шинжилгээг шинжлэн магадлах ухааны салбар гэж үзсэн юм. Тэрээр энэхүү илтгэлдээ гэмт хэргийн газар нь тухайн нөхцөл байдал тогтоох шинжилгээний объект гэж үзсэн бөгөөд үзлэгээр илрэх мөр болон нотлох баримтуудыг судалсны үндсэн дээр гэмт хэрэг үйлдэх аргыг тогтоож, үйлдсэн үйлдлүүдийн дарааллыг шинжлэх боломжтой гэж үзсэн.[1]

Дараа нь 1978 онд В.П.Петров "Нөхцөл байдал тогтоох шинжилгээ" гэсэн нэр томьёог шүүх эмнэлгийн салбарт нэвтрүүлсэн бөгөөд энэ нь Л.Г.Грановскийн нэгэн адил хэрэг явдлын байдалд дүн шинжилгээ хийх, гэмт хэрэгтний ул мөрийг нэгтгэн дүгнэх гэсэн утгатай байв. Гэсэн хэдий ч, түүний хэрэглээний хүрээг харгалзан шийдвэрлэх ажлуудын цар хүрээг түүний зүгээс нэлээд нарывчилсан бөгөөд ямар нэгэн гэмтэл үүссэн дараалал болон хэргийн бодит байдалтай хэрхэн нийцэж байгааг судлах боломжтой гэж дүгнэсэн юм.[2]

Түүний дараа В.М.Комаринец, Ю.И. Ильченко, Д.А.Турчин, В.Е.Лапшин зэрэг эрдэмтдийн бүтээлүүдэд дээрх нөхцөл байдал тогтоох шинжилгээний талаар дурдагдаж байсан бөгөөд тухайн зүйл хэт ерөнхий хэлбэрээр бичигдэж байлаа. Эдгээр эрдэмтэд нь гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээг дэмжигчид байлаа. Харин 1978 онд хэвлэгдсэн А. И. Винберг эрдэмтний "Криминалистикийн нөхцөл байдал тогтоох шинжилгээ дэх оношлогоо ба адилтгал 1979 онд хэвлэгдсэн А. И. Винберг, Н.Т.Малаховская нарын "Шинжлэн магадлах ухааны ерөнхий арга зүйн асуудал" зэрэг бүтээлүүдэд Л.Г.Грановскийгийн өмнө дурдсан санааг үндэслэн тэд шинжээчдийн үйл ажиллагаанаас хамаарч нөхцөл байдал тогтоох шинжилгээ нь үйл явдлын зураглал гаргах, цаг хугацаа, байр, бүтэц, үе шатыг тодорхойлдог гэсэн дүгнэлтэд хүрсэн. Мөн гэмт хэргийн ул мөрөөр хэрэг үйлдэхэд оролцсон хүмүүсийн үйл хөдлөл, тоо, харилцан хамаарлыг мөр үүссэн зүй тогтол болон бусад зүйлээр тогтоож буй ажил юм. Тухайн төрлийн шинжилгээ нь иж бүрэн, цогц шинжилгээ гэдгийг цохон тэмдэглэсэн[3].

Дээрх асуудлыг А. И Винберг., Н.Т.Малаховская. нар судалж дүгнэхдээ төрөл бүрийн нотлох баримтуудын шинж байдлыг шинжлэн судалсныг үндэслэн

[1].Г.Л.Грановский"Криминалистическая ситуационная экспертиза места происшествия" /1977 он. 3-5 дахь тал.
[2]В.Л.Попов, В.Б.Шигеев, Л.Е.Кузнецов. "Судебно-медицинская баллистика.", 2002. Стр 656.
[3]А. И. Винберг"Идентификационная, диагностическая и ситуационнаякриминалистическаяэкспертиза" // Советскоегосударство и право.1978. № 9. С. 73—78.

болж өнгөрсөн үйл явдлын дүр зураглалыг бий болгож тодорхойлдог цогц шинжилгээ гэж үзсэн байна. Одоогийн байдлаар ОХУ-д гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээний ерөнхий онол, аргазүйг боловсруулсан байдал нэгдсэн ойлголт алга байна.

Тухайлбал В.В.Гарманов нөхцөл байдал тогтоох шинжилгээ нь гэмт хэргийн үйл явдлыг бүхэлд нь болон бие даасан элементүүдийг хэргийн газарт байх ул мөр, эд мөрийн баримтаар сэргээн дүрслэх, дүр зураг гаргах чиглэлээр тус бүрийн мэргэшсэн шинжээчдийн хийсэн цогц шинжилгээ гэж үзсэн байдаг. А.Ю.Бутирин нь нөхцөл байдал тогтоох шинжилгээг шинжлэн магадлах салбарын бие даасан төрөл гэж үздэггүй байсан бөгөөд үйл явдлыг материаллаг байдлаар сэргээн дүрслэхэд чиглэсэн тухайн шинжилгээний дэд хэсгүүдийг дурдсан байна.[4]

Харин Х.П.Майлис, В.Д.Исаков, И. А. Гедыгу-шева, А. Н. Архиповой, Н. Н. Китаева, А. Б. Гребенькова в соавторстве с Н. В. Заниным, З. М. Луневым, А. А. Теньковым нарын эрдэмтдийн бичсэн ном сурах бичгүүдэд нөхцөл байдал тогтоох шинжилгээний онол арга зүйн талаар дэлгэрэнгүй, нарийвчилсан байдалтай бичигдсэн байдаг ба тухайн эрдэмтэд нь уг шинжилгээг Шинжлэн магадлах ухааны шинжилгээний төрөл зүйл гэж үзэж байсан. Занин, З.М.Лунев, А. А. Тенков нар нь шинжлэн магадлах салбарын шүүх эмнэлгийн хүрээнд авч үзсэн. Гэхдээ И. А. Гедыгу-шева хүний биед гэмтэл үүсэх, шалтгаан тогтоох, гэмт үйлдэл, үйл явцыг сэргээн дүрслэх нь шүүх шинжилгээний нэг хэлбэр мөн гэж үзэж байв.[5]

Эдгээр эрдэмтэд нь материаллаг нөхцөл байдал тогтоох шинжилгээг янз бүрийн ул мөр, эд мөрийн баримт, гэмт хэрэг үйлдсэн зэвсэг, түүнд хамааралтай бусад нотлох баримт тэдгээрийг шинжлэн судалж дүгнэлт гаргадаг тул тусгай мэдлэг бүхий шинжилгээний төрөл гэж үзсэн. Үүний зэрэгцээ энэхүү шинжилгээг галт зэвсэг, авто осол, шүүх эмнэлгийн болон бусад төрлийн шинжилгээний хүрээнд илүү ашигладаг болохыг хүлээн зөвшөөрч бие даасан шинжилгээ төрөл болгохоор тогтсон.[6] 2000 онд ОХУ-ын Хууль зүйн яам Нөхцөл байдал тогтоох шинжилгээг шинжилгээний төрөл болгон батлсан ч 2009 онд хассан байдаг.[7]

Дээрх эрдэмтдийн үзэл бодол, байр суурийг судлан үзсэний зэрэгцээ манай улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг судлаачийн зүгээс харж гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээний цар хүрээ, ойлголт, бүтэц, ангиллын асуудлыг дараах байдлаар тодорхойлов.

Нөхцөл байдал тогтоох шинжилгээ нь өөрөө маш өргөн утга, агуулга бүхий сэдэв бөгөөд нөхцөл байдал гэх нэр үг нь нийлэмж хорших байдлаар хэрэглэгдэх ба утгын хувьд маш өргөн цар хүрээг илэрхийлэх тул улс төрийн нөхцөл байдал, нийгмийн нөхцөл байдал, маркетингийн нөхцөл байдал гэх

[4]Винберг А. И., Малаховская Н. Т."Судебная экспертология. Обще теоретические и методологические проблемы судебных экспертиз": учеб. пособие. Волгоград: ВСШ МВД СССР, 1979. 183 с.
[5]Гарманов В. В. О предмете и методе ситуационной экспертизы // Судебная реформа и эффективность деятельности органов суда,прокуратуры и следствия. IV научно-практическая конференция молоды хученых: тезисы выступлений. СПб., 2001. С. 119–123.
[6]Бутырин А. Ю. Теория и практика судебной строительно-технической экспертизы.М.: «Городец», 2006. 544 с.
[7]Носова Анастасия Александровна. "Проблемы классификации ситуационных экспертиз" Matters of Russian and International Law. 2018 С 324-325

мэтчилэн бүхий л зүйл дээр тухайн утгыг илэрхийлнэ. Бид тухайн сэдвийн нэр томьёог хэрэглэхдээ манай улсын зарим судлаачид "нөхцөл байдлын шинжилгээ"[8] гэж үзэж буй нь судлаачийн зүгээс эдгээр утга санааг илэрхийлж байгаа зүйлс,нөхцөл байдал, дүр зураглалаас тухайн агуулга бүхий үр дүнг тогтоож байгаа зорилготой нь харилцан уялдаа холбоо бага байна гэж үзээд"нөхцөл байдал тогтоох шинжилгээ"[9] гэж үзсэн. Энэ төрлийн шинжилгээ нь эдийн засаг, нийгэм, улс төр гээд маш олон хэлбэрээр хийгдэх тул шийдвэрлэж буй асуудлын хүрээг хязгаарлаж гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээ гэж тодорхойлсон болно.

Гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээ нь: Гэмт хэргийн болсон бодит үнэн нөхцөл байдлыг тогтоох зорилгоор тодорхой шинжлэх ухааны арга зүйн дагуу шаардагдах тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн, шинжээч мэргэжилтнүүд шинжилгээний объектийг шинжлэн судалж хоорондоо уялдаа холбоо бүхий хамтарсан цогц шинжилгээ хийж дүгнэлт гаргах үйл явц юм.

Хамтарсан цогц шинжилгээ гэж шинжилгээний зүйлийг хэд хэдэн чиглэлээр мэргэшсэн шинжээчид нэгдэж шинжлэх ба гаргасан дүгнэлтүүд нь нэг нэгэнтэйгээ нөхцөлдөнө. Өөрөөр хэлбэл, тус тусдаа дүгнэлт гаргах боломжгүй бөгөөд хийсэн шинжилгээ нь зөвхөн нэг асуудлыг шийдэхэд чиглэгдэнэ. Чиглэл чиглэлээр хийсэн шинжилгээ нь дангаараа дүгнэлтэд хүрэх боломжгүй, харин нэг нэгэнтэйгээ уялдаж байж нотолгооны ач холбогдолтой болно гэсэн үг. Жишээлбэл шүүх эмнэлэг, Физик, галт зэвсгийн шинжээчид хамтарч цогцсод үүссэн шарх сумны хошуунаас үүссэн байна гэж дүгнэнэ.[10]

Нөхцөл байдал тогтоох шинжилгээ нь дараах зүйлийг шийдвэрлэх хүрээнд хийгдэнэ. Үүнд:

1. *Гэмт хэргийн бодит байдлыг сэргээн дүрслэх, зураглал гаргах* (англи-crime scene reconstruction, орос- Экспертизыпореконструкции): Гэмт хэргийн болж өнгөрсөн байдлыг хэргийн газарт болон зохиомол орчинд тодорхой мөрүүдэд болон шинжилгээний объектод адилтгалын болон оношлогооны шинжилгээ хийж шинжилсний үндсэн дээр хоорондын зүй тогтлыг судалж үйлдлийн дараалал тогтоох, зураглал гаргах, сэргээн дүрслэх ажиллагаа юм. Тухайн шинжилгээ нь гэмт хэргийн гэрч хохирогч, сэжигтэн болон яллагдагчийн өгсөн мэдүүлгийг үнэн зөв эсэхийг шалгах, бодит байдлыг тогтоох ач холбогдолтой.
2. *Гэмт хэргийн үйл явдлыг хэсэгчилсэн болон нэгтгэсэн байдлаар мөрдөгч, оролцогчийн дэвшүүлсэн хувилбар, таамаглал, асуултыг шинжилгээгээр нотлох эвсэл үгүйсгэх*: Тухайн шинжилгээ нь мөрдөгчийн гэмт хэргийн болсон байдлын талаар дэвшүүлсэн хувилбар, (таамаглал) эргэлзээтэй асуудлын үнэн зөв эсэхийг тодорхой арга зүй, нотлох баримтын үндэслэлтэйгээр процессын шинжилгээ хийж дүгнэлт гаргаж буй ажил юм.

[8]М.Чинбат, "Хэргийн газрын үзлэгт нөхцөл байдлын шинжилгээг ашиглах нь" 2008 он, Улаанбаатар хот, магистрын ажил, сэдэв, Б.Баяр "Гэмт хэргийн нөхцөл байдлын шинжилгээний өнөөгийн чиг хандлага" илтгэл 2018 он.
[9]Б.Бат-Эрдэнэ "Криминалистик" 2017 он, 57 дахь тал.
[10]Б.Лхагвасүрэн "Шинжлэн магадлах ухаан" Улаанбаатар хот, 2018 он, 147 дахь тал.

3. *Шинжилгээнд ирүүлсэн хэргийн материал болон шаардагдах нотлох баримтыг үндэслэн гэмт хэргийн нөхцөл байдлыг шинжилгээгээр нотлох эвсэл үгүйсгэх*: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэргийн нөхцөл байдалд талуудын байр суурь зөрөлдөж нотлох баримтуудын зүй тогтол нь нотолж буй үйл ажиллагаанаасаа гажиж эргэлзээ төрүүлэх байдал бий болоход тодорхой цуглуулсан баримт материалуудад шинжилгээ хийж дүгнэлт гаргаж буй үйл ажиллагаа юм.

Шинжилгээг шинжлэх ухааны ангиллын хувьд шийдвэрлэж буй агуулгаар нь:

1. Оношилгооны шинжилгээ /диагнастическая экспертиза/;
2. Адилтгалын шинжилгээ /идентификационная экспертиза/;
3. Нөхцөл байдал тогтоох шинжилгээ /ситуационная экспертиза/;
4. Ангиллын шинжилгээ /классификационная экспертиза/[11] гэж ангилж авч үзсэн байна.

Нөхцөл байдал тогтоох шинжилгээ өргөн утгаараа адилтгалын болон оношлогооны шаардлагатай бүх төрлийн шинжилгээг агуулж байдаг бөгөөд тэдгээрийн бүхий л ач холбогдол бүхий дүгнэлтийн үр дүнд шинжилгээ хийж дүгнэлт гардаг. Тийм учраас энэ төрлийн шинжилгээ нь шийдвэрлэж буй агуулгын хувьд бие даасан шинжилгээний төрөл болох нь зүйн хэрэг гэж үзсэн.

Өнөөгийн байдлаар манай улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн газарт үр дүнг нь хэрхэн, яаж, хэн шинжилж, нотлох баримт болгохыг нь мэдэхгүйгээс шууд орхигддог процессын оношлол зүйн шинжилгээ бүрэн хийгдэх боломж бүрдэх бөгөөд тухайн дүгнэлтийн үр дүнг хоорондоо уялдаа холбоо бүхий гэмт хэргийн нотлох баримт болгож үнэлүүлэх юм. Ийм учраас гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээ нь цаашид шинжлэн магадлах ухааны хөгжлийн цар хүрээний илрэл болж чадах юм.

Гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах боломж

Гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээний зорилго нь: Мөрдөгч гэмт хэргийн нөхцөл байдлыг хуулийн дагуу тогтоох үүрэгтэй бөгөөд гэмт хэргийг нотлох баримтаар үнэн нөхцөл байдлыг тогтоохын тулд нотлох баримт, мэдээллийг цуглуулах бөгөөд шаардлагатай бусад таньж олуулах, мөрдөн байцаалтын туршилт, мэдүүлгийг газар дээр нь шалгах зэрэг тодорхой ажиллагааг явуулдаг. Энэ ажиллагааны үр дүнд тухайн мөрдөгчид хэргийн болсон байдлын талаар дотоод илтгэл төрдөг. Үүний дараа мөрдөгч, прокурор, шүүгч нар нь тухайн хэргийг хянан хэлэлцэж нотлох баримтыг дотоод итгэлээр үнэлж шийдвэрлэдэг. Эндээс үүсэж буй асуудал нь мөрдөгч, прокурор, шүүгчийн "дотоод итгэл" нь хэр найдвартай вэ? гэх. Энэ асуудлыг боловсронгуй болгохын тулд түүнд шинжлэх ухааны дэмжлэг үзүүлэх асуудал юм.

Манай улсын шинжлэн магадлах ухааны салбарт шинжилгээний төрөл ангиллыг тодорхой тусгасан эрх зүйн баримт бичиг төдийлөн гараагүй байна. Судлаач бидний үзэж байгаагаар тухайн төрлийн шинжилгээг хийхэд хориглосон хууль болон журам бусад эрх зүйн акт байхгүй тул уг шинжилгээг хийж,

[11]А.И Винберг, Н.Т. Малаховская"Судебная экспертология", Волгоград.г179. г.Стр 155

эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэвтрүүлж, шүүхэд нотлох баримт болгон үнэлүүлэх зам нээлттэй гэж үзэж байна. Харин уг шинжилгээг хэрхэн яаж хийх вэ? гэх асуудал үлдэж байна. Энэ нь тухайн шинжилгээний ерөнхий болон тусгай арга зүйг боловсруулах явдал юм. Мөн тус шинжилгээг хийх эрх бүхий тусгай мэдлэгтэй шинжээчийг бэлдэх асуудал тулгарч байна.

Өнөөдөр тухайн шинжилгээний аргачлал, арга зүйг боловсруулснаар маш их ач холбогдолтой дэвшил манай шинжлэн магадлах ухааны салбарт гарах юм. Үүнд:

- Шинжээч, мэргэжилтний эзэмшсэн тусгай мэдлэгийн цар хүрээг задалж төрөлжүүлж, нарийвчилсан,мэргэшсэн мэдлэг эзэмшүүлсэн байх шаардлагатай байна. Харин өнөөдөр шинжилгээ хийж байгаа болон хэргийн газар ажиллаж байгаа шинжээч, мэргэжилтэн нь хэтэрхий өргөн цар хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа нь гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээг хийх боломжгүй. Уг шинжилгээ нь салбар, төрөл тус бүрээр мэргэшсэн байж нарийвчилсан шинжилгээ хийх процесс ажиллагаа юм./ Жишээ нь: Гарын мөрний шинжээч,мөр судлалын шинжээч, физикийн шинжээч, химийн шинжээч, биологийн шинжээч гэх мэдлэгийн төрөл тус бүрдээ мэргэшсэн шинжээч нь процессийн оношлол зүйн болон адилтгалын шинжилгээг хийж хоорондоо уялдаа холбоо бүхий нэг ерөнхий дүгнэлт гарна.
- Орчин үеийн дэвшилтэт техник технологийг ашиглана../Жишээ нь: Шинжилгээний дүгнэлтийг ард иргэд болон гэрч хохирогч, мөрдөгч, прокурор, шүүгчдийн бүгдэд ойлгомжтой хэлбэрээр 3D, 4D байдлаар зураглал гаргаж дүрс бичлэгээр болон биет хэлбэрээр гаргадаг болох.

Өнөөдөр нийгэмд олон төрлийн маргаантай, асуудалтай маш олон гэмт хэргүүд байна. Энэ нь Шүүхийн шинжилгээний байгууллага болон цагдаагийн байгууллагыг маш муухайгаар нийгэмд харагдуулах хандлага цахим сүлжээ болон мэдээллийн хэрэгслүүдээр иргэдийн дунд тархаж байна. Энэ нь гаднын нөлөөтэй, нөлөөгүй гэх мэт асуудлууд юм. Тухайн эдгээр гэмт хэрэг бүхэнд мэдлэгийн салбар тус бүрээр мэргэшсэн шинжээчдийн баг бүрдүүлэн нөхцөл байдал тогтоох шинжилгээг хийсэн бол хэдэн хүний дотроо бэтгэрч яваа гомдол, эргэлзээ тайлах байсан бол гэж судлаачийн зүгээс харж байна.

Өнөөдөр тухайн шинжилгээний шийдвэрлэх асуудлын агуулгыг мөрдөгч хуулиар хүлээсэн үүргээрээ зохион байгуулж байна. Гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээг мөрдөгч хэргийн газрын үзлэг хийх үйл ажиллагаатай хольж болохгүй. Энэ хүү шинжилгээ нь хамтарсан, иж бүрдэл, цогц байдлаар хийгдэх бөгөөд хэргийн газрын үзлэг хийх ажиллагааны үед хийгдэж болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шинжээчээр оролцож болохгүй тохиолдол нь "тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, прокурор, шүүгч, иргэдийн төлөөлөгч, оролцогч, бусад оролцогчийн хувиар оролцсон бол"[12] гэж заасан байна. Энэ нь хэргийн газар дээрээс мэргэжилтний хувиар оролцоод илрүүлсэн ул мөр эд мөрийн баримтад шинжилгээ хийж болохгүй асуудал юм. Иймд тухайн нөхцөл байдал тогтоох шинжилгээг хийж буй

[12] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он 10.1, 1-р зүйл.

мэргэжилтэн, шинжээч нарыг хэргийн газрын үзлэг хийх бүрэлдэхүүнд мэргэжилтний хувиар оролцуулах нь хууль зөрчих асуудал үүсэж байгаа юм.

Энэхүү шинжилгээ нь тухайн хэргийн газарт бий болсон мөрний зүй тогтол, шинж чанар, цаг хугацаа, байгалийн хүчин зүйл тэр бүгдээс мөр хувирч өөрчлөгдөх процесс, үүсэх зүй тогтол, гаж тогтлыг шинжилж оношилгооны шинжилгээ /диагностическая экспертиза/ Адилтгалын шинжилгээ /идентификационная экспертиза/-ээр тогтоосон дүгнэлтүүдийг тусгай шинжлэх ухааны арга зүйг ашиглан гэмт хэргийн бодит нөхцөл байдлыг тогтоох буюу нэг асуудлыг шийдсэн нэгтгэсэн дүгнэлт гаргана. Америкийн нэгдсэн улсынгэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд шинжээчид багаар ажилладаг жишиг нь энэ төрлийн нөхцөл байдал тогтоох шинжилгээтэй төстэй юм. Хэргийн газрын үзлэгийн мөрдөгч (Crime scene investigator) гэж мэргэшсэн туршлагатай мөрдөгчийн удирдлага дор төрөл бүрийн мэргэжилтэн, шинжээчдийн баг бүрэлдэхүүнээр үзлэгийн ажиллагааг шууд явуулдаг байна. Харин хэргийн газрын үзлэгээр илэрсэн мөр болон нотлох баримтыг цуглуулан, шаардлагатай зүйлд нь шинжилгээ хийж протокол үйлдээд схем зураг гарган эрүүгийн мөрдөгчид шилжүүлэн өгдөг бөгөөд тухайн мөрдөгч нь хэргийг үргэлжлүүлэн шалгадаг байна.[13] Энэ үйл ажиллагаанаас харахад гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээтэй төстэй юм шиг боловч дүгнэлт гаргадаггүй, тодорхой арга зүй, онолын ямар нэгэн баримт материал бүрдүүлдэггүй юм байна.

Одоогийн байдлаар манай улсад гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээний зарим агуулгатай дүйх маргааныг Мөрдөн шалгах туршилт, Мэдүүлгийг газар дээр нь шалгах зэрэг ажиллагаагаар шийдвэрлэж байна.

Мөрдөн шалгах ажиллагааны туршилтын тухайд: Энэхүү ажиллагаа нь хуульд "Хэрэгт ач холбогдолтой тодорхой нөхцөл байдал, үйл явдлыг сэргээн дүрслэх шаардлагатай бол мөрдөн шалгах туршилт хийж болно".[14] гэж заасан байх бөгөөд энэ төрлийн ажиллагааг явуулж буй эрх бүхий мөрдөгч нь голчлон өөрийнх нь эзэмшсэн мэдлэгийн хүрээнд тухайн ажиллагааг зөвхөн мэдүүлгийн хүрээнд хийж байна. Хийгдсэн туршилт нь нотлох баримтын эх сурвалж болохдоо оролцогчдын гарын үсэг зурагдсан туршилтын тэмдэглэл байна. Харин гэмт хэргийн нөхцөл байдлыг тогтоох шинжилгээний хүрээнд энэхүү ажиллагаа нь тодорхой арга зүйгээр шинжлэх ухааны үндэслэл бүхий шинжилгээний дүгнэлт болох нь ач холбогдолтой. Тухайн шинжилгээний дүгнэлт нь ойлгомжтой маргаангүй байдлыг бий болгоно.

Мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагааны тухайд: Энэхүү ажиллагаа нь хуульд "Илэрсэн нөхцөл байдлыг шалгах, явсан замыг тогтоох, зааж өгсөн газрыг шалгах, урьд өгсөн мэдүүлгийн үнэн зөвийг харьцуулан тогтоох зорилгоор яллагдагчийн зөвшөөрснөөр, эсхүл мөрдөгчийн санаачилгаар мэдүүлгийг газар дээр нь шалгаж болно"[15] гэж заасан байх бөгөөд мэдүүлгийн үнэн зөвийг харьцуулан тогтоох гэх зорилгыг агуулснаас мөрийг үүсгэсэн зүй тогтлыг шалгах гэсэн асуудал байдаггүй юм. Энэ төрлийн ажиллагааг явуулж буй эрх бүхий мөрдөгч шалгаж буй мэдүүлэг үнэн зөв эсэхийг хүний ярьсан зүйлээр үйл явдлыг

[13] "Crime scene investigation in action" (CSI) information published Feb 278 2014.
[14] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 23.5.1-р зүйл.
[15] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 25.6.1-р зүйл.

шалгасан ажиллагаа болж байгаа юм. Харин гэмт хэргийн нөхцөл байдлыг тогтоох шинжилгээний хүрээнд тэрхүү яллагдагчийн мэдүүлгийг харьцуулах зүйл нь шинжилгээний дүгнэлтээр тодорхой гарч ирэх ач холбогдолтой. Тухайлбал хэргийн газарт байх мөрнүүдийн байрлал, зүй тогтол гэх мэт.

Иймд гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээг тодорхой хэргийн төрлүүд дээр хийж ажиллах шаардлагатай байна.

Дүгнэлт

Одоогийн байдлаар Монгол Улс, Оросын холбооны улсын шинжлэн магадлах ухааны салбарт болон гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээний ерөнхий онол, арга зүйг боловсруулсан байдал, нэгдсэн ойлголт алга байна. Судлаачийн зүгээс эрдэмтэн судлаачдын бичсэн илтгэл, эрдэм шинжилгээний бүтээл, сэтгүүл болон гадаадын зарим улс орны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглаж байгаа арга, технологийг судлан үзэж өөрийн улсын шинжлэн магадлах ухааны салбарт гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээ онолын хувьд хэрхэн ямар байр суурь эзлэх талаар дурдлаа. Тухайн шинжилгээний онцлог, ойлголт, цар хүрээ, төрөл ангиллыг цухас дурдсан болно.

Манай улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэмт хэргийн нөхцөл байдал тогтоох шинжилгээг ашиглахад мэргэжилтэн болон шинжээч нарын ерөнхий мэдлэгийн цар хүрээг задалж сонирхсон чиглэлээр нь нарийн мэргэшүүлэх, тухайн нөхцөл байдал тогтоох шинжилгээний арга зүйг боловсруулах, шинжилгээ хийх эрх бүхий шинжээч боловсон хүчнийг бэлдэх зэрэг бусад үүсэх хууль, эрх зүйн акт, арга зүй, технологийн тулгамдаж буй асуудлыг нээн харуулахыг зорив.

Эх сурвалжийн жагсаалт

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017;
2. Б.Бат-Эрдэнэ. “Криминалистик”. Уб., 2017;
3. Б.Лхагвасүрэн. “Шинжлэн магадлах ухаан”. Уб., 2018;
4. М.Чинбат. “Хэргийн газрын үзлэгт нөхцөл байдлын шинжилгээг ашиглах нь”. Уб., 2008;
5. Б.Баяр. “Гэмт хэргийн нөхцөл байдлын шинжилгээний өнөөгийн чиг хандлага” илтгэл. 2018;
6. Г.Л.Грановский. “Криминалистическая ситуационная экспертиза места происшествия”. 1977;
7. В.Л.Попов, В.Б.Шигеев, Л.Е.Кузнецов. “Судебно-медицинская баллистика”. 2002;
8. А.И.Винберг. “Идентификационная, диагностическая и ситуационная криминалистическая экспертиза”. // Советское государство и право. 1978. №9;
9. А.И.Винберг, Н.Т.Малаховская. “Судебная экспертология. Обще теоретические и методологические проблемы судебных экспертиз”: учеб. пособие. Волгоград: ВСШ МВД СССР, 1979;
10. В.В.Гарманов. О предмете и методе ситуационной экспертизы // Судебная реформа и эффективность деятельностиорганов суда,прокуратуры и следствия. IV научно-практическая конференция молодых ученых: тезисы выступлений. СПб., 2001;

11. А.Ю.Бутырин. Теория и практика судебной строительно-технической экспертизы. М.: «Городец», 2006;
12. А.И.Винберг, Н.Т.Малаховская. "Судебная экспертология". Волгоград. 1979;
13. Носова Анастасия Александровна. "Проблемы классификации ситуационных экспертиз" Matters of Russian and International Law;
14. "Crime scene investigation in action"(CSI) information published Feb 278 2014.

БИЧИЛ МӨРИЙН ШИНЖИЛГЭЭ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ: ГЭМТ ХЭРЭГ ИЛРҮҮЛЭХЭД БИЧИЛ МӨР АШИГЛАХ ОНЦЛОГ

MICROTRACE'S EXAMINATION, CURRENT ISSUES: FEATURES OF USING OF THE MICRO-TRACES IN SOLVING A CRIME

Г.Ганцэцэг
Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Мөр судлалын лабораторийн мэргэшсэн шинжээч, цагдаагийн хошууч
Gantsetseg G.
Qualified expert, Trasology Laboratory,
National Institute of Forensic Science, Police Major

"Бидний бий болгосон ертөнц бидний сэтгэлгээний эцсийн дүн тул бүрдүүлсэн тэр л маягаараа сэтгээд байвал урагш алхам ахихгүй".
Альберт Эйнштейн

Хураангуй: Манай улсад гэмт хэрэг, гэмт хэрэгтнийг тогтооход бичил мөрөөр хийх шүүх шинжилгээг өнөө хүртэл бүрэн гүйцэтгэж чадахгүй хэвээр байна. Энэ чиглэлээр бидний хийсэн судалгааны ажлын дүнд тогтоосон тулгамдаж буй асуудал нь: - бичил мөрийн ойлголт, төрөл ангиллын талаар онолын боловсруулалт дутуу; - бичил мөрийг илрүүлэх, бэхжүүлэх техник хэрэгслийн хангамж хангалтгүй; - бичил мөр илрүүлж бэхжүүлэх, шинжлэх арга, хэрэгсэл, аргачлалыг шинжилгээний байгууллагад нэвтрүүлээгүй; - бичил мөртэй ажиллах мэргэжилтэн, шинжээчийг сургаж бэлтгээгүй зэрэг байгаа бөгөөд эдгээрийн нэг – бичил мөр, бичил объектын онцлогийн талаар энэ сэдэвт хөндсөн болно.

Abstract: Our forensic authorities still cannot fully conduct micro-trace examinations. Based on the results of our research, conducted in this direction, the following topical issues were identified: - incomplete theoretical refinement of the concept and classification of micro-traces; - insufficient supply of equipment and tools for detecting and fixing micro-traces; - the methods, equipments and methodics of detecting, fixing and examining micro-traces have not been introduced into the practice of the forensic authorities; - Qualified specialists and experts in working with micro-traces have not been trained, and our report is devoted to one of them - features of the using of micro-traces in solving a crime.

Түлхүүр үгс: Бичил мөр, бичил объект, бичил мөр судлал, бичил мөрийн шинжилгээ.

Keywords: Micro-traces, micro-particles, microtrasology, microtrace's examination.

Гэмт хэрэг үйлдсэн газар нотлох ач холбогдол бүхий мэдээллийн маш чухал сурвалж болдог тул тэндээс нотлох баримт илрүүлж, бэхжүүлэх, шинжлэх асуудал хууль сахиулах байгууллагад байнга тулгамдсаар ирсэн. Шинжлэх ухаан, технологийн хөгжлийг дагаад, хэргийн газраас бүдүүн тоймын, уламжлалт мөр,

нотлох баримт илрүүлэх нь улам хоцрогдсоор байна. Асуудлын гол нь, эдгээр мөр ач холбогдлоо алдаад байгаадаа биш, гэмт этгээдүүд тэдгээр уламжлалт мөрийг үзэж, судлаж, үлдэж болзошгүй мөрийг үлдээхээс сэргийлэх, баллах зэрэг арга хэрэглэх болсонд оршиж байна.

Гэмт хэрэг илрүүлэхэд бичил мөрийг мэр сэр ашиглаж ирсэн нь нилээд эртнээс уламжлалтай. Тухайлбал, 1861 онд Германы судлаач Лендер бусдыг алсан хэргийг сүхэн дээрээс илрүүлсэн үсээр адилтгаж байсан баримт, криминалистикийг үндэслэгч Ханс Гроссын бүтээл, зохиолч Эмиль Габарио, Эдгар По, Конан Доил нарын зохиолдоо бичсэн санаа, 1900-гаад оны эхээр Германы Пауль Езерих, Георг Попп нарын бичил объектод хийсэн шинжилгээ зэргийг үүнд дурдаж болно. Бичил мөр ашиглах санаа хөгжин хөгжсөөр, 1950-иад оноос эхлэн гэмт хэрэгтнүүдийн хүсэл зоргоос үл хамааран, заавал үлддэг байж таарах бичил мөрийг илрүүлэх, бэхжүүлэх, түүгээр гэмт үйлдэл, гэмт этгээдийг тогтоох асуудлыг лавшруулан судалж, гэмт үйлдэл, гэмт этгээдийг тогтооход түүнийг түлхүү ашиглаж эхэлжээ.

Олон улсын практикаас харахад хэргийн газрын үзлэгээр бичил мөр, илрүүлэх, тусгаарлан авах, процессын хуулийн шаардлагын дагуу бэхжүүлэх асуудлыг шийдвэрлэх нь цогц судалгаа шаардсан их далайцтай ажил байдаг.

Хэргийн газрын үзлэгээр бичил мөр илрүүлэх, тусгаарлан авах ажиллагаа хэргийн газрын бүх байр байдал, түүнийг бүрдүүлэгч элемент бүрийг болон тэдгээрийн ач холбогдол нэг бүрийг яв цав тодорхойлж, анализ хийхийг шаарддаг. Ийм анализ хийснээр хэргийн газарт болж өрнөсөн үйл явдлыг хийсвэрээр сэтгэн сэргээх, түүнд үндэслэн, тухайн үйлдлийг гүйцэтгэсэн этгээд бичил мөр үлдээсэн байж болох газруудыг тогтоох, тогтоосон газарт үзлэг хийж илрүүлэх, илэрсэн мөрийг зөв бэхжүүлэн авах, улмаар хэргийн газар дээр болон лабораторийн нөхцөлд шинжилгээ хийж тухайн бичил мөрийн гарал үүсэл, харъяаллыг тогтоох боломж олддог. Хэргийн газарт үзлэг хийх тактик, төлөвлөгөө боловсруулахад ийм анализ ихээхэн ач холбогдолтой[1].

Хэргийн газрын үзлэгээр бичил мөр илрүүлэх, бэхжүүлэх ажиллагаа өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой, уламжлалт мөртэй харьцуулбал илүү нарийн арга, ажиллагаа шаардсан, бүхэл бүтэн цогц үйл явц байдаг. Бичил мөртэй ажиллах ажиллагаа өвөрмөц онцлогтой бөгөөд практикт туршиж тогтоосон тодорхой схемээр гүйцэтгэх шаардлагатай тул болгоомжгүй хийсэн ямар ч үйлдэл нотлох баримтын мэдээллийн ач холбогдлыг бүр мөсөн алдагдуулж болно[2]. Бичил мөрийн энэ онцлог нь түүнтэй ажиллахад тусгай арга хэрэгсэл, түүнд сайтар бэлтгэсэн, дадал чадвартай мэргэжилтэн шаардлагатайг аяндаа харуулдаг.

Хэргийн газрын үзлэгээр бичил мөр илрүүлэхэд тусгайлан бэлдсэн иж бүрдэл хэрэгсэл төхөөрөмж ашигладаг. Онолын хувьд мөр гэж нэг объектын гадна бүтцийн онцлог нөгөө объектын гадаргуйд хуулбарлагдан үлдсэн тусгалыг хэлэх ч энэ нь зөвхөн дардас мөрийг хэлэх тул бичил мөрийн тухайд бичил зураас, дардасаас гадна макро ба микро хэмжээтэй шохой, будаг, шингэн,

[1] Лузгин И. М. Моделирование при расследовании преступлений. — М., 1981. С. 8.
[2] Бибиков В. В. Микрообъекты в раскрытии и расследовании преступлений. — М., 1985. С. 21.

аливаа объектын хэлтэрхий зэргийг бүхэлд нь багтаах тул энэ бүгдийг бичил мөрд хамааруулж ойлгох ёстой. Бичил мөрийг нилээд өндөр түвшинд хөгжүүлсэн ОХУ-ын эрдэмтдийн үзэл бодлыг харвал бичил мөр, бичил хэсэг, бичил объект гэж өөр өөрөөр нэрлэдэг. Гэвч, хэрэг илрүүлэхэд хэргийн газраас илрүүлсэн эд зүйлийн бичил хэлтэрхий, бичил биет, бичил зураас зэрэгт бичил мөр судлалын шинжилгээ хийж, тэдгээрийн агуулж буй мэдээлэл-танин мэдэхүйн бүтцийг гэмт хэргээс үлдсэн "мөр" хэмээн тогтоож өгч буй тул үүнийг бүхэлд нь бичил мөр гэж нэрлэх нь зүйтэй гэж бид үзэж байна.

Доктор Б.Бат-Эрдэнэ: "Гэмт үйлдлийн орчинд үүссэн гэмт хэргийн бүтцийн элементийн тусгал, үйл явдлын материаллаг ба субъектив дүрслэлийг гэмт хэргийн ул мөр гэнэ"[3] хэмээн тодорхойлсон нь бичил мөрд ч хамаарна гэж бид үзэж байна. Тухайлбал, цоожны хэлэн дээр хөших үед үүссэн бичил зураас, аливаа бодисын зүйлийн үйрмэг, үртэс, хэлтэрхий зэрэг нь материаллаг мөрд хамаарах бол АНУ-ын практикт тохиолдож байсан, гараж дотор гарч байсан үнэртэй усны үнэрээр хөөж хэрэг илрүүлж байсан зэрэг жишээ субъектив тусгалд орно. Гэмт хэргийн бүтэц маш олон элементээс бүрдэх бөгөөд В.Я.Колдин[4] криминалистикийн техник зүйн судлах зүйлийг тодорхойлохдоо эдгээрийг боловсронгуйлан дээрх элемент, мөрийн агуулж буй өөрийнх нь гарал үүсэл, материал, бүтцийн зэрэг мэдээллийг нэгтгэн "мэдээлэл-танин мэдэхүйн бүтэц" гэж нэрлэх болсныг дурдан хэлэх нь зүйтэй.

Бичил мөрийн шинж байдлаас шалтгаалан түүнийг илрүүлэх гэдэг ойлголт өөрөө эздрээтэй. Тухайлбал, хэргийн газарт халдлагад өртсөн объектуудын төлөв байдлаар баримжаалан хаанаас, ямар бичил мөр илрүүлж, бэхжүүлж болохыг хийсвэрээр сэтгэн тогтоох, үүний дараа байж болох бичил мөрийг эрж байгааг нь тогтоох (илрүүлэх) гэсэн хоёр шаттай ажиллагааг хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, бичил мөр илрүүлэхийн тул хэргийн газарт ажиллаж буй мэргэжилтэн түүнийг хаана эрж хайхаа мэддэг байх ёстой гэсэн үг. Бичил мөр хаана байж болохыг тогтоохоос тухайн орчинд үзлэг хийх ажиллагааны тактикийн онцлог хамаардаг. Жишээлбэл, гэмт үйлдлийг цонхоор орж гүйцэтгэсэн тохиолдолд үзлэгийг хол байгаа хаалганаас биш, цонхноос эхэлж хийвэл цаг хэмнэх, хэрэгт ач холбогдол бүхий мөрийг тогтоож, бусад мөрөөс ялгаж ангилах зэргээр, үр өгөөж өндөр байх магадлалтай. Японы практикт хэргийн газраас 600 гипсэн хэв цутган авч байсан тохиолдол гарч байсан нь ач холбогдлоор ангилалгүйгээр, илрүүлсэн бүх мөрийг бэхжүүлэн авч байсны сонгодог жишээ.

Бичил мөр илрүүлэх нь маш нарийн, чимхлүүр ажил тул бичил мөрийг, эсвэл дээрээ бичил мөр агуулж байгаа зөөгч объектуудыг эрэх ажиллагааг дуусгаад лабораторийн нөхцөлд аль болох түргэн хүргэх арга хэмжээ авах шаардлагатай. Бичил мөр агуулж буй эд зүйлийг гадны нөлөөнд автахгүй, тухайлбал нэмж бичил мөр үүсэхгүй, байсан бичил мөр арилж замхрахгүй, найрлага бүтцээ өөрчлөхгүй болгон бэхжүүлэх зэрэг нь бичил мөртэй ажиллах ажиллагааны онцлогийг бүрдүүлдэг.

[3] Б.Бат-Эрдэнэ. Криминалистик /лекцүүд/. Уб. 2017. 14 дэх тал.
[4] Колдин В.Я. Криминалистика: информационные технологии доказывания М.: Зерцало-М, 2007. С. 37.

Бичил мөртэй ажиллах ажиллагааны эцсийн зорилго нь бүхэлдээ гэмт үйлдлийг тогтоох, гэмт этгээдийг тогтоох, нотлох, түүнийг эрэн сурвалжлах ажлыг шуурхайлахад ач холбогдол бүхий мэдээлэл хүлээн авахад байдаг.

Хэргийн газарт хийх үзлэгийн зайлшгүй нөхцөлийн нэг нь энэ ажиллагааг гүйцэтгэж буй ажилтан бичил мөр илрүүлэх, бэхжүүлэх, тусгаарлан авахад тусгай техник, хэрэгсэл ашиглах болон хэргийн газраас бичил мөр илрүүлэх, бэхжүүлэх, түүнтэй ажиллах дадал, чадвар эзэмшсэн байх явдал. Ийм дадал, чадвартай байж гэмт хэргийг илрүүлэхэд бичил мөрийг тал бүрээр, дүүрэн ашиглах боломж бүрдэнэ.

Хэргийн газарт бичил мөртэй ажиллах ажиллагааны чухал шатны нэг нь үзлэгийн явцад хөтлөх тэмдэглэлд бичил мөрийн байгаа төлөв, илрүүлж бэхжүүлэх, тусгаарлан авахаар авсан арга хэмжээг тусгаж өгөх байдаг. Энэ нь хэргийн газраас илрүүлсэн бичил мөр процессын хүчин төгөлдөр нотлох баримт болж, хэргийн газарт гүйцэтгэсэн ажиллагааг баталгаажуулж өгөхөөс гадна бичил мөр лабораторийн шинжилгээнд тэнцэх, улмаар цаашид хийх шинжилгээнд өгөөж өндөртэй арга хэрэгсэл сонгон ашиглах нөхцөл бүрдүүлнэ. Хэргийн газрын үзлэгийн тэмдэглэл, мөрдөх ба нотлох баримт шинжлэх ажиллагааны хооронд "холбох шат" болж өгдөг. Түүнээс гадна, үзлэгийн тэмдэглэл, нотлох баримт хоёр хоорондоо өвөрмөц холбоо агуулж байдаг бөгөөд тэр нь байхгүй, эсвэл алдагдсан тохиолдолд нотлох баримт өөрөө алга болсонтой адил гэж А. А. Эйсман үзжээ[5].

Хэргийн газарт хийх гүйцэтгэх ажиллагааны нэг чухал шат нь илрүүлсэн бичил мөрийн өвөрмөц онцлог, материалын шинжийн талаарх анхан шатны мэдээллийг гаргаж авахаар газар дээр нь хийх урдчилсан шинжилгээ байдаг.

Урдчилсан шинжилгээний явцад илрүүлсэн бичил мөрийн төлөв шинжээр түүний гарал үүсэл, тухайн хэрэгт холбоотой байж болзошгүйг заах мэдээлэл зэргийг урдчилсан байдлаар тодорхойлох ажиллагааг хэрэгжүүлж болно. Энэ мэдээллийг хэргийн газарт өрнөж өнгөрсөн үйл явдал болон түүнд оролцогчдын тухай мэдээллийг гаргаж авахад ашиглаж болно. Бичил мөрийн төлөв байдлаар хэргийн газарт хийж буй урдчилсан шинжилгээ цэвэр лавлагааны шинжтэй бөгөөд процессын хууль тогтоомжийн хүрээнд хийдэг хэдий ч түүнийг процессын ажиллагаанд тооцдоггүй. Урдчилсан шинжилгээг хэргийн газар дээр, тусгай хэрэгсэл төхөөрөмж ашиглалгүйгээр, мэргэжилтний туршлага, эмпирик мэдлэгт үндэслэн хийдэг тул анхан шатны энэ дүгнэлтийг процессын баримт бичигт тусгадаггүй, зөвхөн шуурхай эрэн сурвалжлах ажиллагаанд ашигладгаараа өвөрмөц онцлогтой. Урдчилсан шинжилгээг зөвхөн хэргийн газар дээр биш, мөн лабораторийн нөхцөлд ч хийж болно. «Урдчилсан шинжилгээ» гэдэг нэр энэ шинжилгээ төгс дуусаагүй ба цаашид шинжилгээг нарийвчлан хийх ёстойг заасан нэр болно. Бичил мөрөөр хийх урдчилсан шинжилгээний гол зорилго нь нотлох баримт гаргаж авах биш, зохих нотлох баримтыг илрүүлж тогтоох арга хэрэгсэл, чиглэлийг тогтооход оршино.

Бичил мөрөөр хэргийн газар дээр болон бусад орчинд урдчилсан шинжилгээ хийснээр гэмт үйлдлийн болон гэмт этгээдийн талаарх ерөнхий ба

[5] Эйсман А. А. Заключение эксперта (структура и научное обоснование). – М.,1967. С. 13.

зарим өвөрмөц мэдээллийг гаргаж тогтоох, ингэснээр эрэн сурвалжлах хүрээг нарийвчилж, үзлэгийн явцад дэвшүүлж болзошгүй үндэслэлгүй, эсвэл буруу таамгийг няцаах боломжоор хангагдана.

Урдчилсан шинжилгээний үр дүнг гүйцэтгэх ажлын болон мөрдөх ажиллагааны явцад эрлийн хүрээг хумих, таамаг дэвшүүлэх, шалгах зэргээс гадна цашид хэрэгжүүлэх гэмт этгээдийг халуун мөрөөр мөшгих, баривчлах, зугтаж болзошгүй замыг хаах, очиж болзошгүй газарт отох, хэргийг илрүүлэхэд ач холбогдол бүхий нэмэлт мэдээлэл гаргаж авах, хэрэг илрүүлэх ажиллагаанд оролцуулах цагдаагийн ажилтнуудын тоо, үйл ажиллагааг төлөвлөх зэрэг шуурхай эрэн сурвалжлах ажиллагаанд ашиглаж болно.

Хэргийн газар дээр бичил мөртэй ажиллах ажиллагааны бүтцийн болон шинж байдлын тохироог бүрдүүлэгч үндсэн элементүүдэд хийсэн ерөнхий анализ, тэдгээрийн хоорондох уялдаа холбооны систем, бие биедээ харилцан нөлөөлөх нөлөө, элемент тус бүрийн ач холбогдол, бичил мөртэй ажиллах ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор нөхцөл байдлын төлөв шинжид бүхэлд нь хийсэн анализ, эдгээр анализаас урган гарсан зорилго зэрэг нь хэргийн газар дээр ажиллах бүх ажиллагаанд системийн хандлагаар биш, тухайн нөхцөл байдлын онцлогийг үнэлэх хандлагыг түлхүү барьж ажиллах шаардлагатайг харуулдаг.

Энэ нь практикт дээрх ажиллагааны үр өгөөжид сөрөг нөлөө үзүүлэх, үр дүнг гажуудуулж болзошгүй бүх хүчин зүйлийг тал бүрээс нь, бүрэн дүүрэн судлаж, тэдгээр хүчин зүйлийн нөлөөг арилгах арга хэмжээ авч байх, бичил мөр илрүүлсэн тухайн нөхцөл байдлыг сайтар тооцон, үнэн бодит үр дүнг зөв үнэлж байх шаардлагатайг харуулж байна. Ийм хандлага бичил мөрийн агуулах мэдээллийг илүү бүрэн дүүрэн үзэж судлах, ашиглах боломжийг хангаж өгнө.

"Нөхцөл байдлын бүх элементийг сайтар сэргээн төсөөлж, улмаар тэдгээрийн нэгдлийг хангах нь тохиолдол бүрт өндөр өгөөжит үр дүнд хүрэх боломж олгодог нь практикт – хэргийн газар дээр бичил мөртэй ажиллах үйл ажиллагаанд, шинжлэх ухааны судалгаанд – нөхцөл байдлын мөн чанарын тухай төсөөлөлд суурилсан шинжлэх ухаанлаг зөвлөмж боловсруулах, бичил объекттой ажиллах боловсронгуй арга, хэрэгсэл бий болгох хэлбэрээр илэрдэг"[6].

Гэмт хэрэг илрүүлэх чухал нөхцлийн нэг нь уг ажиллагаанд оролцох албадыг сайтар зохион байгуулах явдал. Гэмт хэрэг илрүүлэх ажиллагааны явцад түүнд оролцогч албад, албан тушаалтнуудын хамтын ажиллагаа гэж тэдгээр алба, хүн тус бүрт байдаг бүрэн эрх, арга, хэрэгслийг зөв хослуулах боломжоор хангаж өгөх тийм харилцан ажиллагааг ойлгоно[7].

Гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх ажиллагаан дахь хамтын ажиллагаа тодорхой шинжийг агуулж, нэг талаасаа хууль тогтоомжид, нөгөө талаасаа оролцогч тус бүрт байх ажлын хэлбэр, арга барилыг зөв хослуулахад үндэслэх ёстой. Гэмт хэрэг илрүүлэхэд хамтын ажиллагааг зохион байгуулах мөрдөх албаны даргын

[6] Биркин М. М. и др.Экспертная практика. №20. – М., 1983. С. 127.
[7] Абдуганиев А. Н. Взаимодействие следственного аппарата с другими службами органов внутренних дел при расследовании преступлений.– Т., 2001 г.

үйл ажиллагаа эрүүгийн хэрэг үүсгэх шатаас эхэлж, хэрэг мөрдөх бүх шатанд үргэлжлэн, мөрдөх ажиллагааг өндөрлөхөд дуусгавар болно[8].

Бичил мөрийг гэмт хэрэгт нотлох баримт болгох, эсвэл шинжилгээний объект болгохын тулд тэдгээрийг процессын хуульд заасан журмын дагуу илрүүлж, бэхжүүлж, тусгаарлан авсан байх ёстой. Процессын аргаар бэхжүүлэх гэдэгт нэн түрүүнд илрүүлсэн бичил мөр байсан гадаргуугийн онцлог, байрлал, мөрийн өөрийнх нь төлөв, харилцан байрлал, хэмжээ, хэлбэр, үүссэн нөхцөл зэргийг мөрдөх ажиллагааны тэмдэглэлд тусгахыг ойлгоно. Түүнчлэн бичил мөрийг хэрхэн тусгаарлаж авсан, ямар саванд хэрхэн баглаж боосныг дэлгэрэнгүй тусгах шаардлагатай бөгөөд бичил мөрөөр хийх шинжилгээний үзлэг чухам эндээс эхлэж, мөрдөгчийн явуулсан объект шинжилгээнд бүрэн, хөндөгдөлгүй ирснийг нотлож өгдөг.

Бичил мөр илрүүлэхэд шинжлэх ухаан техникийн орчин үеийн техник хэрэгсэл, тэдгээрийг ашиглах сайтар мэргэшсэн дадал туршлагатай байх шаардлагатай. Бичил мөрийн хэмжээ бага, түүнтэй ажиллах ажиллагааны өвөрмөц онцлог, чадваргүй гүйцэтгэсэн тохиолдолд баллах, устах аюултай тул мөрдөгчид гол төлөв зохих мэргэжилтэн оролцуулдаг. Өнөөгийн манай тогтолцоогоор энэ ажиллагаанд ШШҮХ-ийн харъяа нэгжийн шинжээч, мэргэжилтнүүдийг оролцуулдаг бөгөөд мөрдөх ажиллагаанд оролцож буй шинжээчийг мэргэжилтэн гэж нэрлэдэг. Мэргэжилтэн, шинжээч нар мөр илрүүлж, бэхжүүлэх, шинжлэхэд зохих журмаар тусгайлан бэлтгэгдсэн, бичил мөртэй ажиллах дадал, чадвартай, шинжилгээний арга аргачлал эзэмшсэн хүмүүс байх ёстой.

Гэмт этгээдүүд татсан тамхины иш, гарын мөр, эвдлэгч багаж мэтийн өөрийгээ илчлэх мөрийг аль болох үлдээхгүйг хичээх болсон тул гэмт хэрэг илрүүлэхэд төрөл бүрийн бичил мөр ашиглах нь өнөөдөр тэргүүн зорилтын нэг болоод байна. Тиймээс мөрдөгчид, эрүүгийн албаныхан бичил мөртэй ажиллуулахаар шинжээчдийг урьж, хэргийн газрын үзлэгээр бичил сэмэрдэс, хөрсний бичил хэсэг, үйлдвэрийн тоосонцор, лак-будгийн зүйлийн бичил ховхдос, шилний үйрмэг, төмрийн үртэс, шатах-тослох материал, тормосны шингэн зэргийн толбо зэргийг илрүүлж байна.

Гэмт хэрэг илрүүлэх, мөрдөхөд мэдээллийн эх сурвалж болгон ашиглаж болох бичил мөрөөр оношлох ба адилтгах шинжтэй асуултад хариу авч болно.

Тухайлбал, бичил мөр юуны өмнө, гэмт этгээдийн тухай мэдээллийн үнэт эх сурвалж болдог. Жишээлбэл, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн үсэнд хийсэн элементийн анализын шинжилгээгээр түүний агуулах мөнгөний хэмжээ жирийн хүний дунджаас өндөр гарсанд үндэслэн сэжигтнийг гэрэл зургийн лабораторитой холбож шалгаснаар хэрэг илэрч байсан тохиолдол байдаг.

Гэмт хэрэг мөрдөх явцад бичил мөрөөр хийсэн шинжилгээний үр дүнг хэд хэдэн хувилбараар үнэлж үзэж, ашиглаж болно. Жишээлбэл, гэмт этгээд хэргийн газар дээрх эд зүйлтэй, хохирогчтой, гэмт үйлдлийн багаж

[8] Асриев Б. В. Роль начальника следственного отделения в организации взаимодействия следователя и органа дознания при расследовании преступлений // Проблемы предварительного следствия. – Волгоград, 1973 г.

зэвсэгтэй шүргэлцсэн болохоо сайн дураар хүлээж байгаа бол түүний мэдүүлэг шинжээчийн дүгнэлтийг дараах маягаар шалгах хэрэгсэл болж болно:

- Хэрэв гэмт этгээд ямар нэгэн сонирхлоор худал хэрэг хүлээж байгаа бол шинжээчийн дүгнэлттэй зөрчилдөж, хэргийн газраас илрүүлсэн мөр сэжигтэн этгээдийнхтэй адил бус байна;
- Гэмт этгээд хэрэв үнэн мэдүүлж байгаа бол мэдүүлэг нь шинжээчийн дүгнэлттэй давхцаж, шинээр нэмж мөр илрүүлэх, шинжлэх боломж олгох болно.

Бичил мөрөөр харилцан шүргэлцсэн эсэхийг, тухайлбал, хохирогч, сэжигтэн хоёр харилцан шүргэлцсэнийг зааж болно. Жишээлбэл, 1953 онд Швейцарьт өөрийгээ дүүжилж амиа хорлосон эмэгтэйн алганаас дүүжилсэн уяаны биш, нөхрийнх нь унтлагын хувцасны бичил сэмрдэс илэрснээр нөхөр нь алсан болохыг тогтоож байв[9].

Гэмт хэрэг үйлдэхэд оролцогч тухайн газарт ирсэн болохыг бичил мөрийн тусламжтайгаар тогтоож болно. Хүнсний дэлгүүр ухсан хулгайч ууттай давсан дээр гишгиж хагалсан байсанд сэжигтэн этгээдийн гуталд хийсэн үзлэгээр ул хэсгээс давс илрүүлснээр хэрэг илэрч байв.

Бичил мөрөөр гэмт хэрэг үйлдсэн механизмыг тогтоож болно. Жишээлбэл, гараж ухахаар цоожны дөрийг хөрөөдсөн гэмт этгээдийн гутал, хувцсан дээрээ төмрийн үртэс илрүүлэн тогтоож болно.

Бичил мөр гэмт хэрэг үйлдсэн зэвсгийн талаар таамаг дэвшүүлэх үндэс болж болно. Хэргийн газраас илрүүлсэн төмрийн үртэсний хэлбэр, хэмжээгээр төмрийн хөрөө, тасдагч, өрөм, хуурай зэрэг багаж ашигласныг, дусал хэлбэрийн төмөр үсэрч наалдсанаар цахилгаан ба хийн гагнуур ашигласан зэргийг тогтоох боломжтой.

Дээр дурдсан, түгээмэл тохиолдох шинжүүдээс гадна гэмт хэрэг илрүүлж мөрдөхөд ач холбогдол агуулах өөр олон шинжийг бичил мөр агуулж байж болно. Үүний зэрэгцээгээр, бичил мөрийг нотлох баримт болгон ашиглахдаа тэдгээрийн онцлог шинжийг үнэлэмжид, ялангуяа уг бичил мөр тухайн гэмт хэрэгт холбоотой байж болох эсэхэд анхаарлаа хандуулах шаардлагатай. Жишээлбэл хүмүүс түгээмэл өмсдөг хувцасны бичил сэмэрдэс тухайн гэмт хэрэгт холбогдолгүй, өөр хүний хувцасных байж болох талтай.

Гэвч гэмт хэрэг илрүүлэхэд бичил мөр ашиглаж ирсэн практикаас харахад, зөв илрүүлж, бэхжүүлж, тусгаарлан авсан бичил мөр гэмт хэрэг илрүүлэх, мөрдөхөд чухал ач холбогдол өгч байсан тохиолдол дийлэнх байдаг байна.

Бичил мөртэй холбоотой тулгамдаж буй асуудалд онцгой анхаарал хандуулах ёстой нь түүний харьцангуй шинэ, эздрээтэй, практикт тулгамдсан асуудал ихтэйд нь биш, энэ төрлийн нотлох баримтыг гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглах техник, шинжлэх ухаан-арга зүй, зохион байгуулалтын асуудлыг цогцоор шийдэх нь шинжлэн магадлахуйн салбарын хөгжлийн түвшингийн үзүүлэлт болж, үүний зэрэгцээ, цаашид боловсронгуйлан хөгжүүлэх чиглэлийн баримжаа болох учиртайгаар тайлбарлаж болно.

[9] Юрген Торвальд. Хумхийн тоосон мөр /орч. Б.Жаргалсайхан/. Уб. 2019. 153 дахь тал.

Дүгнэлт

Шинжлэх ухаан техникийн дэвшлийг нийгмийн амьдралын төрөл бүрийн салбарт, түүний дотор гэмт явдалтай тэмцэх салбарт өвөрмөц хэлбэрээр ашиглаж байгаа нь гэмт хэрэг илрүүлэх, мөрдөхөд төрөл бүрийн бичил мөр ашиглах боломж олгож байна.

Сүүлийн үед шинжлэн магадлахуйн салбарт шинжлэх ухаан техникийн дэвшлийн нөлөөгөөр бичил мөрийн ач холбогдлыг үнэлэх хандлага нилээд өссөн байна.

Судалгааны дүнгээс харвал (хавсралтыг үзнэ үү) ШШҮХ-д бичил мөрийн шинжилгээ гэж зөвхөн материалын ширхэгт хийх шинжилгээг нэрлэж байгаа нь учир дутагдалтай тул цаашид бичил мөрийн шинжилгээний төрлийг олшруулах шаардлагатай.

Шинжилгээний байгууллагын мэргэжилтэн, шинжээчдийн бичил мөртэй ажиллах ур чадварын түвшин сургалтын хөтөлбөрөөр олгосон дадал, чадвараас хэтрэхгүй байна.

Шинжилгээний байгууллагад бичил мөртэй ажиллах хэрэгсэл төхөөрөмж хангалтгүй байгаагаас бичил мөрийн агуулж байгаа мэдээллийг бүрэн гаргаж авах арга, аргачлал хөгжөөгүй байна.

Бичил мөрийг гэмт хэрэг илрүүлэхэд өргөнөөр ашиглаж эхэлсэн практик ажиллагаа энэ төрлийн объектыг шинжлэн магадлахуйн бичил мөр судлалын хүрэнд, иж бүрдлээр үзэж судлах шаардлагатайг олон улсад харуулжээ.

Мэдлэгийн энэ чиглэл бичил биет хэсгийг үзэж судлах зорилгоор шинжлэх ухааны олон талын мэдлэгийг нэгтгэсэн, өөрөөр хэлбэл, олон салбарын мэдлэгийг (байгаль-техникийн ухаан, криминалистик, шинжлэн магадлахуй гэх мэт) цомтгон зангидсан, салбар дундын шинэ мэдлэг болон хөгжиж байна.

Шинжлэн магадлахуйн бичил мөр судлалын судалгааны зүйлд онолын үндэс, гэмт хэргийг илрүүлэх, нотлох зорилгоор бичил мөр илрүүлэх, бэхжүүлэх, тусгаарлан авах, шинжлэх криминалистикийн, шинжлэн магадлахуйн болон бусад салбарт ашиглаж буй арга, хэрэгсэл багтаж байна.

Бичил мөрийг гэмт хэрэг илрүүлэхэд ашиглах асуудал орчин үед улам өсөн нэмэгдэж байгаа ч манай улсад бичил мөртэй ажиллах, түүнийг илрүүлж бэхжүүлэх, шинжлэх чиглэлд ажиллаж байгаа өнөөгийн түвшин шаардлага хангахгүй байна.

ШШҮХ-д материалын ширхэгт хийсэн шинжилгээний тоо жил бүр өсөж байгаа сайн талтай ч эзлэх хувийн жин нийт шинжилгээний хэдхэн хувь байгаад анхаарлаа хандуулж бичил мөр ашиглан гэмт хэрэг илрүүлсэн зэрэг тохиолдолд түүний жишээг хэрэг бүртгэгч, мөрдөгч, эрүүгийн албаны ажилтнуудад сурталчлан түгээх, тэдний сонирхлыг бичил мөрийн шинжилгээ рүү хандуулах арга хэмжээ зохиох шаардлагатай.

Энэ чиглэлд гадаад орны туршлагаас судлан таниулах, сурталчлах шаардлагатай.

МОНГОЛ УЛСЫН ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ, ОНЦЛОГ

MONGOLIAN RIGHTS OF THE REGULATION PROCESS RENOVATION AND FEATURES

С.Оюунчимэг
Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, хошууч
Oyunchimeg S.
Major, Senior lecturer, Department of Civil law, Law and Social Science Institute, University of Internal Affairs, Mongolia,

✉ oyunchimeg.s@leu.gov.mn

Хураангуй: Захиргааны хэргийн шүүх байгуулагдсанаар Монгол Улсын Хууль зүйн шинжлэх ухаанд, тэр дундаа захиргааны эрх зүйн шинжлэх ухааны хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсан хэдий ч шүүх байгуулагдаад 16 жилийн хугацаанд зохих алдаа дутагдал, засаж залруулах зүйл байсан бөгөөд үүнийг 2016 онд шинэчлэн найруулсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохих хэмжээгээр шийдвэрлэжээ. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар тодорхойлогдсон шинэлэг зохицуулалтыг энэхүү өгүүллээр тодруулахыг зорьлоо.

Abstract: The establishment of administrative courts made significant contributions to the forensic sciences of Mongolia, including the development of administrative law sciences, but there were adequate errors and remedies for 16 years after the court was established, and it was revised to the administrative courts in 2016. To some extent by the law of decision making. The article aims to clarify the new provisions defined by the Administrative Procedure Law of the Court.

Түлхүүр үгс: Субъектив эрхийн зөрчлийн маргаан, обьектив эрх зүйн маргаан, нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэх, захиргааны шүүхийн зорилго, шүүхэд хянагдах захиргааны үйл ажиллагааны төрөл, цар хүрээ, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

Keywords: Subjective litigation, subjective right, objective litigation, types of administrative litigation, open standing, objective of administrative litigation, General Administrative Law, Administrative Court Procedure Law.

Захиргааны хэргийн шүүх байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж эхэлсэнээс хойш захиргааны хэргийн шүүхэд зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар нэхэмжлэл гаргах иргэн, хуулийн этгээдийн тоо жилээс жилд өсч байгаа ба цаашид ч өсөх хандлагатай байна.

Захиргааны хэргийн шүүх байгуулагдаж төрийн захиргааны байгууллагуудын шийдвэрийг хянадаг болсноор тус байгууллагуудад шийдвэрийн хууль зүйн үндэслэл болоод процессын ажиллагааг хянах чиг үүрэг

бүхий хууль зүйн мэргэжилтэн, хууль зүйн хэлтэс, алба байгуулагдан ажиллаж эхэлсэн байна.

Хэдийгээр Захиргааны хэргийн шүүх байгуулагдан 16 жил үйл ажиллагаа явуулж байгаа боловч хууль зүйн хувьд алдаатай оноотой зүйл байсаар ирсэн. Иймд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг 2016 онд Монгол Улсын Их хурлаас баталсан бөгөөд шинэчлэн батлагдсан хуулийн үзэл баримтлал, ач холбогдол, онцлогийг олон нийтэд таниулах, хуульчид хуулийн заалтыг зөв тайлбарлаж хэрэглэх онолын болон практик хэрэгцээ шаардлага байсаар байгааг харгалзан доорх илтгэлийг бичлээ.

ЗХШХШтХ-ийн хувьд шинэчлэн боловсруулах хоёр үндсэн шаардлага байсан гэж хэлж болно. Нэгдүгээрт, хуулийн шинэтгэлийн шаардлага, хоёрдугаарт практик зайлшгүй шаардлага байсан юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан боловсруулсан "Шүүх эрх мэдлийг шинэтгэлийн хөтөлбөр"-ийн хүрээнд шүүхийн бие даасан, шүүгчийн эрх зүйн байдлыг хангахад чиглэсэн Шүүхийн тухай багц хууль батлагдсан билээ. Энэ багц хууль нь товчхондоо шүүхийн бүтэц, тогтолцоо, төсөв, боловсон хүчин зэрэг институт талаас нь бэхжүүлэхэд анхаарсан. Харин шүүхээс иргэд, олон нийттэй харилцах харилцааг зохицуулсан процессын хуулиудыг шинэчлэхгүйгээр шүүхийн шинэтгэл бүрэн гүйцэд хийгдэж чадахгүй юм. Энэ ч утгаараа Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хоёр дахь давалгаа нь шүүхээс хэрэг, маргааныг хянан шийдвэрлэдэг харилцааг зохицуулсан хуулиудын шинэтгэл бөгөөд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/ нь үүний нэг болсон. Мөн Монгол Улсын Их Хурлаас захиргааны байгууллага, албан тушаалтнаас захиргааны акт, хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааг зохицуулсан Захиргааны ерөнхий хуулийг 2015 онд баталсан. Үүнтэй холбоотойгоор Захиргааны хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан хууль нь өөрөө шинэчлэгдэх зайлшгүй шаардлага гарсан. Нэгтгэвэл материаллаг хуулиудын шинэтгэл нь процесс хуулийн шинэтгэлийг дагуулсан.[1]

Монгол Улсад Захиргааны хэргийн шүүх үүсэж, үйл ажиллагаа нь бэхжихэд ЗХХтХ нь онцгой үүрэг гүйцэтгэсэн нь гарцаагүй. Гэвч өнөөдрийн байр сууринаас авч үзвэл уг хуулийн зорилго, үйлчлэх хүрээ нь агуулгыг шинэчлэн боловсруулах зайлшгүй шаардлага үүссэн. Үүнд:

- Өмнөх хуулийн нэгдмэл бус, тодорхойгүй, бүрэн бус зохицуулалтыг боловсронгуй болгох
- Захиргааны ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан өмнөх хуульд байсан захиргааны хэргийн шүүхийн хяналтын хүрээ буюу субъект, объектыг өргөжүүлэх, түүнчлэн захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журам болон бусад материаллаг эрх зүйн зохицуулалтыг хасах
- ЗХХШтХ-д тусгагдаагүй процессын эрх зүйн суурь зарчмуудыг зохицуулах

[1] "Өмгөөлөгч" сэтгүүлийн 2016 оны №12 /71/ дугаарт нийтлэгдсэн. М.Батсуурь "Шинэ хуулийн гол үзэл баримтлал нь шүүхээр хэрэг, маргаанаа шийдүүлж байгаа иргэд, олон нийтэд хамгийн таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх явдал байсан" ярилцлага

- Нийгэм эдийн засгийн бодит хэрэгцээ шаардлага, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх үүднээс шүүхийн хяналтын зарим төрлийн маргааныг хянан шийдвэрлэх үе шат, хугацааг богиносгох \тендер, концесс, сонгуулийн маргаан гэх мэт\, түүнчлэн нийтийн эрх ашгийг шүүхэд хамгаалах боломжийг нээх, захиргааны байгууллага хооронд үүсэх маргааны хяналтын хүрээ, хязгаарыг тодорхой болгох зэрэг зайлшгүй шаардлага байсан. [2]

Иймд ЗХШХШтХ-ийн шинэчилсэн найруулгаар дараах зарчмын шинжтэй өөрчлөлтийг хийжээ.

- Захиргааны хэргийн шүүхийн зорилт, хүрээ өргөжсөн. ЗХШХШтХ-ийн 1 дүгээр зүйлийн 1.1-д "*Энэ хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино*" хэмээн заасан.
- Нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргах боломжийг хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээдэд болон хуульд заасан шаардлагыг хангасан этгээдэд хуульд заасан асуудлаар нэхэмжлэл гаргах боломжтой байхаар заасан. \ЗХШХШтХ-ийн 18.3\
- Шүүхийн хяналтын объектыг "Захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас" хэмээн тодорхойлсноор захиргааны үйл ажиллагааны үндсэн хэлбэр болох захиргааны аки, гэрээ, хэм хэмжээний актын улмаас зөрчигдсөн эрхээ хамгаалуулах боломжтой болсон.
- Хүн хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаас гадна "Зөрчигдөж болзошгүй эрх"-ийн хамгаалалтын талаар шаардах боломжтой болсон. Энэхүү эрхээ зөвхөн захиргааны хэм хэмжээний актын хувьд л шаардах боломжтой юм.
- Захиргааны хэргийн шүүхийн зорилгыг субъектив эрхийн хяналтаас гадна объектив эрхийн хяналтыг хэрэгжүүлэх боломжтой байхаар тодорхойлсон. Гэхдээ энэ байдал нь захиргаа шүүх хоёрын харилцааг үндсээр нь өөрчлөхөд хүргэх ёсгүй бөгөөд захиргааны хэргийн шүүх нь захиргааны байгууллагын дээд шатны захиргааны байгууллага биш тул шүүхээс зөвхөн захиргааг хууль ёсыг сахиулахад л чиглэх учиртай юм. Тухайлбал захиргааны байгууллага нэхэмжлэгч байх нөхцөлийг "хуульд заасан бол" гэж өөрөөр хэлбэл захиргааны байгууллагад шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг зөвхөн хуулиар тусгайлан олгосон тохиолдолд боломжтой байхаас гадна хуулийн 52.5.4-т зааснаар захиргааны байгууллагын нэхэмжлэлд ямар хууль зөрчигдсөн, эсхүл нийтийн эрх зүйн ямар чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрснийг тодорхой заах

[2] http://legaldata.mn/b/251. Г.Банзрагч. "Монгол Улсын захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухайд" нийтлэл. УБ., 2017

ёстой. Учир нь хууль зөрчсөн гэсэн нэхэмжлэлийн шаардлагыг хэт өргөн хүрээнд ойлгож болохгүй.

- Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах хугацааг тусгайлан зааж өгсөн.
- Нотлох баримт цуглуулах үүргийг Захиргааны хэргийн шүүх гүйцэтгэнэ. Хэргийн оролцогч өөрт байгаа нотлох баримтаа шүүхэд гаргаж өгөөгүй нь шүүхийг буруутгах үндэслэл болохгүй. Мөн "Цахим баримт"-ын талаарх ойлголт бусад процесс хуулиудаас түрүүлж, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд орж ирсэн. Цахим гарын үсэг, цахим мэдээлэл, цахим хэлбэрээр гарах аливаа баримт нь хэргийн оролцогчийн хувьд маргаангүй бол шүүх заавал бичгийн хэлбэрээр шаардах нь өөрөө учир дутагдалтай зүйл юм. Иймд, нотлох баримтын нотолгооны хэрэгсэлд "цахим баримт" гэсэн ойлголтыг оруулж өгснөөр шүүх цахим баримтыг цуглуулах, хэрэгт авах, үнэлэх эрх зүйн нөхцөл бүрдсэн.
- Захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхээс өмнө хэргийн оролцогчийн эрхийг хангах үүднээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг нотлох баримтыг хасуулах, захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, шүүх хуралдааныг товлон зарлах, шүүгчээс урьдчилан хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзсэн асуудлаар хуралдуулах процессыг хуульчилсан. [3]
- Шүүгчийг татгалзах гаргах хүсэлт гаргах эрхийг хязгаарласан. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шийдвэрлэсэн асуудалтай нь холбогдуулан шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргах эрхгүй.
- Маргааныхаа онцлогт тохирсон хянан шийдвэрлэх ажиллагааг анх удаа журамласан бөгөөд Үүнийг "Тусгай журмаар шийдвэрлэх маргаан" гэж нэрлэсэн. Шүүхээс маргаан хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллын тусгай журмыг дараах байдлаар хуульчилсан. Тухайлбал захиргааны хэргийн анхан шатны шүүхээс тусгай журмаар шийдвэрлэх маргаан, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэх маргаан, түүнийг шийдвэрлэх хугацаа, процессын ажиллагаа түүний журам, шүүхийн шийдвэрт гомдол гаргах, гомдлоор маргаан үүсгэх ажиллагаа шийдвэрлэлт зэргийг хуульчилж өгсөн бөгөөд тодорхой төрлийн маргааныг богиносгосон хугацаагаар шийдвэрлэхээр зохицуулсан онцлогтой.

[3] Хуульд маргаж байгаа захиргааны акт болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, шүүх хурлын тов тогтоох зэрэг асуудлыг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийх замаар шийдвэрлэхээр тусгасан. Шүүгч бол асуудлыг өрөөндөө суугаад шийдвэрлэдэг захиргааны албан тушаалтан биш бөгөөд асуудлыг шийдвэрлэх "ухаалаг үндэслэл"-ийг олохын тулд маргалдагч талуудад асуудлыг харж байгаа өөр өөрийн өнцгийг тайлбарлах, бусад байр суурьд няцаалт хийх буюу мэтгэлцэх боломжийг олгох замаар итгэл үнэмшил төрүүлсэн үндэслэлээр шийдвэр гаргадаг албан тушаалтан. Тиймээс эхний ээлжинд зайлшгүй мэтгэлцээний үндсэн дээр шийдвэр гаргах шаардлагатай дээрх асуудлыг урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэр гаргаж байхаар хуульчилсан нь практик ач холбогдолтой юм. Шүүхийн практиктаас харахад хэрэгжүүлээд тогтсон, хэргийн оролцогч нарт өөрийн байр суурийг илэрхийлж, хамгаалах боломжийг олгосон маш таатай нөхцөл болсон нь харагдана. Амьдралаас урган гарсан зохицуулалт болсон.

- Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагаатай холбоотой нилээн өөрчлөлт орсон бөгөөд тухайлбал шүүгч шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй шалтгааныг судлан үзэж, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй бол албадлага хэрэглэх эрх зүйн үндсийг тодорхойлсон. Үүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн албадлага хэрэглэх, эрүүгийн хуулийн тусгай ангид заасан шүүхийн шийдвэрийг эс биелүүлэх гэсэн гэмт хэргээр харьяаллын дагуу шалгуулахаар шилжүүлэх гэх мэтээр тодорхойлсон сайшаалтай зохицуулалт болжээ. [4]
- Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах үндэслэлд гуравдагч этгээдийг татан оролцуулахгүйгээр шүүхээс хэргийг хянан шийдвэрлэсэн нь шүүхийн шийдвэрт ноцтойгоор нөлөөлсөн бол гэсэн нөхцөлийг шинээр оруулсан нь шинэлэг зохицуулалт болсон.
- Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдааны журмыг зохицуулсан. \ЗХШХШтХ-ийн 128 дугаар зүйл\ Тухайлбал хяналтын шатны шүүхийн шийдвэр гаргахад оролцсон шүүх бүрэлдэхүүний хоёр шүүгч нь тусгай санал гаргасан, эсхүл УДШ-ийн ерөнхий шүүгч хуульд харшилсан гэж дүгнэлт гаргасан бол хэргийг 30 хоногийн дотор улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэхээр заасан. Нэгдсэн хуралдааныг УДШ-ийн ерөнхий шүүгч даргалах бөгөөд УДШ-ийн захиргааны хэргийн танхимийн нийт шүүгчдийн дөрөвний гурваас доошгүй нь оролцсоноор хүчинтэйд тооцогдоно. Энэ зохицуулалт тодорхой давуу талтай бөгөөд тусгай санал бичих нь багш, судлаачид болон оюутнуудад сургалтын хэрэглэгдэхүүн болдог давуу талтай билээ. Энэ зохицуулалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн ч таван хэрэгт тусгай санал бичигдсэн байдаг онцлогтой. [5]
- Захиргааны ерөнхий хууль болон ЗХШХШтХ-аар захиргааны процессын гол зарчмуудыг хуульчилж өгсөн бөгөөд энэ нь шүүхийн хяналтын хүрээг тодорхойлоход ач холбогдолтой юм. Тухайлбал "нэхэмжлэлийн хүрээнд шийдвэрлэх" 106.5, "захиргааны сонгох боломжийн хүрээнд гарсан захиргааны үйл ажиллагаанд тавих шүүхийн хяналтыг тодорхойлох" 106.7, "гомдлын хүрээнд хянах" 118.3 зэрэг зарчмуудыг тодорхойлсон нь практикт ач холбогдлоо өгч байна.

[4] "Эрх зүйн процессын шинэтгэл, хэрэгжилт" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, УБ., 2019 он, Т.Азжаргал "Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл, тулгамдсан асуудал" өгүүлэл

[5] Хяналтын шатны шүүх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн талаарх гомдлыг хэлэлцдэг тул энэ шаардлагыг хангаагүй гомдлыг шүүгч буцаах боломжтой болсон. Хуучин хуульд энэ нь тодорхойгүй байсан учир шүүгч нар дангаар хэлэлцэхээс татгалзсан захирамж гаргасны төлөө шүүгчийн ёс зүйн хороонд дуудагдах явдлаас болж гомдол бүрийг шүүх хуралдаанд оруулах хандлага байсан. Мэдээж гомдлыг буцаасан захирамжид гомдол гаргах эрх нээсэн. Мөн нийт шүүгчдийн хуралдааны оронд Ерөнхий шүүгч дээр нэмэх нь танхимын нийт шүүгч гэсэн хувилбарыг гаргаж ирсэн. Энэ нь Үндсэн хуулийн "Улсын дээд шүүх нь Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэх" тухай заалт болон "мэргэшсэн шүүхийн тогтолцоо"-той байх зарчимд нийцсэн хувилбар гэж үзэж байна. Өөр өөр чиглэлээр мэргэшсэн 25 шүүгч цуглаж, эрүү, иргэн, захиргааны дурын хэрэг хэлэлцэх нь гүнзгийрэн хөгжиж буй эрх зүйн хөгжилд тэдийлэн нийцэхгүй зүйл байсан.

Дээрх шинэтгэлээс зайлшгүй анхаарч авч үзэх нэг зүйл нь иргэдийн захиргааны хэргийн шүүхэд хандах боломжийг өргөтгөсөн явдал юм. Дээр дурдсанчлан зөвхөн иргэн, хуулийн этгээд зөрчигдсөн эрхээ сэргээхээр шүүхэд ханддаг байсныг өргөтгөж, нийтийн эрх ашгийг төрийн бус байгууллага хамгаалах боломжийг нээсний зэрэгцээ эрх мэдлийн хувьд бие биендээ хамаарахгүй зарим захиргааны байгууллага шүүхэд хандах боломжийг баталгаажуулсан. Мөн захиргааны төлөвлөлт, хэм хэмжээ тогтоосон актын хувьд эрх нь зөрчигдөж болзошгүй тохиолдолд шүүхэд хандах боломжтой болсон. Мөн захиргааны хууль бус ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах эрхийг нээсэн нь сайшаалтай зохицуулалт болсон юм.

Нийгмийн харилцаа өргөжихийн хэрээр урьд байгаагүй эрх зүйн ойлголт, эрхээ хамгаалах арга хэрэгсэл бий болж байна. Тухайлбал, "Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах" асуудал эрх зүйн тодорхой хүрээнд бүрдсэн бөгөөд хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг нээсэн. Ингэж тодорхой хүрээгээр хязгаартай нээсэн нь Засгийн газрын төрийн хөтөлбөртэй уялдаж байгаагаас гадна хэтэрхий өргөн хүрээнд нээх нь шүүхийг улс төрийн ашиг сонирхлын талбар болохоос сэргийлэх, өнөөдрийн агшинд шүүхэд хийсвэр ачаалал нэмэхээс сэргийлсэн. Мэдээж цаашид ачаалал, нийгмийн хэрэгцээ шаардлага зэргийг харгалзан зарим хүрээнд нээхийг үгүйсгэхгүй.

Тодруулбал, тус хуулийн 18 дугаар зүйлд зааснаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд уг этгээд дараах шаардлагыг хангасан байна:

1. Нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх;
2. Дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх.[6]

Эндээс харахад нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах асуудлаар төлөөлөх эрх бүхий этгээд нь байгууллага байхаар байна. Харин ямар байгууллага вэ?

Дээрх шаардлага ёсоор тухайн байгууллага нь дүрэмдээ хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах зорилготой гэдгээ тусгасан байх ёстой байна. Мөн гурван жилээс багагүй хугацаанд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа явуулсан байх ёстой байна.

Нийтийн ашиг сонирхолыг нэг үгээр тодорхойлох боломжгүй, цагийн аясаар өөрчлөгдөж байдаг ойлголт юм. Олон ургальч төрийн нөхцөлд чухам юу нь нийтийн ашиг сонирхолд хамаарах болон хэрэв нийгмийн бүлэг хоорондын ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд аль нь илүү жин эзлэх нь маргаантай ойлголт юм. Мэдээж бүх л нийтийн ашиг сонирхол Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлогдсон байх шаардлагатай. Нийтийн ашиг сонирхол нь хувь хүний ашиг сонирхлыг бүрэн буюу хэсэгчлэн хамгаалж эсвэл

[6]Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийн 18.3.1, 18.3.2 дахь заалт. "Төрийн мэдээлэл" эмхтгэл. 2016 он, №09

хязгаарлаж ч болно. Үндсэн хуулиар хүний эрх эрх чөлөөг баталгаажуулах нь дээд зарчим хэмээн тунхагласан байдаг тул нийтийн ашиг сонирхлыг дагаад хувь хүний ашиг сонирхлыг хамгаалах, хангах нь гол асуудал юм.

Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх ойлголтын онолын үндсийг дурдвал:

Нийтийн ашиг сонирхлын[7] өмнөөс шүүхэд нэхэмжлэх асуудал АНУ-ын Дээд шүүхээс 1954 онд шийдвэрлэсэн нэгэн шийдвэрээс эхтэй гэж зарим судлаачид үздэг. *Brown v. Board of Education of Topeka*[8] хэргийг шийдвэрлэхдээ тус шүүх нийтийн өмчийн сургуульд хүүхдүүдийг суралцуулахдаа арьсны өнгөөр ялгаварлахгүй байх тухай шийдвэр гаргасан нь өнгөт арьст хүүхдүүдийн ашиг сонирхлыг хамгаалахад чухал хувь нэмэр оруулсан гэж үздэг.

Нийтийн ашиг сонирхлын хэрэг маргаан нь хэн нэг хувь этгээдийн ашиг сонирхлоос илүүтэй нийгмийн тодорхой бүлэг, тэдгээрийн гишүүд, эсхүл нийгмийн нийт гишүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг гол төлөв нийтийн эрх зүйн этгээдийн үндсэн хууль, бусад хууль тогтоомж, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, биелүүлээгүй шийдвэр, үйл ажиллагаа, түүний үр дагавраас хамгаалах зорилготой бөгөөд ингэхдээ шүүхийн механизмыг ашиглан тэрхүү зөрчигдсөн ашиг сонирхлыг сэргээн тогтоох зорилготой байдаг байна.[9]

Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах, улмаар маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх нь нэршлийн хувьд хүний эрхийн маргаан (Human rights litigation), стратегийн маргаан (Strategic litigation), нөлөөллийн маргаан (Impact litigation), олон нийтийн маргаан (Social action litigation), нийгмийн өөрчлөлт дагуулах маргаан (Social change litigation) зэрэг олон янзаар нэрлэж иржээ. Зарим судлаачид нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд хандах эрхийг "шүүхэд маргаан үүсгэх замаар эрх зүйн хэм хэмжээг боловсронгуй болгох, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн нэг мөр хэрэгжүүлэх, нийтийн үнэлэмж, хэм хэмжээг бий болгох аргаар оршин байгаа нийгмийг өөрчлөх явдал"[10] бөгөөд "Өөрсдийгөө төлөөлөх чадваргүй, эсхүл боломжгүй иргэдийн өмнөөс шүүхэд хандаж, нийгэмд бодлогын шинжтэй өөрчлөлт хийх"[11] зорилготой гэж тодорхойлж байна.

Нийтийн ашиг сонирхлыг шүүхээс хамгаалах асуудлыг ийнхүү тодорхойлсон нь өнгөц харвал "хэтийдсэн" мэт боловч санаандгүй хэрэг бас биш. Улс орны эрх баригчид болон төрийн эрх бүхий албан тушаалтнууд хуулиар олгогдсон эрх мэдлээ урвуулан ашиглаж, "нийтийн" гэсэн тодотголтой өмч хөрөнгө, баялгийг зүй зохисгүйгээр ашиглах, хууль бусаар бусдад эзэмшүүлэх, улмаар экологийн доройтол, нийтийн өмч хөрөнгө үнэгүйдэх,

[7] Нийтийн ашиг сонирхлын тухай Р.Мухийт. Эрх зүй дэх нийтийн ашиг сонирхлын талаарх үндсэн ойлголтын тухайд. Хууль дээдлэх ёс. 2016 оны №4; Р.Мухийт, С.Билгүүн, Ж.Даваасүрэн. Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг нээх нь. Бодлогын судалгааны тайлан. 2015 он зэргээс үзнэ үү.

[8] Brown v Board of Education of Topeka 347 US 483 (1954).

[9] ''The Role of the Judge in Public Law Litigation'' (1976) 89 Harv. L. Rev. 1281.

[10] Helen Hershkoff, Public Interest Litigation: Selected Issues and Examples (n.d.), available at http://www1.worldbank.org/publicsector/legal/PublicInterestLitigation.doc

[11] Helen Hershkoff & Aubrey McCutcheon, Public Interest Litigation: An International Perspective, in Many Roads to Justice: The Law-Related Work of Ford Foundation Grantees Around the World 283, 284 (Mary McClymont & Stephen Golub eds., 2000)

нийгмийн үнэт зүйлс, зарчим алдагдах зэрэгтэй тэмцэхэд оруулах Public litigation-ны ач холбогдол, үнэ цэнийг илэрхийлсэн тодорхойлолт гэлтэй. Энэ ойлголт анх төлөвшиж, өнөөгийн дүр төрхөө олсон АНУ-д гэхэд л боловсролын тогтолцоо, сургууль, хорих байгууллага, эрүүл мэндийн байгууллагууд, цагдаа, орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагууд гэх мэт нийтийн институцүүдын үйл ажиллагаатай холбоотой хэргийг шүүхээр шийдвэрлэдэг тийм жишиг тогтсон байна.[12]

Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах ойлголтын нөгөө тал бол "олон нийтийн хяналт" бөгөөд энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сонин, сэтгүүл, тв, радио болон олон нийтийн мэдээллийн сүлжээгээр дамжуулан тавигдах хяналт юм. Үүнээс гадна олон нийтийн хяналт нь иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагуудаар дамжин хэрэгждэг.

Ийм ч учраас нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргасан этгээд нь нэхэмжлэлээсээ бүрэн болон хэсэгчлэн татгалзах эрхгүй[13] байхаар зохицуулсан бөгөөд учир нь нийтийн ашиг сонирхол хөндөгдөж буй асуудлын онцлог үүнд оршино.

Нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргасан этгээдийн нэхэмжлэлийг шүүхээс буцаах эсэхийг тодорхой зохицуулахын зэрэгцээ маргаан бүхий актын биелэлтийг шүүхээс захиргааны хэрэг үүсгэн шалгах явцад урьдчилан хэлэлцүүлгээр заавал оруулж хугацаа алдалгүйгээр нэн даруй түдгэлзүүлэх нь эцэстээ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасан шүүхэд гомдол гаргах үндсэн эрх хэрэгжих хууль зүйн нэгэн баталгаа болж иргэн, хуулийн этгээдэд эрх зүйн түр хамгаалал үзүүлэх үр нөлөөтэй механизмыг бүрдүүлэх юм.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль" УБ., 1992 он, ТМ №1
2. Захиргааны ерөнхий хууль, УБ.,2015, ТМ №28
3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль УБ., 2016, №9
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль УБ., 2017, ТМ №24
5. Г.Сүнжид "Захиргааны ерөнхий хуулийн үзэл баримтлал хэрэглээ" УБ., 2017, 107 дахь тал
6. "Өмгөөлөгч" сэтгүүлийн 2016 оны №12 /71/ дугаарт нийтлэгдсэн. М.Батсуурь "Шинэ хуулийн гол үзэл баримтлал нь шүүхээр хэрэг, маргаанаа шийдүүлж байгаа иргэд, олон нийтэд хамгийн таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх явдал байсан" ярилцлага
7. http://legaldata.mn/b/251 Г.Банзрагч "Монгол Улсын захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухайд" нийтлэл, УБ., 2017 он
8. "Эрх зүйн процессын шинэтгэл, хэрэгжилт" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, УБ., 2019 он, Т.Азжаргал "Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл, тулгамдсан асуудал" өгүүлэл

[12] Charles F. Sabel & William H. Simon, Destabilization Rights: How Public Law Litigation Succeeds, 117 Harv. L. Rev. 1015, 1017 (2004); See also Abram Chayes, The Role of the Judge in Public Law Litigation, 89 Harv. L. Rev. 1281 (1976).

[13] Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.3 дахь хэсэг,

9. Нийтийн ашиг сонирхлын тухай Р.Мухийт. Эрх зүй дэх нийтийн ашиг сонирхлын талаарх үндсэн ойлголтын тухайд. Хууль дээдлэх ёс. 2016 оны №4; Р.Мухийт, С.Билгүүн, Ж.Даваасүрэн. Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг нээх нь. Бодлогын судалгааны тайлан.
10. Brown v Board of Education of Topeka 347 US 483 (1954).
11. ''The Role of the Judge in Public Law Litigation'' (1976) 89 Harv. L. Rev. 1281.
12. Helen Hershkoff, Public Interest Litigation: Selected Issues and Examples (n.d.), available at
http://www1.worldbank.org/publicsector/legal/PublicInterestLitigation.do
13. Helen Hershkoff & Aubrey McCutcheon, Public Interest Litigation: An International Perspective, in Many Roads to Justice: The Law-Related Work of Ford Foundation Grantees Around the World 283, 284 (Mary McClymont & Stephen Golub eds., 2000)
14. Charles F. Sabel & William H. Simon, Destabilization Rights: How Public Law Litigation Succeeds, 117 Harv. L. Rev. 1015, 1017 (2004); See also Abram Chayes, The Role of the Judge in Public Law Litigation, 89 Harv. L. Rev. 1281 (1976).

ОЮУНЫ ӨМЧИЙН ХАМГААЛАЛТЫН АСУУДЛУУД

ISSUES OF PROTECTION OF INTELLECTUAL PROPERTY

Ж.Хулан[1]
Санхүү, эдийн засгийн их сургууль
Khulan J.[1]
University of Finance and Economics

Л.Хаш[2] **(Хууль зүйн доктор)**
Санхүү, эдийн засгийн их сургууль
Khash L.[2] **(Ph.D)**
University of Finance and Economics

✉ khulan.j@ufe.edu.mn
✉ khash.L@ufe.edu.mn

Хураангуй: Оюуны өмчийн хамгаалалтын асуудлууд нь нэг улсын төдийгүй дэлхийн хэмжээний асуудал болон урган гарч байна. Үүнд оюуны өмчийн эрхийг хэрхэн хамгаалах талаар зохицуулалт хийгдэж байгаа болон цахим орчиндох асуудал нь чухал ач холбогдолтой байгаа юм. Олон улсын гэрээ дагаж мөрдөх асуудал, оюуны өмчийн талаар ойлголт нь Монгол Улсын хувьд сүүлийн жилүүдэд ихээр яригдах болсон хэдий ч хэрэгжүүлэлт багатай шүүхээр хамгаалагдаж байгаа шийдвэр бага байгаа нь тулгамдаж байгаа асуудлыг нэг нь болж байна. Иймд оюуны өмчийн эрхийг хамгаалах асуудлыг бусад хөгжингүй орнуудад хэрхэн хэрэгжүүлдэг талаар судлах тэдгээр орнуудын туршлагыг Монгол Улсын хууль шинэчлэл хэлбэрээр санал гаргахад чиглэсэн харьцуулан үзсэн болно.

Abstract: Issues of Protection of Intellectual Property is not becoming an issue of one country, but also a world's issue. Here, some work relating to the adjustment on how to protect Intellectual Property is being done, and issues of cyber environment is crucial. Although the issues of observing the international laws and concepts of Intellectual Property have been a topic of much talk in recent years, it is one of the urgent issues that the implementation of court protected verdicts are hardly probable. The purpose of this study is to do research on the issues of how the protection of Intellectual Property rights in the developed countries is implemented, comparing experiences of the countries, we will try to offer some forms of law reforms in Mongolian Intellectual Property laws.

Түлхүүр үгс: Оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, цахим сургалт, интернет, хууль эрх зүйн зохицуулалт, эрх эзэмшигч, хэрэглэгч, интернет үйлчилгээ түгээгч.

Keywords: Intellectual property, to protect writer's rights, online course, internet, adjustment on laws, patent owner, consumer, deliver of internet service

Үндсэн хэсэг

Монгол Улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т "Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн"[1], "Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай" хуулийн[2] 3 дугаар зүйлийн 3.1.1-д "зохиогч гэж өөрийн оюуны бүтээлч үйл ажиллагаагаар бүтээл туурвисан хувь хүнийг", 6 дугаар зүйлийн 6.1-д "Зохиогчийн эрхийн бүтээлд агуулга, зориулалт, үнэ цэнэ, ач холбогдол, илэрхийллийн аргаасаа үл шалтгаалан зохиогчийн оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийг тооцно" гэжээ.

Харин эрдэм шинжилгээ судалгааны ажил болон цахим хичээлийн бүрдэл хэсэг нь оюуны өмчийн үүсмэл бүтээлийн төрлийн нэг бөгөөд энэ нь зохиогчийн эрх болон түүнд хамраах эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "үүсмэл бүтээл гэж өмнө бүтээгдсэн бүтээлд тулгуурлаж түүнийг оюуны бүтээлч хөдөлмөрөөр засварлах, найруулах, орчуулах, хөрвүүлэх, хураангуйлах, эмхэтгэх болон бусад хэлбэрээр өөрчилж, шинээр бий болгосон бүтээл" гэж тодорхойлсон ба мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Үүсмэл бүтээлийн зохиогчийн эрх нь эх бүтээлийн зохиогчийн эрхийг хөндөхгүй бөгөөд энэ хуулийн 12.2.4-т заасан зөвшөөрөл авна" гэж зааж, хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Зохиогч бүтээлийнхээ хувьд эдийн бус баялгийн эрх болон бүтээл ашиглах онцгой эрх эдэлнэ" гэж хамгаалсан байна. Эдгээр эрхүүдэд бүтээлээ өөрийн болон зохиомол, нууц нэрээр, болон нэргүйгээр нийтлэх, бүтээлээ нийтлэх, бүтээлийг ашиглуулах тухай бүр нэрээ дурдуулах, бүтээл болон түүний нэрийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр аливаа арга хэлбэрээр хувиргах, гажуудуулах, өөрчлөхийг хориглох зэрэг эдийн бус баялгийн эрхүүд, бүтээлийг хуулбарлах, нийтлэх, нийтэд түгээх, үүсмэл бүтээл болгон өөрчлөх, түрээсээр ашиглуулах зэрэг бүтээл ашиглах онцгой эрхийг эдлэхийг хуульчилж өгсөн юм.

Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 26 тоот тушаалын хавсралт "Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам"- ын 2 дугаар зүйлийн 2.6-д сургалтад цахим хэлбэрийг ашиглах, хичээлийн материалуудыг цахим хэлбэрт шилжүүлэхээр заажээ.[3]

Дээрх хуулиудын заалтаас үзвэл эрдэмтэн багш нарын бүтээсэн ном, сурах бичиг, гарын авлага, түүнчлэн цахим хичээлийн бүхий л материалууд маань оюуны өмчийн эрх зүйн харилцааны объект гэдгээрээ зохиогчийн эрхийн хамгаалалтанд багтаж байна. гэтэл цахим буюу интернет орчинд эрхийн хамгаалалт хэрхэн үйлчилж, хэрэгжиж байна вэ?

Интернет орчинд internet service provider хүрээнд буюу интернет үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд ямар серверийн хүрээнд хэрэгжүүлж байгаагаас шалтгаалан хяналт, хандалтыг тогтоох үйл ажиллагаа явуулж байдаг.

Манай улсад зохиогчийн эрхийг Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулиас гадна Иргэний хууль /2002 он/, Эрүүгийн хууль /2015 он/,

[1] Монгол Улсын Үндсэн хууль. 1992.
[2] Монгол Улсын Зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрхийн тухай хууль. 2006.
[3] Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 26 тоот тушаалын хавсралт.

Зөрчлийн тухай хууль /2017 он/, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай /2011 он/ хуулир тус тус зохицуулдаг. Эрүүгийн хуулийн хүрээнд эрүүгийн хуулийн 18-р зүйл 18.17 зүйл Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих гэмт хэргийн хүрээнд зохиогчийн тохиолдол болон оюуны өмчийн талаарх бүртгэгдсэн гэмт хэрэг нь 2011-2017 он хүртэл нийт 25 ширхэг байна.

Аймаг	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Улаанбаатар	6	1	3	4	6	2	3

Улсын хэмжээнд 2017 оны 07 сарын 01-ээс 2018 оны 12 сарын 31 хүртэл нийт 143 оюуны өмчийн талаарх маргаан захиргааны шүүхээр шалгагдсан бөгөөд. Шийтгүүлсэн эрүүгийн хэрэг үүссэн шалгагдсан тохиолдол байхгүй. Эдгээр хэргийн 50 хувьд зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулын арга хэмжээ ноогдуулсан. [4]



Энэхүү гарфикт үзүүлсэн байдал нь зөвхөн бүртгэгдсэн хэрэг бөгөөд эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдаж байгаа хэргийн тоон үзүүлэлт болно.

Монгол Улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газар -ын үйл ажиллагааны тайланд Зохиогчийн эрхийн гэрчилгээ авахыг хүссэн нийт 1050 бөгөөд бүтээлийг бүртгэж гэрчилгээ олгож, 2100 бүтээлийг мэдээллийн санд оруулсан байна. "Төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн" хэмээн джрдсан байна.

Оюуны өмчийн улсын хяналтын үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд Зохиогчийн эрхийн зөрчилтэй 18 вэб сайтын үйл ажиллагааг зогсоосон байна.

[4] https://police.gov.mn/as/static

Илэрсэн зөрчлийг төрлөөр нь авч үзвэл:





Зохиогчийн эрхийн зөрчил- 234

- Утга зохиол урлагийн бүтээл -7;
- Дуу авиа бүхий дүрст бүтээл /дуу, кино урлагийн бүтээл/ IPTV – 38;
- Цахим орчин дахь зохиогчийн эрхийн зөрчил -183;
- Дууны урлагийн бүтээлийн зохиогчийн эрх – 3;
- Зар сурталчилгаатай холбоотой -3[5] зөрчил тус тус илэрсэн байна.



Эндээс хархад цахим орчин дахь зохиогчийн эрхийн зөрчил нилээд хувь эзэлж байгаа нь харагдаж байна.

[5] Монгол Улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг оюуны өмчийн газарын 2018 оны тайлан.

Гадаад орнууд дахь зохиогчийн эрхийн хамгаалалтын тухай, ялангуяа цахим буюу интернет орчинд хэрхэн зохицуулагддаг талаар авч товч өгүүлье.

Америкийн нэгдсэн улсад интернет орчинд зохиогчийн эрхийг "Copyright Act"/1976 он/, "Digital Millennium Copyright Act" /1998 он/ хуулиар тус тус зохицуулдаг. 1998 оны хууль нь интернет сүлжээнд зохиогчийн эрхийн объектуудыг хамгаалахад чиглэсэн дэвшилтэт баримт бичиг болсон гэж үздэг байна. Тус хуулиар интернет сүлжээнд байршиж байгаа зохиогчийн эрхийн бүх объектүүд хамгаалагддаг байна. Мөн аливаа этгээд зохиогчийн эрх зөрчсөнөө мэдээгүй бол хариуцлага хүлээдэггүй зохицуулалттай. Хэрэв зөрчил үүссэн бол эхлээд зохиогчийн эрх зөрчсөн этгээдэд бичгээр, электрон шуудангаар зөрчлийг арилгахыг мэдэгдэнэ, харин хүлээж аваагүй тохиолдолд интернет сүлжээ түгээгч сүлжээнээс уг мэдээллийг устгах арга хэмжээ авдаг байна. Баримт: Feist Publications v. Rural Telephone Service 499 U.S. 340 (1991) хэргийн талаарх шүүхийн шийдвэр нь бүтээлийн хуулбарыг бус зөвхөн эх хувийг хамгаалах шүүхийн жишгийг тогтоосон гэж үздэг.

Түүнчлэн "Digital Millennium Copyright Act" хуулиар цахимд албан ёсоор нээлтээ хийгээгүй байгаа киноны хуулбарыг байршуулбал эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ.

Интернэт орчинд зохиогчийн эрхийн зөрчилд хариуцлага хүлээх субъектүүдийг тодорхойлоход хүндрэлтэй байдаг тул нэгдсэн улс "Online Copyright Infringement Liability Limitation Act" /1998 он хуулийг баталсан. Интернет сүлжээнд peer-to-peer /P2P/сүлжээг ашиглаж байхад нэг хэрэглэгч нөгөөгөөс мэдээлэл авч байхад нөгөө хэрэглэгч нь бас буцаагаад өөр мэдээллийг серверээр дамжуулахгүйгээр авч байж болдог тул бууруутай этгээдийг тогтооход хүндрэлтэй байжээ. Тийм учраас дээрх хуулиар хэрэглэгчийн зохиогчийн эрхийн зөрчилтэй мэдээллийг түгээсэн үйлдлийн өмнөөс интернет сүлжээ түгээгч хариуцлага хүлээхгүй байхаар заажээ. Мөн интернет сүлжээ түгээгч нь тухайн дамжуулсан мэдээллийг түгээхэд ямар нэгэн байдлаар оролцоогүй, мэдээллийг өөрчлөөгүй, мэдээлэл нь автомат техникийн процессийн дүнд дамжуулагдсан байх нь харицлага хүлээхгүй байх үндэслэл нь болж байхаар заасан байна. Энэ зохицуулалтын дүнд торрент-трекер[6] вэб хуудсууд хариуцлагаас мултрах боломжийг олгож байна хэмээн зохиогчид гомдол гаргадаг боловч тэр бүр амжилтанд хүрдэггүй байна. Торрент-трекер гэдэг нь peer to peer төрлийн нэгэн сүлжээ бөгөөд ямар нэгэн серверээс биш шууд хүмүүс хоорондоо компьютераасаа файлаа хуваалцах боломж олгодог юм.

Түүнчлэн The Recording Industry Association of America нь сүлжээн дэх хулгайтай тэмцэхээс илүү интернетийн үйлчилгээ түгээгчдийн тусламжтайгаар зөрчлийг арилгахыг хичээж байна. Тухайлбал, хэрэглэгчид өөр хооронд дуу хөгжмийн бүтээлүүдийг идэвхтэй солилцож байвал тус холбоо интернет үйлчилгээ түгээгчид бичгээр мэдэгдэл хүргүүлж, уг мэдэгдлийг хэрэглэгчид дамжуулах эсвэл холбоо нь хууль бус үйлдлээ таслан зогсоохыг шаардаж мэдэгдэл хүргүүлдэг байна. Ингээд шаардлагыг хүлээж авахгүй бол интернетийн

[6] torrent-trucker (англиар)

хурдыг багасгах, эцэст нь интернет сүлжээг таслах хүртэл арга хэмжээ авдагаараа ач холбогдолтой юм.

Нэгдсэн улсын шүүхүүд зохиогчийн эрхийн маргааныг шийдэхдээ хууль ёсны эсэх, тухайн объектыг ямар зорилгоор ашигласан, бүхэлд нь эсвэл тодорхой хэсгийг нь ашигласан, тухайн объектын зохиогчийн эрхийн онцлог, хууль бусаар ашигласны дүнд борлуулалтанд хэрхэн нөлөөлсөн зэргийг харгалзаж үздэг байна.

Интернетийн орчин дахь оюуны өмчийн хулгайн эсрэг эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох үүднээс сенатор Патрик Лехийн санаачлагаар 2010 онд Combating Online Infringementand Counterfeits Act /COICA/хуулийг баталсан бөгөөд энэ хуулиар мужийн ерөнхий прокурорын зүгээс зохиогчийн эрх зөрчсөн вэб хуудасны эздээс өмчлөгч, эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэх нэхэмжлэл гаргах, вэб хуудасны үйл ажиллагааг түр хугацаагаар түдгэлзүүлэх, шүүхийн шийдвэрээр үйл ажиллагааг нь зогсоох хүртэл арга хэмжээ авахаар зохицуулжээ. Мөн 2011 онд сенатор Лехи бусад 11 хүний хамтаар COICA-ийн боловсронгуй хувилбар болох Preventing Real Online Threats to Economic Creativity and The ftof Intellectual Property Act /PIPA/ баталсан ба энэ хуулиар нэгдсэн улсын гадна байрлах зохиогчийн эрхийг зөрчдөг вэб хуудсын хандалтыг хязгаарлах зохицуулалт оруулжээ. Дээрх хуулиудаар мужуудын Ерөнхий прокурын эрх хэмжээнээс гадна Хууль зүйн яаманд хянан шалгах ажиллагаа бүрэн явагдаж дуусаагүй байгаа тохиолдолд ч тодорхой арга хэмжээ авч болох эрхийг олгосон байна. Үүний дараа 2011 онд улс төрч Ламар Смитын санаачлагаар Stop Online Piracy Act /SOPA/ баталсан. Энэ хуулиар сулжээнд оролцогч бүр буюу интернет үйлчилгээ түгээгч, хэрэглэгч, зар сурталчилгаа захиалагч, түгээгч нар нь зохиогчийн эрхийн зөрчил гаргагч субъектэд мэдээлэл дамжуулах, үйлчилгээ үзүүлэхийг хориглохыг мэдэгдэх ба энэ журмыг дагахгүй бол хамтран хариуцлага хүлээхээр тусгажээ.

Англи улс нь нийтийн эрх зүйн системтэй орны хувьд хууль болон шүүхийн жишгээр оюуны өмчийн харилцааг зохицуулна. Зохиогчийн эрхийг интернет сүлжээнд хамгаалах хууль нь Copyright, Designs and Patents Act (1988), мөн Европын холбооноос гаргасан оюуны өмчийн эрхийг хамгаалах эрх зүйн баримт бичгүүдэд нийцүүлэн Copyright and Related Rights Regulations (2003) баталсан байна. Энд сургалтын байгууллагууд, номын сан, архивт хадгалагдаж байгаа бүтээлээс хэсэгчлэн хуулбарлахыг, мөн лицензийн гэрээний үндсэн дээр тоон хэлбэрээр байршсан баримтуудыг ашиглахыг зөвшөөрсөн, ашгийн бус зорилгоор ашиглахыг тус тус зөвшөөрдөг байна. Хариуцлагын тухайд торгууль ногдуулахаас гадна зургаан сараас нэг жил хүртэл хорих ял шийтгэнэ гэж заажээ.

Япон улсын хувьд оюуны өмчийн эрх зүйд хариуцлага хүлээх субъектын талаар тодорхой болгох шаардлага тулгарсан. Энд Токио хотын шүүхээс шийдвэрлэсэн хоёр тохиолдлыг дурдья. Нэг нь, трекер File Rogue-ийг вэб сайтыг явуулж буй үйл ажиллагаанаас ашиг хүртэгч нь гэж үзээд хариуцлага ногдуулсан. Нөгөө нь, трекер Win Mx сүлжээг ашиглаж хэсэг оюутнууд хууль бусаар контент ашигласан хэмээн шийтгэл хүлээж байжээ. Дээрх хоёр трекер нь хоёулаа P2P сүлжээг ашиглагадаг байжээ. Энэ асуудлыг зохицуулахын тулд ISP Liability Limitations Act (2001) буюу интернет үйлчилгээ түгээгчийн хүлээх хариуцлагыг

хязгаарлах хуулийг баталсан байна. Уг хуулиар интернет үйлчилгээ түгээгч зохиогчид учирсан хохирлыг дараах тохиолдолд хариуцахгүй байхаар зохицуулжээ. Үүнд: хууль зөрчсөн мэдээллүүдийг өөрөө байршуулаагүй байх, хэрэглэгч зохиогчийн эрх зөрчсөн мэдээлэл байршуулсан бол устгахыг шаардсан арга хэмжээ авсан байх, зохиогчоос ирсэн гомдлын дагуу эрх зөрчигчид хууль бус үйлдлийг таслан зогсоох шаардлагыг тавих зэрэг арга хэмжээнүүдийг тус тус авсан байх явдал юм.

Франц улсын тухайд Loisur le Droit d'Auteuret les Droits Voisins dans la Socit de l'Information (2006) буюу Зохиогчийн болон оюуны өмчийн эрхийн тухай хууль үйлчилж байна. Тус улсад зохиогчийн эрх зөрчсөн тохиолдолд эрүүгийн хариуцлагад татагдах ба 300 000 еврогоор торгож зэрэгцээ 3 жил хүртэл хорих ялаар шийтгэнэ. Харин зохион байгуулалтайгаар үйлдсэн бол 500 000 еврогоор торгож 5 жил хүртэл хорих ялаар шийтгэнэ. Франц улсын хууль нь зохицуулалтын хэм хэмжээ агуулахаас илүүтэйгээр хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх, чангаруулах зарчмаар зохицуулсан байна.

ОХУ нь 2003 онд "Антипиратский закон" (2003) баталсан ба энэ хууль нь АНУ-ын Stop Online Piracy Act хуулиас санаа авсан байдаг[7]. Уг хуулийн хамгаалалтанд зөвхөн дуу авиа бүхий дүрст бүтээл, кино урлагийн бүтээлүүд багтдаг байсан ба хожим 2015 оны нэмэлт өөрчлөлтөөр хуулиар хамгаалах объектын хүрээг өргөжүүлэхээр заасан юм. Мөн аливаа маргааныг шүүхийн өмнөх шатанд шийдвэрлэх зохицуулалтыг бусад орны нэгэн адил тусгажээ. Тухайлбал, зохиогч гомдол гаргасан тохиолдолд интернет үйлчилгээ түгээгч тухайн мэдээллийг байршуулсан этгээдэд 24 цагийн дотор мэдэгдэх, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна. Ингэхдээ зөвхөн зөвшөөрөлгүй байршуулсан зохиогчийн эрхийн объектыг л устгаж хаана. Кино урлагийн бүтээлтэй холбоотой маргаанаас бусад маргааныг ОХУ-ын Арбитрын шүүхээр хянан шийдвэрлэдэг байна.

Монгол Улсын хувьд интернет орчин дахь оюуны өмчийг хамгаалах тусдаа бие даасан хууль байхгүй ба "Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн" 25 дугаар зүйл "Интернетед зохиогчийн эрхийг хамгаалах" тухай заалтаар зохицуулж байна. Тухайлбал, 25 дугаар зүйлийн 25.1-д "Интернетийн үйлчилгээ түгээгч нь өөрийн серверт байршуулсан вэб хуудсанд зохиогчийн эрхийн зөрчил гаргахгүй байх, зохиогч болон эрх эзэмшигчийг эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй, 25.2-д "Интернетийн үйлчилгээ түгээгч нь зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчийн эрх зөрчигдөж байгаа тухай мэдээллийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх, зөрчлийн тухай мэдэгдсэн даруй тухайн вэб хуудсыг хаах үүрэг хүлээнэ" гэж заажээ.

Монгол Улсын хэмжээнд оюуны өмчийн хамгаалах талаарх асуудлыг нотлох баримтын хүрээнд хийгдэж байгаа нь хэрэв гэрээ байгуулах ажил дутуу тусгасан тохиолдолд өөрийн оюуны өмчийн эрхийг алдах мөн хэрэгжүүлэх боломжгүй болох талтай байгаа жишээ нь хавсралт-1 хавсралт-2 гэх гэрээнд энэ талаар хэрхэн заасан талаар үзэх боломжтой. Энэ хүү зохиоцуулалтыг тусгайлсан

[7] Ельчанинова Наталья Борисовна "Проблема правовой охраны интеллектуальной собственности в сети интернет", 2016 г.

хуулийн хүрээнд эсхүл одоо хэрэглэгдэж байгаа хуулийн зарим зүйл заалтыг нарийвчлан зааж өгөх нь чухал юм.

Дүгнэлт

Монгол Улс нь оюуны өмчийн бүтээлийг “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалж, зохицуулж байгаа боловч интернет орчинд зохиогчийн эрхийг хамгаалах явдал нь тулгамдсан асуудлын нэг болоод байна. Тус хуулийн 25 дугаар зүйлд байгаа интернет сүлжээнд зохиогчийн эрхийг хамгаалах заалт нь техник технологийн хурдацтай хөгжлийн өнөө үед шаардлага хангахгүй байна. Тухайлбал, энэхүү харилцааны хариуцлага хүлээх субъектыг зөвхөн “интернет үйлчилгээ түгээгч” гэх байдлаар томъёолсон нь учир дутагдалтай байна. /хостинг провайдер, интернет провайдер, сервер провайдер, администратор, владельцы сайтов/ Оролцогч нарыг тус бүрээр нь тодорхойлж ямар тохиолдол хариуцлага хүлээлгэх, ямар тохиолдолд хариуцлагаас чөлөөлөх тухай. Хэрэглэгч буюу мэдээллийг байршуулсан, харилцан солилцсон этгээдүүд энэ харилцаанд хэрхэн оролцож хариуцлага хүлээх тодорхойлох зайлшгүй шаардлагатай юм.

Интернет дэх зохиогчийн эрхийн харилцааны объектыг тодорхой болгох, жишээ нь бусад оронд тухайн байгаа АНУ-д оригиналаас хуулбарласан объектыг байршууласан тохиолдолд түүнийг зөрчил гэж үздэггүй байх жишээтэй.

Бусад орны жишгээр тусдаа хуультай болох, одоо үйлчилж байгаа зохиогчийн эрхийн хуульд мониторинг хийх шаардлагатай байна.

Зохиогчийн эрхийн асуудал нь сервер гадаад улсад байвал хууль зөрчсөн үйлдэлд хариуцалага хүлээлгэх буюу тухай сервертэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох гэх зэрэг асуудлууд урган гарч байгаа нь ирээдүйн боловсролын, хөгжилд анхаарвал зохих зүйл болно.

Иймд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Эрх зүйн зохицуулалыг сайжруулах буюу зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд мониторинг хийх
- Цахим орчин буюу интернет орчинг оновчтой тодорхойлж зөв хэрэглэх зөв ойлгох асуудлыг нарийвчлан судлах
- Цахим сургалн орчны тухай асуудлыг хөндөн зохиогчийн эрхийг хамгаалах талаар зохицуулалтыг оновчтой тодорхойлох
- Мэдээллийн хурдацтай энэ урсгалын дунд боловсролын асуудлыг хуулбар байдлаас салгах, ялгах шаардлага
- Plagscan төрлийн шалгах зориулалтай програмыг нэвтрүүлэх гэх мэт болно.
- Бусад улсын сайн туршлагыг нэвтрүүлэх, суралцах хуулийн зүйл нарийвчан тусгах
- Дотоодын болон бусад улстай хамтран ажиллах олон улсын болон хоёр улсын хоорондох эрх зүйн зохицуулалт болон туслалцаа үзүүлэх гэрээг хэрхэн мөрдөх талаар зөвлөмж гаргуулах зэрэг болно.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992.
2. Иргэний хууль. 2002.
3. Зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрхийн тухай хууль. 2006.
4. З.Намжил. "Дэлхийн оюуны өмчийн байгууллага, оюуны өмчийн лавлах". УБ., 2008.
5. Д.Цолмон. "Оюуны өмчийн эрх зүй, зохиогчийн эрх зүйд бичмэл бүтээлийг хамгаалах асуудал". УБ., 2003.
6. Д.Цолмон. Оюуны өмч (Эрх зүйн асуудал). УБ., 2001.
7. ДОӨБ. "Оюуны өмч гэж юу вэ?". Орчуулагч Д.Ганхуяг.
8. ДОӨБ. "Уран бүтээлчээс олон нийтэд" товхимол. Орчуулсан Д.Ганхуяг.
9. Richard Schaffer, Filiberto Agusti, Lucien J. Dhooge, Beverley Earle (2012). *International Business Law and Its Environment* – Eighth edition, 5191 Natorp Boulevard Mason, OH 45040, USA.
10. "Интернетийн эрх зүйн талаар та юу мэдэх хэрэгтэй вэ" нийтлэл, 2010.01.21 http://galbaatar.blogspot.com
11. "Вэб хуудсын зохиогчийн эрхийн асуудал" нийтлэл, 2011.02.21 http://galbaatar.blogspot.com
12. https://iq.hse.ru/more/media/zashita-prav-intellektualnoj-sobstvennosti
13. https://nsovetnik.ru/avtorskie_prava/mehanizmy-zashity-intellektualnoj-sobstvennosti-v-internete/

Хавсралт 1.

Зохиолын гэрээ

20..... он ..... сар ..... өдөр № Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас ..... /цаашид "А тал" гэх/, түүнийг төлөөлж Оранж энтертэйнментийн гүйцэтгэх продюсер ....., нөгөө талаас ..... регистрийн дугаартай /цаашид "Б тал" гэх/ ..... овогтой ..... хамтад нь "Талууд" гэх нар нь Иргэний хуулийн 359-368-р зүйлийг удирдлага болгон доорх нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү гэрээний зорилго нь ажилтан буюу Б тал нь А тал буюу ..... -ийн "IPTV comedy" /ажлын нэр/ төслийн 1 дугаарын зохиолыг бичиж зохиолчоор ажиллах, А тал нь Б талд гүйцэтгэсэн ажлыг дүгнэж хөлсийг төлөхтэй холбоотой талуудын хүлээх эрх үүрэг, хариуцлага, тэдгээртэй холбоотой үүсэх бусад харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. Гэрээний хугацаа

2.1 Энэхүү гэрээ нь батлагдсан өдрөөс эхлэн Б тал гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлж дуусах, А тал гэрээг дүгнэн гэрээт ажил дууссан гэж үзсэнээр дуусгавар болно. Гэрээний үндсэн хугацаа нь 20.... оны ..... -р сарын ..... -ны өдрөөс 20..... оны .....-р сарын .....-ны өдөр ажлыг бүрэн хүлээлгэж дуустал хугацаанд үргэлжилнэ.

ГУРАВ. "А,, талын эрх, үүрэг

3.1 А тал нь төслийн хугацаанд дараах үүргийг хүлээнэ.

3.1.1 Гэрээнд заагдсан хугацаанд Б талд ажлын хөлсийг /5.1 заагдсан/ төлөх

3.1.2 Б талын ажиллах боломжоор хангах

3.1.3 Төслийн зохиолтой холбоотой гарсан аливаа асуудлыг харилцан тохиролцон шийдвэрлэх

3.1.4 Б талыг удирдлагаар хангах

3.2 Б талаас удирдлагаас өгөгдсөн зааварчилгааг мөрдөн ажиллахыг шаардах

3.3 Б талын санаачлагаар гэрээ цуцлагдсан тохиолдолд А тал нь Б талд төлсөн төлбөрөө буцаан авах

3.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах

3.5 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх

3.6 Хууль тогтоомжид заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

ДӨРӨВ. "Б,, талын эрх, үүрэг

4.1 Зохиолч нь төслийн хугацаанд кино зохиолыг бүрэн дуусган хүлээлгэн өгөх үүргийг хүлээнэ. Үүнд:

4.1.1 Ерөнхий продюсер, гүйцэтгэх продюсер, ерөнхий найруулагчтай зөвлөлдөн зохиолын санаа боловсруулах
4.1.2 Зохиолын үг, үйл явдал одоо цагт болж байгаа сонирхол татах сэдэв, тренд үг хэллэгийг судлах, зохиолд оруулах
4.1.3 Төслийн зохиолыг цаашид үргэлжлэнэ хэмээн бодож бичих
4.1.4 Зохиолын засвар өөрчлөлт гарах болсон тохиолдолд засварыг хийх
4.1.5 Төслийн зохиол, санааг гарган ажиллана
4.1.6 А талаас ирүүлсэн зааварчилгааг мөрдөн ажиллах
4.1.7 Удирдлагын зүгээс өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлэх
4.1.8 Төлөвлөгөөт хугацаанд ажлаа хийж гүйцэтгэх

4.2 А талаас /5.1 заагдсан /ажлын хөлсийг хугацаандаа авахыг шаардах эрхтэй
4.3 Хөлсөөр ажиллах гэрээний харилцааг дуусгавар болгох үед Б тал А талаас хөлсөөр ажиллаж байсан тухай болон үргэлжилсэн хугацааны талаар бичгээр тодорхойлолт гаргаж өгөхийг шаардах эрхтэй.
4.4 А" талын санаачлагаар гэрээг цуцалсан тохиолдолд "Б" тал нь хийсэн ажлынхаа хөлсийг А талаас нэхэмжлэх буюу хийгдсэн ажилдаа тэнцэх хэмжээний төлбөрийг тооцуулах эрхтэй.

ТАВ. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

5.1 Энэхүү /гэрээний 4.1-д заагдсан/ ажлыг хийж гүйцэтгэх нэг дугаарын үндсэн төлбөр нь ..... /..... мянган / төгрөг ХХОАТ болон НДШ суутгагдсан дүн байх болно.
5.2 Төлбөрийг зохиолчийн ..... банкны **.....** тоот дансанд гэрээ батлагдсан өдрөөс хойш ажлын 2 хоногт 50%-ийг, үлдсэн 50%-ийг гүйцэтгэл дуусан буюу 2 талын бүтээл хүлээлцсэн актыг үндэслэн мөн ажлын 5 хоногт шилжүүлнэ.

ЗУРГАА. Гэрээ дүгнэх, ажил хүлээлцэх

6.1 Энэхүү гэрээг 2.1-т заагдсан хугацаанд хийгдсэн ажил дуусгавар болох, төслийн удирдлага ажлыг дууссан гэж үзсэн тохиолдолд гэрээ дүгнэгдэнэ.
6.2 Ажил хүлээлцэхэд Б тал А талд дараах зүйлийг хүлээлгэн өгнө.
6.2.1 Төслийн дагуу хийгдсэн зохиол

ДОЛОО. Талуудын хариуцлага

7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талдаа хохирол учруулсан бол учруулсан хохирлоо бүрэн тал нь нөхөх төлөх үүрэгтэй.
7.2. Алданги торгууль төлсөн нь Талуудыг үндсэн үүрэг болон учирсан хохирлыг нөхөн төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
7.3. Ажил гүйцэтгэх явцад аль нэг тал бусдыг хэл амаар доромжлох, ёс зүйгүй харьцахыг хориглоно.

НАЙМ. Нууц хадгалах, оюуны өмчийн эрх

8.1 Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээ, мэдээллийг бусдад задруулахгүй байх, өөрийн болон бусад этгээдийн эрх ашгийн төлөө ашиглахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.

8.2 Төслийг хэрэгжүүлэх явцад мөн төсөл дууссаны дараа зураг авалтын үед хийгдсэн ажил, нэвтрүүлэгт ороогүй хар дүрс, нэвтрүүлгийн зохиол, ирүүлсэн формат, мэдээ мэдээлэл, бичиг баримттай холбоотой аливаа асуудлыг бусдад худалдах, хувилан олшруулах, борлуулах задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.

8.3 Энэхүү гэрээний 8.1-р хэсэгт заасан нөхцөлийг аль нэг тал зөрчсөн тохиолдолд үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа хохирлыг бүрэн төлнө.

8.4 Гэрээг хэрэгжүүлэх явцад бүтээгдсэн зохиогчийн болон оюуны өмчид хамаарах бүх эрхийг "А" тал эдлэх бөгөөд өмчлөх эрхгүйгээр Б талын нэр нь уг бүтээлийн салшгүй хэсэг болж олон нийтэд танигдана.

ЕС. Давагдашгүй хүчин зүйлс

9.1 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

9.2 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

9.3 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, хүчтэй салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.

АРАВ. Маргаан шийдвэрлэх

10.1 Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Санал зөрөлдөөн, маргааныг зөвшилцөөнөөр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд "А" талын харьяалах шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

АРВАН НЭГ. Бусад зүйл

11.1 Гэрээнд заагаагүй нэмэлт ажлыг энэхүү гэрээгээр зохицуулахгүй бөгөөд талууд тохиролцсон тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулах эсхүл нэмэлт гэрээ байгуулж болно.

11.2 Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

АРВАН ХОЁР. Талуудын албан ёсны хаяг

Захиалагч:

.....
Хаяг: .....
.....
Утас: .....
Факс: .....

Гүйцэтгэгч:

Утас:.....
Хаяг: .....
.....

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

..... ийг төлөөлж:
Гүйцэтгэх продюсер
.....

Гүйцэтгэгчийг төлөөлж:
Зохиолч, ...
.....

ХЯНАСАН:

Контент хөгжил хариуцсан захирал .....

Хавсралт 2.

КИНО ЗОХИОЛ БИЧҮҮЛЭХ ГЭРЭЭ

20... оны ...дүгээр сарын....-ны өдөр № .... Улаанбаатар хот

Кино зохиол захиалан бичүүлж, хамтран ажиллах энэхүү гэрээг /цаашид "Гэрээ" гэх/ нэг талаас регистрийн ..... дугаартай ..... ХХК, түүнийг төлөөлж Ерөнхий захирал ..... /цаашид "**А тал**" гэх/, нөгөө талаас, регистрийн ..... дугаартай Монгол Улсын иргэн ..... овогтой ..... /цаашид "**Б тал**"/, хамтад нь "**талууд**" гэх нар Монгол Улсын иргэний хуулийн 476-482-р зүйлийг үндэслэн, дор дурдсан нөхцлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Гэрээний ерөнхий нөхцөл

1.1 А тал нь Б талд кино зохиолын үндсэн санааг гаргаж өгч, кино зохиол болгож бичүүлэхээр захиалж, уг ажлын хөлсийг тохиролцож төлнө.

1.2 Б талнь А талд ..... кино зохиолыг бичих захиалгат ажлыг хийж гүйцэтгэн, тохиролцсоны дагуу ажлын хөлс авна.

1.3 Гэрээний хугацаа: 20..... оны ..... сарын .....-ээс 20..... оны ..... сарын ..... өдөр хүртэл байна.

1.4 А тал нь тус ажлын буюу кино зохиолын өмчлөгч байх бөгөөд Б тал нь тус кино зохиолын өмчлөгчийн эрхийг харилцан тохиролцсоны дагуу шилжүүлэн өгнө.

Хоёр. А талын эрх, үүрэг

2.1 А тал нь Б талын ажлын гүйцэтгэлийн явцад тохирсон графикт хугацааны дагуу уулзалт хийн, тэмдэглэл хөтлөн баталгаажуулж, хүлээн авна.

2.1.1 Зохиолын синопсис гарган батлуулах – 20.....

2.1.2 Зохиолын үйл явдлын дараалал гарган батлуулах 20.....

2.1.3 Зохиолыг эхний хувилбараар гарган танилцуулах 20.....

2.1.4 Зохиолыг эцсийн хувилбараар бүрэн дуусгаж хүлээлгэн өгөх-20.....

2.2 А тал нь гэрээнд тусгагдсаны дагуу захиалсан кино зохиолыг тохиролцсон санаа, үйл явдлын дагуу мэргэжлийн өндөр түвшинд, гэрээт хугацаанд багтаан,хийж гүйцэтгэхийг Б талаас шаардах эрхтэй.

2.3 А тал нь гэрээт хугацаанд захиалгат ажил гүйцэтгэх явцад нэмэлт өөрчлөлт, засваруудыг Б тал буюу зохиолчтой тохиролцон, кино зохиолд оруулах эрхтэй.

2.4 Кино зураг авалтын үеэр зайлшгүй шаардлагатай болсон тохиолдолд кино зохиолын зарим хэсгийг өөрчлөх, засах, солих ажлыг хийх бол зохиолч буюу Б талд урьдчилан мэдэгдэж, тухайн хэсгийн зураг авалтын ажилд зохиолчийг байлцуулан, дээрх өөрчлөлтийгзохиолчоор гүйцэтгүүлэх үүрэг хүлээнэ. Хэрвээ зохиолч биеэр ирж, тус нэмэлт ажлыг гүйцэтгэх боломжгүй бол, энэ ажлыг урьдчилан хийлгэж болно.

2.5 Захиалгат кино зохиолыг А тал бүрэн өмчилнө. А талд оюуны өмчийг өмчлөгчийн бүх эрх хадгалагдана.

2.6 А тал нь Б талд захиалгат ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай өгөгдөл,материалуудыг цаг алдалгүй өгөх үүрэгтэй.

2.7 А тал нь Б талд кино зохиол бичүүлэх ажлын хөлсийг гэрээний хавсралтанд тохиролцон заасан хугацаанд 3 үе шаттайгаар хуваан төлөх үүрэг хүлээнэ.

2.8 Б талын санаачлагаар гэрээ цуцлагдсан тохиолдолд А тал нь Б талд төлсөн төлбөрөө буцаан авах

Гурав. Б талынэрх, үүрэг

3.1 Б тал нь харилцан тохиролцсон энэхүү гэрээний дагуу кино зохиолыг бичихэд шаардлагатай тоо баримт, өгөгдөл, түүхэн фото зураг, бичлэг, материалуудыг гаргаж өгөхийг шаардах эрхтэй.

3.2 Б талнь А талын өгсөн зөвлөмж бусад өгөгдөл материалуудыг ашиглан захиалгат кино зохиолыг бичиж бүтээх ажлыг мэргэжлийн өндөр түвшинд, гэрээнд заагдсан хугацаанд багтаан хийж гүйцэтгэх үүрэгтэй.

3.3 Б тал нь захиалгат зохиолыг эцсийн байдлаар бэлэн болсон эх хувийг доор заасан хугацаанд цаасан дээр хэвлэсэн байдлаар 1 хувь, файл хэлбэрээр 1 хувь тус тус захиалагч талд хүлээлгэж өгөх үүрэгтэй.

3.3.1 Зохиолын синопсис гарган батлуулах – 20.....

3.3.2 Зохиолын үйл явдлын дараалал гарган батлуулах 20.....

3.3.3 Зохиолыг эхний хувилбараар гарган танилцуулах- 20.....

3.3.4 Зохиолыг эцсийн хувилбараар бүрэн дуусгаж хүлээлгэн өгөх- 20.....

3.4 Б тал нь А тал буюу захиалагч талын тавьсан санал болон нэмэлт өөрчлөлт, засвар зэргийг зохиолд засварлан оруулах үүрэг хүлээнэ.

3.5 Б тал нь захиалгат ажлыг гүйцэтгэх явцад А талтай хамтран ажиллахдаа олж авсан мэдээлэл, санаа, кино зохиолынхоо аливаа хэсэг, нэгж болон бүтнээр нь кино зохиолыг өмчлөх, өөр бусдад ашиглуулах, тус киноноос өөр аливаа хэлбэрээр, зорилгоор ашиглах, А талтай холбоотой бусад мэдээ, мэдээллийг чанд нууцлах, цааш дамжуулахгүй байх үүрэгтэй.

3.6 Б тал нь захиалгат ажлыг гүйцэтгэхдээ зохиогчийн эрхийн тухай Монгол Улсын хууль тогтоомж заалтуудыг зөрчихгүй байж, бусдын зохиол бүтээлээс ашиглахгүй байх үүрэгтэй.

3.7 Б тал нь А талын ажлын файлуудыг архив үүсгэж хадгалах, шаардлагатай тохиолдолд захиалагч талд бүрэн шилжүүлэх үүрэгтэй.

3.8 Б тал нь А талд захиалгат кино зохиолын ажлыг дуусган хүлээлгэн өгч, ажлын хөлсөө бүрэн авах эрхтэй.

3.9 Захиалгат зохиолд ашигласан үйл явдал, дүрүүдийн шинж чанар, утга санаа, нэр, өгүүлбэр, харилцан яриа зэргийг А талын зөвшөөрөлгүйгээр өөр кино зохиол, жүжиг,өөр байгууллага, бүтээгдэхүүний аливаа нэг нэвтрүүлэг, сурталчилгаа, реклам зэрэгт ашиглахгүй байх үүрэг хүлээнэ.

3.10Б талын бүтээсэн зохиолд хамааралтай зохиогчийн эрхийн асуудалд А тал хариуцлага хүлээхгүй болно.

Дөрөв. Төлбөр тооцоо

4.1 Гэрээт ажлын нийт үнэлгээг Талууд /тоогоор/ ..... /бичгээр/ төгрөг байхаар тохиролцсон болно.

4.2 Төлбөрийн дараах хуваарийн дагуу хуваан төлнө

4.2.1 Гэрээ хийгдэснээс хойш 3 хоногийн дотор гэрээний дүнгийн 40%

4.2.2 Кино зохиолын эхний хувилбараар танилцуулж батлуулсны дараа 3 хоногийн дотор 30%

4.2.3 Зохиолыг эцсийн хувилбараар бүрэн дуусгаж хүлээлгэн өгсөний дараа 3 хоногийн дотор 30 % тус тус өгнө

4.3 Гэрээний төлбөрийг Б талын дараах дансанд шилжүүлнэ

Банкны нэр:

Дансны дугаар:

4.4 Б тал ажлын гүйцэтгэлийг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэж өгөөгүй, харилцан тохиролцсон зохиолын дагуу хийж гүйцэтгээгүй, кино зохиолыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд гэрээнд заасан хугацаанаас хойшхи хугацаанд гэрээний үнийн дүнгээс хоног тутамд 0,5%-ийн алдангийг тооцож, үлдэгдэл төлбөрөөс суутган авна.

Тав. Нууц хадгалах, Зохиогчийн эрх

5.1Талууд энэхүү гэрээг байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, хувийн нууцад хамааралтай (санаа, сэдэл, ажлын төлөвлөгөө, техник, санхүү, бизнесийн нууц гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгээр болон аман хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүсэх Эрсдлийг хуваарилах

6.1 Б талын гүйцэтгэсэн ажлын үр дүнг А талд шилжүүлэхээс өмнө гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас тухайн ажлын үр дүн устсан, гэмтсэн тохиолдолд бий болох эрсдлийг Б тал дангаар хариуцна.

6.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдэгт байгалийн гамшиг, газар хөдлөлт, үер, зуд, дайн байлдаан зэрэг хамаарна.

6.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүсвэл 2 тал тохиролцож, гэрээг сунгах эсэх талаар шийдвэр гаргана.

Долоо. Бусад зүйл

7.1 Талууд нь энэхүү гэрээг байгуулахаас өмнөх ажлын үнэ хөлс, хэмжээ, чанар, хугацаа болон бусад гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбоотой асуудлаар харилцан амаар буюу бичгээр ирүүлсэн аливаа санал, хэлцэл нь гэрээ албан ёсоор бичгээр байгуулагдаж хүчин төгөлдөр болмогц хүчин төгөлдөр бусад тооцогдоно.

7.2 Талууд хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд харилцан зөвшөөрч гарын үсэг зурж, тамга дарснаар энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

7.3 Гэрээний хугацаа дууссаны дараа талууд гэрээний биелэлтийг дүгнэсэн тухай баримт үйлдэж гэрээнд хавсаргана.

7.4 Энэхүү гэрээгээр үүссэн маргааныг харилцан зөвшилцлийн замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.Зөвшилцөлд хүрэхгүй бол маргаанаа Монгол Улсын ХуульТогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

7.5 Энэхүү гэрээ нь 2 хувь үйлдэгдэж, талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно. Гэрээний хувиуд нь хууль эрх зүйн хувьд ижил тэнцүү хүчинтэй.

Гэрээг байгуулсан:

....." ХХК-г төлөөлж:
КИНО ЗОХИОЛЧ-г төлөөлж:
.....
/овог, нэр/
Продюсер /албан тушаал/

Талуудын албан ёсны хаяг

.....,
.....
.....тоот
.....

Утас: .....
E mail: .....
FB: .....

Утас:
E mail:
FB:

ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ БА ШҮҮХИЙН ЗАХИРГАА

AMENDMENTS AND CHANGES OF THE CONSTITUTION AND THE JUDICIAL ADMINISTRATION

Б.Өлзийсайхан
Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билиг дээд сургуулийн захирал, хууль зүйн доктор, дэд профессор
Ulziisaikhan B.
Director, The Bilig Institute, University of the Humanities, Ph.D in law

✉ ulziisaikhan.b@bilig.edu.mn

Хураангуй. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуульд анх удаа төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг хэрэгжүүлж хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн тусгаар, бие даасан байдлыг бэхжүүлэхийн зэрэгцээ шүүхийн захиргааны байгууллага, түүний чиг үүргийг тусгайлан зохицуулсан байна. Тухайлбал, Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлд "Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана" гэж тусгасан юм. Шүүхийн тухай (1993) хуулийн Дөрөвдүгээр бүлэгт, Шүүхийн тухай (2002) хуулийн Зургадугаар бүлэгт батлан, шүүхийн тухай багц хууль 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс хэрэгжих хүртэл үйлчилсэн. 2012 оны Шүүхийн тухай багц хуулиар шүүхийн захиргааны бие даасан загварыг сонгож, уг захиргааны чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлсэн ба сүүлийн 6 жилд зарим эерэг өөрчлөлтийг бий болгожээ. Гэвч шүүхийн болон шүүхийн ерөнхий зөвлөлийн бие даасан хараат бус байдлын талаар багагүй шүүмж гарч, шүүгчийг шилж сонгох чиг үүрэг бүхий Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх зүйн байдал болон шүүгчийн томилгооны журмыг Үндсэн хуулийн төвшинд дахин авч үзэх, өөрчлөх санал Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгагдаж, улмаар олон удаагийн хэлэлцүүлгийн явцад өөрчлөгдөж зарим хэсэг нь дэмжигдэн 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан байна.

Энэхүү илтгэлээр шүүх эрх мэдлийн шинэтгэл дэх шүүхийн захиргааны төлөвшил, Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаа, түүний үр нөлөөг танилцуулахыг зорьлоо.

Abstract. For the first time in the 1992 Constitution of Mongolia implements the principle of separation of powers, strengthens the independence of legislature, executive and judicial, and regulates the judicial administration and its functions specifically.

Particularly, In Article 49 of the Constitution describes that "The Judicial General Councils shall work for the purpose of ensuring the impartiality of judges and independence of the judiciary". In Chapter Four of the Law on Courts (1993) and Chapter Six of the Law on Courts (2002) were approved and the package of law on Courts was in force from 15 April 2013. By the package of law on Courts of 2012 has chosen an independent model of the judicial administration, creating a legal

framework for function and structure of the judicial administration and has made some positive changes in the last six years. However, there has been considerable criticism for the independence of the judiciary and the Judicial General Council, and suggestions have been made in the draft amendments and changes to the constitution to revise the legal status of the Judicial General Council and the procedure for appointing judges at the constitutional level. It was changed during several discussions and some parts were supported and adopted on 14 November 2019.

The purpose of this report is to introduce the development of the judicial administration in the reform of the judiciary, the concept of amendments and changes to the constitution and its impact.

Түлхүүр үгс: Үндсэн хууль, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, шүүхийн захиргаа, шүүхийн ерөнхий зөвлөл

Keywords: The Constitution, Amendments and changes of the Constitution, The Judicial Administration, The Judicial General Council.

Монгол Улсын Үндсэн хууль 1992 онд батлагдан мөрдөгдсөнөөс хойш 28 жил өнгөрч энэ хугацаанд УИХ[1]-ын зарим гишүүдээс 2000, 2011, 2012, 2015 онд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж өргөн барьж байснаас Төрийн институц хоорондын харилцааны болон УИХ-ын үйл ажиллагааны практикт тулгамдсан зарим асуудлыг шийдвэрлэх хүрээнд 2000 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч тэдгээрийн зарим нь төрийн эрх мэдэл хоорондын хяналт-тэнцлийг хангахад сөрөг үр дагавар авчирсан тухай эрдэмтэн, судлаачид, олон нийтийн зүгээс шүүмжлэл хүлээх болсон[2]. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн зөрчил дутагдлаас сургамж авч УИХ-аас Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг 2010 оны 10 дугаар сарын 23-ны өдөр баталсан бөгөөд 2017, 2019 онд тухайн хуулийн зарим зүйлийн гарчиг, хэсэг, заалтад хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан үүнээс зарим заалтад оруулсан өөрчлөлтийг дурдвал Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль (2010 оны 10 дугаар сарын 23-ны өдөр баталснаар)-ийн 4.1.2."Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл" гэж хууль санаачлагчаас Үндсэн хуулийн ач холбогдол, өндөр шаардлагыг хангахуйц мэргэжлийн төвшинд боловсруулан УИХ-д өргөн мэдүүлсэн төслийн эх бичвэрийг" гэснийг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль(2019 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан байдал)-иар 4.1.2."Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл" гэж хууль санаачлагчаас Үндсэн хуулийн ач холбогдол, өндөр шаардлагыг хангахуйц мэргэжлийн төвшинд боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийн эх бичвэрийг" гэж, түүнчлэн тухайн хуулийн 8 гарчиг, 14 хэсэг, 3 заалтад хуулиар өөрчлөлт оруулсан байна.

[1] УИХ- Улсын Их Хурал

[2] Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тухай. // Өмгөөлөгч (эрх зүйн онол, практикийн аргачилсан сэтгүүл) УБ., 2019 №30/89/. 5 дахь тал.

УИХ-ын 2017 оны 24 дүгээр тогтоолоор Зөвлөлдөх зөвлөл байгуулж, 6 багц асуудлаар зөвлөлдөх санал асуулга зохион байгуулж, түүнээс 5 багц асуудал дэмжигдэж, УИХ-ын даргын 2017 оны 78 дугаар захирамжаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Дээрх зөвлөлдөх санал асуулгаар "Шүүх эрх мэдлийн хариуцлага, хараат бус байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлт"-ийн талаарх багц асуудал (Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах үүрэг бүхий ШЕЗ[3]-ийн бүрэлдэхүүнийг өргөтгөх) 72,5 хувийн[4] үр дүнг илэрхийлжээ. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг судалж, санал дүгнэлт боловсруулах ажлын хэсэг улсын хэмжээнд нийт 3267 хүнийг судалгаанд түүвэрлэн хамруулсан асуулгын судалгааны үр дүнгээс: 1) Монгол Улсын хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн тэнцвэрт байдал, хоорондын холбоо хангагдсан эсэх талаар таны бодол? – Төдийлөн хангагдаагүй (1592 хүн буюу нийт оролцогчийн 49,3 хувь), 2) Таны бодлоор өнөөгийн шүүхийн тогтолцоонд ямар нэг өөрчлөлт оруулах шаардлага байгаа юу? – Тийм шаардлага байгаа (1971 хүн буюу нийт оролцогчийн 62,7 хувь), 3) Хэрэв тийм шаардлага байгаа бол нэн түрүүнд ямар өөрчлөлт оруулах шаардлагатай вэ? – Шүүгчийг шилж сонгох үйл ажиллагааг илүү нээлттэй болгох (1343 хүн буюу нийт оролцогчийн 53.6 хувь)[5]гэж судалгааны тайланд тусгажээ.

УИХ-ын даргын 2017 оны 78 дугаар захирамжаар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсанаас хойшхи төслийн энгийн хувилбар (Шүүх эрх мэдлийн хариуцлагыг дээшлүүлж, хараат бус байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлт)Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл[6]-ийг 2018 онд 3 удаа, 2019 оны эхний 6 сарын хугацаанд 2 удаа өөрчилж, УИХ-ын 2019 оны 68 дугаар тогтоолоор Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулсан. Ийнхүү 1 ажлын хэсэг, 6 ажлын дэд хэсгээс Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл (Хоёрдугаар хэлэлцүүлгийн дараах хувилбар 2019.10.17)-ийг танилцуулж, 2019 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн уг эхийг баталсан. Дээрх цаг хугацаанд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн энгийн хувилбараар танилцуулагдсан төсөл[7] тус бүрээр авч үзвэл:

1. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл (2018.03.19, 2018.04.20)-д Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч болон УИХ-аас томилогдсон хоёр хүн, Засгийн газраас томилогдсон нэг хүн, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс сонгогдсон нэг, давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс сонгогдсон хоёр, анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс сонгогдсон гурван шүүгч нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд орон тооны гишүүнээр УИХ-аас томилогдсон болон Ерөнхийлөгчөөс

[3] ШЕЗ – Шүүхийн ерөнхий зөвлөл.
[4] Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл. Уб., 2019. 18 дахь тал.
[5] Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг судалж, санал дүгнэлт боловсруулах ажлын хэсэг. Асуулгын судалгааны тайлан. 2017 оны 3 дугаар сарын 10.
[6] Тус илтгэлийн хавсралтаас дэлгэрэнгүй танилцана уу.
[7] Тус илтгэлийн хавсралтад Үндсэн хуульд оруулах нэмэлт,өөрчлөлтийн энгийн хувилбараас хэсэгчлэн авч харьцуулалт хийсэн.

томилогдсон, анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс сонгогдсон тус бүр нэг гишүүн. Энэ нь орон тооны 5, орон тооны бус 4 гишүүнтэй, бүрэн эхрийн хугацаа 4 жил, даргыг орон тооны гишүүд дотроосоо олонхийн саналаар сонгоно гэж боловсруулсан нь орон тооны бус гишүүний эрх зүйн байдлыг дордуулсан агуулгатай, цаашлаад зөвлөлийн тогтвортой ажиллах эрх зүйн баталгааг үгүйсгэхээр байжээ.

2. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл (2018.05.29)-д ШЕЗ 11 гишүүнээс бүрдэх бөгөөд гишүүдийн гурвыг УИХ, хоёрыг Ерөнхийлөгч тус тус томилох бөгөөд тэдгээр нь хуульчийн мэргэжлээр арваас доошгүй жил ажилласан, хууль зүйн өндөр мэргэшилтэй. ШЕЗ-ийн гишүүдийн нэгийг хяналтын шатны шүүхийн шүүгчдээс, хоёрыг давж заалдах шатны шүүхийн шүүгчдээс, гурвыг анхан шатны шүүхийн шүүгчдээс сонгож, 4 жилийн хугацаагаар зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллах, даргыг УИХ, ерөнхийлөгчөөс томилсон гишүүд дотроос нэр дэвшүүлж, нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно гэж боловсруулсан нь гишүүдийн тоог нэмэгдүүлэн, төлөөллийн зарчмыг хэрэгжүүлсэн хэдий ч даргын орон залгах гишүүн нь тодорхой, албан тушаалтнаас хараат, боловсруулалтын хувьд эрх зүйн соёл ухамсар төлөвшиж буй улсын хувьд байж боломгүй ялгамжтай төсөл болсон. 2018 онд боловсруулсан дээрх төслүүдэд зөвхөн ШЕЗ-ийн бүрэлдэхүүн, даргыг хэрхэн сонгох, бүрэн эрхийн хугацааг анхаарч байсан нь ШЕЗ-ийн одоогийн бүтцэд олон нийтийн болон зарим судлаачдын зүгээс хэт шүүмжлэлтэй хандаж байсны илрэл гэлтэй.

3. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл (2019.04.04)-д 1) ШЕЗ 10 гишүүнээс бүрдэх, гишүүдийн тавыг УИХ-ын холбогдох байнгын хороо нэр дэвшүүлж, УИХ томилгооны сонсгол хийж, хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3 доошгүйн саналаар, гишүүдийн нэгийг хяналтын шатны шүүхийн шүүгчдээс, нэгийг давж заалдах шатны шүүхийн шүүгчдээс, гурвыг анхан шатны шүүхийн шүүгчдээс тус бүр дундаасаа сонгож, даргыг гишүүд дотроосоо нэр дэвшүүлж, нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно. 2) Шүүгчийн хариуцлагын зөвлөл нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, чөлөөлөх, огцруулах болон бусад шийтгэл ногдуулах шийдвэр гаргах чиг үүрэг бүхий тус зөвлөл 9 гишүүнээс бүрдэх, гишүүдийн 3 иргэдээс; 3 хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан эрдэмтдээс тус тус сонгон шалгаруулж, УИХ-ын холбогдох байнгын хороо нэр дэвшүүлэн УИХ хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3 доошгүйн саналаар, гишүүдийн нэгийг хяналтын шатны шүүхийн шүүгчдээс, нэгийг давж заалдах шатны шүүхийн шүүгчдээс, нэгийг анхан шатны шүүхийн шүүгчдээс тус бүр дундаасаа сонгож, 6 жилийн хугацаагаар зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллах, гишүүдэд тавих шаардлага, төлөөллийн оролцоо зэргийг зааж өгсөн нь Үндсэн хуулиар зохицуулах зүйл, хуулиар зохицуулах зүйлийг зааглаагүй, нэг хэсгийг үндсэн хуулиар нэг хэсгийг нь хуулиар зохицуулахаар боловсруулсан байх жишээтэй.

4. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл (2019.06.06)-д:

1) ШЕЗ 10 гишүүнээс бүрдэх, ШЕЗ-ийн гишүүн дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллах, гишүүдийн тавыг УИХ-ын

холбогдох Байнгын хороо нэр дэвшүүлэн томилгооны сонсгол хийж, УИХ-ийн хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3 доошгүйн саналаар, гишүүдийн нэгийг хяналтын шатны шүүхийн шүүгчдээс, нэгийг давж заалдах шатны шүүхийн шүүгчдээс, гурвыг анхан шатны шүүхийн шүүгчдээс тус бүр дундаасаа сонгож, даргыг гишүүд дотроосоо нэр дэвшүүлж, нийт гишүүний олонхийн саналаар сонгоно. 2) Шүүгчийн хариуцлагын зөвлөл 9 гишүүнтэй, 3 нь шүүн таслах ажлын туршлагатай хуульч; 3 нь хууль зүйн эрдэмтэн; 3 нь иргэдийн төлөөлөл байх бөгөөд 6 жилийн хугацаагаар зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллах бөгөөд даргыг гишүүд дотроосоо сонгоно. Энэхүү төслөөр шүүхийн хариуцлагын зөвлөлийн бүрэлдэхүүнд орох хуульчийг зөвхөн шүүгчээр хязгаарлаагүй бөгөөд шүүн таслах ажлын туршлага бүхий гэсэн өргөн хүрээ бүхий шаардлага оруулж иржээ. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн дээрх төслүүдэд шүүхийн захиргаа буюу ШЕЗ-ийн бүрэлдэхүүнийг 9-11, бүрэн эрхийн хугацааг 4 жил, 4 жилийн хугацаагаар зөвхөн нэг бүрэн эрхийн хугацаанд ажиллах, зөвлөлийн гишүүнд тавих шаардлага, гишүүн болон зөвлөлийн даргыг томилох, сонгох үйл ажиллагааны талаар холбогдох зүйл, хэсэгт байнга өөрчлөлт орж ирсэн бөгөөд 2019 оны 4 дүгээр сарын 04-ний төслөөр шүүгчийн хариуцлагын зөвлөл байгуулах санал оруулж, уг зөвлөлийн бүрэлдэхүүнийг 9, 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг бүрэн эрхийн хугацаанд ажиллах, ийнхүү үндсэн хуульд нэр зааж байгуулах саналтай хоёр зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавигдах бусад шаардлагыг хуулиар тогтоохоор төсөлд оруулж байжээ.

5. Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл (2019.07.16) нь шүүх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлж, тогтолцоог боловсронгуй болгох зорилго бүхий бөгөөд энэ чиг үүргийг Шүүхийн сахилгын хороо байгуулах зарчмаар хэрэгжүүлэх, шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах, чөлөөлөх тохиолдолд саналаа томилсон эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх бөгөөд бусад шийтгэл ногдуулах шийдвэрийг бүрэн эрхийнхээ хүрээнд өөрөө гаргах, тус хорооны үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гэж томьёолжээ. Энэхүү төслийн хувьд УИХ-аар хэлэлцэгдэж буй УИХ-ын гишүүн нэр бүхий 62 гишүүний өргөн мэдүүлсэн төсөлтэй уялдуулах, асуудлыг зөвшилцөх үүрэг бүхий Ажлын хэсгээс Ерөнхийлөгчийн төслийн Шүүхийн сахилгын хороо байгуулахтай холбоотой саналыг ерөнхийд нь дэмжсэн байх бөгөөд энэ нь хэлэлцэгдэж байсан төсөлд агуулгын хувьд туссан гэжээ.

6. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл (2019.11.14)-ийг УИХ 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон 64 гишүүний 100 хувийн саналаар баталсан. *1) ШЕЗ-ийн гишүүдийн тавыг* шүүгчид дотроосоо сонгож, бусад *таван* гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилогдон 4 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд даргыг гишүүд дотроосоо сонгоно. 2) Шүүхийн хараат бус байдлыг хангахтай холбоотой зөвлөлийн үйл ажиллагааны тайланг[8] *Улсын дээд шүүхэд*

[8] *Тайлан гэж* удирдлагын өгсөн үүрэг даалгавар, хийхээр төлөвлөсөн ажлаа биелүүлэх талаар зохиосон ажил, түүний явц, үр дүнг илтгэсэн баримт бичиг. Б.Баярсайхан (2011) Монгол хэлний тайлбар толь. Уб., 1075 дахь тал.
Тайлан тавих, төлөвлөгөөний дагуу хийсэн ажлыг шалгах, үүрэг даалгавар өгөх зэрэг ажил хийгддэг.

танилцуулна. (Тайлбар: хоёрдугаар хэлэлцүүлэгт орохдоо -"Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг УДШ-д танилцуулна[9]" гэсэн агуулгатай байсан). Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно[10]. 3) Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бус*ад* шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтоохоор хуульчлан баталжээ. Дээрх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь ШЕЗ-ийн өнөөгийн тулгамдаж буй асуудал болох төвлөрсөн эрх хэмжээг хуваарилах, бүрэлдэхүүнийг өргөтгөх, бүтцийн хувьд хараат бус байдлыг бэхжүүлэх*эд анхаарсан ч* бүрэн эрхийн хугацааг сонгуулийн хугацаатай адил байхаар зохицуулсан нь улс төрийн нөлөө, оролцоог бүрэн хаасан гэхэд эргэлзээг үүсгэх болжээ. Мөн зөвлөлийн гишүүд, даргыг Ерөнхийлөгч томилохгүй байх зохицуулалтыг Үндсэн хуульд тусгасан нь зөвлөл хараат бус, бие даан ажиллах нөхцлийг бүрдүүлсэн чухал ач холбогдолтой. УИХ-ын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 155-д Шүүхийн захиргааны тухай /шинэчилсэн найруулга/ (Үндсэн хуулиар олгогдсон шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг баталгаатай хангахын тулд шүүхийн захиргааны чиг үүрэгтэй холбоотой хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох), 162-т Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Шүүгчийн эрх зүйн байдлыг шинэчлэн тогтоох, шүүх эрх мэдлийн хүрээнд хийгдсэн бусад шинэтгэлтэй нийцүүлэх, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох), 163-т Шүүгчийн хариуцлагын тухай /Шүүхийн ёс зүйн хорооны эрх зүйн байдлыг боловсронгуй болгож, шүүгчийн ёс зүйн зөрчил, түүнд оногдуулах хариуцлагыг тодорхой болгох/ гэж шүүх эрх мэдлийн чиглэлээр хийх шинэтгэлийг ажлын үндэслэл, зохицуулах харилцааг тодорхойлсон, УИХ-ын 2020 оны 2 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь"-т Шүүхийн хараат бус байдлыг хангаж, шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэхтэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дагуу Шүүхийн захиргааны тухай

[9] Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:
"5. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгч дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно. Санал гаргасан ажлын хэсэг. //Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы төрийн байгуулалтын байнгын хорооны 8 дугаар сарын 26-ны өдөр /даваа гараг/-ийн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл.

[10] Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин есдүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилтийг хангахын тулд Шүүхийн тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн найруулах, зарим нэг хуулийг шинээр батлах хэрэгцээ шаардлага бий болсны дагуу хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/229 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгээс дөрвөн хуулиар зохицуулж байсан харилцааг нэгтгэн Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг боловсруулан олон нийтээр хэлэлцүүлэн санал авахаар 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудсанд нийтэлсэн байна.

хууль /Шинэчилсэн найруулга/-ийг 2020 онд, Шүүхийн сахилгын хорооны тухай хууль /Анхдагч хууль/-ийг 2020 онд, Шүүх байгуулах тухай болон Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2021 онд тус тус Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулахаар баталсан зэрэг нь нэгтгэх бус нарийвчилсан зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатайг хууль тогтоомжоор баталгаажуулсан хэдий ч Шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг ЗГХЭГ-ын 2020 оны 118 дугаар албан бичгийн хавсралтаар УИХ-ын 2020 оны хаврын ээлжит чуулганаар Засгийн газраас санаачлан боловсруулж хэлэлцүүлэх хууль тогтоомжийн жагсаалтыг хүргүүлсэн байх бөгөөд нийт 14 асуудлын хүрээнд нэр заасан 62 хууль (нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулга, багц хуулийн төсөл) багтсан бол 6 дахь асуудал буюу Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 7 асуудал оруулж буйн *нэгдүгээрт* Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулахаар оруулсан нь Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжийг зөрчиж, дөрвөн хуулиар зохицуулсан харилцааг нэгтгэж Шүүхийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг боловсруулсан нь зайлшгүй эргэж нягтлах, цаашилбал Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэх нөхцөл байдал үүсэхийг үгүйсгэх аргагүй юм.

Дүгнэлт

Шинэтгэл нэрийн дор Үндсэн хуулийн анхдагч үзэл баримтлал хийгээд, нийтээр зөвшилцөн хүлээн зөвшөөрч буй агуулга, үзэл санааг хууль тогтоох эрх мэдлийн малгайн дор дур зоригийн шинжтэй болгон хувиргаж болохгүйг Үндсэн хуулийн эхийг баригч, хууль зүйн доктор, проф Б.Чимид агсан өөрийн бүтээлдээ тэмдэглэн сэрэмжлүүлж байсан нь энэ удаагийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн батлахад зохих нөлөө үзүүлсэн гэж тэмдэглэх нь зүйтэй.

Төрийн эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааг хариуцлагатай, харилцан тэнцвэр, хяналттай болгох зорилгын хүрээнд Үндсэн хуулийн III дахь шинэтгэлийг энэ цаг дор хийж, Шүүх эрх мэдлийн шинэтгэлд нэгэн шинэ түлхэц өглөө.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд Шүүх эрх мэдлийн хариуцлагыг дээшлүүлж, хараат бус байдлыг хангахтай холбоотой 3 заалт (49.5, 49.6 ба 48.1) шинээр тусгагдсан нь эерэг үр нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

1. Шүүхийн захиргааны бие даасан загварыг үндсэн хуулийн түвшинд бэхжүүлж байна. Шүүхийг тойргийн журмаар байгуулахыг зөвшөөрсөн нь шүүн таслах ажил, шүүхийн захиргааны харьцангуй тусдаа, бие даасан, мэргэшсэн байдлыг улам хөгжүүлэх шаардлагыг бий болгоно.

2. ШЕЗ-ийн бүрэлдэхүүний тоо, гишүүнд тавигдах шаардлага, бүрэн эрхийн хугацааг Үндсэн хуульд зааж өгсөн нь улс төрч, хууль тогтоогчид хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, томилгоо хийх замаар шүүгчийн томилгоо, шүүхийн захиргаанд нөлөөлөх боломжийг хязгаарлаж, шүүхийн хараат бус байдлын баталгааг сайжруулна;

3. Шүүгчийн сахилгын хороог Үндсэн хуульд нэр зааж байгуулснаар шүүгчид хариуцлага хүлээлгэх тогтолцоог шударга, үр нөлөөтэй болгох, олон

нийтийн хяналтад оруулах нөхцлийг бүрдүүлнэ.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн (2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 12 цагаас эхлэн дагаж мөрдөнө.) бодит үр нөлөө нь холбогдох хууль тогтоомжийг энэхүү нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас хамаарах юм.

Хавсралт

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ, ТЭДГЭЭРИЙН ХАРЬЦУУЛАЛТ

/хэсэгчлэн авав/

Үндсэн хуулийн хүчин төгөлдөр үйлчилж буй зүйл, заалт	**Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл (2018.03.19)**	**Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл (2018.04.20)**	**Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл (2018.05.29)**	**Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл (2019.04.04)**	**Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл (2019.06.06)**	**Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт (2019.11.14) баталсан**
Дөчин есдүгээр зүйл **5.**Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны жүрмыг хуулиар тогтооно.	**Дөчин есдүгээр зүйл** **5.** Шүүхийн ерөнхий зөвлөлийг дараах журмаар байгуулах бөгөөд зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно: 1/Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч болон Улсын Их Хурлаас **томилогдсон хоёр хүн**, Засгийн газраас **томилогдсоннэг хүн**, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс **сонгогдсон нэг**, давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс **сонгогдсон хоёр**, анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс	**Дөчин есдүгээр зүйл** **5.**Шүүхийн ерөнхий зөвлөлийг дараах журмаар байгуулах бөгөөд зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно: 1/Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч болон Улсын Их Хурлаас томилогдсон хоёр хүн, Засгийн газраас томилогдсон нэг хүн, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс сонгогдсон нэг, давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс сонгогдсон хоёр, анхан шатны шүүхийн шүүгчдийн	**Дөчин есдүгээр зүйл** **6.** Шүүхийн ерөнхий зөвлөлийг дараах журмаар байгуулна: 1/Шүүхийн ерөнхий зөвлөл 11 гишүүнээс бүрдэнэ. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн 4 жилийн хугацаагаар зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллана. 2/Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн гурвыг Улсын их хурал, хоёрыг Ерөнхийлөгч тус тус томилох бөгөөд тэдгээр нь хуульчийн мэргэжлээр арваас доошгүй жил ажилласан, хууль зүйн өндөр мэргэшилтэй байна. 3/Шүүхийн ерөнхий зөвлөлийн	**Хоёр.Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох:** **49.5.** Шүүхийн ерөнхий зөвлөлийг дараах журмаар байгуулна: 1/Шүүхийн ерөнхий зөвлөл арвангишүүнээс бүрдэнэ. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллана; 2/Шүүхийнерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыгУлсын Их Хурлын холбогдох байнгын хороо нэр дэвшүүлж, Улсын Их Хурал томилгооны сонсгол хийж, хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар томилно.Тэдгээр нь хууль зүйн өндөр мэргэшилтэй,мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэн байна; 3/Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн нэгийг хяналтын шатны шүүхийн шүүгчдээс, нэгийг давж заалдах шатны шүүхийн шүүгчдээс, гурвыг анхан шатны шүүхийн шүүгчдээс тус бүр дундаасаа сонгоно; 4/Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо нэр дэвшүүлж, нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.	**Хоёр.Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүгчийн хариуцлагын зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох:** **49.5.**Шүүхийн ерөнхий зөвлөлийг дараах журмаар байгуулна: 1/Шүүхийн ерөнхий зөвлөл арван гишүүнээс бүрдэнэ. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллана; 2/Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нэр дэвшүүлэн томилгооны сонсгол хийж, Улсын Их Хурал хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар	**Шүүхийн ерөнхий зөвлөл:** 49.5. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээрнь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Шүүгчийн харааг бус байдлыг хангахтай холбоотой зөвлөлийн үйл ажиллагаанытайланг Улсын дээд шүүхэд танилцуулна. Зөвлөлий

	сонгогдсон гурван шүүгч тус тус орно. 2/Ерөнхий зөвлөлийн Улсын Их Хурлаас томилогдсон болон Ерөнхийлөгчөөс томилогдсон, анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс сонгогдсон тус бүр нэг гишүүн орон тооны байх бөгөөд бүх гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна. Ерөнхий зөвлөлийн даргаар орон тооны гишүүний аль нэгийг дөрвөн жилийн хугацаагаар гишүүдийн олонхийн саналаар сонгоно.	зөвлөгөөн өөс сонгогдсон гурван шүүгч тус тус орно. 2/Ерөнхий зөвлөлийн Улсын Их Хурлаас томилогдсон болон Ерөнхийлөгчөөс томилогдсон, анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөн өөс сонгогдсон тус бүр нэг гишүүн орон тооны байх бөгөөд бүх гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна. Ерөнхий зөвлөлийн даргаар орон тооны гишүүний аль нэгийг дөрвөн жилийн хугацаагаар гишүүдийн олонхийн саналаар сонгоно.	гишүүдийн нэгийг хяналтын шатны шүүхийн шүүгчдээс, хоёрыг давж заалдах шатны шүүхийн шүүгчдээс, гуравыг анхан шатны шүүхийн шүүгчдээс сонгоно. 4/Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг Улсын их хурал, ерөнхийлөгчөөс томилсон гишүүд дотроос нэр дэвшүүлж, нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.	**Гурав.Шүүгчийн хариуцлагын зөвлөл байгуулах:** **49.6.** Шүүгчийн хариуцлагын зөвлөлнь хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, чөлөөлөх, огцруулах болон бусад шийтгэл ногдуулах шийдвэр гаргана. **49.7.** Шүүгчийн хариуцлагын зөвлөл9 гишүүнээс бүрдэнэ.Шүүгчийн хариуцлагын зөвлөлийн гишүүн нь 6 жилийн хугацаагаар зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллана. Шүүгчийн хариуцлагын зөвлөлийг дараахь журмаар байгуулна: 1/Гишүүдийнгурвыгир гэдээс;гурвыгхуульзүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан эрдэмтдээс тус тус сонгон шалгаруулж Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо нэр дэвшүүлэнУлсын Их Хурал хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйнсаналаар томилно; 2/Гишүүдийннэгийг хяналтын шатны шүүхийн шүүгчдээс, нэгийг давж заалдах шатны шүүхийн шүүгчдээс, нэгийг анхан шатны шүүхийн шүүгчдээс тус бүр дундаасаа сонгоно; 3/Шүүгчийн хариуцлагын зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо нэр дэвшүүлж, нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно. **49.8.** Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүгчийн хариуцлагын зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.	томилно. Тэдгээр нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэн байна; 3/Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн нэгийг хяналтын шатны шүүхийн шүүгчдээс, нэгийг давж заалдах шатны шүүхийн шүүгчдээс, гурвыг анхан шатны шүүхийн шүүгчдээс тус бүр дундаасаа сонгоно; 4/Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо нэр дэвшүүлж, нийт гишүүний олонхийн саналаар сонгоно. **49.6.**Шүүгчийн хариуцлагын зөвлөл нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон бусад шийтгэл ногдуулах, чөлөөлөх шийдвэр гаргана. **49.7.**Шүүгчийн хариуцлагын зөвлөл есөн гишүүнтэй байна. Тэдгээрийн гурав нь	н зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно. **Шүүхийн сахилгын хороо:** 49.6. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.

					шүүн таслах ажлын туршлагатай хуульч; гурав нь хууль зүйн эрдэмтэн; гурав нь иргэдийн төлөөлөл байна. Зөвлөлийн гишүүд нь зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. **49.8.**Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүгчийн хариуцлагын зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавигдах бусад шаардлагыг хуулиар тогтооно.	

-oOo-